

ГАРЧИГ

Ерөнхий хэсэг	4-4
Судалгааны арга зүй.....	5-5

I Бүлэг. Аймгийн байгаль, цаг уур, нийгэм-эдийн засгийн нөхцөл

1.1. Булган аймгийн тухай ерөнхий ойлголт.....	6-6
1.2. Байгаль цаг уурын нөхцөл	
1.2.1. Уур амьсгалын нөхцөл.....	6-8
1.2.2. Газрын гадарга.....	8-9
1.2.3. Хөрс, хөрсөн бүрхэвч.....	9-10
1.2.4. Ургамал, ургамлан бүрхэвч.....	10-12
1.2.5. Ан амьтан.....	12-13
1.2.6. Ус зүй.....	13-14
1.2.7. Орчны бохирдол.....	14-14

Дүгнэлт

1.3. Нийгэм - эдийн засгийн нөхцөл	
1.3.1. Нийгэм - эдийн засгийн суурь нөхцөл	
1.3.2. Хүн ам	15-15
1.3.3. Газар тариалан.....	15-16
1.3.4. Мал аж ахуй.....	16-16
1.3.5. Үйлдвэрлэл, үйлчилгээ.....	16-17
1.3.6. Дэд бүтэц, зам харилцаа, бусад салбар.....	17-17
1.3.7. Булган аймагт сүүлийн жилүүдэд нийгэм - эдийн засаг, байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд.....	18-18

Дүгнэлт

II Бүлэг. Булган аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал

2.1 Булган аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц.....	18-21
2.2 ХАА-н ангиллын газрын бүтэц, ашиглалт, хамгаалалтын байдал	
2.2.1 Тариалангийн газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал..	21-23
2.2.2 Жимс, жимсгэний газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал..	23-25
2.2.3 Хадлангийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.....	25-25
2.2.4 Бэлчээрийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.....	26-31
2.2.5 ХАА-н барилга байгууламжийн газар.....	31-31
2.2.6 ХАА-д ашиглах боломжгүй газар.....	31-31

Дүгнэлт

2.3. Хот, тосгон бусад суурины ангиллын газар, түүний ашиглалт,	
---	--

хамгаалалтын байдал	
2.3.1 Хот, тосгон бусад суурины ангиллын газрын бүтэц	32-32
2.3.2 Хот, тосгон бусад суурины тэг гортигийн доторхи газрын ашиглалт, хамгаалалтын байдал.....	32-35
2.3.3 Амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын газрын ашиглалт, хамгаалалтын байдал.....	35-39
2.3.4 Үйлдвэр уурхайн газрын ашиглалт, хамгаалалтын байдал....	39-40
Дүгнэлт	
2.4 Зам, шугам сүлжээний ангиллын газар, түүний ашиглалт	
2.4.1 Зам, шугам сүлжээний ангиллын газрын бүтэц.....	40-40
2.4.2 Автозамын зурвас газар.....	40-41
2.4.3 Инженерийн шугам сүлжээний зурвас газар.....	41-42
Дүгнэлт	
2.5 Ойн сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал	
Дүгнэлт	42-46
2.6 Усны сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал	
Дүгнэлт	47-49
2.7 Тусгай хэрэгцээний ангиллын газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал	
2.7.1 Тусгай хэрэгцээний ангиллын газрын бүтэц.....	49-50
2.7.2 Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний ашиглалт, хамгаалалтын байдал	50-51
2.7.3 Улсыг батлан хамгаалах зориулалтын газар.....	51-51
Дүгнэлт	

III Бүлэг. Газрын менежментийн бүсүүд,

түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт

3.1 ХАА-н ангиллын газрын менежментийн бүсүүд, түүний нөөц нөхцөлийн төлөвлөлт	
3.2 Тариалангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт.....	51-53
3.2.1 Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх талаар төлөвлөсөн асуудлууд.	53-56
3.2.2. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх талаар гаргасан зөвлөмж.....	56-57
3.3. Хадлангийн газрын менежментийн бүсүүд, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт.....	57-58
3.3.1 Хадланд шинээр эзэмших талбайнууд, тэдгээрийн товч тодорхойлолт.....	58-59

3.3.2. Хадлангийн эдэлбэр газрын ашиглалтыг эрчимжүүлж, хамгаалалтыг сайжруулах.....	59-60
3.4. Бэлчээрийн менежментийн бүсүүд, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт	
3.4.1. Бэлчээрийн менежмент.....	60-62
3.4.2. Бэлчээр хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх талаар.	63
3.4.3. Бэлчээрийн усан хангамжийн асуудал.....	64-64
3.5. Хот тосгон бусад суурьшлын бүсийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт	
3.5.1. Булган хот, сумын төвүүдийн эзэмшил газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт.....	65- 67
3.5.2. Булган хот , сумын төвүүдийг үер, усны аюулаас хамгаалах талаар	
3.5.3. Үйлдвэр уурхайн бүс газар, тэдгээрийн нөөц, нөхцөлийн төлөвлөлт	67-68
3.5.4. Амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын газрын төлөвлөлт.....	68 - 71
3.6. Зам, шугам сүлжээний газрын төлөвлөлт	
3.6.1. Автозамын газрын төлөвлөлт.....	72-72
3.6.2. Төмөр замын газрын төлөвлөлт.....	72-72
3.6.3. Шугам сүлжээний газар, түүний төлөвлөлт.....	72-72
3.7. Ойн сангийн газрын төлөвлөлт.....	72-75
3.8. Усны сангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт.....	75-76
3.9. Улсын тусгай хэрэгцээний газрын бүсүүд, түүний нөөц, нөхцлийн төлөвлөлт	
3.9.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, нөхцлийн төлөвлөлт.....	77-80
3.10. Биологийн төрөл зүйлийг хамгаалах талаар.....	80-84

IV бүлэг. Газар ашиглалтын экологи - эдийн засгийн үнэлгээ

4.1. Газрын экологийн чадавхи, түүний хадгалалт, хамгаалалт.	
4.1.1. Газрын экологийн чадавхи.....	85-88
4.1.2. Газрын экологийн төлөв байдал, түүний хадгалалт, хамгаалалт....	88-91
4.1.3. Газрын хадгалалт, хамгаалалт.....	91-91
4.2. Газрын эдийн засгийн үр ашиг, удирдлага , зохион байгуулалт.	
4.2.1. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт.	91-94
4.2.2. Газрын эдийн засгийн үнэлгээ.....	94-95
Ерөнхий дүгнэлт.....	95-96

Ерөнхий хэсэг

Монгол улсад Газрын тухай багц хууль батлагдсанаар Газрын харилцааны олон асуудлууд хууль эрх зүйн хүрээнд цогц байдлаар үе шаттайгаар хэрэгжиж байгаагийн нэг илрэл бол улс, аймаг сум, дүүргийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж мөрдөх явдал юм.

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө гэдэг нь аймгийн хөгжлийн алс хэтийн бодлогыг газрын нөөцийн төлөвлөлтөөр дэмжихийн хамт, газрын нэгдмэл сангийн ангилал бүрт эдийн засгийн үр ашигтай цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг тодорхойлсон зураг төслийн баримт бичиг байдаг. Өөрөөр хэлбэл байгалийн унаган төрх байдал, одоогийн төлөв байдалд үнэлэлт дүгнэлт өгч, түүний нөөц баялгийг тооцоолсны үндсэн дээр газар ашиглалтын хамгийн ашигтай хувилбар, төлөвлөгөөг боловсруулахын дээр цаашид газрын нөөц баялгийг хэрхэн хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга замуудыг зааж өгсөнөөрөө шинэлэг юм. Энэхүү бичиг баримтыг мөрдлөг болгосноор тухайн бүс нутагт газрын шинэтгэлийн олон асуудлууд хуулийн дагуу шийдэгдэхээс гадна, газар эзэмшигч ашиглагчийн эрх ашиг хамгаалагдаж газар ашиглах таатай, тогтвортой орчин бүрдэнэ.

Энэ ажлын хүрээнд Булган аймгийн газар ашиглалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгч нийгэм эдийн засгийн хөгжилийг газрын менежментийн бодлогоор дэмжин зохицуулах зорилт тавив.

Булган аймгийн Засаг даргын захиалгаар Газрын чиглэлийн мэргэжилийн эрх бүхий байгууллага “Глобус” ХХК нь 2005-2006 онд Булган аймгийн Газар Зохион Байгуулалтын Ерөнхий Төлөвлөгөө боловсруулах ажлыг арга зүй, зааврын дагуу мэргэжилийн багийг зохион байгуулж, хийж гүйцэтгэлээ. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд манай байгууллагын ажилтан мэргэжилтнүүдээс гадна Ус Цаг Уурын Эрдэм Шинжилгээний Хүрээлэн, Дархан хотын ХАУТЛаборатори, ХААИС, ШУА-ийн Ботаникийн хүрээлэн, Усны институт, Эрчим Хүчний Судалгаа Хөгжилийн Төвийн мэргэжилтнүүд өргөн оролцсон юм.

Уг ажлыг гүйцэтгэхэд оролцсон албан байгууллага, хувь хүмүүс, мэргэжилтнүүд болон тоон болон зурган мэдээлэлээр хангаж хамтран ажилласан Булган аймгийн Газрын албаны хат олонд зохиогчийн зүгээс гүн талархал илэрхийлье.

Тайланг эмхтгэн бичсэн Д. Цэцгээ

Судалгааны арга зүй

Уг ажлыг гүйцэтгэхдээ ГХГЗЗГ-аас боловсруулан гаргасан “Аймгийн Газар Зохион Байгуулалтын Ерөнхий Төлөвлөгөө Боловсруулах арга зүйн зааврыг” /1/ мөрдлөг болгон ажиллав. Үүнд юуны өмнө хөрс, ургамал, ус зүй, цаг уур, ан амьтан гэсэн байгалийн унаган нөхцөл байдлын судалгааг хийсэн бөгөөд үүн дээр тухайн бүс нутгийн нийгэм - эдийн засгийн судалгаа, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр”, “Мянганы зам”, “Булган аймгийн хөгжлийн үндсэн чиглэл”, Булган аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”, Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр “, “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр” /2-22/ зэрэг олон баримт бичгүүдийг өргөн дэлгэр ашиглав. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байгаль орчны урт хугацааны бодлого хөтөлбөрийг бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ” гэснийг үндэслэн Булган аймгийн Газар Зохион Байгуулалтын Ерөнхий Төлөвлөгөөг нутаг дэвсгэрийн бүсчилсэн зохион байгуулалт буюу нутаг дэвсгэрийг бүсчлэн төлөвлөх аргаар гүйцэтгэсэн болно. Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, практик амьдралыг онолын зарчмуудтай нь холбон судалж, харьцуулан жиших, газар зүйн судалгааны гол арга болох хээрийн судалгаа, зураг зүйн аргуудыг өргөн хэрэглэсэн. Арга зүйн зарчим нь газрын менежментийн бүсийг нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, төлөвлөлтийн аргаар дэмжих явдал байв. Төлөвлөлтийн ажлыг

2005-2010 он хүртэл ойрын,

2010-2015 он хүртэл дунд,

2015-2020 он хүртэл хэтийн гэсэн 3 үе

шаттайгаар төлөвлөв.

Зургийн ажлыг 1:100 000, 1:50 000 болон 1:25 000 масштабын байр зүйн зураг ашиглан гүйцэтгэсэн ба зургийг тоон хэлбэрт оруулах ажлыг газар зүйн мэдээллийн системийн GIS-ийн ARCVIEW- 3.2, ARC INFO-3.5 программ хангамж ашиглан боловсруулав. Үүнд: аймгийн нутаг дэвсгэрээр

Экосистемийн зураг 1:1 000 000

Хөрсний зураг 1:1 000 000

Хадлан бэлчээрийн зураг 1:1000 000

Ургамалжилтын зураг 1:1 000 000

Гүний усны зураг 1:1 000 000

Геологийн тойм зураг 1: 1 000 000

Хадлан бэлчээрийн зураг 1:1 000 000

Ойн сангийн зураг 1: 1 000 000 масштабаар үйлдэж тайлангийн 1-р бүлэгт хавсаргаснаас гадна ГЗБЕТ-ний зургийг 1: 200 000 масштабтайгаар хэвлэж хавсаргав.

Аймгийн Газрын Алба санал болгосны дагуу

хадлан, тариалангийн газрын төлөвлөлтийн зургийг 1:25 000

ерөнхий төлөвлөгөөний үндсэн зургийг 1: 50 000

бэлчээрийн менежментийн зургийг 1:1 00 000 масштабаар,

сум тус бүрээр тус тус хэвлэв.

Ажлын тайлан нь Булган аймгийн байгаль, цаг уур, нийгэм -эдийн засгийн нөхцөл, Булган аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц, ашиглалт хамгаалалтын одоогийн байдал, Газрын менежментийн бодлогын бүсүүдийн төлөвлөлт, Газар ашиглалтын экологи-эдийн засгийн үнэлгээ гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрдэж байна.

I Бүлэг. Булган аймгийн байгаль, цаг уур, нийгэм-эдийн засгийн нөхцөл

1.1. Булган аймгийн тухай ерөнхий ойлголт

Булган аймаг нь манай орны төв хэсэгт Хангайн бүс нутгийн тогтолцоонд оршдог ба 4 873 300 га нутагтай, баруун, өмнө, зүүн талаараа Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ аймгуудтай, хойд талаараа ОХУ-тай хиллэдэг. Засаг захиргааны 16 нэгжтэй, сумууд нь дунджаар 3500 хүн амтай, сумын төвүүд нь аймгийн төвөөсөө 22-240 км зайд оршино. Улаанбаатар хотоос 326 км, бүсийн тулгуур төв Эрдэнэт хотоос 68 км зайд оршино.

Ирээдүйд бүс нутгийн хүн амын гурил, төмс, хүнсний ногооны хэрэгцээг хангах, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, рашаан сувилал, аялал жуулчлал хөгжүүлэх, дотоодын нүүрсний хэрэгцээний тодорхой хувийг хангах чиглэлийг голлон барина.

1.2 Булган аймгийн байгаль, цаг уурын нөхцөл

1.2.1 Уур амьсгалын нөхцөл.

Булган аймаг уур амьсгалын мужлалаар үндсэндээ хуурайдуу, сэрүүвтэр (1750° - 2000° C), хуурай дулаавтар (2000° C аас их), чийглэгдүү сэрүүн (1500° - 1750°), чийглэг хүйтэвтэр (1000° - 1500°) мужид хуваагдах тул ерөнхийдөө эх газрын уур амьсгалтай. Өвөл нь тийм ч их сэрүүн биш боловч нилээд удаан хугацаагаар үргэлжилдэг бөгөөд зун нь бороорхог, харин намар, хаврын улиралууд нь хуурайвтар болно /26,27/.

Нарны цацраг. Нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа Булган аймагт жилд 2753-2776 цаг байна. Энэ нь тухайн орон нутгийн өргөрөг, тэнгэрийн хаяаны хаагдал, үлшил зэргээс ихээхэн шалтгаална. Нар гийх хугацаа XII сард хамгийн бага VII, VIII сард хамгийн их болно.

Нийлбэр цацрагийн хэмжээ тус аймгийн нутагт $125.6 \text{ ккал/см}^2 \text{ V}$ дугаар сард 17.4 ккал/см^2 болно.

Улирлын ялгаа. Өвөл: Өвөл ихэнхдээ тэнгэр цэлмэг, тогтвортой хүйтэн, цас бага, салхины хүч бага байна. Агаарын дундаж температур I дүгээр сард хамгийн бага байх ба $-21,3^{\circ}$ C хүйтэн байдаг. Үнэмлэхүй хамгийн бага температур – 39.7° C-аас 44.5° C хүрнэ. Түүнчлэн хөрсний гадарга дээрхи температур I дүгээр сард дунджаар -16.5° C-аас -20.8° C хүрдэг ба үнэмлэхүй бага температур нь -40.0° C-аас -44.8° C хүйтэн байна. Харьцангуй чийг хамгийн их утгадаа 67% хүрэх бөгөөд I дүгээр сард дунджаар 1.2 мм тунадас унадаг. Өвөл нь энэ хавийн нутагт баруун зүгийн салхи зонхилж салхины хурд дунджаар 1.9 м/с хүрдэг. Тогтвортой цасан бүрхүүл 11 дүгээр сарын хоёрдугаар арав хоногоос 3 дугаар сарын гуравдугаар арав хоног хүртэл үргэлжилнэ. Цасан бүрхүүлийн зузаан 170 мм байна.

Хавар: Хавар цаг агаарын байдал тогтворгүй, агаарын температур түргэн нэмэгдэж өдөртөө дулаан, шөнөдөө хүйтэн, нэг хоногийн доторхи халуун хүйтний хэлбэлзэл их болно. 3 дугаар сард нийтдээ хүйтэвтэр бөгөөд сарын дундаж агаарын температур -6.7° C хүрч цаашид 4 дүгээр сараас эхлэн 0.8° C-аас дээшилж 5 дугаар сард дундаж температур 11.4° C хүрч дулаарна. Энэ улиралд 2,2 м / с байдаг салхины хурд ихсэж хамгийн ихдээ 24 м/с-ээс 40 м/с болдог бөгөөд шороон шуурга олонтоо шуурна. Дунджаар 5-6 өдөр шуурна. Эрс тэс уур амьсгалтай хоногийн температурын хэлбэлзэл их учир хаврын сүүл, намрын эхээр цочир хүйтрэл болох нь олширно. Хавар эцсийн цочир хүйтрэл дунджаар V.19-VI.2-ны үед болох боловч жилээс жилд харилцан адилгүй. Хавар

агаарын температур түргэн нэмэгдэхийн хамт хур тунадас бага учраас харьцангуй чийгшил хамгийн багадаа V дугаар сард 17% хүрнэ.

Зун: Зуны улиралд цаг агаарын байдал харьцангуй тогтвортой агаарын дундаж температур VII сард хамгийн их буюу 16.4°C хүрнэ. Үнэмлэхүй хамгийн их температур 32.2°C-аас 40.1°C хүрч дулаарна. Хөрсний гадарга дээрхи температур дунджаар 22.8°C-аас 27.9°C хүрэх ба үнэмлэхүй хамгийн их температур 59.3°C-аас 68.4°C болдог. Харьцангуй чийгшилийн хэмжээ VIII дугаар сард 69% болно. Зуны улиралд нийт ба доод мандлын үүлний хэмжээ хамгийн их байна.

Намар: Намрын улиралд агаарын температурын хэлбэлзэл их боловч хаврынхтай адилгүй бөгөөд X дугаар сарын дундаж температур 1.3°C, харьцангуй чийгшил зуныхаас буурах боловч хаврынх шиг хуурайшилгүй байна. Харьцангуй чийгшил X дугаар сард 64% болж байна. Намрын улиралд циклон ба эсрэг циклон ээлжлэн солигдох явдал их байдгаас цаг агаар тогтворгүй болж салхины хүч нэмэгдэж салхины хурд дунджаар 2.2 м/с хүрнэ. Намар анхны цочир хүйтрэл дунджаар VIII.31-IX.18-ны үед ажиглагддаг байна.

Дулаан хүйтний горим. Аймгийн нийт нутгаар жилийн дундаж агаарын температур нь 0.9°C-аас -1.6°C байна. 0 C-ээс доош температуртай өдрийн тоо 190-230 хоног байна 242 хоног галладаг. Газарзүйн байршилт /далайн төвшнөөс дээш өндөр/ янз бүр байгаатай уялдаж жилийн дундаж агаарын температур харилцан адилгүй байна. Энэ нь хүйтэн улиралд нам газар хүйтэн агаар хуралдаж өндөрлөг газраасаа хүйтэн, дулааны улиралд эсрэгээр өндөр газраа сэрүүвтэр, нам газраа дулаавтар байдагтай холбоотой юм. Тус аймгийн нутагт агаарын температур өмнөөсөө хойшлох тутам ерөнхийдөө буурах боловч гадаргын байдал орон нутгийн онцлогоос болж жигд биш хуваарилалттай байдаг.

Цочир хүйтрэл: Намар анхны цочир хүйтрэл агаарт, дунджаар VIII.31-IX.18-ны үед болдог ба энэ нь жил бүр харилцан адилгүй бөгөөд анхны цочир хүйтрэл эртдээ VIII.2-VIII.27-нд, хожуудаа IX.20-X.10-ны үед болох ба хөрсний гадарга дээр цочир хүйтрэл болох хугацаа дунджаар VIII.16-ний үед, эртдээ VII.1-нд, хожуудаа IX.10-ны үед ажиглагджээ.

Хаврын эцсийн цочир хүйтрэл агаарт дунджаар Y.19-YI.2-нд, эртдээ Y.2-Y3-нд, хожуудаа Y.30-YI.26-нд болох ба хөрсний гадарга дээр дунджаар YI.11-нд, эртдээ Y.23-нд, хожуудаа YI.29-нд тус тус ажиглагдаж байжээ.

Хөрсний температур: хөрсний гадаргын дундаж температур 2.6°C-5.2°C байдаг. Өвлийн ихээхэн хүйтнээс шалтгаалж хөрс хөлдөх хугацаа дунджаар X.15-ний үед хөлдөнө. Энэ нь мөн жил бүр адилгүй юм. Ажиглалтын материалаас үзвэл жилийн явцад хөрсний хөлдөх хугацаа эртдээ IX.18-нд, хожуудаа X.17-нд ажиглагджээ.

Хөрсний гэсэх дундаж хугацаа IV.03-нд гэсдэг. Мөн хөрсний гэсэх хугацаа хамгийн эртдээ III.12-нд, хожуудаа IV.19-ний үед гэсдэг нь ажиглагджээ

Чийгшил хур тунадасны горим: Жилд дунджаар 324,3 мм тунадас орох ба ихэнх хувь нь дулааны улиралд (жилд унах тунадасны 90%) 291 мм тунадас унана. Харин хүйтний улиралд дөнгөж 10.6% нь унана. Иймээс цас багатай байдаг. Гэвч өвөл салхины хүч бага байдгаас тогтвортой цасан бүрхүүл гол төлөв XI сарын хоёрдугаар арав хоногоос тогтож III сарын гуравдугаар арав хоногоос арилна. Нийт 120-150 хоног цастай байна. Цасан бүрхүүлийн зузаан дунджаар 170 мм хүрнэ. Цас орох анхны хугацаа жилд дунджаар өмнө хэсэгтээ X.6-X.10-ны үед ба энэ нь

жилд харицан адилгүй байх бөгөөд эртдээ Х.4-Х.15-нд, хожуудаа XI.22-XII.14-ний үед ажиглагдаж эцсийн цас орох хугацаа дунджаар Y.8-Y.20-ний үед, эртдээ IV.16-Y.13-нд, хожуудаа YI.1-YI.19-ний үед орж байжээ. Харьцангуй чийгшил жилд дунджаар 63% хүрч, хамгийн их утга нь XII, I сард болон VIII сард илэрч, хамгийн бага утга нь шилжилтийн улиралд IV, V сард болон X сард ажиглагдана.

Агаарын даралт 1 ба 7-р саруудад 880 гПА байна.

Орхон-Сэлэнгийн савын бэсрэг уулсын район бол уур амьсгалын хувьд температурын зөрүү бүхий (улирлын ч, хоногийн ч), эх газрын эрс тэс уур амьсгал ноёрхсон, чийг тунадас харьцангуй бага унадаг (150-350 мм), агаар нь хуурайвтар, жилд сэрүүн ба хүйтэн улирал урт үргэлжилсэн нутгийн хил хязгаарт багтана. Гэвч газарзүйн байрлал, уулс зүйн тогтолцооноос шалтгаалаад уур амьсгалын элементүүдийн хуваарилалтад өргөрөг бүсийн ялгаа илэрдэг байна.

1.2.2 Газарзүйн байрлал, гадаргын онцлог

Булган аймгийн нутаг физик газарзүйн шинэчилсэн мужлалаар /25/ Хангайн уулт их мужид хамрагдах Орхон-Сэлэнгийн савын бэсрэг уулс, тэдгээрийн хоорондох хөндийд багтана. Сэлэнгэ мөрний урд талаар орших Хан Жаргалант, Бүрэнгийн нуруунаас урагш салбарласан уулс Орхон, түүний цутгал голуудаар хэсэгчлэгдсэн байдалтай болж жижиг жижиг нуруудыг үүсгэнэ. Уул нуруудын чиглэл нь ихэнхдээ хойноос урагш уртраг дагасан байрлалтай байна. Эндхийн уул нурууд далайн түвшнээс дээш дунджаар 1500-2200 м өндөр өргөгдсөн, хамгийн өндөр цэг нь Хантайн нурууны ноён оргил д.т.д 2171 м өргөгдсөн Довчин уул, нам цэг нь Сэлэнгэ мөрний хөвөөнд д.т.д 750 м-т оршино.

Дэд доктор З.Мөнхөөгийн ангиллаар энэ нутаг уулс зүйн хувьд Орхон - Сэлэнгийн савын бэсрэг уулс, Дорнод Хангайн өндөр тал гэсэн морфоструктурын хувьд ялгаатай 2 хэсэгт хуваагдана. Сэлэнгийн савын бэсрэг уулсад багтах томоохон уул нуруудад Хантайн нуруу (2171м), Зэдийн нуруу (2156 м) Бүтээлийн нуруу (1815 м), Бүрэнгийн нуруу (2093 м), Бүрэгийн нуруу (2108 м), Могодын нуруу (2139 м), Хөгнө хаан (1967 м) зэрэг уулс багтана.

Эндхийн уулт тогтолцооны геологийн суурь нь Монгол орны бусад нутгийг бодвол эрт атриатаж батжин тогтворжсон учраас тектоник шинэхэн хөдөлгөөний үеэр зөвхөн бүл цүл хөдөлгөөн ноёрхож зөрөгт огшоос, хотос үүсч байжээ. Тийм учраас эндхийн уулсын хажуу налуу, орой хяр нь бөмбөгөр буюу ихээхэн элэгдэж мөлийсөн шинжтэй юм. Элэгдлийн үйл явц удаан хугацаанд үргэлжлэн явагдсаны улмаас голын хөндийнүүд тун сайн тогтворжсон учраас эндхийн уулсын хажуу налуу, орой хяр нь бөмбөгөр буюу ихээхэн элэгдэж мөлийсөн шинжтэй юм. Элэгдлийн үйлц явц удаан хугацаанд үргэлжлийн явагдсаны улмаас голын хөндийнүүд тун сайн тогтворжсон шинжтэй, нэлээд өргөн бөгөөд тууш зүсэлтэд нь босоо, нугалаа цөөн үзэгдэнэ.

Дорнод Хангайн өндөр талд хамрагдах Дашинчилэнгийн хотгор баруун тийш Өгий, Хануйн голын хотгоруудтай хил нийлнэ. Энэ нь д.т.д 1000-1100 м-ийн түвшинд оршино. Өгий, Дашинчилэнгийн хотгорт дунд төрмөлийн эринээс хойш удаан хугацааны туршид хурдас хуримтлагдах нөхцөл бүрэлдсэн учраас хотгорын төв хэсэг болон голуудын дагуу тохиолдох элс хайрга зэрэг хуримтлалын материал харьцангуй зузаан үеэр тархжээ. Эрдэмтэдийн судалгаанаас үзэхэд геологийн тодорхой цаг үед Орхон гол Өгий, Дашинчилэнгийн хотгорыг өөрчлөн хойт зүгт урсгах болж улмаар үндсэн гол болж хувирсан байна. Түүнээс өмнө Тамирын гол үндсэн гол болж байж Орхоныг өөртөө нэгтгэдэг байжээ.

Газрын хотгор гүдгэр, өндөржилт зөвхөн ашиглалтад төдийгүй геологийн өртөнги байдалд багагүй нөлөөлдөг бололтой. Улсын дунджаар бүх нутаг

дэвсгэрийн 60 гаруй хувь далайн түвшнээс 1300 м-ээс дээш бол Булган аймгийн Баяннуур, Дашинчилэн, Рашаант сумын нутагт 1300 метрээс дээш өргөгдсөн талбайн хэмжээ улсын дунджаас 2-4 дахин бага юм. Газар нутаг намсах тутам тодорхой хэмжээнд гадарга тэгш болохын зэрэгцээ хөрс хийсэх, элсэн хуримтлал үүсэх үйл явц идэвхижих нөхцөл бүрддэг байна.

1.2.3 Хөрс, хөрсөн бүрхэвч

Хөрс үүсгэгч эх чулуулаг. Хөрсний физик хими шинж чанар уг хөрсийг үүсгэгч эх чулууллагаас ихээхэн хамаарах бөгөөд газрын гадаргын хотгор гүдгэрээс тэдгээрийн тархалт харилцан адилгүй байна. Тус аймгийн нутагт ихэвчлэн дараахи хөрс үүсгэгч эх чулууллагууд тогтсон байна.

1. Элювийн хурдас - Э
2. Элюви-делювийн хурдас- ЭД
3. Делювийн хурдас -Д
4. Аллювийн хурдас -А

Эллювийн хурдас нь өгөрших үйл явцад орж ан цав гарч хагарсан хурц ирмэг бүхий хад чулуу бөгөөд анхны үүссэн байрандаа үлддэг бөгөөд уулын орой, хяраар тохиолдоно.

Делювийн хурдас нь элювийн хурдасны задрал бутрал, өгөршилийн үр дүнд бий болож улмаар бороо цас, салхины нөлөөгөөр уулсын хормой хотгор, хөндийн ёроолд бөөгнөрөн тогтсон байх ба ихэвчлэн уул хоорондын өргөн нарийн хөндийгээр тархана. Харин аллювийн хурдас нь их төлөв голын хөндийн нуга, татам, дэнжид усны үйл ажиллагаагаар үүсэж тогтсон бүрэлдэхүүнд нь лаг шавраас өгсүүлээд голын том хайрга чулуу хүртэл тохиолдоно. Эдгээр хурдсууд нь механик бүрэлдэхүүний хувьд голдуу дунд шавранцар, хөнгөн шавранцар, элсэнцэр байна.

Хөрс. Тус аймгийн нутаг нь хөрс - газарзүйн мужлалаар /28,34/ манай орны Хангай Хөвсгөлийн уулын их мужид багтах уулт, ойт хээрийн **хүрэн хөрсний бүсэд** багтаж 11 үндсэн хэв шинжийн хөрс тархана /хүснэгт 1/. Хүснэгтээс харахад уулын хөрс 3 362 579 га талбай буюу нийт нутгийн 69.0%-д, тал хөндийн хөрс 913754 га талбай буюу нийт нутгийн 18.7%-д, голын хөндийн хөрс 574533 га талбай буюу нийт нутгийн 11.8 %-д тус тус тархсан байна. Уулын тайгын ширэгт болон уулын ойн бараан хөрс нь ихэвчлэн орхон голын хойт талаарх болон урд талын дундаж уулс бүхий нутгаар түгээмэл тарах бөгөөд харин тал хээрийн хүрэн хөрс нь урд талын хээрийн сумдаар зонхилно. 2005 оны газрын тооллого бүртгэлийн материалаар ХАА-н газар 2765181.6 га талбайг эзэлдэг гэж үзвэл тус аймгийн нутагт тархсан хөрсний 56.7% нь ХАА-н газар ашиглагддаг байна. Дээрх хөрсний чадавхийг илтгэгч гол үзүүлэлт болох ялзмагийн нөөц аймгийн хэмжээнд 420.8 сая. тонн байгаа нь улсын хэмжээнд ялзмагийн нөөцөөрөө 8-р байранд орж байна. Эдгээр хэв шинжийн хөрснөөс ялзмагийн агууламжаар хамгийн их нь уулын тайгын ширэгт, уулын тайгын цэвдэгт хөрс 6.5 %, уулын ойн бараан хөрс 6.2 %, уулын хар шороон хөрс 6.0 % байх ба хамгийн бага агууламжтай нь хужир мараат хам хөрс 0.5 %-ийн агууламжтай байна / Монгол орны 2020 он хүртэл хөгжүүлэх ГЗБЕТ -ний "ХАА-н хөгжилийн бүс газар" бүлгийн тайлан/. Гэвч өндөр ялзмагийн агууламжтай эдгээр уулын хөрс нь ХАА-н газарт бараг ашиглагдаггүй ойн сангийн газарт байдаг.

Хүснэгт 1

Булган аймагт тархсан хөрсний бүтэц

	Хөрсний хэв шинж	Эзлэх талбай,		Хөрсний механик бүрэлдэхүүн	Хөрс үүсгэгч эх чулуулаг	Хөрсний тархалтын гадарга
		га	Хувь			
1. Уулын хөрс						
1	Уулын тайгын ширэгт, уулын тайгын цэвдэгт хөрс	603820	12.4	Хөнгөн шавранцар, дунд шавранцар	Элюви	Уулархаг гадарга
2	Уулын ойн бараан хөрс	115881	2.4	дунд шавранцар	Элюви	Уулархаг гадарга
3	Уулын хар шороон хөрс	899807	18.5	дунд шавранцар	Элюви	Уулархаг гадарга
4	Уулын хар хүрэн, уулын хүрэн хөрс	900099	18.5	Хөнгөн шавранцар, дунд шавранцар	Элюви	Уулархаг гадарга
5	Уулын хүрэн, уулын цайвар хүрэн хөрс	842972	17.3	Хөнгөн шавранцар, дунд шавранцар	Элюви	Уулархаг гадарга
2. Тал хөндийн хөрс						
6	Нугын хүрэн хөрс	182609	3.7	Дунд шавранцар	делюви	Уул хоорондын нарийн ам
7	Хүрэн хөрс	205830	4.2	Хөнгөн шавранцар, дунд шавранцар	делюви	Уул хоорондын хөндий
8	Цайвар хүрэн хөрс	515858	10.6	Хөнгөн шавранцар	делюви	Уул хоорондын хөндий
9	Элсэнцэр, элсэрхэг хөрс	9457	0.2	Элсэнцэр	делюви	Уул хоорондын хөндий
3. Голын хөндийн хөрс						
10	Голын хагшаа хурдаст нугын хөрс	532624	10.9	Хөнгөн шавранцар, дунд шавранцар	аллюви	Голын хөндий
11	Хужир мараат хам хөрс	41909	0.8	Дунд шавранцар	аллюви	Голын хөндий
	Усан сан бүхий газар	22434	0.5			
	Нийт нутаг дэвсгэр	4873300	100			

1.2.4 Ургамал, ургамлан бүрхэвч

Тус аймгийн нутаг дэвсгэр нь ургамал - газарзүйн мужлалаар Евразийн хээрийн муж Дагуур Монголын хээрийн провинци, Дундад Халхын хээрийн тойрогт (Баян нуур, Дашинчилэн, Рашаант, Гурван булаг, Могод), Хангайн уулын

ойт хээрийн провинци, Умард Хангайн уулын ойт хээрийн тойрогт (Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Орхон, Сайхан, Баян-Агт), Хангайн уулын ойт хээрийн провинци, Сэлэнгийн уулын ойн тойрогт (Хангал, Бугат, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Тэшиг) зэрэг сумдууд тус тус багтана \29,30\.

Дундад халхын хээрийн тойргийн нутагт ихэнх хэсгийг нь ухаа толгодорхог тэгш тал хээр зонхилон, бага хэсгийг чулуурхаг нам ба бэсрэг уулс юмуу өндөр биш элсэн уулс, заримдаа боржин чулуун цохио эзэлнэ. Нам уулсын зонхилох өндөр нь далайн түвшнээс дээш 1400-1600 м өргөгдсөн байна. Уулсын орой, ар хажуугийн нугархаг хээрт: үетэн-алаг өвст, алаг өвс-үетэн-улалжит, сийрэг ургамалтай чулуурхаг нугархаг хээрт: жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, сөөг бүхий алаг өвс үетэнт, уулын хуурай хээрт: ботууль-алаг өвст, ботууль-хялганат, хялгана үетэнт, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, сийрэг ургамалтай чулуурхаг хээрт: алаг өвс-агь-үетэнт, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, сөөгт хэв шинжүүд түгээмэл тархана.

Гүвээ, толгод тал хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээрт: хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, хялгана-хазаар өвст, хялгана-алаг өвст хэв шинж, элсэнцэр хүрэн хөрстэй хээрт: хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, үетэн-алаг өвст хэв шинж зонхилон тархана. Мөн харгана бүхий элсэн довцог толгодын хээр тааралдана.

Нам хотосоор дэрс ямагт элбэг тааралдах ба ширгэж буй гол горхитой. тал хөндийгээр дэрс бүхий тачир ургамалтай марзлаг нуга ч түгээмэл тааралдана. Хэсэг хэсэг газарт нуга намгийн улалжит, хээржсэн нугын үетэн-алаг өвст, үетэн-улалжит, давсархаг нугад дэрс-хиагт, дэрс-улалжит, цахилдаг-үетэнт хэв шинжүүд тархана.

Мөн Орхон голын өргөн хөндийгээр дэрс болон дов сондуул бүхий намагжсан нуга ихээхэн тааралдана.

Хангайн уулын ойт хээрийн провинци, Умард Хангайн уулын ойт хээрийн тойрог дундаж ба нам өндөр уулстай гадаргуун төрх хэвээр боловч уулс ихээхэн намсаж толгодорхог талархаг нутагтай ээлжлэн тааралдана.

Уулсын зонхилох өндөр нь далайн түвшнээс дээш 1700-2000 м-т өргөгдсөн байна. Голлох уул нурууд нь: Өрмийн цагаан нуруу \1986 м\, Бөгтөрийн нуруу \1930.5 м\, Хөх чулуутын нуруу \1716 м\, Сантын нуруу \1901м\, Баян өндөр уул \2006.7м\, Хөх чулууны уул \1859.7м\, Баян суурь уул \1751 м\, Их асгат уул \2107\, Хайрхан уул \1881 м\, Угалз уул \1872 м\, Хойт Номгон уул \1911.7м\, Агуйт \1934.2м\ тус тус өндөрлөгтэй байрлана. Ой мод нь эдгээр уулсыг дагаж тааралдах бөгөөд шинэс, хусан ой зонхилон ургана. Уулсын орой, ар хажуугийн нугархаг хээрт: ботууль-алаг өвс-улалжит, үетэн-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, хялгана-алаг өвст, зүр өвс-алаг өвст хэв шинж, сийрэг ургамалтай чулуурхаг нугархаг хээрт: жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, сөөг бүхий алаг өвс-үетэнт, ботууль-алаг өвст хэв шинж, уул хоорондын хөндийн нугад үетэн-алаг өвст, улалж-үетэнт хэв шинж, уулын хуурай хээрт: хялгана-алаг өвст, ботууль-хялганат, ботууль-алаг өвст, хялгана үетэнт, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст хэв шинж, сийрэг ургамалтай чулуурхаг хээрт: жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, алаг өвс-агь-үетэнт, ботууль-алаг өвст, хялгана-алаг өвст хэв шинжүүд тархана.

Гүвээ, толгод тал хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээрт: хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, хялгана-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэнт хэв шинж, алаг өвс-үетэнт хэв шинж, элсэнцэр хөрстэй хээрт: жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, хялгана жижиг дэгнүүлт үетэнт, үетэн-алаг өвст хэв шинжүүд зонхилон тархана.

Тус тойрогт хамаарагдах сумдын нутагт нуга намгийн улалжит, хээржсэн нугын хиаг-алаг өвст, үетэн-алаг өвст, үетэн-улалжит, улалж-үетэн-алаг өвст, давсархаг нугад үетэн-алаг өвст, дэрс-хиагт, дэрс-улалжит, цахилдаг-үетэнт, улалж-алаг өвст хэв шинжүүд тархана.

Хангайн уулын ойт хээрийн провинци, Сэлэнгийн уулын ойн тойрог нь илүү ойжсон нутгийг хамрах бөгөөд ихээхэн уулархаг гадаргатай.

Уулс нь налуу мөлгөр энгэртэй, хавтгайдуу оройтой гол төлөв араараа шинэс, хусан ойтой. Сэлэнгэ мөрний дэнжээр элс даган ургасан нарсан ойтой. Уулсын зонхилох өндөр нь далайн түвшнээс дээш 1800-2100 м-т хэлбэлзэнэ. Голлох уул, нурууд нь Хантайн нуруу \2115 м\, Намнангийн нуруу \2013\, Бэрхийн нуруу \1872.0 м\, Төмөртийн нуруу \1848 м\, Бөхөнгийн нуруу \1820 м\, Ацын нуруу \1732.0 м\, Шарлан хунгийн нуруу \1743м\, Бор хуутын нуруу \1758 м\, Хөх чулуу уул \1926 м\, Хушт булуу уул \1982 м\, Дөндгэр уул \1802 м\, Гөн чулуут уул \1894 м\, Бороодой уул \1446м\, Хонгор өндөр \1738 м\, тус тус өндөрлөгтэй байрлана.

Уулсын орой, ойн зах, ар хажуугийн уулын нугархаг хээрт: үетэн-алаг өвст, хялгана-алаг өвст, алаг өвс-үетэн-улалжит, хиаг-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст хэв шинж, уулсын энгэр, хажуугийн сийрэг ургамалтай чулуурхаг нугархаг хээрт: ботууль-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, сөөг бүхий алаг өвс-үетэнт хэв шинж, уулын хуурай хээрт: ботууль-алаг өвст, ботууль-хялганат, хялгана-үетэнт, хялгана-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст хэв шинжүүд тархана. Уулс хоорондын нарийн хөндийгөөр хиаг-алаг өвст, үетэн-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, алаг өвс-улалж үетэнт хэв шинж тархана.

Тал хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээрт: хиаг-жижиг дэгнүүлт үетэнт, хиаг-алаг өвст, хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, хялгана-алаг өвст хэв шинж зонхилон тархах бөгөөд бага газарт элсэнцэр хөрстэй хиагт, үетэн-алаг өвст, элсэн довцог, толгодын хээрт сөөг-үетэнт хэв шинж тархана.

Тус тойрогт хамаарагдах сумдын нутагт нуга намгийн улалжит, хээржсэн нугын хиаг-алаг өвст, улаан толгойт-алаг өвст, алаг өвс-үетэнт, үетэн-улалж-алаг өвст, бургас-улиаст, давсархаг нугад дэрс-хиаг-алаг өвст, үетэн-дэрст, жижиг улалж-алаг өвст хэв шинжүүд тархана.

Сэлэнгэ мөрний татам дагууд шинэс, улиас бүхий өтгөн бургас бут сөөг ургана. Хөндийн өргөн хэсэгт усны гольдрил хэд хэд салаалан том том арал үүсгэн тэрхүү арлуудад бургасан шугуй, төрөл бүрийн жимсний бут ургана. Сэлэнгэ мөрний үндсэн гольдрил, татуургууд маш их тойрон тахирлах учраас үерийн үед эргээ эвдэн хар усан тохой, элсэн хошуу олноор үүсгэсэн байдаг.

1.2.5 Ан амьтан

Булган аймгийн нутаг нь тайгын, ойт хээрийн, хээрийн гэсэн 3 бүсэд хуваагдах бөгөөд энэ бүсчлэлийнхээ дагуу амьтны аймаг нь өөр хоорондоо ялгагдана.

Тайгын бүсэд хүдэр, шивэр хандгай, нохой зээх, хүрэн баавгай, саарал чоно, шилүүс, бор гөрөөс, ойн булга, жирх, халиу, ойн хөвхөлжин, ойн улаан оготоно, бараан хэрэм зэрэг хөхтөн, нургийн сойр, хөтүү, гурван хумст тоншуул, ханамал хөхөө, ятга шаазгай, савагт ууль, дорнодын бүгээхэй, дуудууш, нарсны бужирга, угалзан бэгбаатар зэрэг шувуу, зулзагат гүрвэл, шивэр гүлмэр зэрэг хэвлээр явагч, хоёр нутагтан амьдардаг. Гол мөрөн нуур сүлжээ сайтай учраас газар усны болон чийглэг орчны хөхтөн амьтаны хэдэн зүйл голын халиу, усны үен, усч бөрөм, усч гэрэлзгэнэ г. м байдаг. Сүүлийн 30 орчим жилд эндэхийн амьтны аймагт нэг шинэ зүйл бий болсон нь усны үен ОХУ-аас ирж нутагшжээ.

Сэлэнгэ мөрөн, Эг, Орхон, Туул гол түүний цутгалуудад шивэр хадран, Хөвсгөлийн хадран, ердийн цурхай, улаан нүдэн, гутаарь, алгана зэрэг агнуурын ач холбогдолтой, эгэл варлан, сахалт эрээлж, чимхүүр загас зэрэг агнуурын ач холбогдолгүй нийт 11 зүйлийн загас амьдардаг.

Ойт хээрийн бүсэд бор гөрөөс, халиун буга, саарал чоно, шар үнэг, дорго, мануул, зэрлэг гахай, бор туулай, монгол тарвага, ойн хүрэн оготоно, мэхээрч оготоно, урт сүүлт зурам, хөх шишүүхэй зэрэг хөхтөн, тоодог, сохор элээ, дагуурын ятуу, гурван хумст тоншуул, хур, харсуун ууль, хөх зарлагат гал сүүлт, хундан өнгөлүүрт гургалдай зэрэг шувууд, шивэр мэлхий, гавшгай гүрвэл зэрэг хоёр нутагтан хэвлээр явагчид амьдардаг.

Хээрийн бүсэд саарал чоно, хярс, дорго, өмхий хүрэн, бор туулай, монгол тарвага, урт сүүлт зурам, дэлдэн зараа, монгол огодой, үлийн цагаан огодой зэрэг хөхтөн, өвөгт тогоруу, шилийн сар, тарважи бүргэд, тоодог, идлэг шонхор, монгол болжмор, бүжимч чогчоохой, талын шишнүүхэй зэрэг жигүүртэн шувууд, монгол гүрвэл, рашааны могой, бамбай хоншоорт могой зэрэг хэвлээр явагч хоёр нутагтан амьдардаг.

1.2.6 Ус зүй.

Булган аймгийн нутагт урсдаг голууд Хангайн нурууны зүүн хойт, Хөвсгөлийн уулсын өмнө хажуу болон тэдгээрийн салбар уулсаас эх авч урсана. Тус аймгийн нутгаар манай орны хамгийн их устай үлэмж их ус хураах талбай бүхий Сэлэнгэ мөрөн түүний томоохон цутгал Эг, Орхон, Туул, Хануй голууд дайрч өнгөрдөг бөгөөд бүгд Хойд мөсөн далайн ай савд багтана. Хангай Хэнтийн уулархаг нутаг, Сэлэнгэ мөрний сав газарт гол мөрний сүлжээний нягт 0.10-0.15 км/км² байгаа нь харьцангуй их юм.

Аймгийн хэмжээгээр 5501 км урт 388 гол, горхи, 37 булаг, шанд, 71 том жижиг нуур бий. Улсын дунджаар 1км² талбайд ноогдох ашиглаж болох усны хэмжээ 22000 м³ байдаг бол Булган аймагт 26000-124000 м³ болж элбэг устай зэрэглэлд багтдаг юм. Нэг хүнд ноогдох усны нөөц 50,1 мянган шоо м байгаа нь дэлхийн дунджаас 4.5 дахин их үзүүлэлт юм.

Гадаргын усны нийт нөөц 1,75 шоо км, үүнээс ашиглаж болох нөөц нь 0,881 шоо км, газрын доорхи усны нийт нөөц 0,5 шоо км, үүнээс ашиглаж болох нөөц нь 0,25 шоо км, нийт усны нөөц 2,25 шоо км, үүнээс ашиглаж болох нийт нөөц нь 1,131 шоо км байна.

Аймгийн хэмжээнд нийт 39 нууртай тэдгээрийн талбайн нийлбэр 58,7 км² Энд 54,5 км² талбайтай 22 нуурыг оруулав.

Булган аймагт оршдог нууруудыг талбайн хэмжээгээр авч үзвэл, Тэшиг суманд Харгал нуур, Олон нуур, Хутаг-Өндөр суманд Айрхан нуур, Баян-Агт суманд Шарга нуур, Цэгээн нуур, Сайхан суманд Хаг нуур (0.7км²), Өрмийн цагаан нуур (0.7км²), Цөнгөрөг нуур (0.5км²), Урд цөнгөрөг нуур (0.6км²), Бөөрөг нуур (0.5км²), Баруун нуур (0.7 км²), Гурванбулаг суманд Цагаан нуур (0.5км²), Дашинчилэн суманд Борогчингийн Цагаан нуур (2.2 км²), Чингийн цагаан нуур (2.6 км² талбайтай), Бүрд Цагаан нуур (0.8км²) байна. Мөн 0.5-2.6 км² талбайтай хэд хэдэн нуур Орхон голын хөндий болон Туул-Хар бухын голын бэлчир орчимд байрладаг. Эдгээр нууруудаас Орхон голын сав дагуух нь ихэвчлэн тектоник гаралтай байхад Туул-Хар бухын голын сав дагуух нь эртний голын хөндийн хаягдмал нуурууд байдаг. Эдгээрээс Борогчингийн Цагаан нуур, Чингийн цагаан нуурын шавар, шүүг ардын эмчилгээ болон орон нутгийн хэрэгцээнд ашигладаг.

Д/д	Нуруудын нэр	Өндөр м	Талбай га	Урт км	Өргөн км	Дундаж гүн м	Усны эзэлхүүн км ³	Эргийн шугам км	Хөгжлийн коэффициент
1	2	3	4	5	6	7	8	9	10
1.	Харгал нуур	1071	13.6	4.9	2.8	15.6	0.1269	14.8	1.12
2.	Олон нуур	980	0.5	0.9	0.5	2.1	0.0007	2.2	1
3.	Айрхан нуур	936	5	4.4	1.1	2	0.0062	16	2.06
4.	Хаг нуур	1500	0.7	1.1	0.6	2.7	0.0008	3	1.01
5.	Өрмийн цагаан нуур	1440	0.7	1.2	0.5	2.5	0.0008	3.4	1.15
6.	Цагаан нуур	1100	0.5	1	0.4	1.9	0.0005	2.6	1.04
7.	Борогингийн нуур	960	2.2	2.9	0.7	2.6	0.0026	6.8	1.29
8.	Чингийн цагаан нуур	960	2.6	2.5	1	2	0.002	9	1.58
9	Цэгнээн нуур	1523	7.2	5.7	1.3	4.8	0.0182	16.6	1.74
10	Шарга нуур	1335	12.4	5.6	2.2	5.9	0.0461	19.8	1.58
11	Шаргын бага нуур	1338	1.3	1.7	0.7	1.5	0.001	4.8	1.12
12	Ямаат нуур	975	1.4	2.8	0.5	2	0.0017	7	1.71
13	Дунд нуур	985	1.2	2.4	0.5	2.5	0.0017	6.9	1.77
14	Зэгэс нуур	986	0.5	1.1	0.4	2	0.0006	3	1.2
15	Хаяа нуур	936	0.5	0.1	0.6	1.2	0.0003	2.2	1
16	Урд нуур	938	0.5	1.1	0.4	1.5	0.0006	2.2	1
17	Цөнгөрөг нуур	1260	0.5	0.9	0.5	1.5	0.0006	2.6	1.04
18	Бөөрөгт нуур	1260	0.6	1	0.6	2	0.0005	3.4	1.24
19	Баруун нуур	1250	0.7	1.7	0.3	1.7	0.0008	3.6	1.21
20	Урд цөнгөрөг нуур	1256	0.6	1.3	0.4	2.5	0.0005	3.4	1.24
21	Бүрд цагаан нуур	950	0.8	1.8	0.4	2.1	0.0008	4	1.26
22	Давст нуур	1400	0.5	0.9	0.3	1.5	0.0003	2	1

Байгалийн чийг ханамшлын нөхцөл.

Газар хөрсний чадавхийн цомхотгосон үзүүлэлтийг олон аргаар илэрхийлж үнэлгээ өгдөг бөгөөд тэр хүчин зүйлсийн хэмжилт судалгааны материал нилээд элбэг олдоцтой, олон станц харуулын материалд дүгнэлт хийх боломжтойг харгалзан бид дулаан хугацаанд орсон тунадасны хэмжээг уг хугацааны ууршуулах чадварт харьцуулсан харьцаа болох чийгжцийн итгэлцүүрээр илэрхийлж бүс нутгийн байгалийн чийг хангамшлын нөхцлийн зургийн зохиосон юм. Мөн уул нуруудын ар, өвөр, газрын өндөржилтийг тооцон олон станц, харуулуудын хооронд харьцуулалт хийж чийгжцийн бүсийг тогтоосон юм. Ийм шалгуур үзүүлэлт нь тухайн бүс нутаг байгалийн нөхцлөөрөө ямар хэмжээгээр ус чийг дутагдаж байдгийг харуулах бөгөөд улмаар тухайн бүс нутгийн ус чийгийн хэрэгцээг тооцоолж түүнд тохируулан арга хэмжээгээ төлөвлөн хэрэгжүүлж бололцоо олдож байгаа юм.

Булган аймгийн хээрийн бүсийн сумдын нутаг дэвсгэр нь ерөөсөө байгалийн нөхцлөөрөө чийгших чадвар багатай нь харагдаж байна. $K_u=0.6$ гаас доош хуурай бүсэд усалгаагүй тариалан эрхэлж, мод сөөгний тарьц, суулгац шилжүүлэн суулгадаггүй юм. Хуурай хээрийн толбо мэт район дулаан хуримтлалаар ямар ч таримал ургамлыг ургуулах боломжтой нь сонирхолтой бөгөөд зөвхөн усалгааг зохион байгуулснаар үр дүнд хүрэх болж байна.

1.2.7 Байгаль орчны бохирдол

Булган аймагт дараах бохирдуулагч эх үүсвэрүүд байна.

Өвлийн улиралд Булган хотын байнгын галлагаатай 7 уурын зуух, гэр хорооллын 3000 гаруй өрх айл, 500 гаруй машины утаа тортог, дулааны улиралд шатахуун түгээх станцууд, бохирын цооног, хогийн цэгээс гадна гэр хорооллын орчин гуу жалгуудаар ил задгай хаясан хогноос орчин ихээхэн бохирдож байна.

Сумын төвүүдийн хувьд хогийн цэгийн байршил, талбайн хэмжээ баланс дээрх тоо хэмжээнээс төдийлэн өөрчлөгдөөгүй байгаа боловч хогийг цуглуулах, тээвэрлэх, устгах, зайлуулах арга хэмжээ зохион байгуулалт муутай байдгаас цаас, нийлэг уут, картон зэрэг салхи шуурганд хийсэн орчныг бохирдуулж байна.

Бүрэгхангай сумын нутагт Туул голын дагуу 75 км зайд олон тооны алт олборлож буй аж ахуйнууд газрын хөрсийг ухаж сэндчин, газрын хэвлийд механик болон химийн бохирдол үүсгэж, алт угааж, мөнгөн ус цанид натриар бохирдсон усаа буцааж Туул голд тавих, гол усны гольдорлыг өөрчлөх зэргээр усыг ихээр бохирдуулж байгаль орчинд хохирол учруулж байна.

Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийн хаягдалын аж ахуйн цагаан тоос Орхон аймагтай хил залгаа орших Хангал сумын ой мод, малын бэлчээрт, уулын үйлдвэрийн тэсэлгээнээс үүссэн тоос, Орхон сумын ой мод, малын бэлчээр их хэмжээний тоосжилт үүсгэж хүн малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрээд байна.

Цөлжилтийн байдал, элсний тархалт.

Булган аймгийн хээрийн бүсийн элс бүхий сумдын нутаг Т.Баасангийн элсний тархалтын мужлалаар Сэлэнгэ-Туулын районы Туул-Тарнын голын дэд районд хамрагдана.

Туул-Тарнын голын дэд мужид тархсан элсэн хуримтлал нь салхи-голын гаралтай бөгөөд дөрөвдөгч галавын үеэс одоо хүртэл хуурай хээрийн ландшафттай байсан энэ гадаргад тогтмол болон түр зуурын урсгалтай голуудын усны эвдлэх үйл ажиллагаагаар гол мөрний хөндий, хотгорын ёроол болох нам газруудад зөөгдөн ирж хуримтлагдсан элс, хайрга, наанги шавар зэрэг сэвсгэр хурдсаас үүсэлтэй юм.

Булган аймгийн хээрийн бүсийн сумдын нутагт Тарнын голын дагуух Монгол элс, Далын гол, Цахирын голын дагуух Зайсангийн элс, Далын элс, Өлзийт овооны элс, Хараатын элс, Ихэрийн элс болон Молцог элс гэсэн 4 томоохон хуримтлалаас гадна Хар бухын голын хөндий дагуу болон төв замын 2 талаар бүрхэвч, бутны довцог элс элбэг тархсан байна.

Дүгнэлт

Байгаль цаг уур, ус зүй, хөрс ургамлан бүрхэвч, газрын гадаргуугын хувьд Булган аймаг бүхэлдээ нийгэм эдийн засгийн олон салбарууд тэр дундаа ХАА-н үйлдвэрлэл, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, үйлдвэр уурхай, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бүрэн боломжтой бүс нутаг бөгөөд газар ашиглалтын явцад дээрх үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдсөн цаашид хэрхэн ашиглах, хамгаалах талаар тухай тухайн бүлэгт дэлгэрэнгүй дурьдах болно.

1.3 Нийгэм –эдийн засгийн нөхцөл

1.3.1. Нийгэм - эдийн засгийн суурь нөхцөл

1.3.2. Хүн ам

Булган аймаг 2006 оны байдлаар 56 428 хүн амтай, тэдний 49,2% нь эрэгтэй, 50,5 % нь эмэгтэй болно. 54,5% буюу 30 733 хүн төв суурингуудад амьдарч байгаагийн 21,2 % буюу 11 984 нь Булган хотод оршин суудаг бөгөөд хөдөө 45,5 % буюу 25 695 хүн амьдарч байна. Нийт өрхийн тоо 15014 ба тэдний 54,1 % буюу 8127 нь төв суурингуудад байгаагийн 18,7 % буюу 2802 нь Булган хотод оршин сууж үлдсэн 45,9 % нь 6889 нь хөдөөд амьдарч байна. Хүн амын дундаж өсөлт 0,9 % байна.

Хүн амыг насны бүтцээр нь авч үзвэл 15 хүртэлх насны хүүхэд 28,9%, 15-59 хүртэлх насны хөдөлмөрийн чадвартай хүн ам 62,2%-ийг, 60-аас дээш насны хүн ам 9 %-ийг эзлэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн албанд 1547 хүн бүртгэлтэй байгаагийн 678 нь эмэгтэйчүүд байна. Төрийн болон төсөвийн байгууллагад нийт 2 600 хүн ажиллаж байна.

Булган хотод их дээд сургууль 1, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 1, байдгаас гадна ерөнхий боловсролын сургууль 18, цэцэрлэг 22 ажилладаг. 160 ортой нэгдсэн эмнэлэг, 30 ортой халдвартын тасаг, 43 ортой хувийн эмнэлэгээс гадна сум дундын 3 эмнэлэг, их эмчийн салбар 12 эмнэлэг ортой ажиллаж 100 хүнд их эмч, эмнэлэгийн дунд мэргэжилтэн , эмнэлэгийн ор ногдож байна.

Аймгийн хэмжээнд нэг хүнд ногдох дундаж орлогын хэмжээ 81 000 төг боловч нийт хүн амын 44,3 % буюу 6000 өрхийн 25000 хүн ядуу амьдарч байна. Үүний 1500 өрх нь аймгийн төвд амьдардаг.

Цахилгааны эх үүсгэвэртэй малчин өрх 2380, авто машинтай 1051 өрх байна.

Нутаг дэвсгэрийн хувьд бага, дэд бүтэц сайн хөгжсөн, том хотуудтай холбогдох боломж ихтэй учир хот хөдөөгийн ялгаа улам багасаж байна.

1.3.3. Газар тариалан

Аймгийн эдийн засгийн салбарт газар тариалан түүний дотор үр тарианы аж ахуй зонхилох байр суурийг эзэлнэ.

Аймгийн хэмжээгээр 2005 онд нийт 20350,5 га талбайд тариалалт хийсэн бөгөөд 19 522,5 га талбайгаас 13393,8 тонн үр тариа, 632,3 га талбайгаас 5912,1 тонн төмс, 184,2 га талбайгаас 1750,1 тонн хүнсний ногоо хураан авсан байна. Түүнчлэн 67 822 га хадлан, 173,3 тон гар тэжээл бэлтгэжээ.

Га-гаас үр тариа 7,0 цн, төмс 92,9 цн, хүнсний ногоо 99,4 цн, хураан аваад байна.

Өмнөх оныхоос төмс, хүнсний ногоо тариалсан талбай 25,4 га, 4,2 га-гаар хураасан ургац 758,9 тн, 274,3 тн-оор өссөн бол үр тариа тариалсан талбай 1212,5 га, хураасан ургац 6618 тонноор, бэлтгэсэн хадлан 366 тонноор бага байна.

1.3.4. Мал аж ахуй

2005 оны мал тооллогын дүнгээр 1 399 268 толгой мал байгаагийн 381 тэмээ, 136 362 адуу, 98 107 үхэр, 689 115 хонь, 475 303 ямаа байна. Энэ онд малжуулалтанд нийт 102,3 сая төг зарцуулж 4523 толгой малыг 130 өрхийн 531 хүнд олгосон боловч нийт дүнгээрээ малчин өрхий тоо 31-ээр хорогдсон байна. Энэ хөрөнгийн 87,0 % нь гадаад орнуудаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн хөрөнгө байсан.

Сэлэнгэ суманд мах сүүний чиглэлийн “Сэлэнгэ” үүлдрийн үхэр, Орхон суманд нарийвтар ноосны чиглэлийн “Хангай” үүлдрийн хонийг өсгөн үржүүлж байна.

Түүнчлэн 495 өрхөд 2411 гахай, 3996 өрхөд 177 225 тахиа тоологдсон байна.

Инженерийн хийцтэй 11, Энгийн уурхайн 47 худаг шинээр гаргахад 64,6 сая төгрөг 21 худаг засварлахад 16,4 сая төг зарцуулсан. Худаг гаргахад зарцуулсан хөрөнгийн 44,1 сая төг, засварлахад гаргасан зардлын 9,3 сая төгрөгийг гадны төслийн хөрөнгөөр бусдыг нь малчин иргэд гаргасан байна.

Сул тал: Зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулах сонирхолын үүднээс Эрдэнэт хотыг тойрсон Хангал, Бугат, Сэлэнгэ, Орхон аймгийн сумдын нутгаар гадны аймгуудын айлууд ирж Эрдэнэт хотыг тойрон нутаглах болсноор бэлчээр ихээр талхлагдаж байна.

Давуу тал: Эрдэнэт хот Хангайн бүсийн төв болж, хүн ам, үйлдвэрлэл үйлчилгээ улам нэмэгдсэнээр МАА-н гаралтай бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ улам нэмэгдэх юм. Түүнчлэн Булган-Уньт-Хөвсгөлийн хатуу хучилттай зам, Эрдэнэт –Мөрөнгийн төмөр зам тавигдсанаар энэ чиглэлийн ачаа, зорчигч эргэлт улам ихээр нэмэгдэж, зам дагасан суурьшил, аялал жуулчлал эрчимтэй хөгжих боломжтой.

Иймд энэ орон зайг нөхөхийн тулд сүү махны чиглэлийн өндөр ашиг шим бүхий нутгийн шилмэл омгийн, эрлийз, цэвэр үүлдрийн малын тоог нэмэгдүүлж сүү махны чиглэлийн эрчимжсэн аж ахуйг эрхлэх боломжтой.

1.3.5. Үйлдвэрлэл, үйлчилгээ

Уул уурхай, эрчим хүч, барилга, мод бэлтгэлийн болон хөнгөн, хүнсний үйлдвэрүүд хөгжих бололцоотой.

2005 онд 1079,6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсний 251,6 сая төг буюу 23,3% нь уул уурхайн, 278,1 сая төг буюу 25,7 % нь цахилгаан дулаан эрчим хүч, 549,9 сая төг буюу 50,9%-ийг боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн эзлэж байна. Эдгээрт харгалзах борлуулалт нь 1387,1 сая төг буюу 38,4%, 376,8 сая төг буюу 27,1 %, 477,5 сая төг буюу 34,4 % болж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад үйлдвэрлэл 15 %, борлуулалт 4,8 % буурсан байна.

Булган хотод хоногт 60 тн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай Гурил тэжээлийн үйлдвэрээс гадна хоногт 10 тн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай 4 жижиг цех, зайрмагийн цех 4, ундааны цех 7, архины үйлдвэр 7 ажиллаж байна. 10 машинтай оёдлын цех ажилладаг. Гурил тэжээл үйлдвэрийн талхны цех хоногт 500 ш, “Өлзий учрал” ХХК хоногт 150 кг талх нарийн боов хийх хүчин чадалтай.

Байгаа нөөц боломж, хүн амын эрэлт хэрэгцээнд тулгуурлан сүү, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах, савлах, арьс шир, ноос ноолуурын анхан шатны боловсруулалт хийх, эсгийний үйлдвэр, хүнсний ногоо хатаах, даршлах, нөөшлөх үйлдвэр ажлуулах бололцоотой.

Аймгийн хэмжээнд Арцат могой, Эрдэнэ суврага, Цонхот, Нэрст, Булган барилга зэрэг барилгын 6 компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 539,9 сая төгрөгийн барилга угсралт их засварын ажил гүйцэтгэсэн байна.

Инженерийн хангамж бүхий орон сууцанд 1200 хүн буюу Булган хотын хүн амын 11 %, хувийн сууцанд 2%, үлдсэн 87 % нь гэр хороололд модон байшинд амьдарч байна Төлөвлөлтийн хугацаанд 850 айлын орон сууц баригдах юм байна.

Холбоо ашиглалтын орлого 419,2 сая төгрөг болсны дотор хүн амаас орсон орлого 220,9 сая хүрсэн байна. Телефон цэгийн тоо 2233 болсны 1721 нь айл өрхийнх байна. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 3500 болсон байна.

Засгийн газрын бөөний худалдаа сүлжээнд Орхон аймагтай хамтран нэгдэж “Эрдэнэт инвест” компаний гэрээт борлуулагч худалдааны төвийг Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Могод, Тэшиг, Сэлэнгэ суманд нээн ажлуулж байна.

Давуу тал: Булган аймгийн нутаг дэвсгэрт 24 төрлийн ашигт малтмалын 112 орд бүртгэгдээд байгаагийн дээр нилээд нутаг дэвсгэрийг хамарсан алт, зэсийн металлогений бүс тогтоогдсон. Сайхан-Овоо, Эрээн, Баяндуурах зэрэг чулуун нүүрсний 3 орд одоо ашиглагдаж байна.

Булган хот Хөвсгөл, Увс аймгуудыг Улаанбаатартай холбосон авто замын зангилаа, Дашинчилэн, Баяннуур сумууд Архангай, Завхан аймгуудыг Улаанбаатартай холбосон зам дээр оршдог тээврийн гол зангилаа нутаг юм.

Сул тал: Туул Заамарын хөндийд алт олборлож байгаа аж ахуйн нэгжүүдийн татварыг орон нутагт төвлөрүүлэхгүй, тэдний байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөлд орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд болон иргэдийн зүгээс хяналт тавихгүй байгаа явдал нь нутаг орны хөгжилд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй экологийн доройтолд хүргэж байна.

Үйлчилгээний чанар, хангамж ялангуяа ахуйн үйлчилгээ шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаагаас зорчигчид, жуулчдын урсгалыг татаж чадахгүй байна.

Түүгээрч үл барам үндсэн хүн ам болох ойт хээрийн сумдын иргэд нь ойрхон оршдог Эрдэнэт хотоос, хээрийн бүсийн сумдын иргэд нь Улаанбаатар хотоос ихэнх үйлчилгээг авч байгаа нь хүн амын шилжилт хөдөлгөөн ихсэх, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжихөд сөрөг нөлөө үзүүлж байна.

Иймд ахуй, соёлын үйлчилгээг хөгжүүлэх талаар аймгийн хэмжээнд тусгай бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай.

1.3.6. Дэд бүтэц, зам харилцаа, бусад салбар

Булган хот нь Эрдэнэт хоттой 61 км хатуу хучилттай, Улаанбаатар хоттой хэсэгчилсэн хайрган хучилттай (148 км) замаар холбогдсон. Булган - Уньт-Хөвсгөлийн 141,2 км хэсэгчилсэн хайрган хучилттай замыг удахгүй хатуу хучилтаар хучих гэж байна. Түүнчлэн Мянганы замын хөндлөн гол тэнхлэгийн хатуу хучилттай (54 км) зам Баяннуур сумыг дайран Дашинчилэн сум хүрээд байгаа бөгөөд цааш Өгийн доод гүүр хүртэл үргэлжилэх болно. Улаанбаатар - Өвөрхангай, Улаанбаатар – Хархорин чиглэлийн хатуу хучилттай зам (34,5 км) Рашаант сумыг дайран өнгөрдөг. Босоо тэнхлэгийн зам Булган Хархориныг холбох юм.

Эрдэнэт, Хархорин, Мөрөн хотуудтай 110 кв-ийн шугамаар холбогдсоноос гадна бүх сум нь төвийн эрчим хүчний системд холбогдсон бөгөөд Эгийн голийн усан цахилгаан станцыг барих зураг төсөл бэлэн болж, хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээд байна.

Булган хотын болон сумуудын холбооны гол кабелийн багтаамж 3970, станцын багтаамж 2797, хэрэглэгчдийн тоо 2369 болоод байна.

Булган аймгийн холбооны шугам доорхи сүлжээнээс бүрдэнэ.

Д/д	чиглэл	урт км	баганы тоо	эзлэх талбай
1	Булган – Уньт	86	1147	172
2	Уньт-Хутаг - Өндөр	46	613	92
3	Хутаг-Өндөр – Тэшиг	95	1267	190
4	Хутаг-Өндөр - Мөрөн	28	336	56
5	Мэргэн хөтөл - Сайхан	34	1253	68
6	Сайхан - Баян-Агт	88	1173	176
7	Булган – Бугат	49	653	98
8	Бугат – Сэлэнгэ	83	1107	166
9	Эрдэнэт – Хангал	44	587	88
10	Хангал – Хялганат	20	240	40
11	Булган – Орхон	22	293	44
12	Орхон - Бүрэгхангай	58	773	116
13	Дашинчилэн - Рашаант	54	720	108
14	107- Гурванбулаг	7	93	14
15	Хишиг - Өндөр - Могод	70	933	140
				1596,26

Дашинчилэн РР 106, Баяннуур РР 105, Дашмэргэн РР 162 дахин дамжуулах станцууд байна.

1.3.7. Булган аймгийн нутагт сүүлийн жилүүдэд байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд

Дэлхийн зөн-Монгол олон улсын байгууллага Булган аймагт салбар зөвлөлөө байгуулан ой бүхий сумдад “Хамтын эзэмшлийн ой” төсөл хэрэгжүүлэхийн зэрэгцээ тус байгууллагын “Хүнсний аюулгүй байдал хөтөлбөр”-ийн хүрээнд “Зудын хохиролыг арилгах мал аж ахуйн менежмент, сургалт”, “Хүнсний ногоо үр, багаж хэрэгслийн тусламж” зэрэг 17 сумын 2260 өрхийг хамарсан төслүүд хэрэгжүүлээд байна.

Геоэкологийн хүрээлэн тус аймгийн хээрийн бүсийн 8 сумын нутаг дэвсгэрт цөлжилтийн төлөв байдлыг үнэлэх судалгаа явуулж цөлжилтийн илрэлүүд тэдгээрийн хэмжээ, зэрэглэлийг тогтоож тэмцэх арга хэмжээг боловсруулсан юм.

Дэлхийн зөн-Монгол олон улсын байгууллагатай хамтран санхүүжүүлэн Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг сумдыг элсний нүүлт хөдөлгөөнөөс хамгаалах ойн зурвас байгуулах, тухайн бүс нутгийн тарьц, суулгацын хангамжийг сайжруулахаар мод үржүүлгийн газар байгуулан ажиллаж байна.

Дүгнэлт

Булган аймгийн нийгэм эдийн засгийн хөгжил урд жилүүдийн үзүүлэлттэй харьцуулахад ахиц байгаа боловч өнөөгийн түвшинд шаардлага бүрэн хангах хэмжээнд хараахан хүрээгүй байна. Иймд аливаа нийгмийн салбарыг өнөөгийн шаардлагын түвшинд аваачихын сацуу нийгэм эдийн засгийн хөгжлийг газрын нөөц нөхцөлийн байдалтай уялдуулан төлөвлөх түүний дагуу хөгжлийн чиг хандлагыг удирдан зохицуулах шаардлагатай байна.

II Бүлэг. Булган аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал.

2.1 Булган аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц, түүний ашиглалт, хамгаалалт.

Газрын нэгдмэл сангийн 2005 оны тайлангаас үзэхэд Булган аймаг нь нийт 4873 мян.га нутаг дэвсгэртэй бөгөөд үүний 2764 мян.га буюу 56.7% нь ХАА-н газар, 28.9 мян.га буюу 0.6 % нь хот тосгон бусад суурины газар, 7843 га буюу 0.2% нь зам шугам сүлжээний газар, 1905 мян. га буюу 39.1% нь ойн сангийн газар, 22.2 мян. га буюу 0.45% нь усан сан бүхий газар, 144.9 мян. га буюу 3 % нь улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзлэж байна /хүснэгт 2, диаграмм/.


Хүснэгт 2

Булган аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц, 2005 он

Д/д	Газрын үндсэн ангилал	Эзлэх талбай	
		Мян.га	хувь
1	Хөдөө аж ахуйн газар	2 764	56.7
2	Хот тосгон бусад суурины газар	28.9	0.6
3	Зам шугам сүлжээний газар	7.8	0.2
4	Ойн сан бүхий газар	1 905	39.1
5	Усан сан бүхий газар	22.2	0.45
6	Тусгай хэрэгцээний газар	144.9	3.0
	Бүгд	4 873	100

Хүснэгтээс харахад ХАА-н газар, ойн сангийн газар нэлээд газар нутгийг эзлэн оршдог нь харагдаж байна.

Газрын нэгдмэл сангийн бүтэц



Газрын үндсэн ангиллын газрууд нь нийгэм эдийн засгийн хөгжлөөс хамааран байнга өөрчлөгдөж байдаг бөгөөд түүний өөрчлөлтийг сүүлийн 2 жилийн байдлаар харуулав /хүснэгт 3/.

Хүснэгт 3

Булган аймгийн нэгдмэл сангийн өөрчлөлт, га

Д/д	Газрын ангилал	2005	2006	Зөрүү, +, -
	Нийт нутаг дэвсгэр	4873300	4873300	0
1	ХАА-н газар бүгд	2765181.6	2764143.06	-1038.54
	үүнээс			
	Бэлчээр	2522332.62	2521198.04	-1134.58
	Хадлан	112020.1	112020.1	0
	Тариалан	67081.4	65959.2	-1122.2
	атаршсан	46057.2	47182.4	+1125.2
	ХАА-н барилга	1292.68	1385.72	+93.04
2	Хот тосгон суурины газар	27780.2	28903.17	+1122.97
	Барилгажсан	2791.13	2779.0266	-12.11
	Гэр хороолол	1266.788	1767.721	+500.93
	Нийтийн эдэлбэр	22503.762	22040.6024	-463.16
	үйлдвэрийн	180.32	171.82	-8.5
	Уурхайн	1038.2	2144	+1105.8
3	Зам шугам, сүлжээний газар	7843	7843	0
	Авто зам	2960	2960	0
	Төмөр зам	0	0	0
	агаарын	227	227	0
	Шугам сүлжээ	4656	4656	0

4	Ойн сан бүхий газар	1905274.9	1905197.7	-77.2
	Ой	1429524.2	1429524.2	0
	Ой мод огтолсон	7089	7089	0
	Мод үржүүлэг	16.55	36.55	+20.0
	Ой тэлэн ургах	468645.15	468547.95	-97.2
5	Усан сан бүхий газар	22239.3	22232.07	-7.23
	Гол мөрөн	12377.3	12370.07	-7.23
	Нуур цөөрөм	9126	9126	0
	Булаг шанд	736	736	0
6	Улсын тусгай хэрэгцээний газар	144981	144981	0
	Тусгай хам.	52790	52790	0
	Хилийн зурвас	79164	79164	0
	Батлан хамгаалах	3504	3504	0
	Тэжээлийн фонд	9520	9520	0

ХАА-н газар нь нийт 2764143.06 га талбайтай бөгөөд үүнээс бэлчээр 2521198.04 га, хадлан 112020.01, атаршсан газар 47182.4 га, ХАА-н барилга байгууламжинд 1385.72 га ба ХАА-д тохиромжгүй газар 16397.6 га тус тус эзлэж байна. Энд тариалангийн газарт 8.3 га нэмэгдэж 1130.5 га хасагдаж атаршсан газарт шилжсэн байна. Мөн атаршсан газар 5.3 га-р хасагдсан байна. Бэлчээрийн газар 1134.58 га талбайгаар хасагдаж барилга байгууламж 93.04 га талбайгаар тус тус нэмэгдсэн байна.

Хот тосгон бусад суурингийн газар нь нийт 28903.17 га газартайгаас барилгажсан талбай 2779.02 га, гэр хороолол 1767.72 га, нийтийн эдэлбэр 22040.6 га, үйлдвэрийн газар 171.82 га, уурхайн газар 2144 га байна. 2006 оны эцэс гэхэд барилгажсан талбай 12.11 га-р хорогдож гэр хороолол 500.93 га талбайгаар нэмэгдсэнээс нийтийн эдэлбэрийн газраас 463.16 га талбай хасагджээ. Энд Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх хуулийн дагуу иргэдэд шинээр 500 га газар олгосон байна. Мөн түүнчлэн үйлдвэрийн газар 8.5 га талбайгаар хорогдож уурхайн газар 1105.8 га-р нэмэгдсэн байна.

Зам шугам, сүлжээний газар нийт 7843 га талбай эзэлдэгээс авто зам 2960 га, агаарын тээвэр 227 га, шугам сүлжээ 4656 га талбай эзэлдэг бөгөөд уг ангиллын газар ямар нэг өөрчлөлт ороогүй байна.

Ойн сан бүхий газар нь нийт 190519.7 га талбай эзэлдэгээс ой 1429524.2 га, ой мод огтолсон газар 7089 га, мод үржүүлгийн газар 36.55 га, ой тэлэн ургах газар 468547.95 га талбайг тус тус эзэлнэ. Энд мод үржүүлгийн газар 20 га талбайгаар нэмэгдэж ой тэлэн ургах газар 97.2 га талбайгаар хасагдаж бусад ангилал руу шилжсэнээр ойн сан бүхий газар нийт дүнгээрээ 77.2 га талбайгаар хорогдсон байна.

Усан сан бүхий газар нь нийт 22232.07 га газартайгаас гол мөрөн 12370 га, нуур цөөрөм 9126 га, булаг шанд 736 га байна. Энд гол мөрөнгийн талбай 7.23 га талбайгаар хорогдсон дүн гарчээ.

Улсын тусгай хэрэгцээний газар нь нийт 144981 га газар эзэлдэгээс улсын тусгай хамгаалалтай газар 52790 га, улсын хилийн зурвас 79164 га, улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 3504 га тус тус байдаг бөгөөд уг ангиллын газар одоогоор өөрчлөгдөөгүй байна.

2.2 ХАА-н ангиллын газрын бүтэц, ашиглалт, хамгаалалтын байдал

2.2.1 Тариалангийн газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал.

Булган аймаг нь манай орны тариалангийн гол бүс нутгийн хувьд талбайн хэмжээгээрээ улсдаа нэлээд дээгүүр байранд Төв, Сэлэнгэ аймгийн дараа ордог бөгөөд бараг бүх сумд тариалалт хийдэг гэж хэлж болно. Үйлдвэрлэлийн үндсэн салбарт газар тариалан чухал байр суурийг эзэлнэ. Булган аймаг нь 2006 оны газрын тоо бүртгэлээр 65 959.2 га тариалангийн газартай гэж бүртгэгдсэнээс үр тариа 65 129.1 га, таримал ургамал, жимс, жимсгэнэ 54 га, төмс хүнсний ногоо 776.1 га талбайг эзлэх бөгөөд атаршсан талбай 47 182.4 га байна. Бидний судалгаагаар нийт 65 960 га байгаагаас 64 604.3 га талбай үр тарианд, 45 га жимс, жимсгэнэд, эмийн ургамалд 9 га, 1 201.7 га талбай төмс хүнсний ногоонд ашиглагдаж байгаагаас гадна 47384 га талбай атаршсан байгаа нь газрын тоо бүртгэлээс үр тариа 524.8 га талбайгаар дутаж, төмс хүнсний ногооны талбай 425.6 га-р, атаршсан талбай 210.6 га талбайгаар тус тус илүү гарч байна. Өөрөөр хэлбэл нийт эргэлтийн талбайн 97.9% нь үр тарианд, 1.8% нь төмс, хүнсний ногоонд үлдэх багахан хувь /0.3%/ нь бусад тарималд ашиглагддаг байна. / хүснэгт 4, хавсралт 1/.

Хүснэгт 4

Тариалангийн талбайн ашиглалтын өнөөгийн байдал

№	Сумын нэр	Хэмжээ, га-аар	Таримлын төрөл	Тарьсан хэмжээ, га-аар	Жилийн дундаж ургац цн/га-аар
1	Могод, Сайхан, Рашаант, Баяннуур, Булганаас бусад	64604	үр тариа	20350	7-7.5 ц/га
2	Бугат, Хангал, Сэлэнгэ, Хутаг-Өндөр болон бусад	900	Төмс	632	90-100
3	Бүх сум	301.7	Хүнсний ногоо /нэр төрлөөр/	184	100-110
4	Баяннуур	45	Жимс жимсгэнэ,	-	-
5	Дашинчилэн	9	Эмийн ургамал, жимс	9	
6	Бүрэгхангай	100	тэжээлийн ургамал	-	-
7		-	Ой үржүүлэг	-	-
8	Бүгд	65960		21159	


Эндээс харахад тус аймаг нь үр тарианы аж ахуйг зонхилж төмс, хүнсний ногоог туслах чанартайгаар эрхэлдэг нь харагдаж байна. Үр тарианы талбайг голдуу аж ахуйн нэгжүүд төрөлжсөн үйлдвэрлэлийн чанартайгаар эзэмшдэг бөгөөд ганц нэг иргэд бага хэмжээний талбайг захирамжаар эзэмшдэг боловч ихэнхидээ түр хугацаагаар аж ахуйн нэгжүүдэд түрээсэлсэн байдаг. Үр тарианд уринш-буудай-буудай гэсэн сэлгээг мөрдлөг болгодог. Төмс, хүнсний ногооны хувьд ихэнхи тохиолдолд өрхийн хэрэгцээний ногоог багахан талбайд тариалах боловч сүүлийн үед аж ахуйн нэгжүүд 20, 50-иас дээш га талбайд үйлдвэрлэлийн чанартайгаар ялангуяа төмс тарих сонирхолтой байгаа нь ажиглагдсан.

Хүснэгт 5


Тариалалтын мэдээ

	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Үр тариа	26953.2	28902	26495	27962	29580	28695.5	21142
Буудай	26906	28270	26452.3	27650	29523.8	28341	20968
Төмс	436.1	461.5	393.8	374.9	571.7	519.6	563.85
Хүнсний ногоо	130.4	151.8	139.1	137	194.9	191.2	154.31

Үр тариа тариалалт



Төмс, хүнсний ногоо тариалалт



2006 онд аймгийн хэмжээнд үр тариа нийт 20350 га талбайд тариалалт хийж 19522.5 га талбайгаас нийт 13391.8 тонн ургац хураан авсан нь өнгөрсөн оноос хураан авсан талбай 1212.5 га, хураан авсан ургац 6618 тонноор тус тус бага байна. Иргэд ХЭАА нийт 1328.5 га талбайд тариалалт хийж 1128.5га-с 934.1 тонн ургац хураан авчээ.

Төмс 632.3 га-д таралалт хийж нийт 5912.1 т төмс хураан аваад байгаа нь өнгөрсөн оноос хураан авсан талбай 25.3 га, хураан авсан ургац 758.9 тонноор их байна.

Хүнсний ногоо 184.2 га-д тариалалт хийж нийт 1750.1 т ургац хураан аваад байгаа нь өнгөрсөн оноос хураан авсан талбай 4.2 га, хураан авсан ургац 274.39 тонноор их байна.

Нэгжийн ургац аймгийн дүнгээр үр тариа 1 га-с 7.0 ц, төмс 92.9 ц, хүнсний ногоо 99.4 ц хураан авсан байна /Булган аймгийн ЭЗ Статистик мэдээ, 2006он /.

Хүснэгт 4-ээс харахад 21159 га буюу нийт эргэлтийн талбайн зөвхөн 32.1 %-д тариалалт хийж байгаа нь хангалтгүй үзүүлэлт бөгөөд энэ хэмжээг цаашид наад зах нь 60%-д хүргэх шаардлагатай байна.

Хүснэгт 6

2.2.2 Жимс, жимсгэний газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал

	Талбарын дугаар	Хэмжээ га-гаар	Таримал жимсний модны төрлүүд	Ургац, цн/га	Шимт чанар	Ашиглалтын өнөөгийн байдал
1	050200001	45	чацаргана	-	-	Ашиглалтгүй
2	050700037	0.5	чацаргана, үхрийн нүд	бкг/ бут	сайн	Сайн
	Бүгд	45.5				

Тус аймгийн Дашинчилэн сумын нутагт таримал эм эмийн ургамлын плантаци байх бөгөөд энд хуучин 5 га байсан бол одоо талбайгаа өргөтгөн 9 га болж төрөл бүрийн эмийн ургамал, чацаргана амжилттай тариалж байна. Энд Мянлангийн голоос шуудуу татаж сувгийн усаар таримлаа усалдаг, чамлахааргүй ургац авдаг байнгын ажиллагаатай аж ахуй юм. Харин Баяннуур сумын Далын голын услалтын системтэй жимс жимсгэний хувьд байдал өөр. Энд услалтын систем эвдэрч тоногдон ямар ч тариалалт хийхгүй суулгац бут гэхээр юмгүй байгаагаас гадна Далын гол ширгэсэн байна.

Тариалангийн газрын нөхөн сэргээлт, ашиглалт хамгаалалт.

Булган аймгийн тариалангийн газар нь хэдийгээр байгаль цаг уурын тааламжтай нөхцөлд орших боловч тариалангийн талбайн бараг тал хувь /45.5%/ ямар нэг байдлаар элэгдэж эвдэрснээс үзэхэд түүнийг ашиглаж эзэмшиж үр шимийг нь хүртэхээс гадна хамгаалж тордох, унаган төрх байдлыг нь хадгалах явдал зүй ёсоор гарч ирнэ. Сүүлийн үед гадна дотны төсөл, улсын компани ажлуудын хүрээнд хөрсийг салхины элэгдэл эвдрэлээс хамгаалах, элсний нүүлтийг зогсоох, цөлжилттэй тэмцэх, нэгэнт элэгдэж эвдэрсэн газрыг нөхөн сэргээх талаар олон талт ажлууд эрчимтэй хийгдэж байна. Үүнд Дэлхийн зөн ОУБ-аас урд талын хээрийн сумдад цөлжилтийг сааруулах иж бүрэн судалгааны

ажил хийгдэж цөлжилтийг сааруулах түүнтэй тэмцэх арга замуудыг зааж өгсөн байна. Мөн ГХГЗЗГазраас Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант, Баян-Агт, Бүрэгхангай сумдын хүчтэй элэгдэж эвдэрсэн тариалангийн нийт 7168 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн нь мөнгөн дүнгээр 286 720.0 мян. төг болж байна. Гэвч цаашид зайлшгүй нөхөн сэргээх шаардлагатай 6 211 га газар байна. Мөн усалгаатай талбайн ашиглалтыг сайжруулахын тулд 196 га талбайн услалтын системийг засаж сэлбэн ашиглалтанд оруулах шаардлагатай байна /хүснэгт 7/. Элсний нүүлт ихтэй газруудад салхины дээд талд хөндлөн чигт дор хаяж 300 орчим га талбайд 1-2 эгнээгээр сийрэг ойн зурвас байгуулах шаардлагатай. Мөн нийт тариалангийн талбайн 50-60 % нь хөрсний үржил шимээр /азот, фосфор, кали/ дундаас хангалтгүй гэсэн зэрэглэлд багтаж байгаа учир орон нутгийн бордоо бууц, сангас, сүрэл зэргийг өргөнөөр хэрэглэж хөрсний үржил шим бүтэцийг сайжруулах, цулгүй уриншийн эзлэх хувийг багасгах, хөрс элдэншүүлэлтийг цомхотгосон тэг элдэншүүлэлтийг нэвтрүүлэх зэрэг наад захын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь хэрэгтэй.

Хүснэгт 7

Нөхөн сэргээлт, тордолт хийсэн болон тордолт хийхээр төлөвлөж буй тариалангийн газрын судалгаа

№	Арга хэмжээ	Газрын байршил	Талбайн хэмжээ, га-аар	Зарцуулсан ба зарцуулах хөрөнгө, мян.төг	Хөрөнгийн эх үүсвэр
1	Ойн зурвас байгуулах	Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант	300		Улсын төсөв
2	Эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээсэн	Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант, Баян-Агт, Бүрэгхангай	7168	286720.0	Улсын төсөв
3	Хөрс сайжруулалт хийх, хөрсний үржил шимийг дээшлүүлэх, нөхөн сэргээх	Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант, Баян-Агт, Сэлэнгэ, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр	30126	1385796	Улсын төсөв
4	Услалтын системийг сэргээн засварлах	Сээрийн 47, Хавцгайтын 74, Шувуутын 30, Далын голын 45	196		Улсын төсөв
5	Атаршсан талбайгаас шууд эргүүлэн ашиглах боломжтой	Бүрэгхангай, Дашинчилэн	5667		-
6	Бэлчээрт шилжүүлэх	Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн	5013		-

Хаягдаж орхигдсон атаршсан талбайнуудаас хөрс сайжруулалт, нөхөн сэргээлт хийлгүйгээр шууд эргүүлэн ашиглах боломжтой талбайнууд нэлээдгүй байгааг дээр дурьдсан. Хүчтэй эвдрэлд орж ойрын хэдэн жилдээ ашиглах ямар ч боломжгүй талбайнуудыг бэлчээрт шилжүүлэх нэг хэсэгтээ малын хөлөөс хүртэл чөлөөлөх арга хэмжээ авах хэрэгтэй байна. Судалгаанаас үзэхэд их доройтсон газрын нөхөн сэргээлт харьцангуй удаан байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Тариалангийн газрын эрх зүйн байдал. Тус аймагт газар өмчлөлийн ажлын хүрээнд газрыг иргэдэд эзэмшүүлэх, ашиглуулах ажил эрчимтэй өрнөж цаашилбал өмчлүүлэх тохироо бүрдсэн гэж үзэж болно. Уг ажил ямар түвшинд байгааг хүснэгт 8-аар харуулав.

Хүснэгт 8

№	Газрын харилцааны хэлбэрүүд	Тоо хэмжээ					
		Иргэн		ААНБ		Гадаадын байгууллага	
		Тоо	Га	Тоо	Га	Тоо	га
1	Эзэмшүүлсэн	-	16620.6	-	47107.4	-	
2	Ашиглуулсан	-	-	-	240	-	16.7
3	Өмчлүүлсэн		1211.8				
	Бүгд	-	17832.4	-	47347.4	-	16.7

Хүснэгт 8-аас харахад иргэд 16620.6 га газрыг эзэмшихээр, 1211.8 га газрыг өмчлөхөөр авсан байхад аж ахуйн нэгж байгууллага 47107.4 га газрыг эзэмшихээр, 240 га газрыг ашиглахаар, гадаадын байгууллага 16.7 га газрыг ашиглахаар гэрээ хийжээ. Энэ хэмжээн дээр тариалангийн газрыг өмчилөх хэлбэр ойрын жилүүдэд өсөх нь ойлгомжтой.

2.2.3 Хадлангийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал

Булган аймгийн хэмжээнд 121540.1 га хадлангийн газартай бөгөөд тэдгээрийн байршил, эзлэх талбай, зонхилох ургамлын хэв шинж, ургац, шимт чанар, тэжээлийн нөөц, одоогийн ашиглалтын байдал, хойшид авах арга хэмжээ зэргийг зураг болон дэлгэрэнгүй хүснэгтээр үзүүлэв /хүснэгт 9/. Хүснэгтээс харахад хадлангийн талбай нь Булган сумаас бусад бүх суманд байрлах боловч гол хадлангийн бүс нутаг нь хойд талын ойт хээрийн сумд болно. Энд алаг өвст, алаг өвс-үетэнт, алаг өвс-үетэн-улажит, улалж-алаг өвс-үетэнт уулын нугын болон голын татамын нуга 65-70%-ийн ерөнхий бүрхэцтэй зонхилж, ургац өндөр 8-12 ц/га байх боловч шимт чанараар төдийлэн сайнгүй 100 кг тэжээлд 32-36 тэжээлийн нэгж агуулагдана. Харин урд талын хээр, ойт хээр хосолсон сумдад хялгана-үетэнт, хялгана-алаг өвст, биелэг-үетэнт, дааган сүүл-үетэнт, үетэн-улалж-алаг өвст хээржсэн болон нугархаг хээрийн хэвш шинж зонхилж ургац 6-8 ц/га байх боловч шимт чанараар сайн 38-42 тэжээлийн нэгж агуулагдана. Өөрөөр хэлбэл хойт талын сумдад байх хадлангийн талбайгаас тогтвортой ургац авдаг гэж үзэж болно. Дээрх хадлангийн талбайгаас жилдээ дундажаар 65-70 мян. тонн хадлан авдаг, тухайлбал 2004 онд 67822 тонн, 2005 онд 70111 тонн хадлан авсан байх жишээтэй. Гэвч хадлангийн талбайн ашиглалт хамгаалалт, тордолтын асуудал төдийлэн хангалтгүй байгаа бөгөөд дээрх асуудлыг шийдсэнээр жилдээ дээрх талбайгаас авах хадланг 15-20 мян. тонноор нэмэгдүүлж 90.4 мян.тонн хүргэх боломжтой. Улсын фондын хадлангын талбайнаас бусад хадлангийн талбайг одоогоор сум орон нутаг эзэмшиж байгаа бөгөөд цаашид иргэд, аж ахуйн нэгжид тодорхой хугацаагаар гэрээгээр эзэмшүүлснээр түүний ашиглалт, хамгаалалт тодорхой хэмжээгээр сайжрах боломжтой.

2.2.4. Бэлчээрийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.

Бэлчээрийн ургамалжилт. Булган аймгийн бэлчээрийн ургамалжилтыг газрын гадаргын төрх байдал, хөрс, ургамлын онцлогийг харгалзан дундаж өндөр болон нам бэсрэг уулын бэлчээр - У, уул хоорондын нарийн хөндий - УХ, Тал хээрийн -Х, Голын хөндий, нам хотосын нугын бэлчээр -Н гэсэн 4 ерөнхий хэв шинжид хувааж дотор нь 11 анги, 36 бүлэг төрөл, 105 төрөлд хуваасны дээр 85 үндсэн төрөл өөрчлөлтөнд орж талхлагдсаныг 126 хувилбараар дунд зэрэг ба их талхлагдсан гэж авлаа \зураг, хүснэгт 10\ .
Үүнд:

Дундаж өндөр ба нам бэсрэг уулын бэлчээр- У

Уулын бэлчээрийг дотор нь хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээрийн, уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг нугархаг хээр, уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээр, уулын сул хөгжилтэй хүрэн хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг хээрийн гэж 4 анги, 11 бүлэг төрөл, 36 төрөлд ангилалаа. Эдгээр бэлчээр нь аймгийн нийт бэлчээрийн эдэлбэр газрын 54.7% буюу 1 343 059 га талбайг хамарч байна. Уулын бэлчээр Хутаг-Өндөр, Орхон, Бугат, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Могод, Хангал зэрэг сумуудад 51.5-65.0 хувьтай тархжээ. Үүнээс өөрчлөлт орсон хувилбарууд нь ихэвчлэн уулын хуурай хээрийн бэлчээрт зонхилжээ. Талхлагдсан бэлчээрт туужууны биелэг өвс, дэрвээн хазаар өвс, ботууль улмаар их талхлагдахад ширэг улалж, агь зонхилон крыловын хялгана, саман ерхөг, саман дурваа, арзгар согсоолж, хонгор зулдуу, хонгор залаа, эгэл цагаан түрүү, одой далан түрүү, сарвуун сонгино, ишгүй гичгэнэ, имт гичгэнэ зэрэг ургамал ургасан байлаа. Ургамлан бүрхэвч их талхлагдсан газартаа 30-35 %, ургамлын өндөр 5-10 см, дунд талхлагдсан үед ургамал бүрхэвч 40-45 % бүрхэцтэй, ургамлын өндөр 8-15 байсан ба жилийн дундаж ургац дундажаар 2.5-3.5 цн байгаа нь урд судалгааны материалтай \1984\ харьцуулахад 20-25%-иар буурсан байна. Түүний 100 кг тэжээлд нь 32.7-48.3 хүртэл тэжээлийн нэгж агуулагдана.

Нам ба бэсрэг уулсын хоорондох хөндийн нугын бэлчээр – УХ

Уулын хоорондын хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй нуга нь 2.6 % буюу 63704 га талбай эзэлнэ. Уг бэлчээрийг 1 анги, 4 бүлэг төрөл, 7 төрөлд ангилалаа. Уул хоорондын нугын бэлчээр Хутаг-Өндөр, Бугат, Хишиг-Өндөр, Баян-Агт, Бүрэгхангай, Могод, Хангал зэрэг сумдад 1.8-7.3 хувьтай тархжээ. Их талхлагдсан бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд ширэг улалж, галуун гичгэнэ зонхилон нангиад хиаг, хэрчлээст бивлэнцэр, ишгүй гичгэнэ, имт гичгэнэ, ямаан шарилж зэрэг ургамал ургасан байлаа. Ургамал бүрхэвч 35-40 % бүрхэцтэй, дунджаар 5-15 см өндөртэй байна. Нэг га-д жилд дунджаар 2.4-3.0 цн ургацтай байгаа нь урд судалгаатай харьцуулахад 40 %-иар буурсан ба 100 кг тэжээлд нь 43.4 тэжээлийн нэгж агуулагджээ.

Тал хээрийн бэлчээр- Х

Тал хээрийн бэлчээрийг дотор нь тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээр, тэгшивтэр хөндийн элсэнцэр хүрэн хөрстэй хээр, довцог бөөрөг элсний сул бэхжсэн хөрс хуурай хээр гэсэн 3 анги, 10 бүлэг төрөл, 35 төрөлд ангилалаа. Эдгээр бэлчээр нь аймгийн нийт эдэлбэр газрын 33.5 % буюу 821950 га талбайг хамарч байна. Тал хээрийн бэлчээр Дашинчилэн,

Рашаант, Баяннуур, Баян-Агт, Гурванбулаг зэрэг сумдад 40.3-50.2 хувьтай тархжээ. Өөрчлөлт орсон хувилбарууд нь тал хээрийн бэлчээрт зонхилох хувийг эзэлж байна. Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт бэлчээр нь энэ ангид хамгийн өргөн тархалттай. Энэхүү төрлийн их талхлагдсан бэлчээрт ширэг улалж, агь, адамсын шарилж зонхилон ургах ба крыловын хялгана, дэрвээн хазаар өвс, дааган сүүл, дэлхээ тогторгоно, имт гичгэнэ, ишгүй гичгэнэ саман ерхөг, арзгар согсоолж, одой далан түрүү зэрэг ургамлууд оролцон ургажээ. Ургамал бүрхэвч 20-35 % бүрхэцтэй, ургамлын өндөр дундажаар 3-10 см байна. Нэг га- д жилийн дундаж ургац 2,5-3,0 цн байгаа нь урьд \1984\ судалгааны материалтай харьцуулж үзэхэд 35-40%-иар буурчээ. Энэ төрлийн 100 кг тэжээлд 28,3-37,1 хүртэл тэжээлийн нэгж агуулагдана. Ямар ч улиралд бүх төрлийн малд тохиромжтой. Их талхлагдсан хялгана, хялгана-алаг өвст бэлчээрт зонхилон үетнээс: ширэг улалж, крыловын хялгана, туужууны биелэг, дааган сүүл, дэрвээн хазаар өвс, алаг өвснөөс: агь, адамсын шарилж, арзгар согсоолж, одой далан түрүү, имт гичгэнэ ургажээ. Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 25-35%, ургамлын өндөр 3-8 см байв. Хялганат хээрт мал их бэлчээрлэхэд агийн эзлэх хувь ихсэж алаг өвс багасан улмаар их талхлагдахад дэгнүүлт үетэн ургамал шингэрч түүний оронд ширэг улалж, адамсын шарилж түрэн орж ирсэн байлаа. Малд идэгдэх жилийн дундаж ургац дундажаар 2,0-2,5 цн байгаа нь урд судалгаатай харьцуулахад 40%-иар буурчээ. Энэ төрлийн 100 кг тэжээлд 32,8-45,2 хүртэл тэжээлийн нэгж агуулагдана.

Нугын бэлчээр-Н

Нугын бэлчээрийг дотор нь голын хөндийн, нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй нуга намгийн, аллювийн нугын болон хээржсэн нугын үелэсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татмын нуга, голын хөндий, нам хотосын аллювийн нугын ба нугын хээржсэн хөрстэй давсархаг нугын гэж 3 анги, 11 бүлэг төрөл, 27 төрөлд ангилалаа. Эдгээр бэлчээр нь аймгийн нийт эдэлбэр газрын 9.2 % буюу 227571 га талбайг хамарч байна. Нугын бэлчээрт өөрчлөлт орсон хувилбарууд зонхилж байгаа нь бидний судалгаанаас харагдаж байна. Талхлагдсан хувилбаруудын онцлогийг авч үзвэл: талхлагдсан бэлчээрт нь ширэг улалж, галуун гичгэнэ, адамсын шарилж зонхилж нугын биелэг, имт гичгэнэ, түнхлэй болон мөлхөө хиаг, , эмийн сөд, их таван салаа эмийн багваахай, ишгүй азаргана, япон болон намгийн холтсон цэцэг, монгол улаан толгойт , цагаан лууль зэрэг ургамлууд орно. Ургамал бүрхэвч 25-30 %-ийн бүрхэцтэй, ургамлын өндөр дундажаар 3-6 см, дэрс нь 50-70 см байна Нэг га-д жилийн дундаж ургац 3.0-4.0 цн байгаа нь урьд \1984\ судалгааны материалтай харьцуулахад 30-40 %-иар буурсан байна. 100 кг тэжээлд 30.1- 51.1 хүртэл тэжээлийн нэгж агуулагдана.

Судалгаанаас харахад өөрчлөлт орсон төрлүүд нь тал хөндий, нуга, нам хотосоор зонхилон тохиолдохын зэрэгцээ уулын энгэр, хажуу хормой, толгодыг хамарсан байна. Энд уул толгодоор нь жижиг дэгнүүлт үетэн-агьт, харгана-агьт, агь-гичгэнэт, агь-үетэнт, тал хөндийгөөр нь ширэг улалж-үетэнт, ширэг улалж-агьт, улалж - харганат, харгана -улалжит, ширэг улалж - адамсын шарилжит, хазаар өвс - харганат, улалж-хазаар өвст, нуга, нам хотосоор шарилж - ширэг улалжит, ширэг улалж - үетэнт, дэрс-ширэг улалжит, ширэг улалж – галуун гичгэнэт, цахилдаг - улалжит, галуун гичгэнэ - ширэг улалжит талхлагдсан төрлүүд түгээмэл тархжээ. Бэлчээрийн төлөв байдлыг авч үзвэл, нийт судалгаанд хамрагдсан газрын 34.6 % буюу 929 590 га нь өвслөг ургамалтай, 20.4 % буюу 546 527 га нь сөөгтэй, 39.7% буюу 1 061 469 га нь чулуутай, 5.3 % буюу 141 901 га нь довонтой байна. Үүнд хамгийн их чулуутай бэлчээр

Сайхан, Баян-Агт суманд, хамгийн их сөөгтэй бэлчээр Баяннуур, Дашинчилэн суманд тус тус тэмдэглэгдсэн .

Бэлчээр ашиглалтын одоогийн байдал. 2005 оны газрын тоо бүртгэлийн материалаас үзэхэд аймгийн хэмжээнд *бэлчээрийн газар* 2 521 198.0 га газрыг эзлэх бөгөөд энэ нь нийт нутаг дэвгэрийн 51.7%-ийг, ХАА-н газрын 91.2 % -ийг эзлэдэг. Одоогийн байдлаар бэлчээрийг зөвхөн нийтээр эзэмших зарчим баримталдаг. Монголчууд эрт дээр үеэс бэлчээрийг зун намрын, өвөл хаврын гэсэн нарийн хуваарьтайгаар ашиглаж ирсэн уламжлалтай билээ. Гэтэл сүүлийн жилүүдэд энэ хуваарь алдагдаж жилийн дөрвөн улиралд нэг газраа тойрон нүүдэллэх, нүүдлийн тоо цөөрөх, малын тоо толгой нэг дор хэт бөөгнөрөх, нутаг усаа бие биенээсээ өрсөн хэрэглэх, бэлчээрийн усжуулалт хангалтгүй зэргээс шалтгаалан бэлчээр ихээхэн талхлагдаж байна. Үүнд ажиллах хүчин хангалтгүй, унаа, хөсөг байхгүй, малчид өөрсдөө зах зээлд болон нийгмийн үйлчилгээнд ойр байх хүсэлтэй, өвлийн бэлчээрээ сахиж хамгаалах зэрэг олон нийгмийн болоод ахуйн хүчин зүйлүүд нөлөөлж байгааг үгүйсгэх аргагүй юм. Энэ нь төрөөс бэлчээрийг зөв зохистой ашиглах талаар төрийн нэгдсэн бодлого, зохицуулалт байхгүйгээс бэлчээрийн менежментийн бодлого алдагдсаныг харуулж байна.

Тус аймагт уулын болон тал хээрийн бэлчээр ихээр тархсан нь мал маллахад тохиромжтой боловч бэлчээрийг хуваарьтай, зохистой ашиглаагүйгээс намаржаа, хаваржаа, зуслангийн ойролцоо бэлчээр ихээр талхлагдсан байна. Мөн түүнчлэн урд ажиллаж байсан худгууд ихээр эвдэрч тоногдсон нь усаа даган хэт ихээр бөөгнөрч буух улмаар бэлчээр талхлагдалд орох бас нэг хүчин зүйл болж байна. Өвөл хавартаа ихэвчлэн уул нурууд, уулсынхаа өвөр, нөмөр нөөлөг газраар нутагладаг. Тус аймгийн урьд талын сумдад тал хээрийн бэлчээр зонхилдог тул бэлчээрийн талхлагдал их байгаа нь судалгаанаас тод харагдлаа. Харин төв болон хойт талын сумдад уулын болон ойт хээрийн бэлчээр зонхилдог тул талхлагдал харьцангуй бага байна. Иймээс бэлчээрийн нөөц ихтэй газарт худаг ус гаргаж зохистой ашиглах нь юу юунаас чухал асуудлын нэг болоод байна. Ер нь Булган аймаг бэлчээрийн газар багатай боловч ялангуяа хойт талын сумд болох Тэшиг, Сэлэнгэ, Бугат, Хутаг-Өндөр, Хангал зэрэг сумдуудад ойн сангийн газраас бэлчээрт ашиглах боломж бий. Бидний судалгаагаар 226.1 мян. газар\ Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Бугат, Хутаг-Өндөр\ ойн сангийн газраас бэлчээрт ашиглах боломжтой нь тогтоогдоод байгаа бөгөөд үүний 48 156 га газар \ Бугатад 15257 га, Хутаг-Өндөрт 32889 га\ нь алслагдсан бэлчээр юм. Мөн Могод сумын нутагт Оцон овоо, Зөрхийн Могойн орчмоор 12 382 га бэлчээр худаг ус байхгүйгээс ашиглалт муутай байна. Мөн атаршуулж орхисон Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант сумдын тариалангийн газраас 5063 га талбайг бэлчээрт шилжүүлэх нь зүйтэй. Мөн улс орны хөгжилийг дагаад бэлчээрийн газраас бусад ангилалд шилжих газар /64914га/ нэлээдгүй байгаа бөгөөд тэдгээрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг тухай тухайн ангиллын газарт тодорхой бичсэн болно. *Ер нь цаашид Булган аймаг бэлчээр бага, дээр нь газар тариалангийн төв бүс нутаг учир цөөн тооны өндөр үр ашигтай эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бодлого баримллах нь зүйтэй.*

Хүснэгт 11

Бэлчээрээс бусад ангилалд шилжих газар, хэмжээ

№	Бусад ангилалд шилжих бэлчээрийн хэмжээ га-гаар					
	Газар тариалан, га-аар	Хадланд	Уурхайн газар	Амралт рашаан сувилал	Усан цахилгаан станц	Зам шугам сүлжээ
	16755	4857	7559	112	28482	7149

Бусад ангиллаас бэлчээрт ашиглагдаж буй газар, хэмжээ

№	Газрын сангийн ангилал	Талбай га-гаар	Цаашдын ашиглалтын төлөв
1	Атаршсан газар	5013	Цаашид олон настын үр цацаж бэлчээрт шилжүүлэх
2	Ойн сан	1578.2	Хадланд
3	Ойн сан	226100	Ойн зах, цоорхой, энгэр газар бэлчээрт ашиглагддаг

Бэлчээрийн газрын доройтол. Бэлчээрийн доройтолд бэлчээрийн даац хэтэрсэн, бэлчээрийг сэлгээгүй байнга ашигласнаас үүдэн гарах талхлагдал онцгой байр суурийг эзэлнэ. Аймгийн хэмжээнд нийт 766 439 га буюу нийт бэлчээрийн 30 % нь талхлагдаж төлөв байдал нь өөрчлөгджээ. Талхлагдсан бэлчээрийг талхлагдлын зэрэглэлээр авч үзвэл нийт талхлагдсан бэлчээрийн 326968 га буюу 42.7 % нь дунд зэрэг, 439 471 га буюу 57.3 % нь их талхлагдсан байгаагаас харахад их талхлагдсан бэлчээрийн эзлэх хувь өндөр байгаа нь харагдаж байна. Бэлчээрийн талхлагдлаас гадна ашиглалтын явцад орчны нөлөөллөөр 1050 га нь техногенийн, 66 720 га нь автогенийн, 497 га гуу жалгатай, 388 га нь усны эвдрэлтэй, 25 346 га элсний нүүлттэй, 134 га ахуйн бохирдолтой байна. Өөрөөр хэлбэл нийт бэлчээрийн 30 % нь талхлагдаж, 3.8 % нь бусад нөлөөлөлд автжээ. \зураг, хүснэгт 12\.

Тус аймгийн бэлчээрийн ургамал хүн, мал, амьтны нөлөөгөөр ихээхэн өөрчлөгдөж тачир намхан ургамалтай, сийрэгхэн тусгагийн бүрхэцтэй, ургац багатай буюу эсвэл мал иддэггүй ургамал зонхилсон шарилжит, агьт, улалжит, дэрст, цахилдагт бэлчээр ихээр тархах болсон байна. Бэлчээрийн талхлагдлаас болж хөрсний элэгдэл, эвдрэл ихсэх, түүний ус, чийгийн горим алдагдаж улмаар хангамж нь багасах, үржил шим буурах, мал идэш тэжээлээр дутагдах, ургамалан бүрхэвч доройтох, мод, сөөг хатах, хээржих болон цөлжих үйл явц ихсэх зэрэг сөрөг үр дагавар ихээхэн гарч улмаар биологийн баялагийн нэг болох ургамлан нөмрөгийн нөөц хомсдох утвар нөхцөлийг бүрдүүлж байна.

Бэлчээр ашиглалт, нүүдэл суудлын тоо, хүрээ нь уст цэгийн байршилаар тодорхойлогддог онцлогтой. Нэг талаар уст цэг нь малын орон зайн тархалт, цаг хугацааны байршлыг тодорхойлогч нь болдог. Иймээс уст цэгээ бараадан нутагласнаас хамгийн их өөрчлөлтөнд орсон бэлчээрийн газар нутаг нь тал хээр, голуудын хөндийн нуга, нам хотос, марзлаг давсархаг газрууд юм. Үүний зэрэгцээгээр тус аймгийн нутгаар төв, баруун чиглэлийн аймгуудын автомашины зам дайран өнгөрдөг тул олон салаа зам \бараг бүх сумдад\ гарч бэлчээрийн ургамлын төрх өөрчлөгдөж зарим нэг газраар\ Дашинчилэн, Гурванбулаг, Баяннуур, Рашаант сумдуудад \ элсний нүүлт явагдаж байгаа нь ажиглагдлаа. Усны эвдрэлд орж гуу жалга үүссэн бэлчээрийн газар бүх сумдуудад мэр сэр байгаа боловч хамрах хүрээ талбайн хувьд харьцангуй бага байлаа. Усны эвдрэлд орж үүссэн хамгийн их гуу жалга Сайхан, Баян-Агт сумын бэлчээрт тэмдэглэгдсэн. Бохирдолтын хувьд бохирдсон бэлчээр мөн нийт сумдад багахан газрыг эзэлж байсан бөгөөд ихэвчлэн ахуйн бохирдолтын хэлбэрээр илэрч ганц нэг сумдын мал угаалгын цэг байрласан газарт химийн бохирдолтын хэлбэрээр илрэв. Мөн аймгийн хэмжээнд 1050 га бэлчээрийн газар техногенийн нөлөөлөлтэй байгаа бөгөөд үүний 710 га газар нь

Бүрэгхангай сумын алт олборлодог аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаагаар, 340 га нь Сайхан сумын нүүрсний уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор илэрсэн.

Хүснэгт 13

Нөхөн сэргээлт, тордон сайжруулалт хийх газар, хэмжээ /га-гаар/

№	Газрын доройтлын хэлбэрүүд	Байршил /Газар, усны нэр/	Хэмжээ, га-аар	Тайлбар
1	Талхлагдсан бэлчээр-бүгд		766439	
2	Үүнээс: Их		439471	Ил задгай ус, гол горхины орчим, тал хээрт
3	Дунд зэрэг		326968	
4	Элсжсэн	Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн г.м	25346	Элсэн хунгар тогтсон
5	Зам харгуй гарсан	Бүх сум	66720	Олон салаа зам гарсан
6	Хортон мэрэгчид тархсан	үгүй	-	
7	Үйлдвэр уурхайн үйл ажилагаагаар ухагдаж төнхөгдсөн	Сайхан, Бүрэгхангай	1050	
8	Усны эвдрэлд орж гуу жалга үүссэн	Бүх сум	497	
9	Бохирдлууд	Бүх сум	134	Малын сэг, өвөлжөө хаваржааны туурь, мал угаалгын цэг г.м
	Бүгд		795966	

Бэлчээрийн даац . Тус аймагт 2006 оны сүүлийн хагаст хонин толгойд шилжүүлснээр 2525.6 мян. мал тоологджээ /хүснэгт 14/. 2000 онд тус аймагт Глобус ХХК-аас бэлчээрийн төлөв байдал чанарын хянан баталгааны ажил хийхэд 3533.9 мян. мал тоологдож бэлчээрийн даац аймгийн хэмээнд дундажаар 257% байсан ба хамгийн их даац хэтэрсэн сум Сайханд 146 %, хамгийн бага Рашаант суманд 123 % байсан бөгөөд өөрөөр хэлбэл бүх суманд даац хэтэрч бэлчээрийн ачаалал дээд цэгтээ хүрсэн байв. Энэ нь гаднаас суурьшин ирсэн малчдын тоог даган малын механик өсөлт их байсантай холбоотой бөгөөд 2001-2003 онуудад болсон ган зудтай холбоотойгоор малын тоо 2525 мян. болтлоо буурсан байна. Малын тоо толгой өсөх нь нэг талаар сайн боловч нөгөө талаар бэлчээрийн даац хэтэрч талхлагдалд их хэмжээгээр орох, ургамалан бүрхэвчийн бүтэц ихээр өөрчлөгдөх, цөлжих явц бий болоод зогсохгүй, ган, зуд болсон тохиолдолд мал олноор хорогдох аюултай байна. Бэлчээрийг зохистой ашиглах, түүний бүтээмжийг дээшлүүлэх нэг гол арга нь малын тоог бэлчээрийн даацад тохируулах явдал мөн. Бэлчээрийн даац гэдэг нь бэлчээрийн нэг га талбайд ноогдох хонин толгой буюу 1 хонин толгойд ноогдох бэлчээрийн талбайг хэлнэ. Бэлчээрийн даацыг тодорхойлохдоо Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 152-р тогтоолыг баримтлан адуу, үхрийг 6.0, тэмээг 5.0, ямааг 0.9, хонийг 1.0 гэсэн коэффициентээр тооцон хонин толгойд шилжүүлэв. Мөн тэжээлийн нөөцийн тооцоог гаргахдаа хээрийн бүсэд 1 хонин толгой жилдээ 5.7 цн, ойт хээрийн бүсэд 6.2 цн өвс тэжээл хэрэглэдэг гэж тооцон сум бүрээр

бэлчээрийн даацыг гаргалаа \хүснэгт 15\). Хүснэгтээс харахад 2000 онтой харьцуулахад нийт сумдад бэлчээрийн даац ялангуяа ачаалал ихтэй байсан Дашинчилэн, Гурванбулаг, Рашаант, Баяннуур, Хангал сумуудад буурсан боловч Сайхан, Баян-Агт, Тэшиг, Хангал, Рашаант сумдад бэлчээрийн даац 1,8-2,8 дахин хэтэрсэн тооцоо онолын хувьд гарч байна. Гэвч эдгээрээс Хангал, Тэшиг сум харьцангуй бага бэлчээрийн газартай боловч ойн сангийн газраас бэлчээрт ашиглаж болох бэлчээрийн нөөц газар ихтэй нутаг юм. Булган сумын хувьд угаас газар нутаг багатай учир зэргэлдээх сумын нутагт нутагладаг онцлогтой. Судалгаанас харахад бэлчээрийн менежментийн бодлого алдагдаж бэлчээрийн асуудал зөвхөн нэг сумын, нэг аймгийн асуудал биш нийт улс орны, экологийн асуудал болоод байгаа бөгөөд төрийн зохицуулалт нэгдсэн нэг бодлого нэн даруй хэрэгтэйг харуулж байна.

2.2.5 ХАА-н барилга байгууламжийн газар

Булган аймгийн хэмжээгээр нийт 17 065 өвөлжөө хаваржаа байгаагийн доор 1194,52 га, Бэлчээр дэх уст цэг, мал угаах цэг болон бусад мал эмнэлэгийн үйлчилгээний зориулалттай газар 71,88 га, Газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалттай үтрэм, үр тариа, хүнсний ногооны агуулах, хүлэмж дарлагын газар 61,1 га, ХАА-н үйлдвэрлэлийн зориулалттай бусад газар 58,2 га нийт ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар 1385,72 га байгаа нь ХАА-н газрын 0,05% болж байна.

2.2.6 ХАА-д ашиглах боломжгүй газар

Байц хад, асга, элсэн манххан, өвс ургамалгүй гуу жалга, сайр зэрэг ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар аймгийн хэмжээнд 16 398 га байгаа нь нийт ХАА—н газрын 0,5% болж байна.

Дүгнэлт

Нийт газрын сангийн 56,7 хувийг ХАА-н газар эзлэж байгаа нь бүс нутгийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд нийцэж буй билээ. Өөрөөр хэлбэл хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг өөрийн нутаг орныхоо ХАА-н үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангахад газар нутгийн хувьд хүрэлцээтэй байгаа бөгөөд гагцхүү түүнийг хэрхэн яаж зөв зохистой ашиглах бэ гэдэг асуудал өнөөдрийн бидний шийдэх асуудал болж байна. Одоогийн ХАА-н үйлдвэрлэлийн хөгжилийн чиглэлийг салбар тус бүрээр дурьдвал,

ХАА-н салбарт тэргүүлэх байр суурийг газар тариалангийн үйлдвэрлэл, түүний дотор үр тарианы аж ахуй зонхилох байр суурийг эзлэх бөгөөд нийт тариалангийн 65960 га талбай байгаагаас 64704.3 га талбай үр тарианд, 45 га жимс, жимсгэнэд, эмийн ургамалд 9 га, 1201.7 га талбай төмс хүнсний ногоонд ашиглагдаж байна. Одоогоор нийт эргэлтийн талбайн зөвхөн 32.1%-д тариалалт хийж байгаа нь хангалтгүй үзүүлэлт бөгөөд цаашид энэ хэмжээг наад зах нь 2 дахин нэмэгдүүлэх шаардлагатай. Байгаль хөрс, цаг уурын хувьд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцөлтэй боловч ашиглалтын явцад нийт тариалангийн талбайн 45.5% хөрсний элэгдэл эвдрэлд ямар нэг байдлаар орсон учир хөрсний элэгдэл эвдрэлээс хамгаалах техник технологийг иж бүрнээр нэвтрүүлэх, тариалангийн талбайн 50-60 % нь хөрсний үржил шимээр дундаас хангалтгүй гэсэн зэрэглэлд багтаж байгаа учир 30 126 га талбайд хөрс сайжруулалт, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, одоогийн тариалалт хийж буй 1201 га төмс хүнсний ногооны талбай нь 100 % хортон шавьжинд идэгдсэн байгаа учир даруй түүнтэй тэмцэх арга хэмжээг авч

явуулах, мөн усалгаатай талбайн хэмжээг 17 663 га талбайгаар нэмэгдүүлэх зэрэг тус салбарыг эрчимжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг даруй авч явуулах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд нийт 2 456 284га талбай бэлчээрт ашиглагддагаас нийт бэлчээрийн 30 % нь талхлагдаж 3.8% нь төлөв байдлын хувьд өөрчлөгдөхийн зэрэгцээ бэлчээрийн даац ихэнхи сумдад 1.0-2.8 дахин хэтэрсэн байна. Одоогийн мөрдаж байгаа газрыг нийтээр ашигладаг уламжлалт бэлчээрийн мал ахуйн эзлэх хувийг багасгаж өндөр үр ашигтай хувиарт эдлэн эзэмшилтэй эрчимжсэн мал ахуй, фермерийн аж ахуй хөгжүүлэх чиглэлийг барих шаардлагатай.

Булган аймгийн хэмжээнд 121540.1 га хадлангийн газартай бөгөөд эдгээр нь бараг бүх сумдад байрлах ба жилдээ 65-70 мян,тонн хадлан авдаг. Хадлангийн талбайн ашиглалт тордолтыг сайжруулснаар энэ хэмжээг 90.4 мянга-д хүргэх боломж бий.

2.3. Хот, тосгон бусад суурины ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал.

2.3.1. Хот, тосгон бусад суурины ангиллын газрын бүтэц.

Хот тосгон бусад суурингийн газар нь нийт 28 903.17 га газартайгаас барилгажсан талбай 2779.02 га, гэр хороолол 1767.72 га, нийтийн эдэлбэр 22040.6 га, үйлдвэрийн газар 17 1.82 га, уурхайн газар 2 144 га байна. 2005 оны эцэс гэхэд барилгажсан талбай 12.11 га-р хорогдож гэр хороолол 500.93 га талбайгаар нэмэгдсэнээс нийтийн эдэлбэрийн газраас 463.16 га талбай хасагджээ. Энд Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх хуулийн дагуу иргэдэд шинээр 500 га газар олгосон байна. Мөн түүнчлэн үйлдвэрийн газар 8.5 га талбайгаар хорогдож уурхайн газар 1105.8 га-р нэмэгдсэн байна. Хот суурин газруудын **хот байгуулалтын үнэлгээгээр** Булган аймгийн төв суурин газрууд нь дараахи үнэлгээтэй байна /хүснэгт 16/. Эндээс харахад усан хангамжаар Гурванбулаг, Рашаант сум хангалтгүй, бусад нь дундаас сайн, цэвдэг хөрс Сайхан суманд алаг цоог, газар чичирхийллийн баллаар Тэшиг, Хангал сум 7 балл, бусад нь 8-9 балл, ул хөрс Хишиг-Өндөр суманд хүчтэй овоолттой Булган, Баян-Агт, Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Орхон, Сэлэнгэ, Хангал зэрэг суманд дундаас бага зэрэг овоолттой, норматив ачаалал нийт суманд 1.5-5.0 кг/см –ийн хооронд хэлбэлзэх ба хөрсний ус 1-10 , Сайхан, Хутаг-Өндөр суманд түүнээс дээш байна. Мөн Булган, Сэлэнгэ, Хангал суманд үерийн хамгаалалт хийх шаардлагатай ба газрын гадаргын налуу 0.5-5.0 % байна. Ийнхүү нийт сум барилгын уур амьсгалын II бүсэд багтана. Ер нь усан хангамж усны түвшин >3 байхад нэн тохиромжтой түүнээс доош бол тохиромжгүй, ул хөрс <3 бол нэн тохиромжтой, өндөржилтийн хувьд д.т.д 1500 м хүртэл тохиромжтой, газар чичирхийлэлийн хүч 6 хүртэл балл байхад барилгын төсөвт өртөг тусгайлан нэмэгддэггүй, нэлэнхүйдээ мөнх цэвдэгтэй хөрс барилгын өртгийг 40 %, хөрсний овойлт 50-20 % тус тус нэмдэг байна. Эндээс харахад байгаль экологийн хувьд хот байгуулах боломжтой гэж үзэж болно.

2.3.2. Хот, тосгон бусад суурины тэг гортигийн доторхи газрын ашиглалт, хамгаалалтын байдал.

Тус аймгийн хэмжээнд 16 суманд аймгийн төв 1, сумын төв 15 байхаас гадна Хялганат тосгон, Сайхан-Овоо, Цульхир, Сэлэнгэбүрэн, Тасаг, Уньт, Хонгор, Хантай, Хужирын бригад зэрэг суурьшил бүхий томоохон баг, бригадын төвүүд оршдог. Эдгээр төвүүдийн суурьшилийн бүс нь нийтдээ 6340 га газрыг эзлэх бөгөөд үүний цэвэр барилгажсан хэсэг 1552.9 га гэр хороолол 2568.6 га байна/хүснэгт 17а,б/. Аймгийн хэмжээгээр 1 хүнд 0.11 га суурьшсан бүс 0.027 га

барилгажсан хэсэг, 0.045 га гэр хорооллын газар ноогдож байна. Эндээс харахад үнэн хэрэгтээ ихэнхи сумдад гэр хорооллын эзлэх талбай давамгайлж байгаа бөгөөд цаашид ч нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь улс орон зах зээлийн эдийн засагт шилжсэнээр улсын чанартай хөрөнгө оруулалттай томоохон хэмжээний барилга байгууламж баригдах асуудал хязгаарлагдсан учир барилгажсан газрын бүтэцийг зөвхөн Засаг захиргааны болон сургууль, цэцэрлэг, эмнэлэг, банк гэсэн төрийн захиргааны зайлшгүй шаардлагатай барилга байгууламжууд бүрдүүлж байгаатай холбоотой юм. Нийтийн үйлчилгээний салбарт хувийн хэвшлийнхний барьсан дэлгүүр, ТҮЦ, гуанз, зочид буудал зэрэг жижиг хэмжээний барилгууд зонхилох бөгөөд эдгээр нь хэмжээний хувьд бага, зарим нь хуучин барилгуудыг хувьчилж авсан байх жишээтэй. Ер нь барилгажсан хэсэгт ялангуяа сумын төвүүдэд хотын функциональ бүсүүдийн ялгаа, хил зааг бараг ажиглагдахгүй нэг нь нөгөөгөө орлох маягаар явдаг байна. Харин гэр хорооллын хувьд тодорхой зааг гарч ирэх боловч энд хүн амд зайлшгүй шаардлагатай эмнэлэг, сургууль, цэцэрлэг, худалдаа үйлчилгээ, цаашилбал, усан хангамж, хогийн цэг зэрэг асуудлууд төдийлэн хангалтгүй шийдэгдсэн байна. Хотын суурьшилын бүс дотор спорт, амралт цэнгээний бүс тодорхой бүс болж хөгжиж чадаагүй наадмын талбай, морь уралдуулах, барих газар зэргээр хязгаарлагдах бөгөөд зөвхөн зайлшгүй хэрэгцээт төрийн болон үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах барилга байгууламж, хүн амын амьдрах байр орон сууцны бүс түлхүү хөгжсөн байна. Хот суурин газарт эзлэх ногоон байгууламж 4.9 га талбайг эзлэж байгаа нь нийт суурьшилийн бүсийн дөнгөж 0.02 %-ийг эзлэж байна. Үйлдвэрийн бүс, жимс, жимсгэнэ, ногооны газар, өрхийн мал аж ахуйн бүс жигд биш боловч зарим газарт тохиолдоно /Булган, Тэшиг, Хутаг-Өндөр г.м/. Энэ нь томоохон хотын хэмжээнд хүртэл хөгжиж чадахгүй байгаагийн нэг илрэл юм. Нэгэнт функциональ бүсүүдийн хил, зааг ялгаа тодорхой гарч ирэхгүй байгаа учир газар ашиглалт, хамгаалалтын ажил ямар нэг хэмжээгээр зөрчигдөж байгаа нь тодорхой. Гэвч сүүлийн жилүүдэд засаг төрөөс Газрын талаар явуулах бодлогыг боловсронгуй болгосноор газар түүний ашиглалт, хамгаалалт жил ирэх тусам сайжирч байна.

Газрыг эзэмших, ашиглах, өмчлөх хууль, эрх зүйн асуудал. Тус аймагт газрын харилцааны тэр дундаа эзэмших, ашиглах өмчлөх асуудал хуулиар зохицуулагдаж явагддаг бөгөөд үүнд гол төлөв эзэмшлийн хэлбэр давамгайлна /хүснэгт 17в/. Одоогоор тус аймгийн хэмжээнд нийт 1326 иргэн, аж ауйн нэгж байгууллагын газрын эзэмших, ашиглах, өмчлөх эрх баталгаажсанаас гэр бүлийн хэрэгцээнд 1363 га газрыг, аж ахуйн хэрэгцээнд 1832 га газрыг, гадаадын иргэн аж ахуйн байгууллагад 2.3 га газрыг тус тус нь эзэмшиж, ашиглаж, өмчилөхөөр олгоод байна. Гадаадын 3 иргэн 2.3 га-г худгийн, болон ахуйн зориулалтаар Хутаг-Өндөр суманд ашигладаг. Цаашид өмчлөлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Хүснэгт 17в

Хот суурингийн газрын харилцааны өнөөгийн байдал

№	Газрын харилцааны хэлбэрүүд	Тоо хэмжээ,га		
		Иргэн	Төрийн болон ААНБ	Гадаадын байгууллага
1	Эзэмшүүлсэн	1162	1832	-
2	Ашиглуулсан	-	-	2.3
3	Өмчлүүлсэн	201 га	-	-
	Бүгд	1363	1832	2.3

Хот суурин газрын доройтол. Хот суурин газруудад байгалийн болон хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр газар ашиглах явцад гарсан доройтолуудыг хүснэгтээр харуулав /хүснэгт 18/. Хүснэгтээс харахад нийт суурьшилын бүсийн 62.3 га буюу 15.1 % нь ямар нэг хэмжээгээр доройтолд орсон байна. Энэ нь хэдийгээр бага мэт боловч төрөл зүйлийн хувьд олон байгаа бөгөөд хот суурин газар ахуйн хатуу хог хаягдлыг ил задгай хаясан, нурсан барилгын туурь хог, гэр хорооллын жорлон муу усны бохир, шатахуун түгээх станцын ойр орчмын шатах тослох материалын хөрсөн дэх нэвчилт /химийн бохирдол/ хүний хүчин зүйлсийн нөлөөлөлд голлох байр эзлэж байгаа бол байгалийн хүчин зүйлд үерийн усны нөлөөгөөр үүсч бий болсон гуу жалга, хээрийн сумдын элсний нүүлт зонхилох байрыг эзлэж байна. Иймд хот суурин газрын ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах, үерийн усны амыг хаах, гуу жалгыг дарах, элсний нүүлтийг ойн зурвас байгуулж зогсоох, хот суурингийн газарт эзлэх ногоон байгууламжийн эзлэх хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 18

Хотын газрын доройтлын байдал

№	Газрын доройтлын хэлбэрүүд	Байршил /Газар, усны нэр/	Хэмжээ, м ²	тайлбар
1	Хөрсний гүний ба өнгөн бохирдол	Нийт суманд	92186	үүнээс 46256 м ² биологийн, 45490 м ² ахуйн хог, 440 м ² химийн
2	Уруйд идэгдсэн	Баян-Агт, Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Тэшигээс бусад суманд	135526	Уруйд идэгдэж гуу жалга гарсан
3	Өнгөн бүрхэвч нь зулгарсан	Бүх суманд	288470	
4	Элсжсэн	Баяннуур, Дашинчилэн, Рашаант, Сэлэнгэ	73311	Элсний нүүлт
5	Намагжилт, давсжилт үүссэн	Булган, Бугат сум урд талаасаа намагжиж болзошгүй	-	
6	Хортон мэрэгчид тархсан	үгүй		
7	Үйлдвэр уурхайн үйл ажиллагаагаар ухагдаж төнхөгдсөн	Хутаг-Өндөр	6142	Мах комбинатын орчимд
8	Үйлдвэр уурхайн үйл ажиллагаагаар бохирдсон	Хялганат	27241	Хөрөө рамын хог
	Бүгд		622876	

Хот суурин газрын нөхөн сэргээлт, тордолт. Иймд хот суурин газрын доройтлоос зайлсхийх, түүний нөлөөллийг багасгахын тулд нэгэнт доройтсон газрыг нөхөн сэргээх явдал зүй ёсоор шаардагдана. Бидний судалгаагаар элсний нүүлтэнд өртсөн Гурванбулаг, Рашаант, Дашинчилэн, Баяннуур сумдад

ойн зурвас байгуулах шаардлагатай байгаа бөгөөд 1 га ойн зурвас байгуулахад 3.5 сая. төг зарцуулагдана гэж үзвэл наад тал нь 20 га талбайд зурвас байгуулахад 70 сая.төг шаардлагатай байх жишээтэй. Дор дурьдсан ажлуудыг хийж гүйцэтгэхэд орон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилга чухал байна.

Хүснэгт 19

Нөхөн сэргээлт, тордолт хийх газрын судалгаа

№	Арга хэмжээ	Газрын байршил	Талбайн хэмжээ, га-аар	Зарцуулах хөрөнгө* мян.төг	Хөрөнгийн эх үүсвэр
1	Ойн зурвас байгуулах	Гурванбулаг, Рашаант, Дашинчилэн, Баяннуур	20га	70 000.	Сумын төсөв, гадны төсөл
2	Эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээх	Хутаг-Өндөр	0.8га	50.0	Тухайн аж ахуйн нэгжээс
3	Зүлэгжүүлэх, цэцэрлэгжүүлэх	Нийт сум	20	600.0	Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд
4	үерийн ам, гуу жалгыг дарах	Нийт сум	10га	500.0	Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд
5	Ахуйн хатуу хог хаягдлыг цэвэрлэх, хогийн цэг, жорлон муу усны цооногийг стандартын дагуу хийх	Нийт сум	10 га	800.0	Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд
6	ШТС орчмын бохирдлыг арилгах	Нийт сум	0.5га	300.0	Аж ахуйн нэгж
	Бүгд			72250.0	

2.3.3. Амралт, рашаан сувиллын газрын ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал.

Энэ зориулалтаар 30 орчим аж ахуйн нэгж нийт 303,1 га газар ашиглагдаж байгаа нь хот тосгон бусад суурингийн ангилалын газрын 1%-ийг эзлэж байна. Энэ нь өчүүхэн бага газар бөгөөд хойшид аялал жуулчлал, амралт, рашаан сувилалын газрын хэмжээг зөвхөн уг үйлчилгээг эрхлэж байгаа аж ахуйн нэгж байгууллагын ашиглаж байгаа юмуу эзэмшиж байгаа газрын хэмжээгээр тооцдог явдлыг өөрчлөх шаардлагатай. Аялал жуулчлал, амралт сувилалын газруудын ойр орчимд айраг, сүү цагаан идээгээ борлуулах, жуулчин амрагч нарт морь, тэмээн хөсгөөр үйлчлэх сонирхол бүхий айлууд бууж орчныг нь талхлах явдал их байна. Хануйн амралтын байдлаас үүний жишээг тодорхой харж болох юм. Хойшид аялал жуулчлал, амралт сувилалын газрыг байгуулахдаа түшиц болж байгаа рашаан ус болон түүх соёлын дурсгалын газраас наад зах нь 5 км хол зайд байрлуулах,

орчных нь газрыг аж ахуйн бусад үйл ажиллагаанаас чөлөөлж байгалийн нь онгон байдлыг хадгалах хэрэгтэй.

Одоогийн байдлаар аялал жуулчлал, амралт сувилалын 3 гол бүс нутаг 3 дэд бүс нутаг байна. Үүнд:

Гол бүсүүд нь:

1. Хөгнө-Тарны байгалийн цогцолбор газар
2. Булган хотын орчин
3. Эрдэнэт хотын орчин

Дэд бүсүүд нь:

1. Баян-Агт сумын Хануйн рашааныг түшиглэсэн
2. Могодын Сайхан хулжийн рашааныг түшиглэсэн
3. Сэлэнгийн хөвөө

А. Хөгнө -Тарны байгалийн цогцолбор газар.

Булган аймгийн урд талын сумуудын нутаг болох Хөгнө-Тарны байгалийн цогцолбор газар, Улаанбаатараас Хархорин орох замын дагуу Элсэн тасархай орчмын нутгаар аялал жуулчлал голлон хөгжиж байна.

Эртний төрмөлийн эриний боржин зэрэг магмын чулуулгаас тогтсон энэ аманд ХҮИ зууны үед Монголчуудын барьсан 2 хийдийн туурь байдаг. 1688 онд Галданбошигтын цэрэг галдан шатааж лам нарыг нь хөнөөсөн байна. Уг хоёр хийдийн нэгийг 1994 онд сэргээн засварласан Эрдэнэ хамбын хүрээ хийд хэмээгдэн буддийн шашны ном хурдаг. Хөгнө хан уулыг 1997 онд байгалийн нөөц газрын ангилалаар 46 990 га талбайтайгаар улсын тусгай хамгаалалтанд авч. 2003 онд 84 390 га болгон өргөтгөж байгалийн цогцолбор газар болгосон. Ойн сан бүхий газар нь 3484 га байна.

Уг цогцолбор газар нь Улаанбаатараас Хархорин тийш чиглэсэн жуулчдын урсгал зам зуур саатан амрах хамгийн бололцоотой газар учир аялал жуулчлалын гол төв болж чадав. Хойшид Хархоринд нийслэл төвлөрсөн ч Улаанбаатар руу чиглэсэн урсгал байнга байх болно.

Хөгнө-Тарнын БЦГ-ын жуулчны баазууд:

1. "Натур тур" ХХК-ийн "Хөгнөхан" жуулчны бааз Рашаант сумаас баруун хойш 24 км, Хар хорины замаас хойш 11 км, Хөгнө хан уулын Бага рашаантын аманд байдаг. 30 гэртэй, нэг ээлжинд 120 хүн хүлээн авах хүчин чадалтай.
2. "Монгол элс" жуулчны бааз Гурванбулаг сум Хөгнөхан уул 6 гэртэй, нэг ээлжинд 24 хүн хүлээн авах бололцоотой.
3. "Монгол хаад" ХХК-ийн "Батхаан" жуулчны бааз Рашаант сумын төвөөс хойш 21 км. Хөгнөхан жуулчны баазын зүүн талд Хийдийн аманд 10 гэртэй, нэг ээлжинд 20 хүн хүлээн авах бололцоотой.
4. "Жи Эм Ти" ХХК-ийн жуулчны бааз Рашаант сумаас баруун тийш 2 км, "Хөгнөхан", "Монгол элс" жуулчны баазуудын дунд Тахилт нуурын баруун эрэг дээр 20 гэртэй, нэг ээлжинд 80 хүн хүлээн авах хүчин чадалтай.
5. "Нүхт" ХХК-ийн "Хөгнө говь" жуулчны бааз Рашаант сумын төвөөс баруун хойш 20 км, төв замаас хойш 6 км, Дунд элсэн тасархайд 15 гэртэй, нэг ээлжинд 60 хүн хүлээн авах бололцоотой.
6. "Хоёр загал" жуулчны бааз Рашаант сумын төвөөс урагш 15 км, Хархорины замаас урагш 7 км, Үнэгт цохио уулын энгэрт Туулайн эвэр

гэдэг газар байрладаг. 26 гэртэй, нэг ээлжинд 80 хүн хүлээн авах хүчин чадалтай.

7. "Онол" дээд сургуулийн "Булаг" жуулчны бааз Хархорины замаас хойш 20 км, Рашаант сумын төвөөс 25 км, Хөгнөхан уулын Цэцэрлэгийн аманд байрладаг. Нэг ээлжинд 22 хүн хүлээн авах хүчин чадалтай.
8. "Монгол Алтай Тур" ХХК-ийн "Монгол Алтай" жуулчны бааз Рашаант сумын төвөөс баруун тийш 18 км, Элсэн тасархайн хажууд төв замын дэргэд Хар бууц гэдэг газар байрладаг Нэг ээлжиндээ 75 хүн хүлээн авах бололцоотой.
9. "Эдэн тур" жуулчны бааз Рашаант сумын төвөөс 30 км, Хархорины замаас хойш 10 км, Хөнгөхан уулын худгийн аманд байрладаг. Нэг ээлжинд 39 хүн хүлээн авах бололцоотой.

Булган аймгийн Гурванбулаг сумын төвөөс зүүн урагш 43 км зайтай Хөгнөхан уулын өвөр далайн түвшнээс дээш 1450 м өндөрт элгэн улаан боржин хадны ан гаваар шүүрэн гоожих Хөгнөханы рашаан байдаг. Герциний үеийн нил боржин чулуунаас тогтсон ууланд унасан хурын ус тэрхүү нүцгэрсэн их боржин цохионуудын ан цаваар гүнээ шурган явсаар уулын хормойгоор нэвчин шүүрч байгаа нь энэ ажээ. Рашааныг ходоод, дотрын өвчинд ухаас гадна нүдэнд сайн хэмээн дусаадаг байна.

Б. Булган хот орчмын бүс

Булган хотоос баруун хойш 12 км, Нисэх буудлаас баруун тийш 7 км, Жаргалантын аманд "Анаг Тур" жуулчны бааз байдаг 15 ор тохилог зочид буудалтай, 2 гэрт хүмүүс хүлээн авдаг, нэг ээлжиндээ 70 хүн хүлээн авах хүчин чадалтай.

"Анаг тур" жуулчны баазаас дээш 1 км орчим зайд Хүүхдийн зуслан байдаг.

Булган хотын хүн амын болон ирсэн зочид гийчдийг ая тавтай байлгах байгалийн болон дэд бүтцийн боломж байгаа боловч хотын үзвэр үйлчилгээний газруудын үйлчилгээний соёлын түвшин Улаанбаатар, Эрдэнэт хотуудыг гүйцэхгүй байгаа тул аялал жуулчлалын төв болж хараахан чадахгүй байна. Ирээдүйд хатуу хучилттай зам, төмөр зам бий болсон цагт үйлчилгээний соёл дагаад дээшлэж аялал жуулчлалын төв болох боломжтой.

Булган хот нь 1667 онд Ачуут, Зүүн Түрүүний голын бэлчирт байгуулагдсан Түшээт хан аймгийн Дайчин чин вангийн хүрээнээс эхтэй юм. Энд дараах зүйлсийг үзэж болно:

Чин ван Ханддоржийн дурсгалын хөшөө

Хатан батар Магсаржавын дуулгат бунхан

19-р зууны үед байгуулагдсан Дашчойнхорлон хийд

Баруун замын штаб байрлаж байсан хуучин сүм.

Монгол улсын баатар Даваадоржийн цэцэрлэг.

Булган хотоос гарч Орхон сумын төв 22 км, гүүрээр гарч, Хишиг-өндөр сум 44 км, Могод сум 63 км, Бүрэг хангай сум 90 км буцаад Орхон сум 56 км, Булган хот 22 км Замын урт 300 км, аялах хугацаа 2-3 хоног.

Орхон суманд нарийвтар ноост "Хангай" үүлдрийн хонь өсгөн үржүүлдэг.

Орхон сумын төвөөс доохно Буган чулуун хөшөө хэд хэд байдаг.

В. Эрдэнэт хот орчмын бүс

Эрдэнэт хотоос Чулуутын 25 км, амралтаар дайран Хангал сум 20 км, Хялгант тосгон 24 км, Сэлэнгэ мөрнөөс голын хойгуур явж Сэлэнгэ сум 30 км

буцаад Эрдэнэт хот 63 км. Аялалын замын урт 200 км, Аялах хугацаа 1- 2 хоног.

84,4 х. д. км талбайтай Орхон аймгийн төв Эрдэнэт хот 90 мянган хүн амтай, 132 мянган толгой малтай, Улаанбаатар хотоос 371 км, Булган хотоос 68 км зайтай оршино. Улаанбаатар хоттой төмөр ба засмал замаар холбогдсон. Эрдэнэтийн овооны 80-100 жил олборлох нөөц бүхий зэс молибдений нөөцийг ашиглан баяжуулах үйлдвэр барьсан нь жилд 25 сая тонн хүдэр боловсруулж байна. Үйлдвэрийн том төв хотын хүн амын болон ирсэн зочид гийчдийн алжаалын тайлж нүдийг баясгах бололцоотой байгалийн үзэсгэлэн, амралт, аялал жуулчдын төвүүд Эрдэнэт хотыг тойронд болон Сэлэнгэ мөрний хөвөөнд хангалттай төвлөрөөд байна. Энэ чиг хандлага цаашид улам өсөж 3 дахь аялал жуулчлалын бүс бүрэлдэн тогтоно.

Эрдэнэт хотын ойролцоох Хөөвөр нуурын шаврыг зөөж үе мөчний өвчинд түрхэж ашигладаг.

Эрдэнэт хотын нилээд олон байгууллагын харъяаны амралтын газрууд Булган аймгийн нутаг дэвсгэрт байрладаг 119 га газар ашигладаг гэсэн тоо байх боловч яг ямар амралтын газрын ашиглаж байгаа газар хэдэн га вэ? гэсэн тодорхой тоо баримт байдаггүй. Баримт бичиг нь хууль ёсны болоогүй байна.

Орхон сумын нутагт Бүрэн бүстийн амралт
Хангал сумын нутагт Эрдэнэт үйлдвэрийн амралтын газар
Хялгантын нутагт хүүхдийн "Долгоин" зуслан, Олимпын хорооны амралтын газар Бугат сумын төвийн дэргэд "Эрдэнэт хивсний амралт" г.м .

Чулуутын рашаан Булган аймгийн Хангал сумын нутагт Чулуут голын эх хойд энгэр , Бөхөнгийн нурууны зүүн урд өвөрд далайн түвшнээс дээш 1540 м өндөрт байдаг. Хангал сумын төвөөс 25 км зайтай шинэс голлосон хустай өтгөн ой дотор дундад төрмөлийн эриний триасын галавын үеийн зузаан үе давхрага, хөх бор өнгөтэй, их хувирсан занар чулууны судлаас гарах ганц ихтэй булаг юм. Гэдэс дотор, ходоодны өвчинд рашаанаас ууж эмчилэн сувилдаг.

Г. Баян-Агтын Хануйн рашааныг түшиглэсэн дэд бүс

Хунт нуурын болон Хануйн рашаанууд нь Улсын чанартай сувилалын төвүүд байхаар төлөвлөгдөж байгаа, байгалийн нөхцөл сайтай, түүх соёлын дурсгалт зүйлсээр элбэг болохоор энд амралт сувилалын бүс нутаг болон хөгжих ирээдүй байна.

Булганы төвөөс баруун тийш 125 км, Баян Агт сумын төвөөс зүүн тийш 12 км, Хануйн голын гүүрний дэргэд баруун эрэгт Хануйн рашааны дэргэд "Дулаан хангай " ХХК-ийн "Хануй" жуулчны бааз байдаг. 13 гэртэй. Нэг ээлжинд 50 хүн хүлээн авах бололцоотой.

Хануйн рашаан Булган аймгийн Баян - Агт сумын нутагт далайн түвшнээс дээш 1000 м орчим өндөрт Хануйн рашаан байна. Баян-Агт сумаас зүүн зүгт 30 км орчим Хануй голынхоо баруун амсарт 30 м хүрэх өндөр их зузаан хүрмэн чулууны , судал дороос нэг эхтэй рашаан оргилж , өвөл хөлдөхгүй харзлан урсана. Шинэ төрмөлийн эриний, гуравдагч болон дөрөвдөгч галавын үед газрын хагархайгаар болон галт уулын өрхөөр удаа дараа бялхан оргилж урсаад Хануйн хөндийг дүүрч хадаалан хөлдсөн хатаж царцан ийм зузаан болсон хүрмэн чулуунаас эх авчээ. Рашааныг ходоод гэдэс дотрын өвчин, элэг цэсөний өвчинд уухаас гадна үе мөчний өвчтэй

хүмүүс хүйтэн рашаанд орж эмчилдэг байна. Гидро карбонат, хлорид, натрийн төрөлд багтана.

Д. Могодын Сайхан хулжийн рашааныг түшиглэсэн дэд бүс

Могод сумын төвөөс зүүн тийш 4-5 км -т 1967 оны газар хөдлөлттөөр үүссэн газрын хагархай тод ажиглагдана.

Могод сумын нутаг Хөл-Асгат гэдэг газар орших Түрэгийн алтан тамган дарханы бичигт хөшөөг 1971 онд улсын хамгаалалтанд авчээ.

Хулжийн рашаан Булган аймгийн Могод сумын төвд далайн мандлаас дээш 1500 м өндөрт оршино. Энд ойт хээр болон уулархаг хээр хосолсон нутаг бөгөөд рашаанаас зүүхэнтэй 1-2 км газар Хар нуур, Цагаан нуур, Загаст нуур, Хөх нуур зэрэг олон жижиг нуур Хулжийн горхины эхээр оршино. Хойшоо чиглэн урсаж Орхонд нийлсэн тэрхүү Хулж горхи эхээрээ тасран ширгэдэг, ус багатай шавар ихтэй болохоос гадна рашааны эргэн тойрон булаг шанд, шавар намаг, дов сондуул их, хужирт тойром олон байна. Нутгийн хүмүүс Хар нуурт орж элдэв өвчнөө эмнэн сувилдаг байна. 300 м орчим диаметртэй дугариг хэлбэртэй, 3 м орчим гүн, захаараа зэгс ургасан эгцдүү эрэгтэй, нуурын ус хүрэндүү өнгөтэй, эхүүн амттай, зэгс шаврын үнэртэй. Нуурын усанд хун шувууд үргэлж байдаг.

Хуучин төрмөлийн үеийн тунамал, хувирмал занар, , мөлгөр хөр чулуу, нөгөө талаас юрийн галавын хүрмэн чулуу нийлсэн зааг газраас, зүүн хойноос баруун урагш чиглэсэн эртний газар цогцлолын ан цаваас зааг зөргөөс гарч байгаа 38 хэм орчим халуун ус юм. Рашааны дэргэд рашаанд орж хувцас өлгөх ганц модон пин байгаа бөгөөд нэг ээлжмнд 50-60 хүн хүлээн авч болох нэг давхар хоёр барилга байдаг. Рашааныг бөөр нуруу, үе мөч, арьс өнгөний өвчинд голлон хэрэглэнэ.

Бүрэгхангай сумын Ногоон морьтод буга агнуулах зорилгоор ангийн отог байгуулсан.

Е. Сэлэнгийн хөвөө

Сэлэнгэ сумын төвд Далх вандад гэж нутгийн хүмүүс нэрлэдэг хүн чулуун хөшөө байдаг нь Киданы үед холбогдох дурсгал юм.

Сэлэнгэ суманд махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн үхрийг өсгөн үржүүлдэг.

2.3.4. Үйлдвэр уурхайн газрын ашиглалт, хамгаалалтын байдал.

Булган аймгийн үйлдвэрийн газар 171,82 га газар эзлэж байгаагийн 140 га нь Хангал сумын нутагт байрлах ус өргөлтийн байгууламжуудын талбай юм. Бусад нь ихэвчлэн Булган хотод төвлөрөх бөгөөд Гурил тэжээлийн үйлдвэр, зайрмаг, ундааны цех, архины үйлдвэр, 10 машинтай оёдлын цех зэргийг дурьдаж болно. Булган аймгийн хэмжээнд нүүрс олборлолт 64 690,9 сая төг, 5,3 % Хүнсний үйлдвэр 587 163,8 сая төг, 48,5 % хувцас үйлдвэрлэл 11060,0 сая төг, 0,9 % хэвлэх үйлдвэр 8486,7 сая төг, 0,7 %, Модон эдлэлийн үйлдвэрлэл 9562,2 сая төг, 0,8 %, цахилгаан дулааны үйлдвэрлэл 493 845,0 сая төг, 40,8 %, усан хангамж 34286,8 сая төг 2,8 %, халуун ус 2235,4 сая төг 0,2 % нийт 1211330 сая төгрөгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Харин уурхайн газар 2144 га, үүнээс үйлдвэрийн зориулалттай байрилга байгууламжийн дэвсгэр газар 22,58 га, сууршлийн бүсийн барилга

байгууламжийн газар 34,56 га байгаа нь бодит байдлаас нилээд зөрүүтэй байна.

Ашигт малтмал ашиглах 36 лицензээр 15 214,1 га талбай олгогдсоноос 9645,5 га талбайд уулын үйлдвэрлэл явагдаж жилдээ дунджаар 4.3 сая.м³ газар шорооны ажил гүйцэтгэн, 6,65 сая.м³ ус хэрэглэж байна. Нийт хэрэглээний усны 20 хувийг дахин эргүүлж ашиглаж байна.

ОХУ-ын “Алтан дорнод Монгол” ХХК –ны 12 талбайд 900 гаруй хүн ажиллаж байгаагийн 540 орчим нь ОХУ-ын иргэн, БНХАУ-ын Энгүүн-Од ХХК, байгаль хамгаалах болон нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөгүй ажилладаг. “Хос хас” ХХК, “Их тэмүүлэл” ХХК ашиглаж байгаа талбайгаа нөхөн сэргээгээгүй хаясан, “Шижир алт” ХХК 117,8 га-д техникийн, 3,6 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн.

Дүгнэлт

Тус аймгийн хэмжээнд 16 суманд аймгийн төв 1, сумын төв 15 байхаас гадна үйлдвэр дагасан Хялганат тосгон, уурхай дагасан Сайхан-Овоо тосгон, өвлийн улиралд 30-аас дээш өрх суурьшдаг Сээр, Цульхир, Сэлэнгэбүрэн, Тасаг, Уньт, Хонгор, Хантай, Хужир зэрэг суурьшил бүхий томоохон баг, бригадын төвүүд оршдог. Эдгээр төвүүдийн суурьшилийн бүс нь нийтдээ 6340 га газрыг эзлэх бөгөөд үүний цэвэр барилгажсан хэсэг 1552.9 га гэр хороолол 2568.6 га байгаагаас үзэхэд гэр хорооллын газар давамгайлж байна. Хот суурин газарт эзлэх ногоон байгууламж 4.9 га талбайг эзлэж байгаа нь нийт суурьшилийн бүсийн дөнгөж 0.02 %-ийг эзлэж байна. Мөн ашиглалтын явцад элдэв бохирдол, гуу жалга, ухагдаж төнхөгдсөн, элсжсэн зэрэг шалтгааны улмаас 62.3 га газар буюу нийт суурьшилийн бүсийн 1% газар дортойтсон байна. Хотын функциональ бүсүүдийн хил, зааг ялгаа зарим газарт тодорхой ялгарахгүй байгаа учир тэдгээрийг газар ашиглалтын хэм хэмжээнд ялган зааглаж хөгжүүлэх шаардлагатай.

Амралт, рашаан сувиллын газрын зориулалтаар 30 орчим аж ахуйн нэгж нийт 303,1 га газар ашиглагдаж байгаа нь хот тосгон бусад суурингийн ангилалын газрын дөнгөж 1%-ийг эзлэж байна. Одоогийн байдлаар аялал жуулчлал, амралт сувилалын 3 гол бүс нутаг 3 дэд бүс нутаг байдаг бөгөөд хойшид дээрх бүс нутгийн үйл ажиллагааг сайжруулах, бусад үзэсгэлэнт болон түүх дурсгалын газруудад энэ салбарыг өргөжүүлэх боломж бий.

Үйлдвэрийн газар 171,82 га талбай эзэлдэгийн 140 га талбайг зөвхөн Хангал сумын нутагт байрлах ус өргөлтийн байгууламжуудын талбай эзэлдэг. Бусад нь ихэвчлэн Булган хотод төвлөрдөг зайрмаг, ундааны цех, архины үйлдвэр гэх мэт жижиг газрууд бүрдүүлдэг. Харин уурхайн газар 2144 га, үүнээс үйлдвэрийн зориулалттай барилга байгууламжийн дэвсгэр газар 22,58 га, сууршлийн бүсийн барилга байгууламжийн газар 34,56 га байгаа нь бодит байдлаас нилээд зөрүүтэй байна.

2.4. Зам, шугам сүлжээний ангиллын газар, түүний ашиглалт

2.4.1. Зам, шугам сүлжээний ангиллын газрын бүтэц.

Зам шугам, сүлжээний газар нийт 7843 га талбай эзэлдэгээс 38% буюу 2960га нь авто замын газар, 2,9 % буюу 227 га нь агаарын тээврийн газар, 59,3 % буюу 4656га нь шугам сүлжээний газар эзэлдэг бөгөөд уг ангиллын газар ямар нэг өөрчлөлт ороогүй байна. Эдгээрээс шугам сүлжээ, авто замын газар улс ардын аж ахуйд өргөн хэрэглэгдэх ба агаарын тээврийн хувьд иргэний зориулалтын онгоц буухаа больсон.

2.4.2. Автозамын зурвас газар

Авто замын газар 2960 га байгаагаас улсын чанартай зам 861,4 га орон нутгийн чанартай за 2033,1 га, аж ахуй байгууллагуудын дотоодын зам, 55 га, авто тээврийн барилга байгууламжийн газар 10,5 га тус тус байна. Замын сүлжээний байдлыг дор сийрүүлэв.

Авто замын сүлжээний нийлбэр урт 2581,5 км бөгөөд 2005 оны байдлаар 149,5 км хатуу хучилттай, 421,5 км хэсэгчилсэн хайрган хучилттай, ердийн хөрсөн 2010,5 км замтай байв.

Улсын чанартай 4 чиглэлийн 550,5 км авто замын 27,2 % нь буюу 149,5 км нь хатуу хучилттай 48,1 % буюу 265 км нь хэсэгчилсэн хайрган хучилттай, 24,7% буюу 136 км нь ердийн хөрсөн замууд байна. Улаанбаатар хоттой 318 км хэсэгчилсэн хайрган хучилттай сайжруулсан замаар холбогдсон. Булган-Уньт-Хутаг-Өндөр-Хөвсгөлийн хэсэгчилсэн хайрган хучилттай сайжруулсан замыг сүүлийн жилүүдэд арчлаж тордох явдал үгүй болсон тул асар их эвдэрч муудан авто хөсөг замын хажуу талаар нь зорчих явдал түгээмэл болж олон салаа зам үүсэж байна.

Эрдэнэт – Булганы 61 км хатуу хучилттай зам ашиглалтанд орж байгаа бөгөөд энэ замын дагуу 500 м өргөнтэй зурвас газар хүчтэй эвдрэлд ороод байна. Зам барьж байгаа компани нь дуртай газраа карьер үүсгэн шороо чулуу авч байгаагаас гадна хатуу хучилттай замын дагууд хүнд механизмын техник явахад зориулан хөрсийг нь хусан сайжруулсан зам үүсгэснээс гадна зам баригдаж байх хугацаанд Эрдэнэт Булганы хооронд зорчих машинууд маш олон салаа зам үүсгэв.

Авто замын хувьд зөвшөөрөгдсөн албан ёсны замаас гадна олон салаа гаргаж зорчих явдал нэлээд тохиолдох бөгөөд зөвхөн бэлчээрийн газраас гэхэд 64 220 га талбай авто замын нөлөөлөлд орсон баримт бий.

Монголын Иргэний Агаарын Тээвэр нь аймгийн төвд байнгын ажиллагаатай 1 нисэх буудалд 155 га газар, Тэшиг сумын төвд улирлын чанартай 1 нисэх буудалд 72 га газар ашиглаж эдгээрт 227 га газар ашиглаж байна

2.4.3. Инженерийн шугам сүлжээний зурвас газар.

Шугам сүлжээний газар 4656 га бөгөөд үүнээс холбооны шугам, мэдээлэл хүлээн авах станцын эзлэх талбай 1834,8 га, эрчим хүчний шугам станцын эзлэх талбай 2587,5 га, ус дулаан дамжуулах хоолойн эзлэх талбай 162,7 га, ус шахах өргөх байгууламжийн газар 28 га, үерээс хамгаалах далан сувагийн эзлэх талбай 43 га тус тус байна.

Эрчим хүчний сүлжээний байдлыг тодруулбал.

Булган аймгийн эрчим хүчний сүлжээний нийт урт . км бөгөөд эдгээрийн зурвас газарт 2587,5 га газар хамрагдаж байна. Булган хот урагш Хархоринтой 204,6 км, баруун хойш Эрдэнэт хоттой 56,2 км, зүүн хойш Мөрөн хоттой 350 км, Эрдэнэт хот Хялганат тосгонтой 60,8 км газар 110 кВ-ын шугамаар холбогдсон.

Булган- Хархорины 204,6 км урт 110 кВ-ийн шугамын замаас Хишиг-Өндөр рүү 1,4 км, Рашаант руу 60,7 км 110- кВ-ийн шугам татсан. Нийт 110 кВ-ийн шугамын урт 383,4 км.

Эрдэнэт – Хялганатын 60,8 км урт 110-ын шугамын замаас Хангал руу км, Хялганатаас - Сэлэнгийн төв рүү 32,8 км, Атар руу 60,8 урт 10 кВ-н шугамаар холбогдсон.

35 кВ-ийн шугам Бүрэгхангай 38,6 км Хишиг-Өндөр 45 км Могод 46,8 км, Өлзийтийг холбосон, Булган – Хутаг -Өндрийн 136 км шугамын замаас 35 км Сайхан –Овоо руу 35 км Хайрханы руу 44 км, Хутаг-Өндөрөөс Тариалан руу 60 км, замаас нь Тавтын уурхай руу татсан км шугам, Гурванбулаг 80 км Хашаатын 43,7 км шугам, Бүрд 68,8 км Рашаант 62 км Дашинчилэн 26 км Баяннуурын км шугам, Рашаант- Эрдэнэсантын 45 км шугам, нийт урт нь 708,1 км

Булганаас - Орхон руу 20 км, Эрдэнэтээс Бугат руу 45,8 км, 10-кВ-ийн шугам, Сайхан-Овоогоос -28 км Сайхан, 40 км Баян-Агт шугам, Хутагаас Тэшиг рүү 77,3 км, 10 кВ-ийн шугам нийт урт нь 163,3 км урт .

Булган аймгийн нутгаар 110 кВ-ын 733,4 км, 36 кВ-ын 708,1 км 10 кВ-ийн 163,3 км нийт 1604,8 км эрчим хүчний шугамууд байрладаг.

Холбооны шугам, мэдээлэл хүлээн авах станцын эзлэх талбай 1834,8 га байгаа бөгөөд сүлжээг нь дор сийрүүлэв.

Аймгийн цахилгаан холбооны сүлжээ , 850 шахам км тоон технологийн радио релейний шугам, сансрын холбооны ВиСАТ станц, олон улсын сансрын холбооны, газрын ИтелСАТ станц нийт 2797 телефон цэгийн багтаамж бүхий холболтын байгууламж, 250 км шилэн кабелийн сүлжээнээс бүрдэж байна.

Булган-Бугат-Хутаг-Өндөр-Тариаланг холбосон агаарын шилэн кабель, Лүн – Баяннуур -Дашинчилэн шилэн кабель тавигдсан цааш Гурванбулаг - Өгий нуур руу түүнчлэн Дашинчилэн, Хишиг -Өндөр - Орхон – Булган - Эрдэнэтийн чиглэлд төлөвлөгдөж байгаа.

SDH STM – 1 тоон радио релейны шугам Лүн – Баяннуур - Дашинчилэн - Гурванбулаг -Хашаат PDH mbps тоон радио релейны шугам Бүрэгхангай – Орхон – Булган – Эрдэнэт

Дүгнэлт

Зам шугам, сүлжээний газар нийт 7843 га талбай эзэлдэгээс 38% буюу 2960 га нь авто замын газар, 2,9 % буюу 227 га нь агаарын тээврийн газар, 59,3 % буюу 4656 га нь шугам сүлжээний газар эзэлдэг бөгөөд агаарын тээврийн газраас бусад газар нь өргөн ашиглагддаг.

2005 оны байдлаар 149,5 км зам хатуу хучилттай, 421,5 км зам хэсэгчилсэн хайрган хучилттай, 2010,5 км зам ердийн хөрсөн байв. Нийт замын газрын 861.4 га нь улсын чанартай зам, 2033,1 га орон нутгийн чанартай зам байна.

Шугам сүлжээний газар 4656 га бөгөөд үүнээс холбооны шугам, мэдээлэл хүлээн авах станцын эзлэх талбай 1834,8 га, эрчим хүчний шугам станцын эзлэх талбай 2587,5 га, ус дулаан дамжуулах хоолойн эзлэх талбай 162,7 га, ус шахах өргөх байгууламжийн газар 28 га, үерээс хамгаалах далан сувагийн эзлэх талбай 43 га тус тус байна.

2.5. Ойн сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал

Ойн санд ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэрт шатсан, хөнөөлт хорхой шавьж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн захаас гадагш 100 м хүртэлх газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газар багтдаг бөгөөд тус аймгийн нийт нутаг дэвсгэрийн 39.1%-ийг ойн сангийн газар эзэлдэг. Ойн санг ерөнхийд нь ойтой, ойгүй гэж 2 ангилах ба ойтой талбай нь дотроо ойгоор бүрхэгдсэн, ойгоор бүрхэгдээгүй гэж 2 хуваагдана. **Ойгоор бүрхэгдсэн талбай** гэдэгт тухайн судалгааны үед ойтой байгаа талбайг хэлэх бөгөөд **ойгоор бүрхэгдээгүй** талбайд одоогоор ой байхгүй боловч урьд өмнө ойтой байсан цаашид ой ургах болоцоотой газрууд шатсан ой, тармаг мод, ойжих болон ойжуулсан талбай орно. **Ойн бус талбайд** ойн сан доторхи тал хээрийн бүстэй залгаагагүй цагаан энгэр, хадлан, бэлчээр, нуур, намаг, зэрэг газрууд орно.

1999 онд тус аймагт хийгдсэн Ойн хайгуул төслийн төвийн ой зохион байгуулалтын ажлаар нийт **1 982 866 га** талбай байгаагаас /36/:


1 504 141 га буюу 75.8% ойгоор бүрхэгдсэн
 243 131 га буюу 12.3% ойгоор бүрхэгдээгүй
 235 594 га буюу 11.9% ойн бус гэж тус тус тогтоожээ/хүснэгт 20, зураг /.

Хүснэгт 20

Ойн сангийн газрын төрөл

Ойгоор бүрхэгдсэн		Ойгоор бүрхэгдээгүй					Ойн бус	
Байгалийн ой	Бут сөөг	Шатсан	тармаг	огтол сон	Ойжих	Ойж-сан	энгэр	Намаг
1427711	76430	100808	98529	6925	36763	106	3491	19046
72.0%	3.85%	5.1%	4.97%	0.3%	1.85%	0.05%	0.2%	0.96
1504141		243131					235594	
75.8%		12.3%					11.9%	

Ойн сангийн газрын төрөл




Хүснэгтээс харахад байгалийн ойгоор бүрхэгдсэн талбай ихэнхи хувийг эзлэж байгаа боловч түүний хэмжээ 1976 оны үетэй харьцуулахад мод эрчимтэй бэлтгэж байгаагаас 10 111 га талбайгаар багассан байна. Ойжих талбайн хэмжээ ч гэсэн ойн түймэр гарсны улмаас 16 705 га талбайгаар буурчээ. Байгалийн ойг мод тус бүрээр авч үзвэл шинэс, хуш, хус зонхилох ба нарс, бургас, улиангар дагалдах үүлдэрээр орж ирж хайлаас тармаг байдлаар тархдаг онцлогтой. Одоо тэдгээрийн тархац, нөөцийг сум тус бүрээр авч үзье / хүснэгт 21, зураг/.

Байгалийн ойн бүтэц ба нөөц

Д/д	Сумдын нэрс	модны төрөл	Эзлэх талбай		Нөөц	
			Га	Хувь	мян.метр ³	хувь
1	Булган	Шинэс	12896	90.0	1745	95.4
		Хуш	148	1.9	16.1	0.9
		Хус	1225	8.6	67.4	3.7
		Улиангар	8	0.06	0.2	0.01
		Бургас	46	0.3	0.5	0.03
		Бүгд	14325	1.0	1829	0.9
2	Баян-Агт	Шинэс	51726	93.5	7456	96.1
		Хус	3572	6.5	299	3.9
		Дүн	55300	3.9	7755	4.1
3	Бугат	Шинэс	124638	83.0	17492	90.5
		Хус	24840	16.6	1822	9.4
		Бургас	163	0.1	2.2	0.01
		Хайлаас	424	0.2	5.4	0.03
		Бүгд	150065	10.5	19321	10.2
4	Бүрэгхангай	Шинэс	9035	49.3	1281	97.1
		Хуш	186	1.0	31.8	1.7
		Хус	9117	49.7	596.7	31.2
		Бүгд	18338	1.3	1909.7	1.0
5	Могод	Шинэс	5178	22.8	606.7	40.9
		Хус	17370	76.7	874.5	58.9
		Бургас	59	0.26	0.6	0.04
		Улиангар	42	0.12	1.3	0.09
		Бүгд	22649	1.6	1485	0.8
6	Орхон	Шинэс	45920	81.3	6210	90
		Хус	10423	1805	687	9.9
		Хайлаас	36	0.06	0.7	0.01
		Улиангар	54	0.1	1.1	0.02
		Бургас	61	0.1	0.6	0.01
7	Сайхан	Шинэс	11835	81.16	1549.9	89.61
		Хус	2748	18.84	179.7	10.39
		Дүн	14583	1.02	1729.6	0.92
		Шинэс	155979	10.93	24113	68.95
		Хуш	5583	0.39	1032	2.95
8	Сэлэнгэ	Нарс	28418	1.99	3585.4	10.25
		Гацуур	526	0.04	47.9	0.14
		Хус	71445	5.00	6035.4	17.26
		Улиас	299	0.02	21.4	0.06
		Улиангар	291	0.02	11.2	0.03
		Хайлаас	140	0.01	1.4	0.00
		Бургас	6426	0.45	126.2	0.36
		Бүгд	269107	18.85	34973.9	18.54
		Шинэс	386133	81.27	58524	83.92
		Хуш	45257	9.53	7965.4	11.42
9	Тэшиг	Гацуур	305	0.06	24.6	0.04
		Хус	41540	8.74	3147.6	4.51
		Улиас	500	0.11	27.3	0.04

		Улиангар	362	0.08	28.3	0.04
		Хайлаас	34	0.01	0.7	0.00
		Бургас	986	0.21	18.1	0.03
		Бүгд	475117	33.28	69736	36.97
10	Хангал	Шинэс	42990	49.86	5827.4	56.52
		Нарс	21073	24.44	2949.9	28.61
		Хус	19779	22.94	1441	13.98
		Улиас	474	0.55	60	0.58
		Бургас	1902	2.21	31.7	0.31
		Бүгд	86218	6.04	10310	5.47
11	Хишиг-Өндөр	Шинэс	15042	57.44	2222.8	78.20
		Хус	11125	42.48	619.4	21.79
		Бургас	22	0.08	0.4	0.01
		Бүгд	26189	1.83	2842.6	1.51
12	Хутаг-Өндөр	Шинэс	183557	76.70	25837.8	86.58
		Хус	46614	19.48	3800.9	12.74
		Улиас	836	0.35	71.5	0.24
		Улиангар	29	0.01	2.2	0.01
		Хайлаас	1062	0.67	22.7	0.08
		Бургас	6688	2.79	108	0.36
		Бүгд	239326	16.76	29843.1	15.82
13	Нийт дүн	Шинэс	1044933	73.2	152868.4	81.0
		Хус	259798	18.2	19571.3	10.4
		Хуш	51174	3.6	9045.3	4.8
		Нарс	49491	3.5	6535.3	3.5
		Гацуур	831	0.06	72.5	0.04
		Улиас	2109	0.15	180.2	0.10
		Улиангар	786	0.06	44.3	0.02
		Хайлаас	2236	0.016	30.9	0.02
		Бургас	16353	1.15	268.3	0.15
		Бүгд	1427711	100.0	188636	100.0

Жич: Гурванбулаг, Рашаант, Дашинчилэн сумдын 3504 га талбайд судалгаа хийгдээгүй учир талбайг газрын албаны балансаар авч зөвхөн нийт талбайд оруулсан байна.



Зураг, хүснэгт 21-ээс харахад байгалийн ойн 73.2 %-ийг шинэс, 18.2 %-ийг хус, 3.6 %-ийг хуш, 3.5 %-ийг нарс, 0.06 %-ийг гацуур, 0.15 %-ийг улиас, 0.06 %-ийг улиангар, 0.016 %-ийг хайлаас, 1.15 %-ийг бургас эзэлдэг байна.

Ойн нөөц гэдэг нь 1 га ойн ургаа модны ишний нийт эзэлхүүнийг хэлдэг бөгөөд дээр тархсан модны нийт нөөц аймгийн хэмжээнд 188 636 мян. метр³ байна. Уг нөөцийг модны төрөл бүрээр авч үзвэл зонхилох хэсэг нь шинэс, хус, хуш зэрэг модонд ноогдож байна /хүснэгт 21/. Ойн сангийн бүх нөөцийг насны бүлгээр ангилж үзвэл :

Залуу ой 812.6 мян. метр³

Дунд насны ой мян. метр³

Болц гүйцэж яваа 26191.8 мян. метр³

Болц гүйцсэн хөгширсэн ой 128 645.8 мян. метр³ тус тус оногдоно.

Насны бүлгийн хувьд 68.2 %-ийг болц гүйцсэн хөгшин ой, 13.9 % нь болц гүйцэж яваа, 17.6 % нь дунд насны, 0.4 % нь залуу ой байгаагаас үзвэл нь дээрх ой насны зөв биш бүтэцтэй болсон байна. Иймд болц гүйцсэн хөгшин ойг модлогын чанар муудахаас өмнө экологи-эдийн засгийн ач холбогдлыг алдагдуулахааргүй огтлолтыг зөв арга технологиор хийх, нөгөө талаар зөв бүтэцтэй ойжуулах ажлыг эрчимтэй хийхийг байдал зүй ёсоор шаардаж байна.

Ойн хэв шинжийн хувьд өндрийн бүс бүслүүрээр тогтоосон ангиллаар тус аймгийн Эгийн голоос хойш өөрөөр хэлбэл Тэшиг сумын ойн сан нь Өвөр байгалийн ой – ургамалжилтын мужийн Жидийн хошуунд, бусад сумдын ойн сан нь “Хангайн ой-ургамалжилтийн муж”-ын Зүүн өмнөт хангайн хошуунд хамрагдана.

Ойн ашиглалт. Булган аймгийн ой нь ерөнхийдээ үйлдвэрлэлийн ач холбогдолгүй хамгаалалтын шинж чанартай учир зөвхөн Тэшиг, Сэлэнгэ, Хутаг-Өндөр сумдын 83 476 га талбайн 13 143 мян. метр³ нөөц бүхий ойд жилдээ 35.9 мян. метр³ мод огтолохоор аймгийн хэмжээнд төлөвлөгддөг. Бусад сумдын ойн хувьд хамгаалалтын бүсийн шинж чанартай учир ойг огтолж ашиглахаас өмнө нөхөн сэргээх, тарьж ургуулах үйл ажиллагааг нэн тэргүүнд явуулах хэрэгтэй. Энэ нь ойг огт ашиглахгүй гэсэн үг биш хөгширч нас гүйцсэн ойг огтлох бусад дагалдах баялагийг хэм хэмжээнд нь ашигладаг. Ер нь тус аймгийн хэмжээнд ойг ашиглалт талаасаа биш, ойг хамгаалах, нөхөн сэргээх талаас нь ойн менежментийн бодлого явуулах хэрэгтэй. Аймгийн статистик мэдээнээс харвал сүүлийн 3 жилд зүсмэл, материал мод модон эдлэлийн үйлдвэрлэл эрс багассан төдийгүй 2005 онд зүсмэл материал огт үйлдвэрлээгүй байна. Гэвч Хялганат тосгонд мод бэлтгэлийн аж ахуй задарснаар олон хөрөө рам зөвшөөрөлгүй ажиллаж тэдгээр нь өөрсдөө мод бэлтгэдэггүй ч ашиг олох үүднээс хувь хүмүүсээс хулгайгаар бэлдсэн модыг худалдан авч зүсмэл материал бэлдсэнээс нарсан ойд ихээхэн хохирол учруулж байгааг үгүйсгэх аргагүй юм. Цаашид зөвхөн зайлшгүй хэрэгцээт түлээний мод, бусад дагалдах баялагийг ашиглах замаар ойн ашиглалтыг хязгаарлах хэрэгтэй байна.

Ойг хамгаалах. арга хэмжээнд ойг гал түймэр, хөнөөлт хортон шавьж, өвчин болон тэдгээртэй тэмцэх, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөөс хамгаалах, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, ойн хэвийн өсөлт нөхөн сэргэлтийг хангах, удмын санг хамгаалах арга хэмжээнүүд багтана. Аймгийн ЗДТГ, БОАлбанаас ойг ашиглах, хамгаалах хэтийн болон ойрын төлөвлөгөө боловсруулж ажилдаг. Тус аймгийн нутагт 1997-1999 онд Ойн хайгуул төслийн төвөөс ойн судалгаа, ой зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд уг ажлаар арчилгааны огтлолтыг нийт 24 648 га талбайд, цэвэрлэгээний огтлолтыг бүх

насны ангид, 78739 га талбайд хийх шаардлагатай гэжээ. Мөн түүнчлэн нийт 100 808 га талбай шатсан бөгөөд түүний дийлэнхи нь Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хутаг-Өндөр сумын нутагт гарсан байна. 2004 онд Ой, усны хайгуул судалгааны төвөөс 60 мян.га талбайд судалгаа хийхэд нийт талбайн 70 %-д хөнөөлт шавьж тархсанаас 85 % буюу 35 700 га-д өрөөсгөл хүр эрвээхэй, 10 % буюу 4 200 га-д сибирийн хүр хорхой, үлдсэн талбайд бийрэн сүүлт, Якобсоны төөлүүрч, шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэй болон иш, модлогын хөнөөлт шавьж тархсан нь тогтоогджээ. Иймд аймгийн ЗДТГ, БОАлбаны захиалгаар нийт 4250 га талбайд хортон шавьжийн устгал хийсэн байна. Үүний Сайхан сумын 450 га, Хишиг-Өндөр сумын 800 га-д орон нутгийн хөрөнгөөр, Тэшиг, Хангал, Сэлэнгэ сумын 1 000, 1 000 га талбайд улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр тэмцлийн ажлыг хийжээ. Цаашид *ойжуулалтын ажлыг* 79 226 га талбайд, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг 89 613 га талбайд нийт 168 839 га талбайд дээрх 2 төрлийн нөхөн сэргээх ажлыг хийх шаардлагатай байгаа бөгөөд юуны өмнө ой ургаж байгаад гадны нөлөөгөөр ойгүй болсон талбайд эхлэн хийх хэрэгтэй байна. Учир нь ойгүй болсон газар хээрших процесс эрчимтэй явагдаж мод ургах экологийн нөхцөл алддаг учир аль болох хурдан хугацаанд нөхөн сэргээх ажлыг хийх хэрэгтэй.


Дүгнэлт

1. Тус аймгийн ой нь *насны бүлгийн хувьд* 68.2%-ийг болц гүйцсэн хөгшин ой, 0.4% нь залуу ой эзлэж насны зөв биш бүтэцтэй болсон учир хөгшин ойг модлогын чанар муудахаас өмнө огтлолтыг зөв хийх, нөгөө талаар зөв бүтэцтэй ойжуулах ажлыг эрчимтэй зохиох хэрэгтэй байна.
- 2.Тэшиг, Сэлэнгэ, Хутаг-Өндөр сумдын ойгоос бусад сумдын ой нь хамгаалалтын бүсийн шинж чанартай учир ойг огтолж ашиглахаас өмнө нөхөн сэргээх, тарьж ургуулах үйл ажиллагааг нэн тэргүүнд явуулах хэрэгтэй.
3. Аймгийн хэмжээнд жилдээ 35.9 мян. метр³ модыг түүвэрлэх аргаар огтлож ахуйн хэрэгцээнд ашиглах боломжтой.
4. Аймгийн хэмжээгээр нийт 10 808 га талбай түймэрт шатаж , 39 900 га талбай хортонд идэгдсэн учир юуны өмнө 79 226 га талбайд ойжуулалтын ажлыг нэн даруй хийх шаардлагатай.
5. Хулгайгаар мод бэлтгэх явдлыг бүрмөсөн зогсоох, элдэв төрлийн мод огтлолтыг тусгай зөвшөөрлөөр зөвхөн мэргэжилийн байгууллагаар хатуу хяналтан дор хийлгэх.
- 6.Гал түймэрээс урьдчилан сэргийлэх ажлыг хүчтэй болгох, хортон тархсан талбайд нэн даруй химийн хор цацах, устгал хийлгэх.

2.6. Усны сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал

Усан сан бүхий газарт гадаргуугийн усны эзлэж байгаа талбай, мөнх цас, мөсөн гол, түүнчлэн усны нөөц чанарыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай усны эрэг орчмын /хөвөө/ зурвас газар багтдаг. 2005 оны газрын тоо бүртгэлийн материалаас үзвэл усан сан бүхий газар нь нийт 22 232.07 га талбай эзэлдэгээс гол мөрөн 12370 га, нуур цөөрөм 9126 га, булаг шанд 736 га байна. Энд гол мөрөнгийн талбай ширгэж хатсанаас 7.23 га талбайгаар хорогдсон дүн гарчээ /зураг/.

Усан бүхий газрын бүтэц



Усны нөөц. Булган аймаг Сэлэнгэ мөрний ай савд багтах бөгөөд усны нөөц сайн ангилалд багтдаг Хангайн аймгуудын нэг юм. Аймгийн хэмжээгээр 5501 км урт 388 гол, горхи, 37 булаг, шанд, 71 том жижиг нуур бий.

Улсын дунджаар 1км² талбайд ногдох ашиглаж болох усны хэмжээ 22000 м³ байдаг бол Булган аймагт 26000-124000 м³ болж элбэг устай зэрэглэлд багтдаг юм. Нэг хүнд ноогдох усны нөөц 50,1 мянган шоо м байгаа нь дэлхийн дунджаас 4.5 дахин их үзүүлэлт юм.

Гадаргын усны нийт нөөц 1,75 шоо км, үүнээс ашиглаж болох нөөц нь 0,881 шоо км, газрын доорхи усны нийт нөөц 0,5 шоо км, үүнээс ашиглаж болох нөөц нь 0,25 шоо км, нийт усны нөөц 2,25 шоо км, үүнээс ашиглаж болох нийт нөөц нь 1,131 шоо км байна.

Гэвч гадаргын усны нөөцийн эдгээр хэмжээ харьцангуй ойлголт бөгөөд жилийн урсацын 70 гаруй хувь Хойд мөсөн далайд урсан оддог өвөрмөц онцлог бас бий. Өвөл хаврын хүйтэн сэрүүнд ил задгай ус хөлдөж ашиглах аргагүй болдог нь газрын доорхи усыг ашиглахад хүргэдэг агаад энэ нь хөрөнгө хүчний хомсдолоос ихээхэн хязгаарлагдаж усан хангамжийн дутагдалд автах тал ажиглагддаг байна. Булган аймаг хэдийгээр байгалийн усан хангамж сайтай боловч нийт ус хэрэглээний 80 гаруй хувийг газрын доорх уснаас ашигладаг байна. Усны нөөцийг зохистой ашиглах замаар бүс нутгийн эдийн засгийн хүч чадлыг нэмэгдүүлэх, мал аж ахуй, усалгаатай газар тариалан, жимсний аж ахуй хөгжүүлэх, усны эрчим хүчийг ашиглах өргөн боломж байгаагаас гадна аялал жуулчлал хөгжүүлэх боломж бас бий.

Булган аймгийн нутагт тогтмол урсгал бүхий гол горхи уулнаас мултарч тал газраар урсахдаа сэвсгэр хурдсанд ширгэж усаа алдах, бүр мөсөн хатаж ширгэх явдал олонтой тохиолдоно. Мөн шургаж алга болдог болон урсгалынхаа явцад 1-2 удаа шургадаг гол горхи цөөнгүй байдаг. Хангайн нурууны голууд хур борооны усаар /50-60%/ зонхилон тэжээгддэг. Харин цас мөсний хайлбар ус урсацын бүрэлдэхүүнд үлэмж бага хувийг эзэлдэг. Хаврын шар усны үерлэлт сав газрын дундаж өндрөөс хамаарч аймгийн нийт нутагт харилцан адилгүй хугацаанд явагддаг. Нутгийн зүүн, зүүн урд, урд талын голууд дээр шар усны үер 3-р сарын сүүлээс 4-р сарын дунд хүртлэх хугацаанд ажиглагдаж байхад, нутгийн баруун талаар /Сайхан Баян-Агт сумын нутагт /арай хожуу эхлэж 5-р сарын дунд үе дуустал ажиглагддаг байна. Шар усны үерийн хамгийн их хэмжээ жижиг голууд дээр 5-р сарны эхээр ажиглагдах ба зарим жижиг гол горхи, булгууд дээр нилээд эрчимтэй явагдаж жилийн хамгийн их урсацынхаа хэмжээнд хүрдэг. Хаврын шар усны дараагаар усны түвшин аажмаар буурч гачиг үе эхлэж, 6-р сарын сүүлч хүртэл үргэлжилнэ. Хур борооны үер 7-р сарын эхээр эхлэж 8-р сарын сүүлчээр дуусна. Хур борооны үерийн энэ үед голууд жилийн хамгийн их урсацынхаа хэмжээнд хүрдэг. Намар 9-р сарын дунд үеэс усны түвшин багасч 10-р сарын шувтаргаар

хөлдөж, 140-160 хоног мөсөн бүрхүүлтэй байдаг. Цасны нөөц ус Хангайн нурууны хойд хажуу, Хөвсгөлийн уулархаг нутагт 2-р сарын 2, 3 дугаар 10 хоногт хамгийн их хэмжээндээ хүрч дунджаар 20-30 мм зузаан болдог.

Томхон голуудын усны судалгааг хүснэгт 22-оор харуулав. Энд эрэг орчмын газрыг тогтоохдоо голын уртыг 50 м өргөнөөр үржүүлж авлаа.

Хүснэгт 22

Гадаргын усны судалгаа

Гол нуурын нэр	Эзлэх талбай, км ²	Эрэг орчмын газар	Усны чанар
	Усан толио		
1. Сэлэнгэ мөрөн	282050	593км*0.05км	Цэнгэг, нөөц сайтай
2. Эг гол	42400	535км*0.05км	Цэнгэг, нөөц сайн
3. Үүр гол	12250	338км*0.05км	Цэнгэг, нөөц сайн
4. Орхон гол	132855	1124км*0.05км	Цэнгэг, нөөц сайн
5. Хануй	5172		Цэнгэг, нөөц сайн
6. Туул	46000		Цэнгэг

Хүснэгт 23

Гүний ус ашиглалтын судалгаа*

Худгийн төрөл	Газрын байршил	Усны нөөц	Ашиглалтанд орсон он	Ашиглалтын өнөөгийн байдал
Гүн өрмийн/ Моторт/ Эргүүлэгт	Сум, бригадын төв	27	1970-1980	Дунд зэрэг
	Хөдөө бэлчээрт	32	1970	Дунд зэрэг
Гар худаг	Хөдөө бэлчээрт	19	1970	Дунд зэрэг

Эдгээр худгууд нь 1970-1980 оны үед бэлчээр усжуулалтын ажлын хүрээнд хийгдсэн худгууд бөгөөд одоо ашиглалт төдийлэн сайн биш, одоо ажиллаж байгаа нийт 78 худаг байгаа бөгөөд энэ нь тэр үед ажиллаж байсан худгийн дөнгөж тал хувь юм. Иймд усжуулах ажлын хүрээнд юуны өмнө эвдэрсэн худгуудыг засч сэлбэн ажилд оруулах хэрэгтэй. Ирээдүйд усны эрчим хүчийг амьдрал ахуйдаа өргөн ашиглах нэг том ажил бол Эгийн гол дээр усан цахилгаан станц барихаар төлөвлөж байгаа явдал юм.

Усны бохирдол. Булган аймгийн нутаг дээгүүр урсах гол мөрөн ерөнхийдээ урсац сайтай Хангайн нуруунаас эх авсан цэнгэг устай түргэн урсгалт голууд байдаг нөгөө талаас тэдгээрийг аж ахуйн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах явдал харьцангуй бага зөвхөн хүн малын унд, ахуйн хэрэгцээнд ашигладаг учир харьцангуй бохирдол багатай. Гэвч сүүлийн жилүүдэд Бүрэгхангай сумын нутагт алт олборлох явдал газар авснаас Туул голын усыг энэ зорилгод ашиглаж гольдрилыг нь өөрчлөх, хэмжээг багасгах улмаар бохирдуулах явдал гарах болсонд зохих байгууллагууд анхааран ажиллах хэрэгтэй байна. Мөн түүнчлэн сумын төвүүд дээр байдаг усан сан болон гүний усанд гэдэсний эмгэг үүсгэгч савханцар болон бусад элементүүд илэрсэн дүн бий / Булган сумын усан сан, Хишиг-Өндөр, Сэлэнгэ сумын төв дээрх гүний худаг г.м/.

Дүгнэлт

Булган аймгийн нутаг дэвсгэр дээгүүр манай орны хамгийн их устай үлэмж их ус хураах талбай бүхий Сэлэнгэ мөрөн түүний томоохон цутгал Эг, Орхон, Туул, Хануй голууд дайрч өнгөрдөг бөгөөд Сэлэнгэ мөрний ай савд багтаж 5501 км урт 388 гол, горхи, 37 булаг, шанд, 71 том жижиг нуурыг агуулдаг. Энэ утгаараа усны нөөц сайтайд тооцогддог.

Нэг хүнд ноогдох усны нөөц 50,1 мянган шоо м байгаа нь дэлхийн дундажаас 4.5 дахин их үзүүлэлт юм.

Дээрхээс үзэхэд байгалийн усан хангамж ялангуяа хойт талын нутгаар хангалттай болох нь харагдаж байна. Харин инженерийн хийцийн усан хангамжийн хувьд төдийлэн сайн биш, социализмын үед баригдсан худгуудын дөнгөж тал хувь одоо ажилладаг. Цаашид усны нөөцийг улс ардын аж ахуйд өргөн ашиглах боломжтой.

2.7. Тусгай хэрэгцээний ангиллын газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал

2.7.1. Тусгай хэрэгцээний ангиллын газрын бүтэц

Улсын тусгай хэрэгцээний газар нь нийт 144 981 га газар эзэлдэгээс улсын тусгай хамгаалалттай газар 52790 га, улсын хилийн зурвас 79164 га, улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 3504 га тус тус байдаг бөгөөд уг ангиллын газар одоогоор өөрчлөгдөөгүй байна.

2.7.2. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.

Булган аймгийн нутагт улсын тусгай хамгаалалттай дараахи газрууд байна.

1. Уран тогоо, Тулга уулын байгалийн дурсгалт газар

Уран-Тогоо-Тулга уул нь манай орны ойт хээрийн бүсэнд орших үзэсгэлэнтэй уулс бөгөөд 1965 онд дархалсан байна. Эдгээр уулс өвөрмөц тогтоцтой, сөнөсөн галт уулс бөгөөд талбайн хувьд үлэмж бага буюу үндсэндээ дээрх галт уулсын тогоо хамгаалагдаж ирсэн. Энэ нь дархан газрын экологийн бүхэл бүтэн орчныг хамгаалах шаардлагатай зохих ёсоор зөрчилдөж байсан юм. Тусгай хамгаалалттай газар нутгийн шинэ ангилалаар галт уулын өвөрмөц онцлогийг хамгаалах зорилгоор дархалсан явдал дархан газрын шаардлагад тохирохгүй байсан учраас УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолоор байгалийн дурсгалт газар болгосон байна. Нийтдээ 5800 га талбайтай. Уран-Тогоо-Тулга уул нь Хангай Хэнтий уулархаг их мужид хамаарах Орхон-Сэлэнийн савын бэсрэг намхан уулын дэд хэв шинжид багтана. Урангийн хөндий гэдэг 1420-1450 м үнэмлэхүй өндөр бүхий уудам талд, хоорондоо 6-7 км зайтай орших энэхүү Уран-Бүрхээр хийгээд Тулга-Их Тогоо-Жалавчийг ойт хээр голлосон Дулаан хаан (2058 м) Шитийн овоо, Шантын ам, Хавиргын Эрээн 1864 м Мэргэн хөтөл, Морин-Ширээ, Сэрүүн хөтөл, Индэрт (1850 м) Хавчингийн даваа, Рашаант өндөр (1922 м) Цийлингийн нуруу зэрэг өндөр уулс хүрээлнэ.

Тулга уулын үнэмлэх өндөр 1540 м, харьцах өндөр 140 м орчим, тогоо нь зүүн хойшоо, урагшаа, баруун хойшоо сэтрэн элэгдэж эвдрээд тулганы чулуу маягтай, гурван хэсэг дугуй ханан уул болон үлджээ. Хойт талын дугуй хана хамгийн намхан, зүүн талын дугуй хана хойд хэсэгтээ шовх нилээд өндөр урт, баруун урд талын дугуй хана мөн нилээд өндөр, урт бөгөөд тус тус дугуйран ханалж оршино. Хэрэв Тулгын тогоо бүтэн байсан бол амсар дээгүүрээ эргэн тойрон 1200 м орчим байжээ.

Их тогоо уулын үнэмлэх өндөр нь 1620 м харьцах өндөр нь 180 м бөгөөд тогоон дотроо жижиг цөөрөм байдаг. Их тогоо уул нь тогоо дотроо давхар тогоотой байгаа нь нэгэн үе оргилохоо зогссоноо хоорондоо урт удаан хугацаатай хоёр дахин давхар их идэвхитэй оргилсныг гэрчилнэ.

Жалавч уулын үнэмлэх өндөр 1560 м харьцах өндөр нь 120 м орчим байна. Жалавчийн тогоо нь урагшаа их сэтэрхийнүүд мэт өргөн чөлөө гарсан ба баруун тийшээ бага зэрэг сэтрэн эвдэрч намхан нахис болжээ. Жалавчийн тогооны амсрын ихэнх хэсэг нь болох зүүн урд үзүүр хамгийн өндөр оргил нь болно. Унтарсан галт уул Уран-Бүрхээр, Тулга- Их Тогоо - Жалавч унтарсан галт уулс хавийн геологийн тогтоц нь Умард Монголын атриат уулсын буюу Байгаль нуур орчмын атриат уулсын тогтолцоонд багтана. Үндсэн чулуулгийн бүрэлдэхүүнд триасын галавын дунд, дээд, үеийн андезитэт, трахиоандезитэт толболжин (порфир), мөлгөр хөрзөн хийгээд юрийн галавын дунд дээд, үеийн чулуулгаас андезит хүрмэн чулуу, мөлгөр хөрзөн, түүнчлэн чулуун нүүрсний галавын үеийн нүүрслэг занар, хувирмал занар зэрэг чулуулаг голлон зонхионо.

Уран-Бүрхээр болон Тулга-Их Тогоо-Жалавч нь гуравдагч галавын сүүлч миоцен, плиоценийн үеэс дөрөвдөгч галавын голоцений үе хүртэл удаа дараа дэлбэрэн оргилж тогтсон галт уул Уран-Бүрхээр нь барагцаалахад хоёр түмээс хоёр түм таван мянган жилийн тэртээ хүрч иртэл оргилж байгаад унтарчээ. Уран бүрхээрийн чанх ар шилд залгаа орших модтой өндөрлөгүүд нь Урангаас түрүүнд бүр эртний галт уул байжээ. Түүнчлэн Тулгын баруун урд хормойд хамгийн эрт түрүүчийн галт уул байсан мөр тэмдэг болох дугуй цар бүдэгхэн, харин Их Тогоо уулаас урссан хүрэм Жалавчийн хүрмийг дарсныг үзэхэд энэ уул хожуу унтарсан байдал харагдана.

Уран бүрхээр, Тулга - Их Тогоо - Жалавч энэ хоёр дархан газрын орших газар нутаг нийтдээ ойт хээр, уулт хээрийн нилээд сайн үржилт хар хүрэн, хар шороон хөрстэй учир хээрийн ба ойт хээр, уулт хээрийн бүсийн дундаж уулс зэрэг газраар голчлон тархаж ургасан алаг өвс нугалаг хээр, үет ургамал алаг өвст нугат хээр болно. Энэ нутгийн түгээмэл дэлгэрсэн ургамалд ботууль, хиаг, ерхөг, агь, хялгана, согоовор, дааган сүүл, биелэг өвс, тэргүүнтэн шим тэжээлтэй өвс ногоо орно. Уулсын ар гол төлөв шинэсэн ойтой. Шинэсэн ой энэ хавийн уулсын арыг битүү, энгэрийг алаг цоог хучих боловч сүүлийн хэдэн арван жилийн дотор уулын энгэр, хажуу, бэл рүү зулзаган мод хучиж байна. Энэ нутгийн ойд шинэснээс гадна улиас, хус бий. Уулсын энгэр ам хөндий, гуу жалгын хадархаг газраар хайлаас ургана. Ойн чөлөө цоорхой, уулсын ар энгэр, хажуу хормой, гуу жалга, ойн зах, асга хад зэрэг газраар хулсан торлог, нохойн хушуу, гандигар, хад балгана, тавилгана, яргай, чаргай, алтан харгана, нохойн шээрэн гэх мэт сөөг ургамалтай. Мөн цагаан төмс, мангир, алтанзул, алтан гагнуур, тайжийн жинс, далан түрүү, үхэр гоньд, хунчир, хөвөн оройт, монгол туйплин, эмийн болон хүнсний ургамал, навтуул хурган засаа, үнэгэн сүүл, хонхон цэцэг, бэр цэцэг, хазаар өвс, шар шийр биелэг өвс, бугын зогдор, улалж, улаан толгой, далан товч, зэрэг ургамалтай.

Дурсгалт газар нь тус орны эх газрын эрс тэс ширүүн уур амьсгалтай бөгөөд тэнд амьтны аймгаас хэвлээр явагчид могой хамгийн элбэг юм. Хүйтэн улиралд эдгээр галт уулын гүний дулаан бүлээн уур хийн илчинд хорогдож ичиж амьдардаг. Хөхтөн мэрэгчдээс тарвага, зурам, бор туулай, үхэр огдой, хөвдний бор оготно гэх мэт амьтад байран оршино. Эдгээр ууланд байнга байдаг нутгийн шувуудаас ятуу, бор шувуу, ууль харцага, буцдаг шувуунаас ангир, хөхөө, өвөөлж байна. Урангийн тогооны нуурт ангир тогтмол ирж суурьшдаг.

Байгалийн дурсгал болсон энэ хоёр үзэсгэлэнт газарт бас дугуй дөрвөлжин хэлбэртэй булш, хиргисүүрийн өгөршсөн боржин чулуу хөшөө бий. Тулгын тогоон дахь голын хиргисүүрээс хойш дөрвөлжин булш 10 байна. Үүнээс гадна

Тулгын зүүн хойд ар болон баруун сугын товцог толгой, Их Тогоо уулын хавь газарт булш, хиргисүүр нилээд бий.

2. Хөгнө-Тарны байгалийн цогцолбор газар

Хөгнө хан уул нь Булган аймгийн Гурванбулаг, Рашаант сумдын нутгийн заагт, Орхон, Сэлэнгийн ай савын бэсрэг уулсын өмнөд хэсэгт нуур голоос нилээд тусгаар байдалтай орших, тайгын болон хээрийн ургамал, амьтан нэг дор оршин амьдардгаараа ихээхэн онцлогтой уул юм. Иймээс ландшафтын иж бүрдлийн хослол, экосистемийн өвөрмөц төрхийг хамгаалах зорилгоор 1997 онд 46990 га талбайг байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авсан юм. Хөгнө хан уулыг эрт дээр үеэс "хан" хэмээн шүтэн хамгаалж ирсэн бөгөөд энд тахилгын овоо, сантын овоо, бага ханы овоо зэрэг тахилгатай. Гэсэн ч Хөгнө хан уулын байгалийн сайханыг үзэж сонирхох гэсэн аялагч жуулчид ихэссэний зэрэгцээ түүнд үйлчлэх зорилготой аялал жуулчлалын бааз олноор байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Хүн мал машин техникийн хөдөлгөөн ихэсч ургамал бэлчээрийг талхан мод жимсийг хайр найргүй түүх, амьтан агнах, байршлыг алдагдуулах, ховор ургамал ялангуяа "Хөгнө, Тарны" гэж олонд алдаршсан яргайг огтчин сүйтгэж байгаатай холбоотой 2003 онд тусгай хамгаалалттай газрын ангилалыг дээшлүүлэн зохион байгуулалттай аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилго бүхий Хөгнө-Тарны байгалийн цогцолбор газар болгосон байна. Нийтдээ 84390 га талбайг эзэлнэ.

Хөгнө-Тарны байгалийн цогцолбор газар нь Төв, Өвөрхангай, Булган аймгуудын хилийн заагт орших бөгөөд байгалийн мужлалаар Хангай – Хэнтий уулт их мужид хамрагдана. Энэ нутгийн гадарга нь Орхон –Туулын савын 1500-2000 м өндөртэй бэсрэг, нам уулс, цав толгод, тэдгээрийн хооронд орших талархаг гадарга бүхий тогтоцтой. Энд Хангайн гол нурууны дорнод шувтарга зүүн үзүүр болох Батхаан, Дэлгэрхаан, Үст буурал, Аргал, Угалз-Гурван өндөр, Хөгнө ханы уулсын системд багтах Цэцэрлэг, Эрдэнэ-Өндөрийн нуруу зэрэг бэсрэг уулстай. Уулсын хажуу хэм тэгш бус, өөрөөр хэлбэл өвөр нь нилээд эгц цавчим, богинхон бэлтэй байхад ар нь уужим тавиухан урт бэлтэй.

Батхааны ар, өвөр хормой хааяа уулс нилээд өндөр бөгөөд өвөр хормойн Лүнгийн хавчиг Аянгын хавчиг зэрэг уулс нь 1700-1800 м ар хормойн Тогоот, Улаанхад Хуягт зэрэг уулс нь 1900 м өндөрт хүрнэ. Харин Хөгөнханы уулын системд хамрагдах уулс нь харьцангуй нам, хамгийн өндөр оргил нь Цэцэрлэг 1968.8 м өндөртэй. Түүний захын хамгийн нам уулс цав толгод 1300-1500 м өндөртэй.

Энэ нутагт орших уулс нь эрт болон дунд төмрөлийн эриний үед өргөгдөн үүссэн Монгол Амар мөрний савын атриат уулсын тогтолцоонд багтах ба эрт төрмөлийн дунд үеийн элсэн чулуу, хувирмал занар, аргиллит, боржин, асмалжин, боржин-сиенит, мөлгөр хөрзөн, гантиг зэрэг асар их хувирсан хурдас чулуулаг болон маш зузаан хүчиллэг бялхмал чулуу зонхилно. Геологийн түүхэн хөгжлийн явцад тектоник үйл явцын нөлөөгөөр гүний ан цаваар ихээхэн хэрчигдсэн, түүнийг дагаж дэл судал ихтэй, түүндээ усан, утаат даралтат болор, молор эрдэнэ, хар, цагаан, ягаан, халтар гялтгануур, соронзон гүр, гянт, өнгө бүрийн аргай, жонш зэрэг ашигт малтмалын төрлийн зүйлс элбэг. Хөгнөхаан уул нь ухаа цайвар боржингоос ихэнхдээ тогтжээ.

Хөгнө хан болон түүний орчны уулсын ам хөндийгөөс хамгийн том нь Тарнын гол хөндий юм. Тарнын голд зүүн талаас нь Чулуутын гол нийлэх бөгөөд Тарнын гол зүүн урдаас баруун хойш урсаж Харухын голд цутгаж улмаар Туул голд усаа өгнө.

Тарнын голын зүүн биеэр зүүн урагш 80 орчим км урт үргэлжилсэн "Их Монголын элс" хэмээх элсэн тарамцаг орших бөгөөд энэ нь монгол орны хойд (Хангайн) хэсгийн элсний тал хувиас илүүг (58.3%) эзэлдэг.

Энэхүү томоохон элсэн хуримтлал нь Тарнын голын эх болох Шарлин. Жаргалант голуудын бэлчир, Их Монгол уул (1675.0м) орчимд хамгийн өргөн (9-10 км) бөгөөд энд хааяа зах орчмоороо хэсэг бүлэг бөөгнөрөл үүсгэн тарна. Элстийн голын гольдрол даган Чулуутын овоо (1525.9 м) - ноос доош бараг Булган аймгийн Гурванбулаг сумын төв хүртэл нарийн зурвас (3.5 км) байдлаар үргэлжилнэ. Молцог элс нь ургамлаар бат бэхлэгдсэн учир нүүлт хөдөлгөөнд өртөх нь бага боловч сүүлийн жилүүдэд бэлчээрийн даацаас хэтэрсэн мал бэлчээх, элсний ургамлыг зүй бусаар ашигласнаас нүүлт хөдөлгөөнд орж байна.

Ландшафтын хувьд уулын ой, уулын хээр зэрэг бүслүүрлэг хэв шинжүүдээс гадна бүслэг шинжтэй умардын хуурай хээрийн ландшафт, бүсийн бус татмын нугын ландшафт тархана.

Ус зүйн сүлжээгээр тус нутаг нь Умард мөсөн далайн ай савд багтана. Хөгнө ханы районд гол мөрний сүлжээ багатай. Уулын ар өврөөс эх авдаг гол мөрөн байхгүй. Хамгийн том гол нь түүний баруун бэл хормойг эмжин тогтсон Монгол элсний баруун талаар Хангайн нурууны гол нь түүний баруун бэл хормойг эмжин тогтсон Монгол элсний баруун талаар Хангайн нурууны зүүн хэсгийн бэсрэг уулсын нэг болох Зүүн Хайрхан уулын умарт биеэс эх аван урсах Тарнын гол урсаж Туул голын зүүн гараас цутгах бөгөөд энэ гол нь Орхон-Туулын мужийн ай савд багтана. Тарнын голын баруун гараас Ар Жаргалант, Чулуут зэрэг голууд цутгадаг. Ууландаа гол горхи бараг байхгүй, харин гүний усны нөөц сайтай олон булагтай.

Тус район нь хөрс-газарзүйн мужлалтаар Орхон-Туулын мужийн бүсийн хэв шинжит хар шороон хөрс зонхилсон Дашинчилэнгийн тойрогт багтана. Хөгнө хан, Батхаан орчмын усан хагалбар уулсын орой хяр, ар хажуугаар 1800 метрээс дээш өндөрт уулын ширэгт-тайгын, түүнээс доош ойн зах хүртэл уулын ойн бараан хөрс тус тус тархана. Харин захын харьцангуй нам 1600-1800 м уулсад өтгөн өвслөг ургамалтайхусан ойд уулын нугат ойн хөрс тархах бөгөөд энэ хөрсний тархалтын хүрээнд харьцангуй эгц хажууд уулын ойн бараан хөрс хоршил үүсгэж тогтворжсон байдаг. Ам хөндийн хөрснөөс нимгэн давхрагатай сайн чулуурхаг хар шороон хөрс тархжээ. Мөн элсэнцэр хар хүрэн хөрс Хөгнө-Тарны элсний хоёр талаар харьцангуй өргөн зурвас талбайд тархана. Цогцолбор газарт нугын хөрс булаг, шанд гол, горхины гольдрол дагуу чийгсэг алаг өвс, цахилдагт бүлгэмдэл доор тогтворжино.

Энэ нутагт ой хээр, хээр зонхилдог тул ургамал нөмрөг нэн баялаг төдийгүй манай орны ойн тархалтын өмнөд хэсэг болдгоороо онцлог юм. Ойн бүтцийн хувьд авч үзвэл голуудын хөндийгөөр бургас, моносон шугуй, Хөгнөхаан уулын ар, бэл хормойгоор шинэс, шинэс-хусан холимог ойтой, оройгоороо хуш ургана. Эндэхийн хушин ой Хангай Хэнтийн хушин ойгоос хааш хаашаа 200 гаруй км алслагдсан тул хушин ой тус нутагт эндемикт тооцогдоно. Уулын асга, хөндий жалгаар хайлаас харгана зэрэг мод буттай, Хөгнө хан ууланд гуравдагчийн үеийн үлдвэр ургамал, унаган, субэндемик, нэн ховор, ховор 17 зүйл, элбэг 399 зүйл тархдаг. Эдгээрээс "Монгол улсын улаан ном"-д (1997) 7 зүйл ургамал орсон. Ургамлын аймаг аж ахуйн ач холбогдлоор баялаг. Энд 100 гаруй зүйл эмийн, 100 гаруй зүйл хадлан, бэлчээр тэжээлийн, 80-д зүйл үнэртний, 10-аад зүйл жимс жимсгэний 5-6 зүйл цайны ургамал болон цагаан төмс, мэхээр, сонгино, цагаан мангир зэрэг 3-4 хүнсний ургамал ургадаг ажээ.

Цогцолбор газрын бэсрэг уулсаар буга, гөрөөс гахай, мануул, үнэг, хөрс, чоно, дорго, өмхий хүрэн, туулай зэрэг амьтадтай. Мөн дагуурын дараа, сахалт багваахай, жижиг соотон багваахай, урт сүүлт зурам, хадны барагшин, орог зусаг, үлийн цагаан огтоно, монгол чичүүл, сибирийн алаг даага зэрэг жижиг хөхтөн амьтад элбэг. Суурин жигүүртнээс цармын бүргэд, харцага идлэг шонхор, шилийн сар, начин шонхор, хайргууна шонхор, хотны бүгээхэй, адууч чогчоохой, хон хэрээ, шаазгай, шар шувуу, ууль, ятуу хийгээд нүүдлийн жигүүртнээс хөхөө, өвөөлж,

элээ гол горхиор ангир, галуу, нугас, тоодог, хавтаалж, зуун хурга зэрэг шувууд ирдэг.

Хөгнө-Тарны байгалийн цогцолборт газар нь түүх соёлын дургалт зүйлс ихтэй бөгөөд хүрэл зэвсгийн үеэс өнөөг хүртэлх түүх соёлын үе үеийн арвин их дурсгал хадгалагдаж байдаг. Тухайлбал Батхаан уулын ар өвөр, Ар, өвөр, Жаргалант голуудын хойт дэнжээр эртний булш, хиргисүүр олон байдаг. Мөн Бичигтэй амны хаданд бичиг, Тогоот улаан хаданд тогоо, Хуягтад хөө хуяг байдаг байсан бөгөөд Тогоот улаан хадны тогоо 1973 онд Эрдэнэсант сумын орон нутгийн музейд авчирч тавьжээ.

Хөгнө хан ууланд Өвгөн, Залуу хийд, Мойлтын амны хойд талд Сэнжит цохионд хүрэл зэвсгийн үеийн хадны сүг зураг, янгирын зураг, Ямаатын цагаан хөтлийн ар талын амны хаданд янгир, чоно, бугын зураг, Элсэн тасархайн элсний зүүн дэргэд боржин чулуун 2 хөшөө, Аман хадны буюу мааний хадны мааний үсэг, Хөгнө хан уулын баруун урд үзүүр Устын амны дэлээс 12 орчим км-т Ташуугийн өвөлжөө гэдэг газар Хийдийн давааны ар талд олон тооны булш байдаг. Мөн Монгол элсэн дунд орших Ширээт нуурын ар хөвөөнд Өндөр гэгээн Занабазар мэндэлсэн зэрэг түүх соёлын дурсгалаар баялаг газар юм.

3. Хан Жаргалант уулын байгалийн нөөц газар

Булган аймгийн Бугат сумын нутагт Бүрэнгийн нурууны баруун хэсэгт орших бөгөөд физик газарзүйн мужлалаар Орхон Сэлэнгийн сав дахь бэсрэг нам уулсын мужид багтана. Энд Сэлэнгэ мөрний өмнөд цутгал болох Уул, Алтаад, Зад, Барт, Баруун нарийн, Өлзийбүрэн, Чачиртай голууд тэдгээрийн цутгал олон жижиг гол горхитой. Уур амьсгалын мужлалаар чийглэгдүү сэрүүвтэрзун, хахир өвөлтэй мужид багтана. 1-р сарын дундаж температур -24°C, 7-р сарынх 16°C хэм байна. Жилд 300-400 мм хур тундас унана.

Хөрсөн бүрхэвчээр Эг-Сэлэнгийн тойрогт багтана. Уулын ар хажуугийн дээд хэсэгт 1600-1700 м-т уулын тайгын ширэгт, доошой дотор уулын ойн бараан, доод бэл хормойгоор нь уулын нугат ойн хөрс, уул нуруудын өвөр хажуугаар уулын хар шороон, хар хүрэн, хөрсний аль аль нь байна. Уулын хоорондох хөндий хонхорт хар хүрэн, нугат хүрэн, хөрс элбэг тархсаны зэрэгцээ нарийвтар ам хөндийд хар шороон хөрс, нугын ба нуга намагийн хөрс зурвас байдлаар тархана.

Хан Жаргалант уулын өврөөр 10 мянга гаруй мал бүхий 15 өрх өвөлжиж хаваржина. Баруун нарийн голын адагт 700 орчим толгой малтай 4 өрх тогтмол өвөлждөг. Голын адагт ангийн отог бий. Сэлэнгэ мөрнөөс загасчилахаар ирсэн хүмүүст зориулагдсан 8 хүний 4-5 байшинтай. Мөн голын адгаас дээш 40 орчим га талбайд тариа тарьдаг байна.

Уул, Алтаад, Зад, Барт голуудын хөндийд хадлан нилээд хэмжээгээр бэлтгэдэг. Эндхийн ойгоос үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэдэггүй, зөвхөн ойролцоо нутаглах малчид түлшний мод болон хашаа хороо барих зэрэг ахуйн хэрэгцээнд шаардагдах багахан хэмжээний мод бэлтгэнэ. Хушт, Булууд 1997 онд, Уулын голын савд 1998 онд ойн түймэр гарчээ.

Хан Жаргалантын байгалийн нөөц газар нь аж ахуй ашиглалт харьцангуй багатай нөөцөд хадгалан үлдээх боломжтой байгалийн үзэсгэлэнт газрын нэг юм.

Нөгөө талаар Хан Жаргалантын нуруу бол ихсийн онгон байдаг гэж ард түмэн шүтсээр ирсэн тахилгатай уул учир нутгийн ард түмэн энэ уулыг онголон тахих саналыг байнга тавьж байдаг. Эндхийн ойд хандгай, буга, бор гөрөөс, хүдэр, зэрлэг гахай зэрэг ховор ан амьтнаас гадна сойр, ятуу, хөтүү зэрэг шувууд байдаг. 30 гаруй төрлийн ховор нэн ховор ургамал ургахаас

гадна нэрс, үхрийн нүд, хад, алирс зэрэг жимс, жимсгэнэ, ойн дагалт баялаг арвинтай. 92,0 (60) мянган га нутаг дэвсгэрийг 2003 оны УИХ-ын 30-р тогтоолоор улсын тусгай хамгаалалтанд авсан.

2. Намнан уулын байгалийн нөөц газар

Хөвсгөл аймгийн Тариалан, Булган аймгийн Хутаг-Өндөр сумдын нутагт орших бөгөөд Орхон-Сэлэнгийн савын бэсрэг уулсын мужид хамрагдана.

Зүүн хойноос баруун урагш сунаж тогтсон үнэмлэхүй өндөр нь далайн түвшнээс дээш 2013,0 м өргөгдсөн, харьцах өндөр нь 700-800 м байна. Нэгдмэл нэг суурьтай боловч ам хөндийгөөр өөр хоорондоо ихээхэн хэсэгчилэгдсэн байдаг онцлогтой. Хамгийн өндөр цэг нь Бухат далан уул 2013 м өндөр уулсын орой хяр бөмбөгөр, хажуу нь хэм тэгш бус, өвөр хажуу нь эгцэвтэр хад чулуурхаг, гадаргад нь ул чулуулаг ил гарч хадан цохио үүсгэсэн явдал ч мэр сэр байхад ар хажуу нь налуувтар ой модоор битүү хучигдсан байна. Уулсын хажуу нь эртний ан цав болон урсгал усны элээх эвдлэх үйл ажиллагааны нөлөөгөөр үүссэн төдий л урт биш ихээхэн хэрчигдсэн V хэлбэрийн ам хөндийгөөр зүсэгдсэн байдаг.

Эдгээр ам хөндий нь ихэнхдээ тогтмол болон түр зуурын урсгал ус гол горхи олонтой. Тухайлбал уулын ар хажуугаас Хөндлөн булаг, Ар, Өвөр Шивэртийн гол, Улаан толгойн булаг зэрэг олон гол горхи эх аван урсана. Өвөр хажуугаас Их, Бага Цагаан бургас, Дэцлэн, Ихт, Улиастай зэрэг олон жижиг гол горхи эх авч Сэлэнгэ мөрөнд цутгана. Уулын урд хормой нь Сэлэнгэ мөрний гольдрол руу түрэн орж зарим газраа огцом эрэг мөрөгцөг үүсгэсэн байдаг.

Зундаа дулаавтар, өвөл хүйтэн 1-р сарын дундаж температур -24°C , 7-р сарынх 16°C хэм байна. Жилд дунджаар 300-400 мм хур тундас унана.

Уулын өөвөр хажууд уулын хээрийн хар хүрэн, хар шороон хөрс, ар хажууд уулын тайгын ширэгт хөрс, оройн хэсэгтээ уулын тайгын цэвдэгт хөрс тус тус тархжээ. Ойн цоорхой, гол горхины дагуу нугат хар шороон хөрстэй. Энд улалж алаг өвст шинэсэн ой, дээд хэсэгтээ хаг-хөвдөт шинэсэн, хуш-шинэсэн ойтой. 1998,1999 онуудад түймэр гач байв.

Намнан уул нь ан амьтнаар харьцангуй баялаг. Энд буга, бор гөрөөс, гахай, хүдэр зэрэг туурайтан амьтдаас гадна сойр, ятуу, хөтүү зэрэг шувуу бий. Харин ойн булга, шилүүс элбэг байсан нь одоо устаж үгүй болжээ. Сүүлийн жилүүдэд бугын тоо ихээр цөөрсөн нь хулгайн агналттай холбоотой. Намнан уул нь цомхон учраас агнах бололцоо ихтэй, ан амьтад өөр тийшээ дайжих боломжгүй юм. Нөгөө талаар хоёр аймгийн зааг нутагт орших тул хамгаалалт султай, бие биетэйгээ “барьцаж” ашиглах хандлага их гарах болжээ.

30 гаруй дүрсийн ховор, нэн ховор эмийн ургамал ургахаас гадна нэрс, үхрийн нүд, хад, алирс зэрэг жимс жимсгэнэ нэн элбэг байдгаас жил бүрийн намар ашиглалт харьцангуй их байдаг.

Намнан уулын өвөрт Хутаг-Өндөр сумын Тээл багийн 8300 толгой мал бүхий 33 өрх өвөлжиж, хаваржина. Харин Хөвсгөл аймгийн Тариалан сумын 15 мянга гаруй малтай 16 өрх Намнангийн ард 6 дугаар сарын 1-ээс 9 дүгээр сар хүртэл зусдаг байна. Энэ нутгийн бэлчээр төдийлөн их талхлагдаагүй боловч цаашид мал сүрэг өсч олон мал төвлөрөх тохиолдолд алдралд амархан орж болох талтай.

Энэ нутагт түүх дурсгалын газрууд их бий. Намнангийн хүрээний туурь, Бий булаг балгас, Өндөр ухаагийн овоо зэргийг дурдаж болно.

Намнан уулыг хамгаалах боломж, орон нутгийн санал хүсэлт, ховор ургамал, ан амьтан, тэдгээрийн тоо толгой, тархалт, ландшафтын өвөрмөц байдал, түүх соёлын дурсгалт зүйлс, малчдын нутагшилт зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэж байгалийн нөөц газрын ангиллаар тусгай хамгаалалтад хамруулсан байна.

Намнан уулын байгаалийн нөөц газар нь 45,6 (29,6) мянган га талбайг хамаарна.

2.7.3. Улсыг батлан хамгаалах зориулалтын газар

Энэ зориулалтаар 3504 га газар Бугат сумын нутагт Эрдэнэт хотод байрлах цэргийн ангиудын буудлагын талбайн газар олгогдсон байдаг нь зориулалтаараа ашиглагдахаасаа илүү малын бэлчээрт түлхүү ашиглагдаж байна.

III Бүлэг. Газрын менежментийн бүсүүд түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт

3.1. ХАА-н ангиллын газрын менежментийн бүсүүд, түүний нөөц нөхцөлийн төлөвлөлт

3.2. Тариалангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Тус аймаг нь газар тариалангийн гол бүс нутгийн хувьд тухайн газрын чадавхид тулгуурласан түүнийг аль болох үр ашигтай ашиглах менежментийн зөв бодлого явуулах нь тус салбарыг бат бэх, эдийн засгийн тогтвортой үр ашигтай хөгжүүлэх нэг үндэс болно. Булган аймгийн тариалангийн газрыг газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл хөгжүүлэх бүс, газар тариаланг мал аж ахуйтай хослон хөгжүүлэх бүс, өрхийн хэрэгцээний тариалан эрхлэх бүс гэсэн 3 том бүлэгт хуваалаа / хүснэгт 24, хавсралт 1/.

1. Газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл хөгжүүлэх бүс.

Энэ бүс нутаг нь ерөнхийдээ үр тарианы талбайнууд байрлаж байгаа нэлээд томоохон хэмжээний талбайд нэгэн төрлийн таримлыг дагнан тариалалт хийж буй аж ахуйн нэгжүүдийн талбай хамрагдах бөгөөд хөрсөн бүрхэвчийн хувьд газар тариаланд тохиромжтой агроүйлдвэрлэлийн 1. 2. 3-р зэргийн хөрстэй дундаж өндөр болон нам бэсрэг уулсын хоорондох хөндий, жижиг ухаа гүвээт талд байрлах талбайнуудыг хамруулав. Энд агроүйлдвэрлэлийн I зэргийн хөрс болох нугын хар хүрэн, хүрэн хөрс, дунд зэргийн зузаан хүрэн, дунд зэргийн зузаан, нимгэн хар хүрэн хөрс 21.5% тархахын зэрэгцээ агроүйлдвэрлэлийн II зэргийн хөрс буюу дунд зэргийн зузаан бага зэрэг үйрмэг чулуутай, хөнгөн шавранцар хүрэн хөрс давамгайлсан /62.5%/ тархаж, агроүйлдвэрлэлийн III зэргийн хөрс болох дунд зэргийн зузаан, нимгэн хөнгөн шавранцар хүрэн хөрс бага /16.0%/ хэмжээгээр тархана /хүснэгт 28/. Иймд агроүйлдвэрлэлийн I зэргийн хөрстэй газартаа нутагшсан сортын үр тариа, агроүйлдвэрлэлийн II зэргийн хөрстэй газартаа үр тариа, тэжээлийн ургамал, агроүйлдвэрлэлийн III зэргийн хөрстэй газруудад үр тариа дагнан тарих нь зохимжтой. Иймд энэ бүсэд орших талбайнуудыг үр тарианы аж ахуйн нэгжүүдэд зарим нэг жижиг талбайг ганц нэг иргэдэд эзэмшүүлэх хэрэгтэй. Энэ бүс орчмын нутагт ялангуяа тариалатын хугацаанд мал бэлчээрлүүлэхийг хатуу хориглох бөгөөд хураалтын дараа тодорхой хугацаанд зохицуулалтайгаар түр хугацаагаар мал бэлчээрлүүлж болно. Удаан хугацаагаар мал бэлчээх нь талбайн хөрсний бүтэц малын хөлөөр эвдэгдэж улмаар салхинд амархан хийсэх, элэгдэж эвдрэх үйл явцыг

түргэснэ. Энэ бүсэд ялангуяа хойт талын сумд Тэшиг, Хутаг- Өндөр, Сэлэнгэ, Хангал мөн Орхон, Бүрэгхангай зэрэг сумд зонхилж бусад сумдаас хэсэг хэсэгхэн газрыг хамруулж болно.

2. Газар тариаланг мал аж ахуйтай хослон хөгжүүлэх бүс.

А. Фермерийн аж ахуйн бүс. Энэ бүсэд уулын нарийн ам хөндий, булаг шанд, гол горхины хөлд байрлах жижгээр эсгэсэн харьцангуй чийгийн хангамж сайтай талбайнуудыг газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж болох бөгөөд түүнтэй зэрэгцэн цөөн тооны мал аж ахуйг айл өрх дангаар буюу эсвэл хэд хэдээрээ хоршсон байдлаар хослон эрхэлж болно. Талбайн хэмжээний хувьд төрөлжсөн үйлдвэрлэлийн бүсийг бодвол багавтар байна. Энд нэгэнт чийгийн хангамж сайтай учир голдуу агроүйлдвэрлэлийн I /39.1%/ ба II /52.6%/ зэргийн хөрс давамгайлж далд хөрсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал эмийн ургамал, малын тэжээлийн даршны ургамал тариалж болно. Боломжтой газруудад бага оврын услалтын систем болон энгийн аргаар шуудуу татаж тариалалтыг явуулахад илүү үр дүнтэй байна. Гэхдээ тариалалтыг дэмжсэн тодорхой эзэмшилтэй төрөлжсөн фермерийн /сүүний г.м/ аж ахуйнуудыг ч ойр орчимдоо байршуулахад болохгүй зүйлгүй. Уг аж ахуй нь хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн фермерийн аж ахуй байх учир тариалангийн үйл ажиллагаанд саад учруулахгүй харин бие биенээ дэмжсэн хэрэгцээтэй үед бүтээгдэхүүнээ солилцох хэмжээнд зохион байгуулагдсан байх шаардлагатай. Уг бүс нь төв суурин газар дэд бүтэц зам харилцаагаа даган хөгжих учир Бугат, Хангал сумдынхыг аймгийн төв болон Эрдэнэт хот руу зөөхөөр, Орхон сумынхыг аймгийн төв рүү, Бүрэгхангай, Дашинчилэн, Рашаант сумынхыг Дархан, Улаанбаатар хот руу зөөвөрлөхөөр төлөвлөсөө.

Б. Өрхийн тариалангийн бүс.

Өрхийн тариалангийн бүс нь сум аймгийн хэмжээнд тариалалт явуулах боломжтой газруудад хэсэгчилэн төлөвлөгдсөн бөгөөд хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах зорилгоор суурьшил даган хөгжихөөр төлөвлөгдсөн юм. Энэ бүс нутаг нь уулын болон голын нуга дагасан ихэвчлэн усалгаатай, үржил шим бүхий хөрстэй газрууд байх бөгөөд энд агроүйлдвэрлэлийн I зэргийн хөрс /76%/ давамгайлна. Энэ бүс өрхийн хэрэгцээний ил болон далд хөрсний төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалахад ашиглагдана. Цөөн тооны мал бүхий иргэд тусгай зохицуулалттайгаар байх боломжтой. Нэгэнт хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах зорилгоор суурьшил даган хөгждөг зүй тогтолтой учир сумдын төв, амралт сувиллын газар, баг бригадын төвийн ойролцоох боломжтой газруудыг сум тус бүрт сонголоо / дэлгэрэнгүй хүснэгт 1, зураг/.

3. Атаршуулах газар. Одоогийн байдлаар тус аймагт 47384 га атаршсан газар /хүснэгт 24, хавсралт 2 / байх бөгөөд энэ нь 2005 оны газрын тоо бүртгэлийн материалаас 1327 га талбайгаар илүү гарч байна. Атаршсан талбайн хэмжээгээр Рашаант, Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Могод, Сайхан зэрэг сумд дээгүүр байранд орно. Атаршсан талбайнууд нь хөрсний үржил шим доройтсон, салхины элэгдэл эвдрэлд орж элс харвасан, мөндөр цохидог, хяруу унадаг, хэт алслагдсан, намагжсан, ус ордог, гуу жалга гарсан, чулуу ихтэй зэрэг олон хүчин зүйлийн улмаас тухайн талбай бүхэлдээ болон хэсэгчилэн атаршсан байна. Атаршсан талбайн төлөв байдал, хөрсний чадавхийг ажиглахад хөрсний үржил шим, элэгдэл эвдрэлийн хувьд ихэнхи нь ашиглахад хэт доройтсон талбай байгаа боловч зарим нэг талбайнуудын хувьд ашиглах боломжтой талбайнууд ч багагүй байна. Иймд дээрх талбайнуудыг нөхөн сэргээлт хийж бүрмөсөн бэлчээрт шилжүүлэх, хөрс сайжруулалт хийж эргүүлэн тариаланд ашиглах гэсэн 2 үндсэн хэсэгт хуваалаа. Эргүүлэн тариаланд ашиглах

талбайг шууд ашиглах, нөхөн сэргээлт хийх болон хөрс сайжруулалт хийсэний үндсэн дээр ашиглах гэж дотор нь ялган үзэх хэрэгтэй. Нөхөн сэргээлт хийж бүрмөсөн бэлчээрт шилжүүлэх талбайд Баяннуур сумын Молцог элс, Гурванбулаг сумын Бэрхийн ар, Дашинчилэн сумын Баяжихын хөндийн хүчтэй эвдрэлд орсон талбайнуудыг нэрлэж болох бөгөөд Рашаант сумын хувьд одоо шууд эргүүлэн ашиглах боломжтой. Хөгнө хан уулын өврийн болон Бадын хөндийн зарим талбайнууд /баруун хойд талдаа/ харьцангуй хөрс сайтай эвдрэл багатай учир бага зэрэг агротехникийн хөрс сайжруулалт хийсний үндсэн дээр эргүүлэн тариаланд ашиглах, тэжээлийн ургамал тарих боломжтой. Зам харилцаа дэд бүтэц сайн хөгжсөн учир фермерийн аж ахуйн зориулалтаар ашигласан ч болохгүй зүйлгүй. Харин Тээг, Хуягтын сайр, Туулай, Баянхөндийн талбайнууд угаас элсэнцэр хөрстэй, элсэн хурдас, эвдрэл ихтэй учир ойрын хэдэн жилдээ тариаланд эргүүлэн ашиглах боломжгүй нөхөн сэргээлтийн байдлыг ажиглах нь зүйтэй. Бусад сумдын хувьд харьцангуй хөрс сайтай Баян-Агтын Дөхөмийн талбайнууд, Бүрэгхангайн Зөөхий, Цахиурт, Давааны ар, Ар хөндийн, Хишиг-Өндөрийн Баянгол, Хавчуу, Баярт, Дашинчилэнгийн Хар чулуутын талбайнуудыг шууд эргүүлэн ашиглах боломжтой. Бусад атаршсан талбайнуудын хувьд хүчтэй эвдрэлд орсноос бусад талбайг нөхөн сэргээлт, хөрс сайжруулалт хийх замаар ойрын үед эргүүлэн ашиглах бололцоотой. Хүчтэй эвдрэлд орсон талбайнуудын хувьд ойрын хэдэн жилдээ нөхөн сэргэх явцыг ажиглаж байж дараахи асуудлыг шийдэх нь зүйтэй. Тус аймаг атаршсан газраас 9529 га талбайг иргэдэд эзэмшүүлэхээр төлөвлөсөн бөгөөд энэ нь бүрэн боломжтой бөгөөд гагцхүү атаршсан талбай нь экологийн хувьд эмзэг байдалтай байдаг учир ашиглалтын явцад түүнд нягт нямбай хандах, арчилгаа тордолгоо хийхийг шаарддаг онцлогтой болохыг анхаарах нь зүйтэй.

3.2.1 Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх төлөвлөсөн асуудлууд

4. Усалгаатай тариалан. Тус аймгийн хувьд харьцангуй байгалийн усан хангамж сайтай манай орны томоохон голуудын нэг болох Сэлэнгэ, Эг, Орхон зэрэг голууд бусад жижиг салаа салбар голуудынхаа хамтаар урсдаг учир усалгаатай тариалан эрхлэх арвин боломж бий. Эдгээр голууд нь усны нөөц, урсгал ус сайтайд тооцогддог. Иймд социалист системийн үеэс усны хайгуул судалгааны ажил өргөн цар хүрээтэйгээр хийгдэж байсан бөгөөд түүний нэг нь 1982 онд УХТЭШ Институттээс эрхлэн хийсэн усалгаатай ашиглаж болох талбайн фондын судалгаа юм. Тус ажлын хүрээнд Булган аймгийн нийт нутаг дэвсгэрт 62129 га талбайг хамруулан явуулж үүнээс 77 объектын **43 487 га талбайг шинээр** илрүүлэн фондод бүртгэсэн байна/37/. Бид энэ судалгааг үндэслэн усалгаатай ашиглаж болох талбайн жагсаалтыг сум тус бүрээр гаргалаа /хүснэгт 24, 25, хавсралт 1,2/. Үүнд нийтдээ 18 864 га тариалангийн талбай дээрх судалгаа хийсэн тэг гортигт хамрагдаж байгаа бөгөөд үүний төмс, хүнсний ногоонд ашиглагдаж байгаа 1 201 га талбай бараг тэр чигээрээ ямар нэг хэмжээгээр энгийн аргаар усалгаатай ашиглагдаж байгаа гэж үзэж болно. Харин үлдэх **17 663 га талбайг дээрх судалгааг үндэслэн нэмж усалгаатай** ашиглаж болно гэсэн үг. Гэвч энэ судалгааг одоогоос 20 гаруй жилийн өмнө хийгдсэн учир тухайн үед байнгын урсгал устай байсан голууд нэлээд ширгэснээс одоо ашиглах боломжгүй болсон газар ч байна. Ийм газруудад Гурванбулагийн Бэрхийн арын Тахилт гол, Рашаант сум хойд талд /Өрхөт/ Савангийн гол гэх мэт газрууд зүй ёсоор орно. Мөн Хишиг-өндөр, Бүрэгхангай, Сайхан сумдын хувьд дахин нарийвчлан судлах шаардлагатай. Дээрх судалгаанаас харахад Эг, Сэлэнгэ, Орхон гэх мэт томоохон голуудын сав газраар улсын болон гадаад дотоодын төслийн төсөв хөрөнгөөр томоохон услалтын систем барих боломж байна. Харин жижиг гол горхи бараадан өрхийн хэрэгцээний төмс, хүнсний

ногоо тариалахад жижиг хэмжээний услалтын систем, суваг шуудуу татан энгийн аргаар орон нутаг, иргэд, аж ахуйн нэгжийн төсөв хөрөнгөөр услалтын системийн асуудлыг шийдэж болох байна. Атаршсан газрын хувьд ч усалгаатай ашиглаж болох зарим нэг талбай байна. Тухайлбал Баян-Агт сумын Хавцгайтын 00025, 0028, 00033, 00034-р талбай, Бүрэгхангайн Тасаг орчмын 00008, 00023, 00024-р, Босгын толгой, Сажийн эх орчмын талбайнууд усалгаатай ашиглаж болох судалгаа хийгдсэн талбайд хамрагдаж байгаа бөгөөд эдгээр талбайн зарим нэгд фермерийн аж ахуй эрхлэх боломжтой. Ер нь тус аймгийн хувьд усалгаатай тариаланг хөгжүүлэхийн тулд :

а. Юуны өмнө хуучин услалтын системтэй байсан газруудын услалтын системийг сэргээн засварлаж ажилд оруулах, Орхоны Шувуут, Баяннуурын Далын гол гэх мэт.

б. Өөрсдийн хүч хөрөнгөөр ажлуулж болох жижиг оврын услалтын системийг дэмжин ажлуулах

в. Энгийн аргаар суваг шуудуу татаж усалгааны асуудлыг хялбар аргаар шийдэх

г. Улсын болон гадны тусламжаар томоохон голуудын сав газар төрөлжсөн үйлдвэрлэл явуулах том услалтын систем байгуулах хэрэгтэй байна.

5. Төлөвлөсөн газар. Тус аймгийн хэмжээнд шинээр ашиглаж болох атар газрын судалгааг 1970 оны үед ГЗБХЗТИнститутээс хийсэн атар сонгох болон 1980 оны үед хийгдсэн хөрс судалгааны тайлбар бичиг, 2005 онд Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний ажлын хүрээнд хийсэн хээрийн судалгаанд үндэслэн сум тус бүрт хэд хэдэн газрыг ирүүлж нийт 16 755 га газрыг хамрууллаа /хүснэгт 24,26,27/. Эдгээр талбай нь энд тэнд хэсэгчилсэн байдлаар орших бөгөөд Сайхан сумын зарим нэг талбайнуудаас бусад бүх талбайг шинээр атар хагалахаар төлөвлөлөө. Тус сумын хувьд хуучин ашиглаж байгаад 1990 оны үеэс атаршуулж орхисон талбайнуудыг дахин ашиглах бололцоотой гэж үзсэн учир төлөвлөсөн газарт багтаалаа. Гэвч шинээр атар газар хагалахын өмнө нэн түрүүнд хуучин атаршуулж хаясан газраа эргүүлэн ашиглах арга замыг хайх нь зүйтэй болохыг чухалчлан анхааруулъя. Агроүйлдвэрлэлийн шинж чанарын хувьд нийт талбайн 2.4% нь агроүйлдвэрлэлийн I зэрэг, 51.6% нь агроүйлдвэрлэлийн II зэрэг, 46.0% нь агроүйлдвэрлэлийн III зэргийн хөрстэй байгаа нь тийм ч муу хөрс биш юм /хүснэгт 28/. Баян-Агт сумын төвийн хойд талаарх талбайн хувьд хөрс нэлээд сайн ихэвчлэн агроүйлдвэрлэлийн I зэргийн хөрстэй бөгөөд энд сумын төвийн хэрэгцээг хангах зорилгоор фермерийн аж ахуй эрхлэх боломжтойгоос гадна Балиг гол дагуух талбайд усалгаатай тариалан эрхлэх боломж бий /Усалгаатай газрын фондын судалгаа хийгдсэн/. Энд төмс, хүнсний ногоо, малын тэжээл дарш тариалж болох юм. Харин Баян-Агт сумын төвөөс урагш болон Сайхан сумын баруун хойд талаархи Сайханы уурхай орчмын талбайнууд нь агро II, III зэргийн хөрстэй бөгөөд энд усалгаагүй /Бөөрөөс бусад газарт, Бөөрт усалгаатай газрын фондын судалгаа хийгдсэн/ төрөлжсөн үйлдвэрлэл үр тарианы аж ахуй эрхлэх боломжтой. Бөөрт нийт 200 га талбайг услах боломжтой гэж судлагджээ. Мөн урагшилаад Могод сумын баруун хойд талаархи талбайнууд агро I /Хулж гол дагуух/ зэргийн хөрстэй бөгөөд тэдгээрийг фермерт, мөн хойд талын II зэргийн хөрстэй төв зам дагуух талбайнуудыг төрөлжсөн үр тарианы үйлдвэрлэл эрхлэх нь илүү тохиромжтой гэж үзлээ. Хишиг-Өндөр сумын зүүн урд талаар Хужирын бригад, Тогтоогийн худгийн ойролцоох төв зам дагуух талбайнуудад фермерийн аж ахуй эрхлэх нь илүү тохиромжтой болов уу. Бүрэгхангай сумын хувьд зүүн хойд талаархи хадлангийн талбайд байрлах талбайнууд хөрс сайтай, төрөлжсөн үйлдвэрлэлийн бүсээс зайдуу учир газар тариалан мал аж ахуй хослон эрхлэх фермерийн аж ахуйн бүс болгов. Мөн урд талын Сажийн эхийн талбайнууд төв замд ойр оршихын дээр усалгаатай тариалан эрхлэх

боломжтой фондын газарт бүртгэгдэж судлагдсан учир фермерийн аж ахуй эрхэлж болох юм. Дашинчилэн сумын урд талын талбайнуудад ч төв зам, дэд бүтэц, суурьшилд ойр учир фермер эрхлэх боломжтой.

Хүснэгт 27

Төлөвлөсөн тариалангийн газрын тодорхойлолт

Д/д	Сумдын нэрс	Талбай,га	Агроүйлдвэрлэлийн групп			Тариалангийн төрөл		УТЭБ
			I	II	III	ТҮ	Фермер	
1	Баян-Агт	2167	177	1990		1437	730	177
2	Бүрэгхангай	2294		736	1558		2294	628
3	Дашинчилэн	760			760	760		
4	Могод	1142	224	351	568	430	712	
5	Сайхан	9492		5048	4444			1772
6	Хишиг-Өндөр	899		531	368	-	899	-
	Бүгд	16755	401	8655	7699	12488	4267	2577

Жич: УТЭБ-усалгаатай тариалан эрхлэх боломж

ТҮ- төрөлжсөн үйлдвэрлэл

Тус аймгийн тариалангийн газрыг хөрсний чадавхи агроүйлдвэрлэлийн шинж чанараар нь хувааж үзвэл дараахи байдалтай байна.

Хүснэгт 28

Тариалангийн газрын хөрсний чадавхи, агроүйлдвэрлэлийн шинж чанар.

Д/д	Тариалангийн төрөл	Нийт талбай, га	Агроүйлдвэрлэлийн шинж чанар		
			Агро групп	Агро II групп	Агро III групп
1	Төрөлжсөн үйлдвэрлэл явуулах тариалан	61799	13270 ба 21.5%	38606 ба 62.5%	9923 ба 16%
2	Фермерийн аж ахуйн хэмжээнд явуулах тариалан	3330	1301 ба 39.1%	1752 ба 52.6%	277 ба 8.3%
3	Өрхийн тариалан	831	632 ба 76%	154 ба 18.5%	45 ба 5.5%
4	Усалгаатай тариалан	18864	4623 ба 24.5.%	12313 ба 65.3%	1928 ба 10.2%
5	Эргэлтэнд байгаа тариалан /нийт дүнгээрээ/	65960	15203 ба 23.%	40512 ба 61.4%	10245ба 15.6%
6	Атаршсан тариалан	47384	79 ба 0.2%	17813 ба 37.6%	29492 ба 62.2%
7	Шинээр хагалах атар	16755	401 ба 2.4%	8655 ба 51.6%	7699ба 46.0

Хүснэгт 28-аас харахад эргэлтэнд байгаа тариалангийн газрын 23 % нь агро I групп, 61.4 % нь агро II групп, 10.2 % нь агро III группын хөрстэй байна. Агро I группын хөрсний дийлэнхи нь өрхийн тариалан болон фермерийн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа бөгөөд дээрх үйлдвэрлэл нь харьцангуй хөрс сайтай газар үйлдвэрлэлээ явуулдаг байна. Төрөлжсөн үйлдвэрлэлийн хувьд ч тийм муу хөрс байхгүй байна. Ер нь Булган нутаг байгаль цаг уур, хөрсөн бүрхэвчийн хувьд газар тариалан эрхлэхэд тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх бөгөөд гагцхүү газрын үр өгөөжийг байгаль орчинд халгүй бүрэн чадавхиар нь ашиглах зөв менежментийн бодлого явуулах шаардлагатай.

Газар тариалангийн салбарын давуу талууд:

1. Байгаль цаг уурын нөхцөл сайтай, хөрс, байгалийн усан хангамж гэх мэт
2. Төвийн бүс нутагт оршдог, зам харилцаа дэд бүтэц сайн хөгжсөн
3. Өнө эртнээс газар тариалан эрхэлж ирсэн арвин туршилгатай
4. Өөрийн хэрэгцээгээ орон нутгаасаа хангах бүрэн боломжтой
5. Усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой

Газар тариалангийн салбарын сул талууд:

6. Газар тариалангийн үйлдвэрлэл явуулах нэгдсэн бодлого дутмаг
7. Талбайнуудын бараг тэн хагас ямар нэг хэмжээгээр элэгдэл эвдрэлд орсон, хөрсний үржил шим буурсан, төмс, хүнсний ногооны хортон шавьж газар авсан
8. Тариаланд эргүүлэн ашиглах боломжтой талбайнуудыг олноор атаршуулсан, өнжөөсөн, тэдгээр талбайн эзлэх хувь өндөр
9. Аж ахуйн нэгжүүд тарж бутарсан туршилга багатай иргэд газар эзэмших болсон
10. ХАА-н техник хуучирч муудсан
11. Услалтын систем эвдэрч тоногдон ажиллахаа больсон

3.2..2. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх талаар гаргасан

зөвлөмж

1. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх байгаль-цаг уур, нийгэм-эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд тохирсон нэгдсэн бодлого явуулах. Үүнд хойд талын Тэшиг, Сэлэнгэ, Хутаг-өндөр, Хангал, Баян-Агт цаашилбал Бугат, Орхон, Бүрэгхангай сумдын ихэнхи талбайг Булганы гурил тэжээлийн үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилгоор төрөлжсөн үйлдвэрлэлийн чиглэлээр хөгжүүлэх, Сайхан, Могод, Хишиг-Өндөр, Дашинчилэн зэрэг урд талын сумдын газрыг төрөлжсөн үйлдвэрлэл болон мал аж ахуй газар тариаланг хослон эрхлэх хуваарьт эдлэн эзэмшилтэй фермерийн аж ахуйн чиглэлээр хөгжүүлэх.
2. Тариалангийн газрын бүтэцийг сайжруулах, цулгуй уринш, өнжөөсөн талбайн эзлэх хувийг бууруулах, одоогийн байдлаар нийт эргэлтийн талбайн зөвхөн 1/3 орчим хувьд тариалалт хийж байгааг наад зах нь 2/3%-д хүргэх.
3. Газрын эзэмшил ашиглалтын асуудлыг оновчтой зөв шийдвэрлэх, эзэмшилийн хувьд маргаантай газруудын асуудлыг нэг мөр болгох, санхүүгийн хувьд чадавхитай, ажлын арга барилтай тариалан эрхлэх сонирхолтой иргэд аж ахуйн нэгжид газрыг хувиарлах, тариалалт хийхгүй он удаан жил өнжөөж орхидог байдлыг халах, тариалангийн газрын кадастрын зураг хийлгэх.
4. Нэгж талбараас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд усалгаатай тариалан эрхлэх, агромилиорацийн арга хэмжээг өргөн авч хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл талбайн арчилгаа, тордолгоог сайжруулсны үндсэн дээр нэгж талбараас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, одоогийн хөрсний чадавхийг шавхаж ургац авдаг арга барилаас салах.
5. Усалгаатай тариалан эрхэлж болох **17 663 га талбайг** судалгаагаар илрүүлсэн учир дээрх талбайг усалгаатай ашиглах арга замыг хайх энд юуны өмнө урд ашиглаж байгаад эвдэрч тоногдсон 196 га услалтын системийн талбайг засаж сэлбэн ашиглалтанд оруулах бусад шинээр барих их бага оврын услалтын системийн асуудлыг орон нутаг, аж ахуйн нэгжийн хүч хөрөнгө, гадна дотны зээл, төсөлд хамруулан шийдэх.

6. Аймгийн хэмжээнд тариалангийн нийт талбайн 45.5% ямар нэг хэмжээгээр элэгдэж эвдэрсэн явдалд дүгнэлт хийж хөрсийг салхины элэгдлээс хамгаалах иж бүрэн арга хэмжээг дорвитой авч хэрэгжүүлэх
7. Төмс, хүнсний ногооны талбай нэлэнхүйдээ хортон шавьжинд идэгдсэн тул зохих байгууллагад хандаж арга хэмжээ авах, нэгдсэн журмаар хор гербицидээр хангаж устгах арга хэмжээ авах.
8. Нийт тариалангийн талбайн 50-60% нь хөрсний шим тэжээлийн бодисоор хангалтгүй зэрэглэлд багтаж байгаа учир хөрсний үржил шимийг дээшлүүлэх, юуны өмнө орон нутгийн бордоо бууц, сангас, сүрэл зэргийг өргөн хэрэглэх. Хөрс шим тэжээлийн бодис тэр дундаа азотоор нэлээд дутмаг байгаа учир уриншинд хөрсийг азотоор баяжуулагч царгас, хошоон зэрэг буурцагт ургамлыг ногоон бордуурт өргөн хэрэглэх шаардлагатай байна.
9. Ойрын хэдэн жилдээ талбайн хэмжээг нэмэгдүүлэх биш байгаа талбайн ашиглалтыг сайжруулах замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх.
10. Атаршсан газраас боломжтой талбайг иргэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх.
11. Төлөвлөсөн газраас ойрын хэдэн жилдээ болж өгвөл нэмж шинээр атар хагалахгүй байх, онцгой шаардлагатай үед фермерийн аж ахуйд зориулагдсан бага хэмжээний газрыг хэсэгчилэн хагалах.

3.3. Хадлангийн газрын менежментийн бүсүүд, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Булган аймгийн хэмжээнд газрын тоо бүртгэлээр нийт 112020.1 га хадлангийн газартай бөгөөд тэдгээрийн байршил, эзлэх талбай, зонхилох ургамлын хэв шинж, ургац, шимт чанар, тэжээлийн нөөц, одоогийн ашиглалтын байдал, хойшид авах арга хэмжээ зэргийг зураг болон дэлгэрэнгүй хүснэгтээр үзүүлэв /хүснэгт 9/. Дээрх хадлангийн талбай нь Булган сумаас бусад бүх суманд байрлах бөгөөд тэдгээрээс жилдээ дундажаар 65-70 мян. тонн хадлан авдаг, тухайлбал 2004 онд 67822 тонн, 2005 онд 70111 тонн хадлан авсан байх жишээтэй. Бидний судалгаагаар жилдээ дээрх талбайгаас 90.4 мян.тонн хадлан авах боломжтой бөгөөд өөрөөр хэлбэл одоо авч байгаа хадлангийн хэмжээг 15-20 мян. тонноор нэмэгдүүлэх боломж бий. Дээр нь ой, бэлчээр зэрэг бусад ангиллын газраас хадаж болох бөгөөд эдгээр талбайгаас 4.7 мян, тн хадлан авч болох тооцоо бий /хүснэгт 31/. Бид хадлангийн газрыг менежментийн дараахи бүсүүдэд хуваалаа, үүнд: элдэв арчилгаа тордолгоо хийлгүйгээр тогтвортой байнгын ургац өгдөг хадлан, хашиж хамгаалах, сэлгэх ашиглах замаар тордон сайжруулах хадлан, усалгаа оруулах болон олон наст ургамлын үрийг өтгөрүүлэн цацах замаар тарималжуулах хадлан, бусад ангиллын газраас хадаж болох хадлан, улсын фондын хадлан гэсэн 5 бүсэд хуваан үзсэн /хүснэгт 30/. Үүнд аймгийн хэмжээнд тогтвортой байнгын ургац авдаг хадлангийн гол бүс нутгаар Тэшиг, Хутаг-Өндөр, Хангал, Бугат, Бүрэгхангай, Дашинчилэн зэрэг сумдыг нэрлэж болох бөгөөд эдгээр нь өөрсдийн хэрэгцээг хангахаас гадна бусад хадлан тэжээл дутагдалтай сумд болон урд талын хээрийн сумдыг өвс тэжээлээр хангах боломжтой. Бусад сумдын хувьд өөрсдийн дотоодын хэрэгцээгээ хангах, эрчимжсэн мал аж ахуй болон хуваарьт эдлэнт фермерийн аж ахуйнуудыг хангахаар төлөвлөгдсөн. Ер нь нийт сумдад фермерийн аж ахуйнуудад ойр жижиг талбайнуудыг эрчимжсэн мал аж ахуй болон хуваарьт эдлэнт фермерийн аж ахуйнуудад ашиглагдахаар төлөвлөсөн. Улсын фондын хадлангаас бусад нь орон нутгийн мэдэлд байна. Гэвч хойд талын хадлангийн гол бүс нутгийн хадланд алаг өвст, алаг өвс-үетэнт, алаг өвс-үетэн-улажит, улалж-алаг өвс-үетэнт уулын нугын болон голын татамын нуга 65-70%-ийн

ерөнхий бүрхэцтэй зонхилж, ургац өндөр 8-12 ц/га байх боловч шимт чанараар төдийлэн сайнгүй 100 кг тэжээлд 32-36 тэжээлийн нэгж зонхилж байгаа нь дундаж хэмжээ юм. Харин урд талын хээр, ойт хээр хосолсон сумдад хялгана-үетэнт, хялгана-алаг өвст, биелэг-үетэнт, дааган сүүл-үетэнт, үетэн-улалж-алаг өвст хээржсэн болон нугархаг хээрийн хэвшил зонхилж ургац 6-8 ц/га байх боловч шимт чанараар сайн 38-42 тэжээлийн нэгж агуулагдана.

3.3.1. Хадланд шинээр эзэмших талбайнууд /төлөвлөсөн/, тэдгээрийн товч тодорхойлолт.

Ойн цоорхой болон бэлчээрийн газраас хадаж болох боломжтой газрын судалгааг сум тус бүрээр гаргаж байршил, хэмжээг зурагт үзүүлэхийн зэрэгцээ тэдгээрийн зонхилогч ургамал, ургац, тэжээлийн нөөц, шимт чанар цаашид хэрхэн ашиглах талаар дэлгэрэнгүй хүснэгтээр талбар бүрээр харуулав /хүснэгт 9,30,31,32/. Хүснэгтээс харахад ойн сангийн газраас 1578.2 га үлдэх 4856.6 га талбайг бэлчээрийн газраас хадах боломжтой. Мөн усалгаатай ашиглаж болох газрын фондод бүртгэгдсэн /услалтын систем барих судалгаа хийгдсэн/ Бүрэгхангай, Дашинчилэн сумын бэлчээрийн талбайг усжуулах замаар таримал хадлан бий болгох талбайгаар авсан. Эдгээр бүх талбайг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшилд байхаар төлөвлөв. Дээрх төлөвлөсөн газрууд нь одоогийн байгаа хадлангийн төвшинд нөөцийн хувьд хүрэхгүй боловч тэдгээрийг сайжруулах замаар ашиглах мөн гарц сайтай хуртай жил шууд ашиглах боломжтой талбай ч бий. Ялангуяа ойн сангийн газраас ойн цоорхойнуудаар хадах талбайгаас тогтвортой ургац авах нэлээд боломжтой.

Хүснэгт 32

Бусад ангиллын газраас хадаж болох газрын судалгаа.

Сумдын нэрс	Нэгж талбарын дугаар	Хадаж болох талбайн хэмжээ,га	Аль ангиллын газраас	Бэлтгэх арга
Баян-Агт	026-0.32	406.2	Ойн цоорхойгоос 150 га, бэлчээрээс 256 га	Хадах
Гурванбулаг	003-005	1449	Бэлчээрээс	Хашиж хамгаалах замаар хадах
Хишиг-Өндөр	009-010	328.6	Бэлчээрээс	Хашиж хамгаалах замаар хадах
Дашинчилэн	005	842.9	Бэлчээрээс	Усалгаатай хадлан бий болгох
Бүрэгхангай	017	348.2	Бэлчээрээс	Усалгаатай хадлан бий болгох
Тэшиг	031	353.2	Ойн цоорхойгоос	Хадах
Сайхан	015-016	120.5	Бэлчээрээс	Хадах
Сэлэнгэ	020-028	1225	Ойн цоорхойгоос 425 га, бэлчээрээс 800 га	Хадах
Бугат	037-043	1363	Ойн цоорхойгоос 650 га, Бэлчээрээс 713 га	Хадах
Бүгд		6436.8	Ойн сангаас 1578.2, бэлчээрээс 4856.6 га	

3.3.2. Хадлангийн эдэлбэр газрын ашиглалтыг эрчимжүүлж, хамгаалалтыг сайжруулах

Хадлангийн талбайн одоогийн төлөв байдал, нөөцийг зөв тогтоосний үндсэн дээр түүнийг бүрэн дүүрэн зөв зохистой ашиглах явдал хадлангийн газрын ашиглалтыг сайжруулах менежментийн нэг үндэс мөн. Бид хадлангийн талбайн ашиглалтыг сайжруулах үүднээс тэдгээрийг хэд хэдэн бүлэгт хуваасан гэж дээр дурьдсан. Хүснэгт 3-аас харахад нийт хадлангийн талбайн 72 704.2га буюу 64.9% нь байнгын хадаж ашигладаг тогтвортой ургац авдаг хадлан байх бөгөөд 34886 га буюу 31.1% нь сэлгэж өнжөөх, хашиж хамгаалах замаар тордон сайжруулж ашиглах, 4420 га буюу 3.9 % нь олон настын үрийг хачирлан цацаж өтгөрүүлэх замаар тарималжуулах хадлан байна. Тордон сайжруулах талбайд урд талын хээрийн сумдын талбай зонхилох бөгөөд тэдгээрийг дэлгэрэнгүй хүснэгтээр харуулсан бөгөөд түүний нэгтгэлийг дор хүснэгт 33-аар харуулав.

Хүснэгт 33

Нөхөн сэргээлт, тордолт хийх хадлангийн газрын судалгаа.

№	Арга хэмжээ	Сумын нэр	Талбайн хэмжээ, га-аар	Зарцуулсан хөрөнгө* мян/төг	Хөрөнгийн эх үүсвэр
1	Услах	Дашинчилэн, Бүрэгхангай, Баяннуур	3191	-	Улсын төсөв
2	Тордон сайжруулалт хийх	Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Баян-Агтаас бусад	34886	-	Орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж
3	Тарималжуулах	Баяннуур, Орхон, Бүрэгхангай, Хутаг-Өндөр, Хишиг-өндөр	4420	-	Орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж
	Бүгд				

Хадлангийн талбайн эзэмшил, ашиглалтын хувьд нийт талбай улсын фондын хадлангаас бусад нь орон нутгийн мэдэлд байх ба тэдгээрээс одоо зөвхөн 138 га талбайг аж ахуйн нэгж гэрээгээр эзэмшдэг /хүснэгт 34/. Үүнд Хутаг-Өндөр суманд 100 га, Могод суманд 38 га талбай бүргэгдсэн. Иргэд, аж ахуйн нэгж, гадаадын байгууллага ашигласан, өмчилсэн хадлан байхгүй. Иймд цаашид хадлангийн талбайг иргэд, аж ахуйн нэгжүүдэд өргөн эзэмшүүлэх, ашиглуулах хэрэгтэй.

Хүснэгт 34

Хадлангийн эзэмшилт, ашиглалтын өнөөгийн байдал

№	Газрын харилцааны хэлбэрүүд	Тоо хэмжээ, га		
		Иргэн	ААНБ	Гадаадын байгууллага
1	Эзэмшүүлсэн	-	138	-
2	Ашиглуулсан	-	-	-
3	Өмчлүүлсэн	-	-	-
	Бүгд	-	138	-

Хадлангийн талбайг ашиглах зөвлөмж :

1. Булган аймаг хадлангийн арвин нөөцтэй боловч түүний байгалийн унаган төрх байдал, ургамлын гарц, ашиглалтыг сааруулахгүйн тулд зөв менежментийн бодлого явуулах хэрэгтэй.
2. Хадлангийн талбайн зүйлийн бүрэлдэхүүн цөөрсөн, ургамал тачир намхан, сийрэг болсон газруудыг тордон сайжруулах гэж дэлгэрэнгүй хүснэгтэнд тэмдэглэсэн байгаа бөгөөд эдгээр талбайг малын хөлөөс хамгаалах, жил дараалан хадахгүй сэлгэж хадах, олон наст ургамлын үр цацаж өтгөрүүлэх, хөрсийг сийрүүлэх, өвөл цас тогтоох, хурын улиралд борооны усыг хуримтлуулж услах, ялзарсан өтөг бууцаар бордох зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна.
3. Бүрэгхангай сумын 017, Дашинчилэн сумын 005-р нэгж талбарт услалтын систем байгуулах боломжтой гэж судалгаа хийгдсэн тул дээрх 1191 га талбайг услаж хадланд ашиглах цаашилбал малын тэжээл, дарш тариалах хэрэгтэй.
4. Хадлангийн талбайд үерийн ус орохоос хамгаалж хаалт хашилт хийх, суваг шуудуу татах, том чулууг түүх, довонг тэгшлэх, хуучин борог өвс, мод бутыг цэвэрлэж хадах зэрэг ажлуудыг хийх нь түүнийг ашиглалтыг сайжруулна.
5. Хадлангийн талбайн нөөц сайтай учир тэдгээрийг түшиглэн жижиг фермерийн аж ахуй, цөөн тооны сүүний чиглэлийн эрчимжсэн мал ахуй эрхлэх боломж бий.
6. Хадлангийн талбайг иргэд болон аж ахуйн нэгжүүдэд нэн даруй гэрээгээр эзэмшүүлэх хэрэгтэй.

3.4. Бэлчээрийн менежментийн бүсүүд, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт.

3.4.1. Бэлчээрийн менежмент.

Одоогийн байгаа бэлчээр нь жилээс жилд бусад ангиллын газарт шилжиж хумигдаж байгаа мөн дээр нь байгаа бэлчээрийг зөв зохистой ашиглаагүйгээс бэлчээрийн талхлагдал, төлөв байдлын доройтол газар авч байгааг бид дээрх бүлэгт тодорхой өгүүлсэн. Иймд бэлчээрийг зөв зохистой ашиглах, үр өгөөжийг нь дээшлүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах үүднээс зайлшгүй ямар газраа ямар бодлого барих, тэр бодлогын бүсүүдийг газрын нөхцөл нөөцийг зөв тооцоолсны үндсэн дээр тодорхой менежментийн бүсүүдэд хувааж өгөх явдал юм. Ер нь тус аймагт бэлчээрийг дан ганц уламжлалт мал аж ахуйн зохицуулалттайгаар ашиглаж ирсэн бөгөөд цаашид энэ байдлыг багасгаж цөөн тооны өндөр ашиг шим бүхий эрчимжсэн мал аж ахуйн шаардлагад нийцүүлж түүний эзлэх хувийг нэмэгдүүлж хөгжүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг тодорхой түвшинд хөгжүүлэх бодлого барина. Ингэснээр газар тариалангийн гол бүс нутгийн хувьд газар тариаланг давамгайлах байдлаар хөгжүүлэх боломж бүрдэх юм. Цаашид бэлчээрийн газрыг дараахи үндсэн 4 бүсэд хувааж ашиглах нь зүйтэй /зураг, хүснэгт 35/. Үүнд:

1. Хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн суурьшмал мал аж ахуйн бүс.

Энэ бүсэд эдлэн газрын хэм хэмжээ нь урьдчилан нормчлогдсон, газар нутгийн хувиарлалтын дагуу газар эзэмших гэрээнд заасан болзол нөхцөлийг хангасан нарийн төрөлжсөн эрчимжсэн мал аж ахуй эрхлэх фермер, аж ахуйн нэгжийг байршуулав. Иймд энэ бүсийг эрчимжсэн мал аж ахуйн бүс ч гэж ойлгож болно. Энэ бүсэд өндөр ашиг шимтэй саалийн үнээний

фермийг 25, 40, 50 үнээтэй байхаар зохион байгуулах нь илүү тохиромжтой. Эдгээр үнээг дулааны улиралд дан ганц байгалийн тэжээлээр тэжээх бөгөөд харин бусад улиралд таримал тэжээл овъёос, сүрэл, дарш, тэжээлийн манжин, давс хужир, хивэг зэрэг багсармал тэжээлээр тэжээх шаардлагатай байдаг тул бэлчээрээс гадна тэжээлийн ургамал тариалах тариалангийн талбайтай байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл эдгээр аж ахуйн нэгжүүд нь эрчимт мал аж ахуйгаас гадна туслах чанарын газар тариаланг давхар хөгжүүлнэ. Иймд атаршсан тариалангийн талбайнуудыг тэжээлийн ургамал тариалахад өргөн ашиглахаар төлөвлөв. Энэ бүсийн хөрс, ургамлан бүрхэвч нь байгалийн унаган төрх байдлын хувьд нэлээд даац сайтай уулын ам хөндий, гол хөндий, булаг шанд орчмын чийгийн хангамж харьцангуй сайтай газрууд байх бөгөөд энд уулын хар хүрэн хөрс, нугын хар хүрэн, нугын хүрэн, хар хүрэн зонхилон тархах бөгөөд ургамлан бүрхэвчийн хувьд өндөр тусгаг бүрхэц бүхий алаг өвст, алаг өвс-хялганат, алаг-өвс үетэнт, алаг өвс-үетэн-улалжит бэлчээрийн төрлүүд зонхилон тархсан байна. Иймд хойд талын ойт хээрийн сумд болох Бугат, Хангал, Тэшиг, Сэлэнгэ, Орхон зэрэг сумд тус бүс нутгийг хөгжүүлэхэд илүү тохиромжтой. Тэшиг суманд ирээдүйд Тавтын уурхайг даган сумын төвийн дэргэд дагуул хот тосгон бий болно гэж үзсэн учир энд усалгаатай талбайн фондын талбайг түшиглэн фермерийн аж ахуй хөгжүүлэх боломжтой гэж үзлээ. Бугат, Хангал, Сэлэнгэ сумын хувьд аймгийн төв болон Эрдэнэт хотыг, Орхон сум аймгийн төвийг тус тус бүтээгдэхүүнээрээ хангах боломжтой. Бүтээгдэхүүнээ аль болох хүн ам ойр суурьшсан хот тосгон суурин луу зөөж тээвэрлэхээр дэд бүтэцэд ойр байх нөхцөлийг мөн харгалзан үзэв. Уг бүсэд дээрх сумдын нийтдээ 21 671 га газрыг хамруулав.

Энэ бүсэд газар эзэмшигч нь байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах, хамгаалах асуудлыг бүрэн хариуцах бөгөөд үйлдвэрлэлийнхээ үр ашгийг дээшлүүлэх зорилгоор газарт оруулж байгаа хөрөнгө оруулалт нь байгаль орчинд халгүй байх, эдлэн газраа хашиж хамгаалах, хөрсний үржил шимийг дээшлүүлэх, ургацыг нэмэгдүүлэх, газрын гарцыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг бүрэн хариуцаж өөрийн хөрөнгөөр хийнэ. Эрүүл ахуйн нарийн чанд дэглэмд захирагдаж үйлдвэрлэлээ явуулах учир бусад төрлийн мал амьтан холилдон нутаглах, бусадын мал, мал тууврын зам эзэмшил дээгүүр дамжин өнгөрөхийг хатуу хориглоно.

2. Хуваарьт эдлэн болон нийтийн ашиглалтын газрыг хосолмол ашиглах суурьшилын бүс.

Энэ бүс нь байгалийн нөхцөлийн хувьд дээрх хуваарьт эдлэн газрыг арай гүйцэхгүй уулын бэл хормой, энгэр газар, тал хөндий, нам ухаа гүвээг дагаж орших бөгөөд дунд зэргийн зузаан хүрэн хөрс, хар хүрэн хөрс, нугын хөрс түгээмэл тархаж 40-50 %-ийн ерөнхий бүрхэцтэй алаг өвс-үетэнт, хялгана-алаг өвст, хялгана-үетэнт бэлчээрийн төрлүүд зонхилно. Энэ бүсэд уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэхийг хориглохгүй боловч мах сүүний чиглэлийн үхэр, хонь, адууны эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэхийг хэтийн зорилгоо болгоно. Иймд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгжид газрыг хувиарлан олгоно. Нэгэнт фермер аж ахуйн чиглэлийг хэтийн зорилгоо болгож байгаа учир ХАА-н газрын ашиглалтыг сайжруулах, үр шимийг нэмэгдүүлэх, аж ахуй дундын хоршилтийг дэмжиж, техник болон бусад үйлчилгээний газруудыг хөгжүүлэхийг эрмэлзэнэ. Хадлангийн газрыг тэдгээрийн дундын эзэмшилд гэрээгээр эзэмшүүлэх хэрэгтэй. Уг бүсийг ихэвчлэн хойт талын сумдаар хөгжүүлэх боловч Дашинчилэн, Рашаант, Баянуур гэсэн дэд бүтэц сайн хөгжсөн Улаанбаатар, Дархан гэсэн томоохон хот суурин газруудад ойр сумдад хөгжүүлж бүтээгдэхүүнээ төв суурин газар борлуулах арга хэмжээг авч болох юм.

Энд бэлчээрийн талхлагдал бусад доройтол хойт талын сумдыг бодвол илүү ажиглагддаг хязгаарлалтай ашиглах эмзэг хөрс экологитой бүс нутаг учир түүнийг нөхөн сэргээх сайжруулах арга хэмжээг газар эзэмших гэрээнд зайлшгүй тусгаж өгөх шаардлагатай. Энэ бүсэд нийт 91 677га талбай буюу нийт бэлчээрийн 3.5%-ийг төлөвлөлөө.

3. Өрхийн аж ахуйн суурьшилийн бүс.

Төв суурин газрын цөөн тооны мал бэлчээхэд зориулсан багавтар хэмжээний төв суурин газар ойр байх бүс юм. Иймд сумын төв болон төв суурин газар бүрт багахан хэмжээний газрыг дээрх зориулалтаар төлөвлөв. Газрыг өрх айлаар хамтран эзэмших бөгөөд газрын эзэмшил, ашиглалт, чанартай холбогдсон аливаа асуудлыг өрх хариуцаж, малын тооноос хамааруулан түрээсийн төлбөр төлнө. Газар хязгаарлагдмал, түрээсийн төлбөр төлөх учир өндөр ашиг шимтэй цөөн тооны малтай байхыг эрмэлзэх нь чухал. Энэ бүсэд бэлчээрийн мал аж ахуй эрхлэхийг хориглож жимс, жимсгэнэ, хүлэмжийн аж ахуй, гахай, тахиа, зөгийн аж ахуй хөгжүүлэх бодлогыг давхар баримтална.

4. Уламжлалт мал аж ахуйн буюу чөлөөт ашиглалтын бүс.

Энэ бүс нь газар нутгийн хувьд нэлээд түгээмэл орон зайг эзлэх бөгөөд бэлчээрийг өвөл, хавар, зун намар гэсэн сэлгээтэйгээр нийтээр эзэмшинэ. Нийт бэлчээрийн 821223 га буюу нийт бэлчээрийн 43% нь өвөл хаврын бэлчээрт 1088596 га буюу 57% нь зун намрын бэлчээрт эрчимтэй ашиглагдаж байна. Нэгэнт газар нутгийн хэмжээ харьцангуй чөлөөтэй учир тал хөндий, ухаа гүвээ, голын хөндийгээр тархаж ургамлан нөмрөг тачир сийрэг, ургац, гарц багатай байна. Иймд улирлын хуваарийг нарийн чанд мөрдөж малын хөлөөс чөлөөлж сэлгээтэй ашиглахгүй бол талхлагдалд орох магадлал хамгийн өндөртэй газар юм. Нэгэнт талхлагдсан газрыг 2-3 жил өнжөөж байгалийн аясаар нөхөн сэргэсний дараа эргүүлэн ашиглах хэрэгтэй. Аймгийн болон сумын малчин иргэд, гаднаас шилжин ирэгсэд уг бүсэд нутаглана. Мал тууврын зам уг бүсээр дамжин өнгөрөх бөгөөд энд 2 хэсэг зурвас газрыг төлөвлөж нийтдээ 119 641 га газрыг хамрууллаа /зураг, хүснэгт 35/. Эхний хэсэгт аймгийн хойд талаар Баян-Агт, Сайхан, Хутаг-Өндөр, Бугат сумын нутгийг, дараагийн хэсэгт урд талын сумд Могод, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн сумдын нутгийг дайран өнгөрөх юм.

3.4..2. Бэлчээр хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх талаар.

Тус аймгийн нийт бэлчээрийн 30 % ямар нэг хэмжээгээр талхлагдаж, 3.4 % нь бусад нөлөөлөлд автсан гэж дээр дурьдсан билээ. Тэгвэл энэ байдлаас гарч түүний бүтээмжийг дээшлүүлэхийн тулд цогц арга хэмжээ авч явуулах шаардлагатай байна. Үүнд:

1. Бэлчээр зохион байгуулалтыг малын төрөл, тоо толгой, бэлчээрийн онцлог байдал, түүний хамрах хүрээ, даац, ургамлын сэргэн ургах чадвар хэнзлэлт зэргийг харгалзан шинжлэх ухааны үндэслэлтэй нарийн төлөвлөгөөтэйгээр малчидтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр хийх, тухайлбал,

- бэлчээрийн газрыг улирлаар, цаашилбал сар өдрөөр хэзээ хаана ямар малыг, ямар хугацаатай бэлчээрлүүлэх нарийвчилсан хуваарь гаргах, эхний

удаа ашигласан бэлчээрийг 25-30 хоногийн дараа хэнз ногоо идүүлж байхаар тохируулж бэлчээрийн эргэлтийг тогтоох ,

- өвөл, хаврын бэлчээрийг эртнээс нөөцөлж түүнийг холын болон ойрын бэлчээр гэсэн 2 хэсэгт хуваан ашиглана. Холын бэлчээр нь өвөлжөө, хаваржааны эзэмшил бэлчээрт хамгийн алсын бэлчээр бөгөөд мал тарган, хээл нь хондрээгүй үед буюу өдрийн урт, цаг агаар дулаан үед гаднаас нь дотогшлуулах замаар ашиглахад тохиромжтой. Ойрын бэлчээр нь өвөлжөө, хаваржааны дэргэд хамгийн ойр нөөцөлсөн бэлчээр байх учраас цагийн хүнд нөхцөлд мал тарга хүчээ алдаж сульдаж турж эцсэн юмуу хээл нь томорч хүндэрсэн мал төллөж байгаа үед ашиглах нь зүйтэй.

- Зун-намрын улиралд отрыг алс хол соргог сэрмүүн бэлчээрт хийх нь бэлчээр ашиглалтыг сайжруулан өвөл, хаврын бэлчээрээ хамгаалах ач холбогдолтой байдгийг анхаарах.

2. Бэлчээр усжуулалтыг сайжруулах, эвдэрсэн худаг усыг засч сэлбэх, эзэмшилтэй болгох.

3. Нэгэнт талхлагдсан бэлчээрийг наад зах нь хээрийн бүсэд 3-4 жил, ойт хээрийн бүсэд 2-3 жил ашиглахгүйгээр өнжөөх, байгалийн аясаар нөхөн сэргээх, мөн бэлчээрийг бордох, услах, хагд өвсийг шатаах, хөрсийг хагалалгүйгээр сэндийлэх, дов сондуулыг хэрчих, тэгшлэх, олон наст ургамлын үр цацах зэрэг олон аргуудыг хэрэглэж болох юм.

4. Гаднаас суурьшин ирж буй малчдын нүүдэллийг аль болох хязгаарлах, малыг нэг дор хэт олноор бөөгнөрүүлэхгүй байх .

5. Бэлчээрийг эзэмшилд өгөх, цаашилбал төлбөр тогтоох.

6. Бэлчээрийн газар нь газар тариаланд ашиглах, зам их гаргах, хот суурин газар барьж байгуулах, алтны уурхайг олноор байгуулж байгаагаас хүнд ачааны техник хүний үйл ажиллагаа ихэссэн зэрэг аж ахуйн ашиглалтаас болж ихээхэн багассаар байгааг анхаарах.

7. Байгалийн болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах.

хүснэгт 36

Бэлчээр ашиглалтыг сайжруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Авах арга хэмжээ	Газрын байршил	Хөрөнгө мян/төг	Тайлбар
1	Худаг усан санг барих	-	-	
2	Худаг усан санг засварлах	Рашаант, Бад, Тарнын гол дагуу		
3	Зам харгуйг сайжруулах	Бугат, Хутаг-Өндөр		Алслагдсан бэлчээрт зам харгуй гаргах
4	Хашиж хамгаалах	Урд талын сумд		
5	Усжуулах бэлчээр	Ихэнхи сумдад 39258га		
	Бүгд			

Сүүлийн жилүүдэд бэлчээрийн талхлагдал ихсэж байгаатай холбогдуулан төрөөс бэлчээрийг зохистой ашиглах нэгдсэн бодлого явуулах, бэлчээрийг амрааж хуваарьтай ашиглах, байгалийн аясаар нөхөн сэргээх, малын тоо толгойг нэг дор хэт их төвлөрөөлэхгүй бэлчээрийн даацад тохируулах, өндөр үр

ашигтай цөөн тооны эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бодлогыг барих, бэлчээр усжуулалтыг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.4.3 Бэлчээрийн усан хангамжийн асуудал.

Булган аймаг нь хэдийгээр байгалийн усан хангамж сайтай, гол горхи элбэгтэй боловч бэлчээрийн ашиглалтыг сайжруулах, усан хангамжийг нийт нутгаар жигд хувиарлахад учир дутагдалтай байдаг. Одоогоор аймгийн хэмжээнд бэлчээрийн газарт моторт худаг 27, эргүүлэгт худаг 42, гар худаг 39 ажиллаж байгаа нь социализмын үед барьж байгуулсан худгийн дөнгөж тал хувь нь юм. Бэлчээрийн усан хангамж урд талын сумдаар нэлээд дутагдалтай гэж хэлж болох бөгөөд энд инженерийн хийцийн худгууд тоногдож эвдэрснээс гадна гол горхи нь ширгэж устсан газар олон бий. Тухайлбал Дашинчилэн сумын Хар бухын гол, Рашаант сумын Бад, Тарнын гол гантай жилд ширгэж хатдаг. Бэлчээрийн усан хангамжийг дээшлүүлэхийн тулд юуны өмнө урьд ашиглагдаж байгаад эвдэрсэн худгуудыг засаж сэлбэх явдал юм. Мөн худгуудын ашиглалт хамгаалалтанд хяналт тавих, эзэнтэй болгох хэрэгтэй байна. Булган аймагт 1982 онд УХТЭШ Институттээс эрхлэн явуулсан гидрогеологийн хайгуулын ажлаар 61 582 га талбайг хамруулсаас 77 объектын 42 940 га талбайг шинээр илрүүлэн фондод бүртгэсэн байна/37/. Үүний 41 216 га талбай нь инженерийн хийцтэй услалтын систем барьж байгуулах журмаар ашиглах 1 513 га талбайг нь орон нутгийн хүчээр ашиглах, 152 га талбайг хялбар аргаар услаж ашиглах боломжтой талбай гэж үзжээ. Уг судалгаагаар усалгаатай ашиглаж болох талбай, усны эх булгийн нөөцийн материал цуглуулах, голын хэвгий, хөндлөн зүсэлтийг нивлөрдэж, их усны мөрөөр усны зарцуулгыг тодорхойлох зэрэг хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн ба голуудын олон жилийн дундаж урсац 50-75%-ийн хангамжийн зарцуулгууд, тэдгээрийн жилийн доторхи урсацын хувиарлалтыг тооцож, хур борооны, үерийн янз бүрийн хангамжийн зарцуулгуудыг тооцжээ. Уг судалгаанд үндэслэн эхний ээлжинд Баян-Агт сумын Хавцгайтад суманд 460 га, Бүрэгхангай суманд 160 га, Гурванбулаг суманд 200 га, Дашинчилэнд 450 га, Могод суманд 400 га, Орхон суманд 200 га, Сайхан суманд 300 га, Тэшигт суманд 660 га, Хангал суманд 300 га, Хишиг-Өндөр суманд 110 га, Хутаг-Өндөр суманд 2100 га талбайг тус тус хадлан бэлчээрт усалгаатай ашиглаж болох юм /зураг, хүснэгт 25 /.

Фондод бүртгэгдсэн эдгээр талбайнуудыг услаж ашигласнаар зөвхөн малын тэжээл бэлтгэлээр тооцоход малын тэжээлийн бэлтгэлийн хэмжээ 10 %-иар нэмэгдэх боломжтой .

3.5. Хот тосгон бусад суурин газрын суурьшилын бүсийн газрын нөөц нөхцөлийн төлөвлөлт.

Хот суурингийн газрыг зөв оновчтой ашиглаж, хамгаалахын тулд суурьшилийн тэг гортиг доторх нутаг дэвсгэрийг хотын функциональ бүсүүдэд төрөлжүүлэн ангилж /хүснэгт 37/ тэдгээрийн үүрэг роль, онцлогийг тодорхойлов. Үүнд:

1. Амины орон сууцны бүс. Энд сумын төвүүдэд орших айл өрхийн дангаараа буюу хэд хэдээрээ тодорхой эзэмшил газар хайс, хашаатайгаар нэг буюу хэд хэдэн байр орон сууцыг блоклон барьсан хөршийн хэлбэрээр оршин сууж байгаа амины орон сууцны барилгын газрыг багтаасан бөгөөд энд нийтдээ 97.2 га талбайг хамрууллаа. Энэ бүс нь Хутаг-Өндөр, Орхон, Баяннуур, Баян-Агт, Булган, Бүрэгхангай, Гурванбулаг, Могод, Рашаант, Сэлэнгэ зэрэг сумдын суурьшилын бүсэд тод ажиглагдана. Энд бие засах газар, муу усны цооног,

хогийн цэг зэрэг нь нийтийнх байна. Ихэвчлэн гадна талаараа жижиг хайс хашаа барьжээ.

2. Нийтийн орон сууцны бүс. Энэ бүс нь аймгийн төвд тод илрэх бөгөөд 3-4 давхар баригдсан төвлөрсөн усан хангамж, инженерийн системд холбогдсон газар байх бөгөөд эзэмшил газар багатай, байрнаас хайш хайшаа 50 м газрыг нийт дундаа эзэмшинэ. Энд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дэлгүүр зэрэг тусгайлан баригдсан цогцолбор үйлчилгээний төв баригдаагүй. Энд тэнд бичил хороолол маягаар 3-5 ширхэгээр нэг дор баригдсан байна. Гаднаа аж ахуйн жижиг агуулахын зориулалттай амбаар сав, нэгдсэн нэг хогийн цэгтэй. Эдгээр бичил хорооллууд нь социализмын үед хот төлөвлөлт, архитектурын төслийн дагуу баригдсан нийтдээ 14.2 га талбайг эзлэн оршино.

3. Гэр хорооллын бүс. Энэ бүс нь дээрх 2 бүсийг бодвол аль ч сумд нэлээд түгээмэл хөгжингүй оршино. Эзлэх талбайн хувьд ч харьцангуй их 2220.6 га талбайг эзлэн оршдог бөгөөд нийт хүн амын дийлэнх хувь амьдардаг орон сууцны нэг хэлбэр юм. Энд айлууд хороо, гудамны хэлбэрээр уг бүсийг үүсгэх бөгөөд 1 гудам хооронд 10-20 м, 1 өрхөд 20*35 м газар дундажаар оногдоно. Цахилгаан, зөөврийн усан хангамж, зарим газар өрхийн эмнэлэг, дэлгүүр, ТҮЦ байна. Хогоо суурьшилын бүсийн хогийн цэгт голдуу зөөвөрлөн хаядаг. Гэр хорооллын газрыг төлөвлөхдөө зам, шугам сүлжээ, усан хангамж, сургууль, эмнэлэг цэцэрлэг зэрэг хүн амын үйлчилгээнд зайлшгүй хэрэгцээт объектуудыг барих газрыг урьдчилан төлөвлөж тусад нь авч үлдэх хэрэгтэй. Гэр хорооллын газар нь дийлэнх хүн амын орон сууцны хэрэгцээг хангадаг учир цаашид сум бүрт тодорхой хэмжээний газрыг шинээр олгохоор төлөвлөж өгсөн /зураг/ бөгөөд гэхдээ эхний ээлжинд гудам хооронд байгаа онгорхой, тасархай газруудыг нөхөж олгох, цаашид шинээр төлөвлөсөн газарт газар олгох нь зүйтэй. Энд нийтдээ 495 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд гэр хороололд олгохоор төлөвлөлөө.

4. Нийтийн үйлчилгээний бүс нь дотроо үүрэг, зорилго, хариуцлагынхаа дагуу хэд хэдэн төрөлжсөн бүсэд хуваагдаж болох боловч “бүгдийг нэг дороос” гэсэн зарчмыг баримтлан худалдаа ахуйн үйлчилгээний салбаруудыг нэг дор төвлөрүүлэн төлөвлөх ёстой. Энэ бүсэд банк, холбоо, дэлгүүр, гуанз, бар, ресторан, хүнсний зах зэрэг үйлчилгээний газруудыг багтааж 346.5 га газрыг хамрууллаа. Гэвч зарим суурин газруудад энэ бүсийн ялгаа одоогоор тод ажиглагдахгүй байгаа боловч хойшид баримтлах үүднээс боломжтой газруудад уг бүсийг ялгаж өгөв. Энэ бүс нь эдийн засгийн нөлөө бүхий төв суурин газруудыг холбож өгсөн замаас зайлшгүй хол зайд тухайн үйлчилгээний газар руу ирэх хөдөлгөөнийг хүлээн авч хэд хэдэн цэг рүү саадгүй сарниулж чадах орон зайн нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой боловч дээрх суурин газрууд нь томоохон хотуудын хэмжээнд хүртэл хөгжиж чадаагүй учир эсрэгээр зам дагуу төв суурин газраа бараадан байрласан байна.

5. Спорт, амралтын бүс. Энэ бүсэд спортын болон соёлын ордон, морин тойруулга, морь барих газар, наадмын талбай, биеийн тамирын талбай зэргийг хамарч нийтдээ 220.4 га талбайг эзлэнэ.

6. Ногоон байгууламжын бүс. Уг бүсэд төв суурин газруудын эзэмшил доторх болон зориудаар байгуулсан сад, цэцэрлэг хойшид байгуулж болох ногоон байгууламжийг хамруулав. Уг бүс нь хүн амын эрүүл мэнд, нөхөн сэргэх, алжаал ядаргаагаа тайлах, агаарын бохирдлыг багасгахад чухал үүрэг гүйцэтгэх учир хот төлөвлөлтөнд байх зайлшгүй бүс юм. Одоогоор уг бүс нь 4.9 га талбайг эзлэж байгаа нь нийт суурьшилийн бүсийн дөнгөж 0.02 %-ийг эзлэж

байгаа нь туйлын хангалтгүй байгаа учир цаашид энэ хэмжээг 17.6 га талбайд хүргэхээр төлөвлөв.

7. Аж үйлдвэрийн бүс. Булган, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Сэлэнгэ /Хялганат/ зэрэг сумдаас бусад газар уг бүс нь төдийлэн тод ялгарахгүй боловч хөдөө аж ахуйн машин –тракторын бааз-засварын газар, авто граж-засварын газар, саалийн ферм, гахай тахианы ферм, газар тариалангийн бригад, салаа, ХАА-н бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийдэг жижиг цех, үйлдвэр агуулах гэх мэтийн хэлбэрүүдээр илэрдэг онцлогтой. Уг бүсийн газрыг төлөвлөхдөө аль болох хотын тэг гортигийн гадна буюу салхин дор газар байгуулах нь хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд чухал ач холбогдолтой.

8. Эрүүл мэнд соёл боловсролын бүс. Энд бага дунд ерөнхий боловсролын сургууль, ТМС, цэцэрлэг, эмнэлэг зэрэг газруудыг аль болох тусад нь ялгаж бүс байхаар төлөвлөсний дээр бусад зориулалтын газарт олгохгүй байх нь зүйтэй.

9. Засаг, захиргааны бүс. Энд мэдээжийн хэрэг, аймаг болон сумын захиргаа, банк, холбоо гэх мэтийн захиргаа, удирдлагын ач холбогдол бүхий объектуудыг байхаар төлөвлөв.

10.Зам харилцааны бүс. Энд хот суурингийн тэг гортиг доторхи төв болон туслах чанартай замуудыг төлөвлөж га газрыг багтаалаа. Эдгээр замууд нь 5-7 м-ийн өргөнтэй байх бөгөөд дээр нь хамгаалалтын зурвас 1-3 м байна. Хатуу хучилттай болон ердийн шороон зам байж болно.

11.Өрхийн мал аж ахуйн бүс. Хөдөөгийн хот суурин газрын иргэд цөөн тооны мал агуулах сонирхол өндөр байдгийг харгалзан мал бүхий иргэдэд зориулж уг бүсийг ялгаж өглөө. Энэ бүс нь суурьшилын бүсийн тэг гортигноос гадна байхаас гадна мал бэлчээх зам нь хотын тэг гортиг дундуур гарахгүй аль болох бэлчээр усандаа ойр байхаар төлөвлөнө. Мөн малаас гарч байгаа өтөг бууцыг ч хаана хаях газрыг бодолцох хэрэгтэй. Булган суманд сумын зүүн урд хэсэгт, Тэшиг суманд мөн ялгаагүй, Хутаг-Өндөр суманд баруун талд нь гэх мэт суурингийн тэг гортигноос гадна байхаар төлөвлөв.

12. Ногооны газрын бүс. Ногооны бүсийг аль болох суурьшилын тэг гортигноос гадна талд үржил шим бүхий хөрстэй, усалгаанд ойр газар олгох хэрэгтэй / Булган, Бугат, Могод , Дашинчилэн, Цульхир, Уньт/.

13. Эрүүл ахуйн бүс. Хот суурингийн тэг гортиг дотуур дайран өнгөрч байгаа гол горхи, булаг шанд, мөн худаг, усан сан зэргийг ундны усны эх үүсвэр хэмээн үзэж тэдгээрт 100 м-ээс доошгүй өргөнтэй эрүүл ахуй хамгаалалтын бүс татав. Хотын тэг гортиг гортиг дотор дээрх зайлшгүй байх ёстой, тусгай үүрэг хариуцлага бүхий функциональ бүсүүдийг ялгаж өгсөнөөс гадна ойрын ирээдүйд барилгажих газар, шинээр суурьших гэр хорооллын газар мөн цаашид хот тэлэн өргөжих бүсийг тусад нь төлөвлөв. Үүнд.

14. Барилгажих бүс. Энд юуны өмнө одоогийн байгаа барилгажсан талбайн нягтралыг дээшлүүлэх асуудлыг нэн тэргүүнд тавих бөгөөд дараагийн ээлжинд бидний дурьдсан газруудад газар олголт хийх юм /зураг/. Газар олголтыг хийхдээ барилгажих хэсгээс гадна тухайн орчны тохижилт, хашаа хайс, зам харгуй, ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлтийн асуудлыг давхар хөндөж цаашид үүнд хяналт тавих хэрэгтэй. Энд нийдээ 223 га газрыг шинээр барилгажих газарт олгохоор сум бүрт төлөвлөв.

15.Шинээр олгох гэр хорооллын газар. нь барилгажих газрын нэгэн адил

одоогийн гэр хороолол дотор байгаа онгорхой цоорхой газар, гудамуудыг нөхөх гүйцээх замаар хийгдэх бөгөөд дараагийн ээлжинд бидний заасан газруудад гэр бүлийн хэрэгцээнд шинээр газар олгоно / зураг/. Гэхдээ гэр хорооллын газарт байх өрхийн эмнэлэг, хүүхдийн цэцэрлэг, худаг, дэлгүүр зэрэг наад захын үйлчилгээний газруудыг байхаар төлөвлөж газрыг бусад хэрэгцээнд олгохгүй байх хэрэгтэй. Энэ хэрэгцээнд сум бүрт тухайн газрыг зааж нийт 495 га газрыг төлөвлөв.

16. Хот тэлэн өргөжих бүс. Хот хэтийн ирээдүйд тэлэх бүсийг сум тус бүрээр гаргаж нийт 599 га газрыг хамрууллаа. Энд Тавтын алтны уурхайг даган хөгжих суурин том байр суурийг эзлэх бөгөөд “2020 хүртэл хөгжүүлэх Монгол Улсыг ГЗЕТөлөвлөгөөнд “ 0.5 мян. хүн амтай 170 өрхтэй 85 га газрыг хамарсан суурин байхаар төлөвлөжээ. Гэвч судалгааны үед яг уурхайн орчим уг суурин байгуулах нь хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд зохимжгүй гэж үзсэн учир Тэшиг сумын баруун талаар уг сууринг /2000 хүн амтай/ байгуулахаар төлөвлөлөө. Мөн Сэлэнгэ суманд Эгийн голын цахилгаан станцын дэргэд 200 хүн амтай суурин хөгжүүлэхээр төлөвлөв. Түүнчлэн одоогийн Хантай багийн суурингийн оршиж байгаа газар нь Эгийн голын УЦС-ийн усан сангийн доор орох болж байгаа тул 10 гаруй км –т нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөлтөнд тусгалаа.

Дээрхээс гадна хот суурин газрын төлөвлөлтөнд хотын хогийн цэг, оршуулгын газрыг зайлшгүй байхаар төлөвлөж өгөх шаардлагатай бөгөөд тэдгээрийг одоогийн байгаа газарт, хэмжээг бага зэрэг тэлэх маягаар ойрын үед ашиглахаар төлөвлөв.

Төв суурин газруудын төлөвлөлийн зургийг сум, томоохон багийн төв тус бүрээр 1:2 000 масштабаар хэвлэн гаргав.

Дүгнэлт .

Булган аймгийн хот суурингийн суурьшилын бүс нь ерөнхийдээ социализмын үеийн хот төлөвлөлтийн дагуу баригдсан. Зах зээлийн үед нэг хэсэг барилгажих асуудал нэг хэсэгтээ зогсонги байдалд орсон боловч сүүлийн үед аж ауйн нэгж байгууллага, гадаадын төсөл, улсын төсвөөр нэлээдгүй шинэ барилга баригдах буюу сэргээн засварлах ажил эрчимтэй явагдаж байгаа. Гэр хорооллын хувьд ч харьцангуй үсрэнгүй хөгжиж байна. Аймгийн төв Булган сум нь зах зээлийн харилцааны шинэ нөхцөлд хотын ерөнхий төлөвлөгөө батлуулж хэрэгжүүлсэн цөөхөн хэдэн сумын тоонд ордог, энэ утгаараа бусад сумдаа бодвол суурьшилын бүсийн функциональ бүсүүдийн ялгаа нэлээд тод ажиглагддаг сум юм. Бусад сумын төвүүдийн суурьшилийн бүсүүдийн хувьд функциональ бүсүүдийн ялгаа төдийлэн ажиглагдахгүй нэг нь нөгөөгөө орлох маягаар явдаг. Харин гэр хорооллын бүс харьцангуй тод ялгарна. Иймд цаашид хот суурингийн суурьшилын бүс газрыг үндэслэлгүй тэлэх асуудлыг хязгаарлах, барилгажилтын нягтралыг сайжруулах, бүсүүдийн ялгаа, үүрэг ролийг тодотгох, орон зайн шийдэлийг зөв зохицуулах хэрэгтэй. Төлөвлөлтийн ажлын хүрээнд 495 га газрыг гэр хорооллын газарт, 223 га газрыг шинээр барилгажих газарт, бусад зориулалтаар хот тэлэх газарт 599га талбай олгохоор тус тус төлөвлөв.

3.5.3. Үйлдвэр уурхайн бүс газар, тэдгээрийн нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Булган аймгийн нутаг дэвсгэрийн 96 % нь 1: 200 000 масштабын 20 орчим хувьд нь 1: 50 000 масштабын геологийн зурагаар бүрхэгдсэн бөгөөд, одоо давхардсан тоогоор 277 аж ахуйн нэгж 3 249 296,4 га талбайд ашигт малтмалын эрэл хайгуулын ажил гүйцэтгэж байгаа нь Булган аймгийн нийт нутгийн 67% болж байна. Эдгээр ажлын үр дүнгээр доор дурьдагдаж байгаа

ашигт малтмалын орд, илрэл, эрдэсжсэн цэгүүдийн эдийн засгийн ач холбогдол бүр тодорхой болохоос гадна цаашид геологи хайгуулын ажил явуулах хэтийн төлөв бүхий талбайн сонголт хийгдэх юм.

Түүнчлэн одоо 16 ашиглалтын лицензээр эзэмшиж байгаа 15 214,1 га газрын 63% буюу 9645,5 га газар уурхайн эдэлбэрт орох болно.

Энэ ажлын хүрээнд сүүлийн 40-өөд жил цугларсан геологийн судалгааны бүх материалыг системчилэн нэгтгэж боловсруулалт хийсэн ба агаар сансрын зургийн товлол тайлалыг ашиглан ойрын жилүүдэд ашиглах ашигт малтмалын орд илрэлүүд, түүнийг түшиглэн босох уул уурхайн үйлдвэрүүдийн хэтийн төлөвийг тодорхойлж, уурхайнуудыг түшиглэн байгуулагдах үйлдвэржилтийн бүс газруудыг төлөвлөв.

Булган аймгийн нутагт хар металлаас төмрийн 1 орд, 6 илрэл, хромын 1 илрэл, титаны 2 эрдэсжсэн цэг, гянтын 2 илрэл, өнгөт металлаас зэсийн 3 орд, 20 илрэл, 84 эрдэсжсэн цэг, хөнгөн цагааны 2 илрэл, молибдений 1 орд, 3 илрэл, мөнгөн усны 1 эрдэсжсэн цэг, бериллийн 2 эрдэсжсэн цэг, ниобий 3 эрдэсжсэн цэг, үнэт металлаас алтны 2 орд, 4 илрэл, мөнгөний 1 эрдэсжсэн цэг, Металл бус ашигт малтмалаас нүүрсний 1 орд, 2 илрэл, бал чулууны 1 эрдэсжсэн цэг, хайлуур жоншны 2 илрэл, гоёлын чулууны 9 илрэл, 3 эрдэсжсэн цэг мусковитийн 6 илрэл, барилгын материалаас тоосгоны шаврын 4 орд, шохойн чулууны 3 орд, хайрганы 7 орд, элсний 1 орд, барилгын чулууны 4 орд, галт уулын шааригийн 5 орд, Шилэн хөвөнгийн 4 орд, асбектийн 1 илрэл, рашаан усны 1 орд илрээд байгааг нэгтгэн үзвэл 24 төрлийн ашигт малтмалын 112 орд, 70 илрэл, 200-гаад эрдэсжсэн цэг тогтоогдоод байна. Эрдэм шинжилгээний сэдэвчилсэн судалгааны ажлуудаар бүтэц хэлбэршлийн, металлогенийн болон хүдрийн бүсүүд ялгагдсан нь тус нутгийн эрдэс баялагийн хэтийн төлөвийг тодруулж байна. Эдгээрээс алтны шороон орд, барилгын материалын зарим орд, илрэлүүдийг орон нутгийн чанартай ашиглах боломжтой. Нарийн технологи шаардагдах орд газрыгадаад дотоодын зах зээлийн хэрэгцээ шаардлагаас шалтгаалж хамтарсан үйлдвэрийн хэлбэрээр ашиглах юм. Эдийн засгийн хувьд ашигтай ойрын 15 жилд ашиглалтанд орох магадлалтай ашигт малтмалын 13 орд газрыг сонгон газар бүсчлэн хуваарилах төлөвлөлтөд тусгалаа. Үүний үр дүнд 2 газарт үйлдвэржилтийн бүс үүсэх төлөвтэй байна. Үүнд:

- Бүрэгхангай сумын нутаг дахь алтны бүлэг ордын бүс
- Тэшиг сумын Тавтын алтны орд

Тэшиг сумын Тавтын алтны ордыг Малайзын хөрөнгө оруулалтаар ашиглаж эхлэхээр болоод байгаа бөгөөд энэ ордыг ашигласнаар жилд 500 кг алт олборлох юм.

Эрдэс баялгийн олборлолт, боловсруулалтыг дагаж Хуучин Тэшиг сумын төв байсан газар 2010 онд 2000 гаруй хүнтэй суурин шинээр үүснэ гэж тооцоолов.

3.5.4. Амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын талаар

Шинээр нийт 46 аялал жуулчлал, амралт сувилалын газар болон хүүхдийн зуслан байгуулахаар 111,5 га газар төлөвлөв. Үүнд:

Булган сумын нутагт Булган уулын хамгаалалтын бүс нутагт - 5га,
Бүрэгхангай: Ногоон морины ам- 2 га, Хахаачийн ам – 2 га,

Хавиргын хайлаастайн ар – 2 га, Бодь модны ам -2 га, Бичигт хадан хошуу -2 га, Зүрхийн ам - 2 га, Асгат дулааны ам - 2 га,
Дашинчилэн: Чин толгой-1 га, Цогтын цагаан байшин орчим - 1 га,
Могод : Хулжийн халуун рашаан /Автобусны сэгнээс дэрс дагаад Сайрын булан хүртэл /-3га, Асгатын адаг – 1 га, Сэнжид Бураатад 3 га,
Орхон: Оросын булагт – 2 га, Мойлтын нугад – 2 га, Чингэлийн голын Ар булагт - 1 га,
Хутаг - Өндөр : Гуртын ширгүү - 2 га, Уньтын бэлчир – 2 га, Хавиргын уулын бэлд - 2га, Улиастай - 2 га, Хануйн бэлчир – 2 га, Дондогийн бэлчир – 2 га,
Тэшиг: Эг Тарвагатайн болон Төмрөнгийн голын сав дагуухи мөн байгалийн үзэсгэлэнт газар – 1 га, Харгал, Ямаат орчмын газарт болон Эгийн голын сав дагуу – 3 га, Эрэн Тавт, Эгийн голын сав дагуу газарт – 2 га, Эрэн болон Жаргалант голын сав дагуу болон бусад байгалийн үзэсгэлэнт газарт – 1 га,
Хишиг - Өндөр: Наран-10 га, Бэлчир-1 га, Могой-1 га, Бургаст-1 га, Жагайт-1 га,
Хангал: Бизъяад -1 га, Галтайд – 4 га, Цуврайд – 4 га, Нумтад 2 га,
Баян-Агт: Цагаан голын рашаан - 2.5 га, Шарга нуурын орчим - 1 га, Бага нуурт- 0.5 га, Хануйн рашаан – 2 га,
Гурванбулаг: Олон төнхлөг – 3 га, Уурхай-2 га,
Сэлэнгэ : Валын хадны орчим – 5 га, Дух нарсанд – 5 га,
Сайханд: Хунтын рашаан – 5 га, Рашааны нугад - 2 га, Аятайд 1.5 га
бүгд 111.5га

Ойрын 15 жилд аялал жуулчлал амралт сувилалын 3 гол бүс, 2 дэд бүс шинээр бий болох хандлагатай байна.

Гол бүсүүд нь :

1. Дашинчилэнгийн
2. Хутаг-Өндөрийн
3. Уран тогоо уулын

Дэд бүсүүд нь :

1. Хунт нуурын
2. Эгийн голын

Дээр дурдагдсан аялал жуулчлал, амралт сувилалын бүс нутгуудын рекреацийн боломж бий болгосон материаллаг бааз болон үзэж харах зүйлс, сонгон авсан үндэслэлүүдээ дор сийрүүлье.

1. Дашинчилэнгийн төлөвлөгдөж буй бүс

Улаанбаатар хотоос Лүн сум 132 км, Баяннуур сум 60 км, Чин толгойг дайраад Цогтын цагаан балгас 30 км, Дашинчилэн сум 40 км, Хар бухын голын балгас 13 км, Гурванбулаг сум 40 км, Хөгнө хөн уул 30 км, Рашаант сум 30 км, Эрдэнсантаар 40 км дамжин Улаанбаатар хот 195 км. Аялах замын урт 650 км, Аялах хугацаа 3-4 хоног.

Лүн сумаас Өвөрхангай, Хархорин чиглэлд явахад хөдөлгөөний нягтрал ихтэй байдаг, Элсэн тасархай хүртэл байгалийн нөхцөл нэг хэвийн уйтгартай замаар явах тул суртчилгааг сайн хийж Хархорин явах жуулчдын чиглэлийг Мянганы замаар Баяннуур, Дашинчилэн сумын нутгаар харганат хээр, элсэн довцог, шувууд чуулсан хужир мараа бүхий нуур цөөрөм хосолсон байгалийн үзэсгэлэн, түүх соёлын дурсгалт зүйлсийг сонирхон Өгий нуур хүрээд тэндээс урагш Хархорин орж төв замаараа Улаанбаатарт ирдэг эсвэл үүний эсрэг чиглэлд аялдаг маршрутыг зохион байгуулах хэрэгтэй. Ингэснээр Баяннуур Дашинчилэнгийн шинэ аялал жуулчлалын төвийг бий болгох юм.

Их Цагаан нуур Их замын хойд талаар ойрхон орших ээгст нууруудад зуны цагт шувууд их цуглардаг. Хамгийн том нуур нь Их Цагаан нуур юм.

Чин толгойн хэрэм Дашинчилэн сумын төвөөс зүүн хойш 18 км-т Чин толгойн зүүн ёроолд Х зууны үеийн Хятан улсын үеийн хотын хэрэм байдаг. Хожим нь энд ХҮИ зууны үеийн Цогт хунтайжийн цэргийн хүрээ байжээ. Хэрмийг хөрсөнгөөр барьсан нь уран барилгын сонин жишээ юм.

Харуул овоо Чин толгойн оройд 40 м голчтой, 30 орчим м өндөр овоо байдаг. Эдгээрийг 1998 онд улсын хамгаалалтанд авчээ.

Цогт хунтайжийн цагаан байшин Чин толгойн хэрэмнээс зүүн хойш Халдан зүрх уулын бэлд Туулын хөндийд байдаг. Энэ нь Цогт Хунтайжийн ээж Мадай Тайгал хатны өргөө номын сургууль байжээ. Одоо байшингийн хана таван м орчим өндөр чулуун тавцан, бичигт хөшөө байдаг. 1601 оноос барьж эхэлсэн энэ дурсгалыг яаж барьсаныг бичсэн бичиг бүхий чулуун хөшөө энэ харшнаас баруун тийш холгүй байдаг. Энэ дурсгалыг 1971 онд улсын хамгаалалтанд авчээ.

Хар бухын голын балгас Дашинчилэн сумын нутагт Харбухын голын гүүрний хажууханд байдаг. Галт уулын хүрмэн чулуу, билүү занар, чулууг үелүүлэн алаглуулж өрж барьсан 2 давхар ордны маш үзэсгэлэнтэй хана суврага үлджээ. Х зууны үеийн Хятан улсын үеийн хотын хэрэмний туурь дотор Монголчууд энэ чулуун хийдийг ХҮИ зууны үед барьсан бололтой. Хадаасангийн балгас гэж нэрлэдэг энэ дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтанд авчээ.

Номын булгийн рашаан Хар бухын голын гүүрнээс баруун тийш 5 км орчимд замын хойд талд байдаг. Ходоодны өвчнийг анагаахад уудаг.

1. Уран уулын байгалийн дурсгалт газар.

Булган хотоос Ачуутын голыг өгсөж Баруун туруун Чачиртай голыг гаталж Тээлийн голыг өгсөж Түлүүгийн даваа 52 км, Мэргэний хөтлөөр давж Уран уул 13 км- Хутаг сум 68 км Бийбулагийн хийдийн туурь 10 км замын урт 300 км аялах хугацаа 2-3 хоног.

Энд Булган- Уньт –Мөрөнгийн хатуу хучилтай зам, Эрдэнэт - Мөрөнгийн чиглэлийн төмөр зам дайран өнгөрөх тул гол хөдөлгөөн, хүмүүсийн урсгал төвлөрөх нь мэдээж юм. Энд аялал жуулчлалын 3 дахь бүс нутаг төвлөрөх юм.

Байгалийн дурсгалт газар Уран уул нь Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутагт Булган хотоос баруун хойш 80 км зайтай, Булган хотоос Мөрөн явдаг их замын баруухан талд орших унтарсан галт уул юм. 1686 м өндөр, орой дээрээ тогоотой Уран бүрхээр уулын тогооны амсар нь 500-600 м орчим, өргөн, гүн нь 50-60 м бөгөөд бороо хур ихтэй жилд ёроолдоо 20 м орчим голчтой нуур үүссэн байдаг. Тогооны урд ирмэгээсээ ёроолоо хүртэл шинэсэн ой модтой. Урангийн хөндийд орших унтарсан галт уулс болох Тулга, Тогоо, Жалавч уулнууд нь Уран уулнаас ургаш 12 км зайд оршино. Тулга уулын амсар нь гурван газраар сэтэрч тулгын гурван чулуу шиг харагддаг учир Тулга гэж нэрлэжээ. Эдгээр уулсыг 58 х. д. км талбайтайгаар 1965 оноос улсын тусгай хамгаалалтанд авсан байгалийн дурсгалт газар юм. Ойн сан бүхий газар нь 836 га байна.

2. Хутаг-Өндөрийн бүс.

Бий булагийн хийдийн туурь Хутаг сумаас баруун хойш 10 км-т Сэлэнгэ мөрний хойд хөвөөнд IX - X зууны үеийн Уйгар улсын худалдааны төв хот байжээ. Хожим 1588 онд Монголчууд хэрмэн дотор нь сум барьж Бийбулагийн хийд гэж нэрлэжээ. 1998 онд улсын хамгаалалтанд авсан.

Булган хотоос гарч Ачуутын голыг өгсөн Баруун туруун, Чачиртайн голыг гаталж Тээлийн голыг өгсөж Түлүүгийн аваагаар даваад 52 км Мэргэний хөтлөөр давж Уран уул 13 км урагш эргээд Баян Агт сум 84 км, Шарга нуур 30 км, Цэгээн нуур 30 км, Сайхан сум 60 км буцаад Булган хот 100 км Аялах замын урт 400 км, Аялах хугацаа 2-3 хоног.

4. Хунт нуурын бүс

Асгатын рашаан Сайхан сумын төвөөс урагш далайн түвшнээс дээш 1480 м өндөр газарт байдаг. Шинэ төрмөлийн эриний хар бараан өнгөтэй маш зузаан хүрмэн чулууны судал дороос нэг эхтэй булаг оргилон гарч 5 м хиртэй урсаад хүрмэн чулуун асган доогуур шурган ордог. Өвөл хөлдөлгүй харзлан урсдаг, ундрага нь цагт 9600 л орчим. Өвөл зунгүй усны хар оготоно байнга байдаг. Нутгийн хан дотрын элдэв өвчинд уудаг.

Сайхан сумын нутаг Байширын ус гэдэг газарт байгаа буган чулуун хөшөө бүхий цогцолбор, Могойн гол, Шинэ ус нуурын зүүн тал Хиргист хөндийн аманд орших Уйгарын Моюнчурын гэрэлт хөшөө зэргийг 1971 онд улсын хамгаалалтанд авчээ.

Хунт нуур Сайхан сумын төвөөс баруун урагш 26 км Орхоны савд далайн мандлаас дээш 1350 м өндөрт рашаан нуур байдаг. Эргэ тойрон хадтай цав толгод, боржин цохио хадаар хүрээлэгдсэн, шавар шороон хурдас ихтэй уудам хотос хонхорт тогтсон гүн нуур. Нуурын баруун хойно 600 м орчим зайнд боржин суурьтай элсэрхэг дэнжийн хааш хаашаа 15 м зайтай хүр хөмгөөс энэ гүний рашааны олон булаг ундрэн гарч бүгд нийлээд нуурыг тэжээх бөгөөд заримдаа газарт шургаж замхарсан байдаг. Бүх булгийн нийлбэрээс доогуур нийлбэр ундрага нь цагт 2160 л ус болж байна. Өвөл хөлдөггүй байнга харзлан урсдаг. Хунт нуурын хэмжээ 1 км урт, 500 м орчим, нилээд гүнзгий юм. Энэ нуурын хавиар хүхрийн үнэртэй нарийн ширхэгтэй хар хөх болон хар бор өнгөтэй, их эрдэсжсэн лаг наанги шавартай. Үе мөчний өвчтэй хүмүүс нуурын усанд орж, шавар эмчилгээ хийх, Ходоод гэдэсний өвчтэй хүмүүс булгаас нь ууж эмчилдэг.

Энэ рашааны хавьд бүдүүвтэр ширхэгтэй, цайвар саарал өнгийн цайвар гялтгануурт боржин хийгээд диорит зэрэг чулуу нь герциний үеийн гүний боржиндуу чулуулаг болохын дээр тэнд одоо цагийн буюу дөрөвдөгч галавын үйрмэг чулуун болон шаварлаг тунамал хурдас дүүрсэн мөнх цэдвэг, улирлын цэдвэг зэргийн нөлөөгөөр үүссэн хонхор овгор, товгор энхэл тунхал газрууд эргэн тойрон тогтсонтом жижиг нуурууд захаар нь ургасан дэрс, зэгс, хужир марз ихтэй. Энэ орчимд дэрс цахилдаг, ширэг өвс зонхилсон хээр тал, уул толгод бөгөөд тэр хавьд хойш чиглэсэн урссан Орхон голын баруун хойно 2-3 км зайд байна.

5.Эгийн голын бүс

Булган аймгийн хэмжээнд хамгийн сүүлд төвийн эрчим хүчний системд холбогдсон нь Тэшиг сум юм. Улаанбаатар хотоос 7 хоногт 1 удаа онгоцоор тогтмол нислэг хийдэг. Нислэгийн хугацаа 1 цаг 20 мин.

Тэшиг сумын Шувууны үүрийн рашааныг ходоодны шархтай хүмүүс ууж хэрэглэдэг.

Тэшиг сумын төвд онгоцоор очиж Эг Сэлэнгийн бэлчир, Эг Тарвагатайн бэлчир, Эрээн Тавтын бэлчир зэрэг газруудаар усан замаар аялан загасчилж болох юм. Рекреацийн асар их нөөцтэй нутаг боловч зам харгуй хүндрэлтэй учир одоохондоо аялал жуулчлалын төв болж хараахан чадаагүй байна.

Тавтын алтны орд ашиглагдаж эхлэх, Мянганы замын босоо тэнхлэгийн зам баригдаж дуусах үед аялал жуулчлалын том төв болох нь гарцаагүй.

1. "Централ Монголиан Айрлэнз" ХХК-ийн Тавтын жуулчны бааз Тэшиг сумын төвөөс баруун тийш 33 км, Тэшиг сумын Эг-Тавтын голын бэлчирээс холгүй, Эгийн голын хойд хөвөөнд Шарлинт гэдэг газар байрладаг. Нэг ээлжинд 20 хүн хүлээн авах бололцоотой.
2. "Централ Монголиан Айрлэнз" ХХК-ийн "Баруун Согоот" жуулчны бааз Эгийн голын шинэ гүүрнээс баруун тийш 12 км-т Эгийн голын хойд хөвөөнд Эмт гэдэг газар байрладаг, Нэг ээлжинд 20 хүн хүлээн авах бололцоотой.

Хутаг-Өндөр сумаас 68,0, Тэшиг сумаас 173,2, Сэлэнгэ сумаас 197,2 мянган га нутгийг нийт 438,4 мянган га газрыг хамарсан нутгийг хамарсан Зэд - Бүтээлийн нурууны Дархан Цаазат газрыг байгуулахаар судалгааны ажлыг дуусгаж, үндэслэлийг боловсруулаад байна.

3.6. Зам, шугам сүлжээний газрын төлөвлөлт

3.6.1. Авто замын газрын төлөвлөлт

Мянганы замын хэвтээ тэнхлэгийн баруун чиглэлд Лүн -Дашинчилэн 94 км, Дашинчилэн - Өгийн доод гүүр 106 км, босоо тэнхлэгийн чиглэлд Бага-Илэнхийн боомтоос Булган - Хархорин одоо ашиглагдаж буй зам бөгөөд сайжруулалтын арга хэмжээнд хамрагдана. Эрдэнэт Мөрөнгийн чиглэлд 141,2 км хатуу хучилттай замыг барихад 26,3 тэрбум төгрөг зарцуулна. Хануй Эгийн гол дээрх төмөр бетон гүүр барих ажилд 470 сая төгрөг зарцуулсан. Эдгээр замуудын нилээд хэсэг нь хуучин хэсэгчилсэн хайрган хучилттай улсын чанартай зам байсан тул зөвхөн хучилт нь өөрчлөгдөж шинээр паспоржуулах 260 км замд 2600 га (1040 га) газар төлөвлөгдөж байна. Эдгээрийн 2576 га нь бэлчээрээс 24 га нь ойн сангаас хасагдаж байна.

3.6.2 Төмөр замын газрын төлөвлөлт

Эрдэнэт - Мөрөнгийн төмөр замыг байгуулснаар Бүрэнхааны фосфоритын орд , Алаг-Эрдэнийн хөнгөн цагааны ордууд ашиглалтанд орж жилдээ 2-2,5 сая тонн баяжмал төмөр замаар тээвэрлэгдэх бололцоотой. Энэ төмөр зам нь Бүрэнгийн нурууны салбар уулсын хөндийгөөр Алтаатын голын дагуу Сэлэнгэ мөрнийг гатлан Хутаг-Өндөр сумын төвөөр дайран Намнан уулын ар бэлээр Хөвсгөл аймгийн Их уул сум орно.

Хэтийн төлвөөр 246,2 км урт төмөр зам 6 өртөөнд нийт га газар, үүнээс өртөөнд 360 га газар, төмөр замын зурвас газарт 2810,4 га шаардлагатай ба нийт 3170,4 га газар төмөр замд ашиглагдахаар төлөвлөгдсөн болно. Өртөөний уртыг 2 км, өргөнийг 300 м байхаар Төмөр замын зурвасыг 120 м байхаар тооцов. Энэ зурвасыг байгуулснаар тусгай хамгаалалттай газраас 7,2 га, ойн сангаас 50,4 га, тариалангаас 36 га, бэлчээрээс 3076,8 га газар хасагдах тооцоо байна.

3.6.3. Шугам сүлжээний газар, түүний төлөвлөлт

Ирээдүйд Булган аймагт “Монгол улсын эрчим хүчний нэгдсэн систем” хөтөлбөрийн хүрээнд баригдах эрчим хүчний эх үүсвэр, шугамуудад нийтдээ 1320.4 га газар шаардагдах юм. 220 кВт-ын 198 км урт , 400 кВт-ын 85,6 км урт шугам тавигдах бөгөөд эдгээр 1243,4 га 1156 га (2939 га) газрууд шаардагдана (110 кВ-ийн 190 км шугам 886 га газар) .

220 кВт-ын шугамын өргөн 12,8 м төлөвлөх зурвас нь шугамын захаас 25 м, 400 кВт-ын шугамын өргөн 25,6 м төлөвлөх зурвас шугамын захаас 30 м-ээр тооцов. Бэлчээрээс 117,6 га, ойн сангаас 144,4 га газар хасагдах тооцоотой байна

Эрдэнэт хотоос Хангал сумын төвийг дайруулан Хялганат тосгон хүртэл 200 суурин хэрэглэгч бүхий шилэн кабель тавих бөгөөд 240 сая төг зарцуулах юм.

3.7. Ойн сангийн газрын төлөвлөлт.

Ойн санг менежментийн дараахи 4 бүсэд хуваалаа /зураг, хүснэгт 3 8/. Үүнд:

1. Онцгой бүсийн ой. Энд Гурванбулаг сумын нутагт орших Хөгнө-Тарны БЦГазрын, Хутаг-Өндөр сумын Уран тогоо уулын ДГ-ын, Намнан уулын БНГ, Бугат сумын Ханжаргалант уулын БНГ-ын нийт 53 115 га ойг онцгой бүсийн ойд багтаалаа. Уг газар ямар нэг аж ахуйн үйл ажиллагаа явуулах, мод огтлохыг бүрмөсөн хориглох бөгөөд зөвхөн хамгаалалтын бүсэд нь аялал жуулчлалын үйл ажиллагааг тусгай заавар журмын дагуу явуулна. Өөрөөр хэлбэл зөвхөн ойг нөхөн сэргээх, хамгаалах, тордон сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг явуулна.

2. Хамгаалалтын бүсийн ой. Хамгаалалтын бүсийн ой нь нэлээн өргөн хүрээтэй бөгөөд дээр хэлснээр Булган аймгийн ой нь ерөнхийдээ хамгаалалтын шинж чанарыг агуулна. Учир нь тус аймгийн нутаг дэвсгэрт тархсан ойн ашиглалтын нөөц бага учир үйлдвэрлэлийн ач холбогдол гэхээсээ илүү байгаль орчны тэнцвэрт байдал хөрс, усыг хамгаалах ач холбогдол нь илүү гэж үздэг байна. Иймд энд аялал жуулчлал, аж ахуйн элдэв үйл ажиллагаа, ойн дагалдах баялаг, самар, жимс, мөөг түүх, мал бэлчээх, хадлан хадах, ойн цэвэрлэгээ огтолгоо хийх зэрэг зарим нэг үйл ажиллагааг тодорхой хуулинд заасан хэм хэмжээний дагуу хязгаарлалттай ашиглаж болно. Энд бид нийт 1 254 мян.га газрыг хамруулсан бөгөөд түүний 1 164 мян.га талбайг байгалийн ой, 80.9 мян.га талбайг гол, горхи булаг шандны эх орчмын эргэн тойрны 3-5 км доторх хориотой бүсийн ой, 9.8 мян. га талбайг сэргэн ургаж буй төгөл, сөөг эзлэж байна. Ойн хориотой бүсэд аливаа аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглох бөгөөд арчлах, тордохоос өөр зориулалтаар мод огтлохыг хориглоно.

3. Ашиглалтын бүсийн ой. Уг бүсэд ой зохион байгуулалтаар хэрэглээний түлээний мод бэлдэж болох бөгөөд Тэшиг, Сэлэнгэ, Хутаг-Өндөр сумдын 88 951 га талбайг хамрууллаа. Мод огтлолтыг түүвэрлэн огтлох аргаар явуулах бөгөөд нөөцийн 25 %, өтгөрлийг 0.5-с бууруулахгүйгээр өсвөр болон залуу модыг хамгаалах технологиор явуулах зарчмыг баримталах бөгөөд аймгийн хэмжээнд жилдээ 35.9 мян. метр³ мод огтолохоор төлөвлөсөн / хүснэгт 39/. Энд зөвхөн хуулинд заасан хэм хэмжээний дагуу модыг бэлдэж ашиглах бөгөөд. Тухайлбал, мод бэлтгэх өргөн 100 м-ээс, мод бэлтгэлийн 1 талбай 5 га-с хэтрэхгүй байх, мод бэлтгэсэн талбайдаа огтолсон 1 модны оронд 5 мод суулгах гэх мэт наад захын арга хэмжээнүүдийг мөрдлөг болгох хэрэгтэй.

4. Ойн сангийн бусад газар. Энд нийтдээ 470.7 мян. га газрыг хамруулсан бөгөөд үүнээс ойн цоорхой 55 229 га, ойгоос гадагш 100 м өргөнтэй авсан өвслөг газар 324 545 га, огтолсон ой 6375 га, түймэрт шатсан ой 80969 га, өвчин хортонд идэгдсэн талбай 3 550 га байна. Ойн цоорхой, ойн захаас гадагш 100 м өргөнтэй өвслөг газар нь аж ахуйн хэрэгцээнд өргөн ашиглагддаг бөгөөд энд

иргэд малаа бэлчээх, хадлан хадах, зуслан гарах зэрэг үйл ажиллагааг явуулдаг учир энэ орчмын газар хамгийн ихээр талхлагдаж хүний сөрөг үйл ажиллагаанд өртдөг. Иймд тус газрыг зөв зохистой унаган төрх байдлыг алдагдуулахгүй ашиглах, байгалийн жамаар мод өсөн үржих нөхцөл бололцоог хангаж өгөх бодлого барин ашиглах нь зүйтэй.

Ер нь цаашид аймгийн хэмжээнд түймэрт шатсан, өвчин хортонд идэгдсэн, мод огтолсон талбайг хэрхэн нөхөн сэргээх талаар дурьдвал: Үүнд:

1. Арчилгааны огтлолтыг нийт 24 648 га талбайд явуулах шаардлагатай байгаа бөгөөд ингэснээр ойн чанар бүтэц, бүрэлдэхүүн, ойн эрүүл ахуй, ариун цэвэр сайжраад зогсохгүй 337 965 мян. метр³ модыг аж ауйн хэрэгцээнд авч ашиглах боломж бүрдэнэ /хүснэгт 40/.
2. Цэвэрлэгээний огтлолтыг бүх насны ангид ойн нөөцийн 10-15 %-д явуулснаар хатсан хуурай унасан модыг цэвэрлээд зогсохгүй ойн түймэр, хортон шавьжинд идэгдэхээс сэргийлнэ. Энд 78 739 га талбайг хамруулж 1 608 085 мян. метр³, хатсан 457 756 мян. метр³ унанги мод авч ашиглах боломж бүрдэнэ /хүснэгт 41/.

Хүснэгт 41

Цэвэрлэгээний огтлолтыг хийх түүвэр

Д/д	Сумдын нэрс	Талбай,га	Нөөц, шоо метр	
			Хатсан	унанги
1	Баян-Агт	5829	156811	16830
2	Бүрэгхангай	1402	33260	6490
3	Бугат	3674	68650	42360
4	Бугат	1202	46080	0
5	Могод	4918	143720	0
6	Сайхан	2359	37630	15200
7	Орхон	4668	148670	36780
8	Хишиг-Өндөр	1773	80430	2530
9	Хутаг-Өндөр	10486	259444	162851
10	Сэлэнгэ	10063	541130	11155
11	Тэшиг	25841	0	0
12	Хангал	6594	92260	163560
	Аймгийн дүн	78739	1608085	457756

3. Ойг хортон, түймрээс хамгаалах. Ойн түймэр нь ойн экосистемд томоохон сөрөг өөрчлөлт үзүүлдэг хүчин зүйл юм. Аймгийн хэмжээнд бидний судалгаагаар нийт 80969 га талбай шатсан байгаагийн дийлэнх нь Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр, Орхон, Хангал, сумын нутагт гарчээ. Улс орон зах зээлийн харилцаанд шилжсэнээр иргэд ойн дагалдах баялаг самар жимсийг өргөнөөр түүх, ан гөрөө хийх, хадлан хадах зэргээр ойд түймэр их тавих болсон. Мөн нөгөөтэйгүүр цаг уурын хуурайшилт нөлөөлж байгааг үгүйсгэх аргагүй. Иймд ард иргэдэд түүнээс сэргийлэх сургалт семинар сурталчилгааг өргөн хийх, зайлшгүй тохиолдолд түүнтэй тэмцэх бэлтгэл, арга ажиллагааг байнга хангасан байх шаардлагатай. Ой гадны нөлөөгөөр гэмтэх, мод бэлтгэх, түймэрт өртсөний дараа ойд хортон шавьж үүсэх таатай нөхцөл бүрддэг байна. Аймгийн хэмжээнд нийтдээ 39 900 га талбайд ямар нэг байдлаар хортон тархсан гэх мэдээ бий боловч эхний ээлжинд их голомт бүхий сибирийн хүр хорхой, өрөөсгөл хүр, бийрэн сүүлт тархсан Хишиг-Өндөр сумын 500 га, Хутаг-Өндөр сумын 500 га, Сайхан сумын 350 га, Сэлэнгэ сумын 1000 га, Тэшиг сумын 1200 га талбайд зохих байгууллагаас тэмцлийн ажлыг даруй хийх хэрэгтэй байна. Уг хорхой, шавьж нь модны залуу нахиа найлзуурыг иддэг учир модлог ургамал бүрмөсөн хатаж үхдэг байна. Манай оронд түүнтэй

тэмцэхдээ нутгийн омгийн бактерийн бэлдмэл, денробациллин, леподизм, хлорофос зэргийг өргөн хэрэглэдэг.

4. *Хүний сөрөг үйл ажиллагаанаас хамгаалах.* Энд модыг хулгайгаар огтлох, өсвөр залуу мод, бут сөөгийг хугалж гэмтээх, огтлох ойн дагалдах баялаг самар жимсийг заасан хэмжээнээс илүү түүх, ойн чадавхиас хэтэрсэн хэмжээнд мал бэлчээх, хадлан хадах зэрэг асуудлуудыг хориглоно.

Ойн нөхөн сэргээлт, ойжуулалт. Ойн менежментийн нэг чухал асуудал бол ойн нөхөн сэргээлт юм. Үүнд байгалийн аясаар байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар болон зориудаар ойжуулах гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэнэ. Ойжуулалтын ажлыг мод ихээр огтолсон, түймэрт шатсан Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Тэшиг, Орхон, Могод, Хангал зэрэг сумын нутагт эхний ээлжинд хийх шаадлагатай байна. Үүнд ойжуулалтын ажлыг 79 226 га талбайд, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг 89 613 га талбайд, нийт 168 839 га талбайд нөхөн сэргээх ажлыг хийх шаардлагатай. *Ойжуулалтын ажлыг* юуны өмнө ой ургаж байгаад гадны нөлөөгөөр ойгүй болсон талбайд эхлэн хийх хэрэгтэй байдаг бөгөөд учир нь ойгүй болсон газар хээрших процесс эрчимтэй явагдаж мод ургах экологийн нөхцөл алддаг учир аль болох хурдан хугацаанд нөхөн сэргээх ажлыг хийх хэрэгтэй. Үүний тулд тарих технологийг нарийн баримтлах, ойгүй болсон талбайд 2 жилийн дотор ширэгжилт явагдахаас өмнө ойжуулах, шилмүүст ойд огтлолт явуулсны дараа навчит үүлдрээр солигдохоос өмнө шилмүүст үүлдрээр ойжуулах, ойжуулалтыг 2-3 настай шинэсний тарьцаар 1 га-д 4300 ширхэг байхаар, үрээр бол 1.2 кг буюу 1000 ш байхаар тооцож суулгах, цаашид мод үржүүлгийн газрыг олноор байгуулах хэрэгтэй. *Байгалийн сэргэн ургалтанд* туслах арга хэмжээнд хөрс боловсруулах, эрдэсжүүлэх зэрэг үр ургах нөхцөлийг бүрдүүлэх, өсвөр модыг хамгаалах, түүний өсөлтөнд саад болж буй сахлаг өвс, гишүү модыг зайлуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй.

3.8. Усны сангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Судалгаагаар Булган аймаг нь нийт хэрэглээний усныхаа 80%-ийг газрын доорх гүний усаар хангадаг болох нь тогтоогдсон. Цаашид энэ хэмжээг бууруулж гадаргын усны ашиглалтыг сайжруулах улмаар гадаргын болон гүний усны ашиглалтын хэмжээг ойртуулах зөв менежментийн бодлого зайлшгүй хэрэгтэй. Иймд бид уг ажлын хүрээнд усны нөөц, түүний байгалийн тэнцэл, усны чанарыг хамгаалах, түүний ай сав газар, эрэг орчмын бүс газар, усархаг, намгархаг газрыг зохистой ашиглах, хамгаалах үүднээс 2 бүс тогтоолоо /хүснэгт 42/. Үүнд:

1. Эрэг орчмын бүс. Эрэг орчмын бүсийг тогтоохдоо нуур, гол горхины эргийн дагуу 50 м өргөнтэй, усархаг, намгархаг газрын эргэн тойрны 100 м өргөнтэй зурвас газрыг усны эрэг орчмын бүс болгон авч нийт 68 024 га талбайг хамрууллаа. Уг бүсэд усны чанарт нөлөөлж болох аливаа үйл ажиллагаанд чанга хяналт тавихаас гадна энэ зурваст газар хагалах, барилга байгууламж барих, орчны төрх байдлыг өөрчлөх, нуур голын усанд ан амьтан чөлөөтэй хүрэх замыг алдагдуулахаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Нуурын эргийн бүс түүнд цутгадаг гол горхины эргийн бүс, тэдгээрийн эх авсан газрын бүс аль болох нэгдмэл байх, өөрөөр хэлбэл нэг нь нөгөөгөө өргөтгөж байхад анхаарах нь чухал.

2. Усны эрүүл ахуйн бүс. Гол горхи, булаг шанд, худаг, усан сан нь усан хангамжийн эх үүсвэр гүйцэтгэж байгаа бол тэдгээрт 100 м-с доошгүй өргөнтэй эрүүл ахуйн бүс тогтооно гэж заасан байдаг. Иймд бид төв суурин газрын ойролцоох болон ундны усны эх үүсвэр болсон газруудад эрүүл ахуйн бүсийг

тогтоож нийт 71 002 га талбайг хамрууллаа. Уг бүсийг ундны усны эх үүсвэр гэсэн утгаараа эрүүл ахуйн бүсийн нэгэн адил хамгаалах бөгөөд аливаа барилга байгууламж, жуулчны бааз, хоноглох газрыг нуур, голын эргээс 100 м хол байрлуулах мөн аливаа химийн бодис, зоо мал эмнэлгийн ариутгал-боловсруулалтын цэг, ХАА-н түүхий эд боловсруулах, үйлдвэрлэх газрыг усны хамгаалалтын бүсийн гадна, урсгалын доод хэсэгт байрлуулж хаягдсан усыг тусгайлан цэвэрлэж зайлуулах ёстой. Иймд Булган сумын төвд байрлах Зүүн түрүүний гол дагуу байрласан ноос угаах үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зохих байгууллага хяналт тавих хэрэгтэй байна. Мөн гол горхины эх, нуур тойрмын эргэн тойронд 2 км дотор байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүхийг хориглох ба удаан хугацаагаар олон тооны малыг бөөнд нь бэлчээрлүүлэхээс аль болох зайлсхийх хэрэгтэй. Усны урсгалын дээд талд оршин буй ус ашиглагч усны байгалийн горим, тэнцэл, чанарт сөрөг нөлөө үзүүлэхгүй бусдын ус ашиглах нөхцөлийг боогдуулахгүй байх үүргийг хуулиар хүлээнэ. Хэний эзэмшил, ашиглалтанд байгааг үл харгалзан бэлчээр дэх уст цэгийг нийтээр эзэмшинэ. Ер нь усны нөөц, чанарыг доройтуулахгүй байх үүднээс усны эх булгийг хамгаалах, тохижуулах, зүлэг мод тарих, хайс хашаа хатгах, усыг ашиглахдаа түүний нөөц чадавхид зохицуулан ашиглахыг эрмэлзэх нь усны ашиглалтыг сайжруулах нэг үндэс болно.

Усны эрчим хүч

Эгийн голын УЦС-ийг байгуулснаар орчны бичил уур амьсгалд эерэг өөрчлөлт орж, төвийн эрчим хүчний системийн оргил ачаалалын горимыг тохируулах, цахилгааны импортын хараат байдлаас гарах, ойрын 15-20 жилд өсөн нэмэгдэх цахилгааны хэрэгцээг найдвартай хангах, эрчим хүчний биеэ даасан аюулгүй байдлыг баталгаажуулах зэрэг стратегийн ач холбогдолтой юм. Ойрын ирээдүйд Хутаг-Өндөр сумын нутагт Эгийн гол дээр 220 000 квт 220 МВт суурилагдсан хүчин чадалтай усан цахилгаан станц баригдаж Эрдэнэт рүү 220 кВт-ийн 2 хэлхээт 63-70 км шугамаар холбоно. 25 220 кВт-ийн өсгөх дэд станц барина. 130 км хатуу хучилттай зам тавигдана. 200 орчим хүнтэй суурин бий болно. Голын хөндийн 2 талаар уул хашин нарийссан хэсэгт 710 м урт 95 м өндөр, 8 м өргөн далан байгуулж тогтоох нуур нь 45 км урт, 2,8 м дундаж өргөнтэй, 125 км² талбайтай байх юм. Тооцоот түрэлтийн өндөр 59-65 м, Усан санд 6380 га бэлчээр, 950 га хадлан, усан сан бүхий газрын талбай 2450 га байснаа 12500 га болж өсөх болж байна. 1260 га ой, 1200 га тариан талбай, суурингийн эдэлбэр 250 га, Жилд 480 кВт цаг цахилгаан үйлдвэрлэнэ. Жилийн ашиглалтын зардал 2,7 сая доллар, хөрөнгө оруулалтын өгөөж 13 %, 100 орчим жил ажиллах бөгөөд төсөвт өртөг 300 сая долларыг 15-20 жилд хөрөнгө оруулалтаа нөхнө. Шугамын өртөг 2,8 тэрбум 7,5 жилд нөхнө. Үүнд 13 100 га талбай шаардагдана.

Мөн цаашид ашиглаж болохоор судлагдаж байгаа Орхон сумын Орхон гол дээрх 100 М Вт хүчин чадалтай усан цахилгаан станц барьж 220-ын 20 км шугамаар төвийн эрчим хүчний системд холбоно. Жилд үйлдвэрлэх цахилгаан нь 219 сая кВт цаг, Далангийн урт нь 495 м, өндөр нь 90 м, Түрэлт нь 65,6 м, Усан сангийн ашигтай эзлэхүүн 700 сая м Усан сангийн талбай 60 км. Эрдэнэт хоттой 55 км замаар холбогдоно. Төсөвт өртөг нь 165 тэрбум төг, шугамын өртөг 2,3 тэрбум төг. Барилга байгууламж нь 107,8 сая Тоног төхөөрөмж 24 сая, түрэлтэд хоолой 7,4 сая түр байгууламж болон бусад зардалд 20,8 сая доллар зарцуулна. Жилд 10 орчим сая долларын борлуулалтын орлоготой 1,6 сая ам долларын ашиглалтын зардалтай байна. Зээлийн төлбөр ашиглалтын зардлаа хаагаад жилд цэвэр 4 сая ам долларын цэвэр ашигтай ажиллана. Хөрөнгө оруулалтын зардлаа 10 жилд шугам нь 4,5

жилд нөхнө. Шаардагдах газрын хэмжээ 5592 га. Энэ станцыг барьж чадвал Улаанбаатарын Дулааны станцуудаас гарах нүүрсхүчлийн хийн бохирдлыг 210 000 тн-оор багасгаж агаарын бохирдлыг бууруулах бололцоотой.

Сэлэнгэ мөрний Арцатын 118 квт төсөвт өртөг нь 332 тэрбум төгрөг хөрөнгө оруулалтаа 10 жилд нөхнө. Эрдэнэт рүү 220 кв-ийн 2 хэлхээт 60 км шугамаар холбоно. Шугамын өртөг 2,7 тэрбум төг 5,2 жилд нөхнө Үүнд 9790 га газар хэрэгтэй болох юм.

3.9. Улсын тусгай хэрэгцээний газрын бүсүүд, түүний нөөц, нөхцлийн төлөвлөлт.

3.9.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, нөхцлийн төлөвлөлт

Дархан цаазад болон байгалийн цогцолбор газрын ангилалаар дараах газруудыг улсын тусгай хамгаалалтанд авахаар төлөвлөлтөнд тусгалаа

А. Зэд - Бүтээлийн нурууны дархан цаазат газар

1. Байгалийн нөхцөл байдал

Газар зүйн хувьд Физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Орхон-Сэлэнгийн сав дахь бэсрэг, нам уулсын мужид багтана. Газрын гадарга нь тектоникийн хувьд хойт Монголын атриат системийн Бүтээлийн нурууны хөмбөн өргөгдөлд хамаарагдана. Бэсрэг, нам уул нурууд, гол мөрдийн хөндий хосолсон гадаргатай. Түүний бүрэлдэхүүнд Сэлэнгэ мөрний хойт биеэр орших Хантай, Бүтээлийн нуруу болон улсын хилин дагуух Зэдийн нуруу тэдгээрийн салбар уулс орно. Хамгийн өндөр цэг нь Хантайн нурууны ноён оргил Будлан Пүүсгэр уул /2171 м/, Нам цэг нь Эг- Тарвагатайн голын бэлчир юм.

Уур амьсгал, ус зүй. Халуун, хүйтний агууриг ихтэй, дунд зэрэг эх газарлаг уур амьсгалтай. Жилийн дундаж температур 0,3-3,5 С байна. үнэмлэхүй бага температур -36 -45 С, үнэмлэхүй их температур +32-35С хүрнэ. Хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 80-100 хоног, +100С-ээс дээших идэвхтэй температурын нийлбэр хэмжээ жилд 1500-1950С байна. Жилд дунджаар 310-360 мм хур тунадас унах ба 96-97 орчим хувь нь 4-10 сар хүртэлх хугацаанд орно. Ус зүйн сүлжээ баян, энд Сэлэнгэ мөрний томоохон цутгал Эг, Эрэн, Илэнх, Азарга, Тарвагатай, Зэлтэр голуудын сав хамрагдана.

Хөрс, ургамал. Дундаж өндөр уул зонхилох тул хөрсний босоо бүслүүр сайн илэрч хөгжөөгүй. Ой ургамалшилын мужлалаар Өвөр Байгалийн их мужийн Зэдийн мужид багтах бөгөөд өмнөд сибирь умард монголын хэв шинжид хамаарах уулын тайгын ойн бүслүүрт хамаарагдана. Энд алаг өвс улалжит шинэсэн ой зонхилно. Ойн түймрийн дараа хус ихээр түрж байна. Голуудын дагуу бургас сөөг бүхий торлогт намгархаг нуга, үетэн-алаг өвст нуга ээлжлэн тархана.

Амьтны аймаг. Ой, хээрийн амьтны холимог бүрдэлтэй, 6 багт хамаарагдах 53 зүйл амьтан тэмдэглэгдсэний дотор шавьж идэштэн 8, сарьсан далавчтан 4, туулай хэлбэртэн 4, мэрэгчтэн 20, мах идэштэн 12, туруутан 5 байна. Ховор амьтны жагсаалтад орсон дагуур зараа, монгол тарвага, хөх ольби, заарт ондоотораас гадна хярс, үнэг, хүрэн баавгай, ойн булга, нохой зээх, цагаан үен, шүлүүс мий, зэрлэг гахай, баданга хандгай зэрэг 15 зүйл амьтан бий. Эндхийн хөхтнөөс Монгол улсын улаан номд 4 зүйл /дагуур зараа, алтайн чацуулин, баданга хүдэр, бараан хандгай/, Олон улсын улаан номд 2 зүйл /нохой зээх,

саарал чоно/, Монголын ховор амьтны жагсаалтад 2 зүйл /бараан хандгай, халиун буга/ оржээ. Монгол болжморын тархацын хойт хязгаар.

2. Нийгэм, эдийн засгийн байдал

Хантай, Бүтээл, Зэдийн нуруу нь сум, багийн төвөөс алслагдмал, улсын хил дагуу орших уулын тайга, намаг бүхий бартаа ихтэй нутаг тул газрын ашиглалт бараг байхгүй. Дархан газар нь 2 аймгийн 5 сумын нутаг дэвсгэрийг хамаарна.

Хүснэгт 43

Зэд - Бүтээлийн нуруунд төлөвлөсөн Дархан цаазат газрын нутаг дэвсгэрийн хэмжээ, га

Аймаг	Сум	Талбайн хэмжээ мянга/га	Дархан газрын нийт талбайд эзлэх хувь
Булган	Хутаг-Өндөр	68,0	13,3
	Тэшиг	173,2	33,8
	Сэлэнгэ	197,2	38,5
Сэлэнгэ	Түшиг	28,8	5,6
	Цагаан нуур	45,2	8,8
Дүн		512,4	100,0

Дархан газрын хил дотор Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хонгор, Хантай багийн 11 өрх, нутагладгийн 500 малтай 3 өрх Бүтээл уулын өвөрт, малчдын бэлчээр ашиглалтын одоогийн байдал нь Дархан газрын Булган аймгийн Сэлэнгэ, Сэлэнгэ аймгийн Түшиг, Цагааннуурын харьяалагдах нутаг дэвсгэрт бэлчээр ашиглалт байхгүй. Дархан газрын нутаг дэвсгэрийн 90 хувийг ой тайга эзлэх тул хадланд ашиглах талбай хязгаарлагдмал.

Эндхийн ой ашиглалт харилцан адилгүй. Зэдийн нуруунд ашиглалт бага, зөвхөн ахуйн хэрэгцээнд ашигладаг. Харин Хантайн гол нуруудад ашиглалт их. Хантайн өвөр амууд болон Азарга, Хөцөөгийн голын савд нарс, шинэсийг хавтгайруулан огтлох аргаар бэлтгэсэн байна. 1991 оноос аж ахуй задарч олон жижиг нэгжүүд болон дээрх газруудад бэлтгэхээ больж зөвхөн Хялганатын эргэн тойрон ажиллаж Дух нарс, Дүгэр нарсыг осрчлон огтолж дуусгаад байна. Мөн хулгайн ан хийх, бугын эвэр түүх явдал ихэссэнтэй холбоотойгоор 1996, 1997 онуудад Хантайн нуруунд, 1998 онд Бүтээлийн нурууны зүүн хагаст, 1999 онд Сангастай, Шүрэнд их хэмжээний түймэр гарчээ.

Ойн дагалт баялаг болох самар, үхрийн нүд, нэрс, гүзээлзгэнэ, алирс зэрэг жимс жимсгэний нөөц ихтэй тул нутгийн иргэд түүж ашигладаг.

Хүснэгт 44

Ашигт малтмалын хайгуулын лиценз олгосон байдал.

Лицензийн дугаар	Байршил		Эзэмшигч	Талбай га
	Харьяалал	Газрын нэр		
042х	Булган Тэшиг	Эрин, Жаргалан, их тогоо	Эм энд Даймонд ХХК	
1543х	Булган Тэшиг	Өвөрмөц цоож гол	Саудс Монголиан гоулд майнинг ХХК	
1694х	Сэлэнгэ Түшиг	Нарийн шүрэнгийн гол	Д. Цэрэнпил Сэлэнгэ Сүхбаатар сум	
1730х	Сэлэнгэ Түшиг	Хошуу овоо	С. Лхагвасүрэн	
2513х	Сэлэнгэ Түшиг	Нарийн шүрэнгийн гол	Д.Буянжаргал	

3. Зэд - Бүтээлийн нурууг улсын тусгай хамгаалалтад авах шаардлага, үндэслэл.

1. Хантай-Бүтээлийн нурууны Дархан цаазат газар байгуулснаар Евразийн шилмүүст ой их мужид багтах Сибирийн тайгын тус улсын нутаг руу нэвтрэн орсон зурвасхан хушууг хамгаалах боломжтой болох юм.

2. Тус районы уулын тайга, голын хөндий боролжит нугын ландшафт, тэдгээрийн харилцан үйлчлэл, уялдаа холбоо, хувьсал өөрчлөлтийн зүй тогтлыг илрүүлэх, харьцуулан судлах, улмаар энэ нутгийг зохистой ашиглах, хамгаалах боломж бүрдэх болно.

3. Хил дамнасан олон улсын дархан цаазат газар байгуулж, бүс нутгийг хамтран судлах, зэрлэг ан амьтны амьдрах орчинтой нь цогцолбороор хамгаалах зэрэг зорилт хэрэгжих замыг нээж өгнө.

4. Ой модыг хавтгайруулан огтолсон, түймэр хортон шавьжид нэрвэгдсэн, хулгайн ан өссөнтэй холбоотойгоор буга, хандгай зэрэг амьдтын тархац нутаг хумигдаж, цөөрч дайжих болжээ. 1980 онд 12 000 буга тоологдож байсан бол 1998 онд 900 буга тоологджээ. Иймд устаж ховордож байгаа амьтдыг өсгөх, оршин амьдрах орчныг хамгаалахад энэхүү Дархан цаазат газар онцгой үүрэг гүйцэтгэх юм.

5. Манай орны ойн нөөцийн 30,2 хувь нь төвлөрдөг Сэлэнгэ мөрний ус зүйн горимд шийдвэрлэх нөлөөтэй Тарвагатай, Азарга, Зэлтэр зэрэг голууд эх авдаг Зэд-Бүтээлийн нурууг тусгай хамгаалалтад авснаар Ой болон цэвэр усны их нөөцийг агуулсан дундаж уулсын жинхэнэ тайгын ландшафтыг бусад хам бүрдлүүдтэй нь цогцолбороор хамгаалах нөхцөл бүрдэх юм.

6. ТХГН-ийн сүлжээнд хамрагдаагүй байсан Орхон-Сэлэнгийн бэсрэг уулсын муж, Сэлэнгэ, Булган аймгийн нутаг дэвсгэрийн гол төлөөлөл болсон эдгээр нурууд тусгай хамгаалалтад авагдсанаар монгол орны байгалийн бүх муж бүс бүслүүрийн төлөөлөл ТХГН-ийн сүлжээнд үндсэндээ хамрагдах юм.

Б. Бүрэнгийн нурууны байгалийн цогцолборт газар.

1. Байгалийн нөхцөл байдал

Газар зүйн байдал. Хангай-Хэнтий уулархаг их мужийн Орхон-Сэлэнгийн сав дахь хөндий хосолсон гадаргатай. Уул нурууд нь ойн хилээс дээш гарсан оргилгүй тул бүхэлдээ ой модоор хучигдана. Хамгийн өндөр цэг нь 1985 м өргөгдсөн Бүрэнгийн нурууны оргил Сонгинот уул, нам цэг нь Сэлэнгэ-Могойн голын бэлчир юм.

Уур амьсгал ус зүй. Зунд дулаавтар, өвөлдөө хүйтэн, халуун хүйтний агууриг ихтэй, дунд зэрэг эх газрын уур амьсгалтай. Жилийн дундаж температур $0,3^{\circ}$ - $3,5^{\circ}$ С. үнэмлэхүй бага температур -36° - 45° С, үнэмлэхүй их температур $+32^{\circ}$ - 35° С хүрнэ. Хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 80-110 хоног байх ба $+10^{\circ}$ С-ээс дээших идэвхтэй температурын нийлбэр хэмжээ жилд 1500° - 1590° С байна. Хур тунадас харьцангуй их 300 мм, 96-97 орчим хувь нь улиралд 4-10 сар хүртэлх хугацаанд унана. Ус зүйн сүлжээ баян газрын тоон орох ба Сэлэнгэ мөрний жижиг цутгал Эвэрт, Бургалтай, Хэцүү, Ар могойн голуудын сав хамрагдана. Бүрэнгийн нурууны араас 10 гаруй жижиг гол эх авч урсана.

Хөрс ургамал. Ой ургамшилын мужлалаар Хангайн их мужийн Хангайн зүүн хойт нутагт хамрагдана. Энд шинэс голлон хуш, нарс, хус холилдон ургана. Эндхийн ойд уулын тайгын ширэгт хөрс голлох суурийг эзлэхийн зэрэгцээ ар бэл хормойгоор уулын ойн бараан, нугат ойн хөрс багагүй тохиолдоно.

Евразийн шилмүүст ой их мужид хамаарах тул уулын хажуу бүхэнд ойн улалжит шинэсэн ой зонхилно. Гол мөрний татам дагуу бургас, сөөг бүхий торлогт намгархаг нуга, үетэн – алаг өвст нуга ээлжлэн тархана.

Ан амьтан. Монгол орны хөхтөн амьтны мужлалаар ойт хээрийн тойрогт хамаарна. Энэ нутагт 6 багт хамаарах 53 зүйл хөхтөн амьтан тэмдэглэгдсэний дотор агнуурын чухал ач холбогдолтой 16 зүйлийн тоо толгой цөөрч, тархац нутаг багассан байна. Ус агнуурын шувууд нүүдлийн үедээ цуглардаг гол, нуурууд элбэг. Улаан номд орсон шувуудаас цасч дэглий, халбаган хушуут, хар өрөвтас, гангар хун, хээрийн галуу, хушуу галуу, байгалийн нугас, явлаг сар, усны цагаан сүүлт бүргэд, хар тогоруу цэн тогоруу, тоодог, уран шувуу тааралдана.

2. Нийгэм- эдийн засгийн байдал.

Бүрэнгийн нуруу улсын хилээс хол, ашиглалт ихтэй бүс нутгийн төв дунд орших хэдий ч аж ахуйн ашиглалт бараг байхгүй.

Хүснэгт 45

Бүрэнгийн нуруунд төлөвлөсөн БЦ газрын нутаг дэвсгэрийн хэмжээ,га

Аймаг	Сум	Талбайн хэмжээ мян/га	Нийт талбайд эзлэх хувь
Булган	Хангал	21,6	15,4
Сэлэнгэ	Баруун бүрэн	72,4	51,3
	Хушаат	47,0	33,3
Дүн		141,0	100,0

3. Бүрэнгийн нурууг улсын тусгай хамгаалалтад авах шаардлага, үндэслэл

1. Дархан, Эрдэнэт, Булган, Хялганат зэрэг томоохон хот сууринууд төвлөрч хүн ам олноор суурьшсан төдийгүй аж ахуйн эдэлбэрт эртнээс ашиглаж буй учраас байгалийн унаган төрх нь зарим талаар алдагдахад хүрчээ. Манай орны ойн нөөцийн 30,2 хувь нь төвлөрдөг Булган, Сэлэнгийн аймгийн ойн фонд сүүлийн 20 жилд мод бэлтгэл, түймэр, хортон шавьжийн нөлөөнд автаж нөөц нь их хэмжээгээр буурчээ. Иймд энэ бүс нутгийн нэг гол хэсэг болсон Бүрэнгийн нурууг Улсын тусгай хамгаалалтад авах зайлшгүй шаардлагатай болоод байна.

2. Бүрэнгийн нурууны араас 10 гаруй жижиг гол эх авч урсдаг нь Сэлэнгэ мөрний ус зүйн горимд ихээхэн нөлөөтэй юм. Эндхийн ойн нөөцийн ихэнх нь голуудын усны горимыг зохицуулах үүрэгтэй байна.

3. Ан амьтныг зүй бусаар агнах явдал ихссэнээс ойн том туурайтан амьтдын байршил нутаг хумигдан, тоо толгой нь цөөрч ховордож устах аюулд хүрээд байна.

4. Бүрэнгийн нурууны орчимд Амарбаясгалант хийд Сэвд могой, Ар тойлбо зэрэг үзэсгэлэнт газар нутаг багтдаг тул аялал жуулчлал хөгжүүлэх ирээдүйтэй тул Байгалийн цогцолборт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авах боломжтой.

5. Бүрэнгийн нурууны ой одоогийн эмх журамгүй ашиглалтыг хязгаарлах, хяналт тавих, ой тайгын ховор амьтдыг хамгаалан үржүүлэх замаар нэг талаас ховордож байгаа амьтдын амьдрах орчныг хамгаалах, нөлөө талаас ойн их нөөцийг агуулсан дундаж уулсын жинхэнэ ой, тайгын ландшафтыг бусад хам бүрдлүүдтэй нь цогцолбороор хамгаалах нөхцөл бүрдэнэ.

3.10. Биологийн төрөл зүйлийг хамгаалах талаар.

Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн хавсралтын “Нэн ховор ургамлын жагсаалтад” орсон 133 ургамлаас 5 зүйл, ховор 317 ургамлаас 17 зүйл ургамал болон Монголын улаан номонд орсон 128 зүйл ургамлаас 14 зүйл ургамал тус аймгийн нутаг дэвсгэрийн цэгт тэмдэглэгдсэн байна \ зураг, хүснэгт-\). Мөн нэн ховор ховор ургамлын тархалтыг байгалийн бүс бүслүүрээр авч үзвэл дундаж өндөр уулын бүслүүрт, уулын нугад, тал хээрт, голын татамд зүйл ургамал тус тус тааралдана /зураг, хүснэгт 46 /.

Булган аймгийн нутагт тархсан Монголын улаан ном, байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн нэн ховор, ховор ургамлын жагсаалтын Монгол, латин нэрийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 46

Монголын улаан номонд орсон ургамлын жагсаалт

№	Зур аг дээ рх ин- дек с	Латин нэр	Монгол нэр	Ургах орчин	Тархалт	Статус, ач холбог- дол
1	14	<i>Stellaria dichotoma</i>	Ацан ажигана	Хайрга чулуутай, хуурай хээр бүхий энгэр, асга хад заримдаа мөлгөр хайрга элсэрхэг хөрсөнд	Бүх сумдад, уулын болон тал хээрт	Ховор, Эмийн ургамал
2	1	<i>Adonis mongolica</i>	Монгол хундгана	Ойн бүслүүрийн доод зах, хээрийн бүсийн дээд захын заагт уулын хормойн болон бэлийн элдэв өвст хээр, жалгын ам, голын хөндийд ургана.	Хишиг Өндөр, Орхон, Могод, Бүрэгхангай	Унаган үлдвэр, нэн ховор Эмийн ургамал
3.	15	<i>Adonis sibirica</i>	Сибирь хундгана	Ойт хээрийн бүслүүрийн ойн нуга, зах, сийрэг шинэсэн ой, уулын энгэрийн нуга, хормойд ургана.	Тэшиг, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Бугат	Ховор, эмийн ургамал
4	16	<i>Juniperus pseudo-sabina</i>	Хуурамч хонин арц	Тайгын бүслүүрийн нураг, хад, ойн дээд захын хушин ой, ширэнгэнд ургана	Сэлэнгэ, Тэшиг	Ховор, Эмийн ургамал
5	17	<i>Paeonia anomala</i>	Ягаан цээнэ	Шинэсэн, холимог, хусан ой, ойн зах, голын дэнжийн сөөгөн ширэнгийн чийглэг хөрсөнд ургана.	Сэдэнгэ, Тэшиг, Хангал, Бугат,	Ховор, эмийн ургамал
6	2	<i>Rhodiola rosea</i>	Алтан гагнуур	Ойт бүслүүрийн хад чулуутай энгэр, асга, цохионы завсар, ёроол, горхийн чулуурхаг, хайргатай эрэг, ойн цоорхой, торлогтой сийрэг ойд ургана	Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Бугат, Хутаг	Нэн ховор, эмийн
7	18	<i>Valeriana officinalis</i>	Эмийн бамбай	Ойт хээрийн бүслүүрийн шинэсэн ой түүний зах, хусан ой, ойн татмын нуга, хусан тордог, бургасан ширэнгэ, гуу жалга, хадны ёроолоор ургана.	Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Бугат, Хутаг-Өндөр	Ховор, Эмийн
8	3	<i>Gypripedi</i>	Шар	Хусан ой, ойн цоорхой, зах,	Сэлэнгэ,	Нэн

		um calceolus	саадганц эцэг	ойн бүсийн гол горхийн эргийн нугад ургана		ховор
9	4	Gypripedi um macranth om	Их саадганц эцэг	Сийрэг шинэсэн ой, хус- шинэсэн холимог, улиангар- хусан ой, нарс, хусан ойн төгөл, ойн зах, нугад ургана.	Сэлэнгэ, Тэшиг	Нэн ховор
10	19	Melica nutans	Бөхөгөр шогшрог о	Ой сөөгөн ширэнгэ, хусан ойд ургана.	Сэлэнгэ, Хангал	Ховор
11	5	Rhodode ndron dauricum	Дагуур Тэрэлж	Ойт хээрийн бүслүүрийн шилмүүст ой, холимог ой, тэдгээрийн цоорхойн чулуурхаг хажуугаар ургана.	Сэлэнгэ, Тэшиг, Хангал,	Нэн ховор, эмийн
12	6	Botrychiu m Lanceolat um	Юлдэн шүүдэр ойм	Ойт хээрийн бүсэд уулын нугад ургана	Сэлэнгэ, Хангал	Нэн ховор
13	7	Saxifraga hirculus	Ямаан сэрдэг	Ойт хээрийн бүслүүрийн хадтай энгэр, чийглэг цохио, асга, нуга,, голын эрэг, торлог, ойн захаар ургана.	Тэшиг, Сэлэнгэ, Хутаг- Өндөр, Бугат, Хангал	Нэн ховор, эмийн
14	8	Sambucu s manshuri ca	Манж Гандигар	Ойн бүслүүрийн ойн цоорхой, зах, асга хад, хавцал ам, голын хөндийн шугуйд ургана.	Сэлэнгэ, Тэшиг, Хутаг- Өндөр	Нэн ховор, эмийн

Хүснэгт 47

Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтанд орсон нэн ховор, ховор ургамлын жагсаалт

№	Зураг дээрх индекс	Латин нэр	Монгол нэр	Ургах орчин	Тархалт	Статус, ач холбогдол
1	9	Gentiana macrophyll a	Томнавчит Дэгд	Шинэсэн болон холимог ой, тэдгээрийн зах, эргийн болон ойн нуга, нугат энгэр, намхан хусан ширэнгэ, гол горхины эрэг	Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Хутаг- Өндөр, Бугат, Могод, Хишиг- Өндөр, Бүрэгхангай	Нэн ховор, эмийн
2	10	Gentiana pulmonaria	Сэгсгэр Дэгд	Ойн бүслүүрийн эрэг дагасан чийглэг нуга, мөлгөр хайрга, бургасан төгөл, горхийн эрэг	Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Хутаг- Өндөр, Бугат, Баян- Агт, Хишиг-	Нэн ховор, эмийн

					Өндөр, Бүрэгхангай	
3.	11	Solidago dahurica	Алтаргана Илаархай	Ойн бүслүүрийн дээд хэсгээр шинэсэн болон холимог ой, түүний зах, голын шугуй, хусан ойд ургана.	Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Баян-Агт, Хишиг-Өндөр, Бүрэгхангай	Нэн ховор, эмийн
4	12	Lilium martagon	Буржгар Сараана	Шинэс, нарс, хусан ойн энгэр, нугаар ургана.	Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Баян-Агт, Хишиг-Өндөр, Бүрэгхангай	Нэн ховор,
5	13	Hedysarum fruticosum	Сөөгөн Шимэрс	Голын эргийн элсэрхэг газар, талын нарсанд ургана.	Сэлэнгэ, Хангал	Нэн ховор,
6	32	Stellaria media	Дунд ажигана	Ногооны талбай, усалгаатай тариан талбай, орон байрны дэргэдүүр чийглэг газар дагж ургана.	Хангал, Рашаант, Гурванбулаг, Сайхан, Хутаг-Өндөр	Ховор, эмийн
7	20	Nymphaea tetragona	Дөрвөлжин бөлбөө	Голын татмын хар ус, нуур, цөөрөм, татуурга	Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Бугат, Баян-Агт, Сайхан	Ховор, эмийн
8	21	Potentilla norvegica	Норвегийн Гичгэнэ	Голын элс, мөлгөр хайргат эрэг, тариа, ногооны талбай, суурин газар, замын хажуугаар хөл газрын ургамал болж ургадаг.	Хангал, Орхон, Бүрэгхангай Дашинчилэн, Баяннуур, Рашаант	Ховор, эмийн
9	22	Gentiana algida	Цагаан дэгд	Ойн бүслүүрийн дээд хэсэг хийгээд нам хуст торлог, хуш-шинэсэн ойн захаар ургана.	Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Баян-Агт, Бугат, Хангал, Булган	Ховор, эмийн
10	23	Phragmites communis	Эгэл нишингэ	Гол, нуурын эрэг, булаг, шанд орчим, хужирлаг элс, эрэг орчмын болон булаг дагасан нуга	Бүх сумдад	Ховор, эмийн

11	24	Nuphar lutea	Шар саахуунцэ цэг	Усны зах, тогтуун урсгалт гол	Тэшиг, Сэлэнгэ, Хутаг-Өндөр	Ховор, эмийн
12	25	Potamogeton obtusifolius	Мохоодуу навчит Усанхөрш	Нуур, голын эргээр	Баян-Агт, Сайхан, Могод	Ховор
13	26	Caragana spinosa	Тэмээн Харгана	Голын эрэг, голын татам, хайргархаг, чулуурхаг хажуугаар ургана.	Гурванбулаг, Рашаант, Баяннуур, Дашинчилэн, Бүрэгхангай	Ховор
14	27	Pinus sibirica	Сибирь Хуш	Тайгын ойн дээд хэсгээр ургана.	Тэшиг, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Хангал, Гурванбулаг	Ховор
15	28	Hedysarum dahuricum	Дагуур Шимэрс	Хээр, уулын хажуугийн хээрт ургана.	Орхон, Бүрэгхангай, Дашинчилэн, Хишиг-Өндөр	Ховор
16	29	Chelidonium majus	Их шүүдэргэн э	Гацуур, хуш бүхий шинэсэн ой, хусулиангаран төгөл, хад асгарга, хадны ёроол, гуу жалга, энгэр дагаж ургана.	Бугат, Сэлэнгэ, Хангал, Хутаг-Өндөр, Тэшиг, Бүрэгхангай	Ховор
17	30		Заан хүж	Уулын нугад	Баян-агт сумын Зуун мод, Далын даваанд	Бөөрны өвчинд
18	31		Жудаг өвс	Уулын нугад	Тэшиг, Тавт, Хужирт, Дулаанхаан	Ховор, эмийн

Баян-Агт суманд ургадаг “Заан хүж”, Тэшиг суманд “Жудаг өвс” ургадаг зэрэг ургамалыг судлан ургадаг нутгийг нь орон нутгийн хамгаалалтанд авах, тармилжуулах туршилт хийх шаардлагатай.

Ашигласан ном,

1. Лигаа У., Даваасүрэн Б., Нинжил Н. Монгол орны эмийн ургамлыг өрнө дорнын анагаах ухаанд хэрэглэхүй. УБ. 2006. 651 х.
2. Грубов В.И. Определитель сосудистых растений Монголии (с атласом). Ленинград. 1982. 441 х.
3. Монгол Улсын Улаан ном. УБ. 1997. 206-388 х.
4. Өлзийхутаг Н. Бобовые Монголии. УБ. 2003. 585 х.
5. Банникова И .А. Лесостепь Евразии (оценка флористического разнообразия). Москва. 1998 г. 146 с.
6. Флора Восточного Хангая. Москва. 1983 г. 184 с.

7. Конспект флоры Внешней Монголии (сосудистых растения). Москва. 1996. 136 с.
8. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. /Байгалийн ургамлын тухай Монгол Улсын хуулийн ховор ургамлын жагсаалт № 153. 1995 оны 8-р сарын 25.
9. Байгалийн ургамлын тухай Монгол Улсын хуулийн хавсралт. Нэн ховор ургамлын жагсаалт.

IV бүлэг. Газар ашиглалтын экологи - эдийн засгийн үнэлгээ

4.1. Газрын экологийн чадавхи, түүний хадгалалт, хамгаалалт

4.1.1. Газрын экологийн чадавхи. Аливаа Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн ажлын үндсэн зарчим бол тухайн аймаг сум орны нийгэм эдийн засгийн алс хэтийн хөгжлийг газрын нөөцийн төлөвлөлтөөр дэмжих, газрын нэгдмэл сангийн ангилал бүрт эдийн засгийн хамгийн үр ашигтай цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх явдал байдаг. Иймд газрын нөөц, нөхцөл, төлөв байдлыг тухайн нутаг дэвсгэрийн газрын гадарга, хөрс, ургамал, ус зүй, уур амьсгал зэрэг ижил төстэй байдлаар нь багцлан нэгтгэж тэр бүлэгт хөгжүүлж болох эдийн засгийн хувьд хамгийн ашигтай байгаль орчинд халгүй байх тодорхой салбар, аж ахуйн чиглэлийг зааж өгсөн юм. Үүнд ландшафт-типологийн зарчимд тулгуурлан байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор байдлаар нь хэд хэдэн бүлэгт хувааж экологийн чадавхиар нь ашиглалтын чиглэл, ялгааг дараахи байдлаар тодорхойлов ./хүснэгт 48 /

Хүснэгт 48

Булган аймгийн нутаг дэвсгэрийн ангилгаа

Газрын гадарга		Эзлэх талбай, га	Экологи үнэлгээ	Ашиглалтын чиглэл
Ой хээрийн дундаж ба нам уулс, тэдгээрийн дотоодын нугачаат хөндий	Уулын ойн ялзмагт, глейрхэг хар бараан хөрстэй ойт хээрийн дундаж өндөр уулсын орой болон ар хажуу	70203	Экологийн чадавхи сайтай	Экологийн байдлыг алдагдуулахгүй хадгалан хамгаалах, зэрлэг амьтан сарлагийн бэлчээрт ан
	Уулын ойн цэвдэгт ба ширэгт хар шороорхуу хөрстэй ойт хээрийн дундаж ба нам уулсын ар, өвөр, баруун зүүн хажуу болон түүний доод хэсэг, хормой	115943	Экологийн чадавхи сайтай	Биологийн төрөл зүйлийг хамгаалах, аялал жуулчлал, амралт сувилал хөгжүүлэх, байгалийн дагалдах баялгийг хязгаарлалттай ашиглах

Нугархаг хээрийн дундаж ба нам уулс хоорондын тэгшивтэр хөндий	Уулын с/х хар хүрэн хөрстэй, сийрэгдүү өвс ургамалтай, чулуурхаг гадаргатай дундаж ба нам уулсын орой, дээд энгэр хажуу	418881	Экологийн чадавхи сайтай	Бүх төрлийн мал, ан амьтны бэлчээрт ашиглах
	Уулын хүрэн ба хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай дундаж ба нам уулсын хажуу налуу, хормой	552110	Экологийн чадавхи сайтай	Бүх төрлийн мал, ан амьтны бэлчээрт болон уулын доод хормой хэсгийг тариаланд түүвэрчлэн ашиглах
	Нугын хүрэн ба хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай уулс хоорондын нарийн ам хөндий	63704	Экологийн чадавхи сайтай	Бүх төрлийн мал, ан амьтны бэлчээрт болон тариаланд түүвэрчлэн ашиглах
	Шавранцар хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай уулс хоорондын тэгшивтэр хөндий	294137	ашиглалтын явцад хөрс хамгаалах, үржил шимийг тэтгэх	Газар тариалангийн үйлдвэрлэл бүх төрлийн малын бэлчээрт эрчимтэй ашиглана
Хуурай хээрийн дундаж ба нам уулс хоорондын тэгшивтэр ба долгиорхог хөндий	Уулын с/х хүрэн ба хар хүрэн хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг гадаргатай дундаж ба нам уулсын орой, хажуу налуу	101253	хөрс хамгаалах, үржил шимийг тэтгэх, усны горимыг тохируулах	Бүх төрлийн малын бэлчээрт
	Шавранцар хүрэн ба хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай уулс хоорондын ухаа гүвээт долгиорхог өргөн хөндий	667882	хөрс хамгаалах, үржил шимийг тэтгэх, усны горимыг тохируулах	Газар тариалангийн үйлдвэрлэл, бүх төрлийн малын бэлчээрт
	Элсэнцэр хүрэн хөрстэй өвслөг ургамалтай уулс хоорондын ухаа гүвээт долгиорхог өргөн хөндий	243498	Экологийн даац муутай нэмэлт арчилгаа тордолгоо хийж сэлгээтэй ашиглах	Бүх төрлийн малын бэлчээр, тариаланд ашиглаж болох боловч тодорхой хязгаарлалттай ашиглах

Бүс дундын голын хөндий болон гадагш урсгалгүй нам хотосууд	Голын хөндийн аллюви нуга намгийн хөрстэй гидрофит ургамал бүхий нойтон нуга	73515	Экологийн чадавхи сайтай	Малын бэлчээр, мелиорацийн арга хэмжээ авсны үндсэн дээр хэсэгчлэн ашиглах
	Аллювийн нугын хээржсэн ба үелсэн с/х хөрстэй өвслөг ургамалтай татамын нуга	74781	Экологийн чадавхи сайтай	Ихэнхдээ малын бэлчээрт ба хэсэгчлэн газар тариалан түүний дотор усалгаатай тариаланд
	Уулын бэл хормойн гуу жалгын бүрдэл	89275	Экологийн чадавхи муу	Хязгаарлагдмал ашиглана
Дүн		2.765		

Жич: Энд нутаг дэвсгэрийн хувьд хамгийн түгээмэл орон зайг эзлэн оршиж экологийн нөхцлөөс шалшгаалан хөгждөг ХАА-н газрыг хамруулав.

1. Ой хээрийн дундаж ба нам уулс, тэдгээрийн дотоодын нугачаат хөндийд тэгш, хавтгай, бөмбөгөрдүү хэлбэртэй, хажуу нь ихээхэн мөлгөр, д.т.д дундажаар 1800-2000 м-ийн өндөрт өргөгдсөн, 100-200 м-ийн харьцах өндөртэй дундаж ба нам уулсын ам хөндийг хамруулав. Энд хөрс ба ургамлан бүрхэвч нугархаг шинжтэй, экологийн хувьд харьцангуй чадавхи сайтай, хөрс нь тогтворжсон үе давхарга, ялгарал сайтай, үржил шимээр сайн боловч тархалтын хувьд нэлэнхүйдээ биш алаг цоог бага хэмжээний талбайг эзлэн оших тул ХАА-н үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиг муутай учир өрхийн аж ахуй, жижиг үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулан зөвхөн түүвэрлэн ашиглах боломжтой. Газрын гадаргын болон гүний усны хангамж бусад газруудыг бодвол сайн. Хэдийгээр хөрс, чийгийн хангамж сайн боловч ХАА-н таримал тариалахад дулааны температур дутагдах сул талтай учир далд хөрсний газар тариаланг бага хэмжээний талбайд хэсэгчилэн хөгжүүлбэл зохино. Ургамлан бүрхэвчийн хувьд нугын болон нугархаг хээрийн зүйлийн бүрэлдэхүүнээр арвин, ургац сайтай, сахлаг өвслөг ургамал бүхий ургамлан бүрхэвч зонхилох тул бүх төрлийн малд тохиромжтой даац сайтай бэлчээрт тооцогдоно. Энд ботууль-алаг өвс-улалжит, ботууль-үетэнт, алаг өвс-үетэн-улалжит, үетэн-алаг өвст, зүр өвс-алаг өвст, зүр өвс-үетэнт, хялгана-зүр өвст, хялгана-үетэнт, хялгана-алаг өвст төрлүүд өндөр ерөнхий бүрхэцтэйгээр /50-60%/ зонхилон ургана. Мөн нэн ховор болон ховордсон ургамлын төрөл зүйл элбэг тааралдана. Иймд энэ бүсийг ашиглахдаа экологийн унаган байдлыг алдагдуулахгүй байх, зэрлэг ан амьтан, сарлагийн бэлчээрт ихэвчлэн ашиглахаас гадна хүн амын социаль нөхөн сэргэлт аялал жуулчлал, амралт сувилал хөгжүүлэх, байгалийн дагалдах баялаг самар, жимс, эмийн ургамал түүх зэргээр ашиглаж болно. Гэхдээ тусгай хяналтан дор эрчимтэй бус хязгаарлалттай ашиглах нөхцөлийг бүрдүүлж ашиглана.

2. Нугархаг хээрийн дундаж ба нам уулс хоорондын тэгшивтэр хөндий нь жинхэнэ хуурай хээрийг бодвол арай нугархаг, товчхондоо ойт хээр хуурай хээрийн завсрын шинж чанарыг агуулсан байдаг. Энд хад чулуу багатай, чийгэрхэг, шаварлаг бүтэцтэй, үе давхарга сайтай, үржил шим бүхий хар хүрэн хөрс зонхилно. Арай өндөрлөг газраар нь хүрэн хөрс тааралдах боловч хуурай хээрийн хүрэн хөрсийг бодвол нэлээд ялгагдах үлдмэл нугын шинж чанартай байна. Хөрс нь голдуу шавранцар механикийн бүрэлдэхүүнтэй байх учир

ашиглалт даах чадвар сайн, агроүйлдвэрлэлийн I, II зэргийн хөрс голдуу байна. Ургамлан бүрхэвчийн хувьд ботууль-алаг өвс, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-хялганат, үетэн-улалж-алаг өвст, хялгана-үетэнт, хялгана-хиагт, биелэг-үетэн-алаг өвст, хиаг-алаг өвст төрлүүд 45-50% ерөнхий бүрхэцтэйгээр зонхилон ургана. Уг газрыг адуу болон бог мал, ан амьтны бэлчээрт илүү тохиромжтой. Мөн түүнчлэн газар тариаланд түүвэрчлэн ашиглаж болно. Ашиглалтын явцад хөрс хамгаалах, үржил шимийг тэтгэх, усны горимыг тохируулах арга хэмжээг авахад илүүдэхгүй.

3. Хуурай хээрийн дундаж ба нам уулс хоорондын тэгшивтэр ба долгиорхог хөндий нь нугархаг хээрийн ангийг бодвол чийгийн хангамж муу байдагтай уялдан хөрс ургамлан бүрхэвч төдийлэн сайн биш, ихэвчлэн хар хүрэн, хүрэн хөрс зонхилох ба ялзмагт үе дээрхээс нимгэн, шавранцар заримдаа элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, агроүйлдвэрлэлийн II, III зэргийн хөрс зонхилно. Ургамлан бүрхэвчийн хувьд жижиг дэгнүүлт үетэн-алаг өвс-агьт, жижиг дэгнүүлт үетэн-хялганат, хялгана-үетэнт, хялгана-хиагт, хялгана-ерхөгт, ерхөг-хялгана-агьт, биелэг-үетэн-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-хиагт, хиаг-алаг өвст төрлүүд 40-45% ерөнхий бүрхэцтэйгээр зонхилон ургана. Газрын гадарга, эзлэх талбай, хөрс ургамлан бүрхэвч, цаг уурын хувьд малын бэлчээр болон газар тариалангийн үйлдвэрлэлд хамгийн өргөн дэлгэр ашиглах боломжтой. Иймд бүх төрлийн малын бэлчээр, газар тариалангийн үйлдвэрлэлд өргөн ашиглана. Энэ газар нутгийг тариаланд ашиглахдаа хөрс хөнгөвтөр учир хөрс хамгаалах, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, ус чийгийн горимыг сайтар бодолцох шаардлагатай. Ялангуяа урд талын сумдын хөнгөн хөрс бүхий газруудад дээрх арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд зарим тохиолдолд өнжөөх сэлгэх арга хэмжээг ч авч хэрэгжүүлж болно.

4. Бүс дундын голын хөндий болон гадагш урсгалгүй нам хотосууд нь уулын болон тал хээрийн бүсийг бодвол багахан газар нутгийг хамрах боловч зөв зүйтэй ашиглабал ХАА-н үйлдвэрлэлд өндөр үр ашиг өгөх болоцоотой нутаг юм. Энд ихэвчлэн Сэлэнгэ, Эг, Орхон, Туул гол болон түүний салбар салаа бусад жижиг гол горхи нуур цөөрөмийн сав газрууд багтах бөгөөд хөрс нь усны байнгын нөлөөгөөр үүсч бий болсон аллювийн нугын хөрс зонхилох голдуу хүнд шавранцар механикийн бүрэлдэхүүнтэй, ялзмагт үе давхарга зузаантай, хужир мараагүй, чулуу багатай хөрс зонхилно. Энд нугын улалж-үетэнт, улалж-улаан толгойт, улалж-алаг өвст, үетэн-улалж-алаг өвст төрлүүд мөн л хангалттай өндөр бүрхэцтэйгээр ноёлно. Ашиглалтын хувьд чийг намагт нам хотосуудыг малын бэлчээрт зонхилон ашиглах боловч мелиорацийн арга хэмжээ авсны үр дүнд газар тариаланд хэсэгчлэн ашиглаж болно. Харин хээржсэн үелсэн сулавтар хөгжилтэй аллюви хөрс бүхий нам хотосуудыг малын бэлчээрт ашиглахаас гадна усалгаатай газар тариаланд ашиглах өргөн боломж бий. Гуу жалгын бүрдэлтэй хөрс бүхий газар нь ашиглах боломжоор ихээхэн хязгаарлагдмал тохиромж муутай хөрс байдаг тул түүнийг ашиглах гэхээсээ хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь илүү оновчтой.

Дээрхээс нэгтгэн дүгнэхэд нийт нутаг дэвсгэрийн 70-80% нь байгаль экологийн хувьд чадавхи сайтай учир хэсэгчлэн болон нэлэнхүйд нь ашиглах боломжтой, 15-20% нь чадавхи муутай эмзэг учир хязгаарлагдмал хүрээнд, тодорхой цаг хугацаанд нөхцөл зааврын дагуу ашиглах боломжтой гэж үзэж болно.

4.1.2. Газрын экологийн төлөв байдал, түүний хадгалалт, хамгаалалт.

Булган аймаг нь байгаль экологийн хувьд хэдийгээр хөрс, ургамал, ус чийг сайн экологийн хувьд харьцангуй чадавхи сайтай газар нутаг боловч ашиглалтын

явцад нэлээдгүй доройтол гарсан байдаг. Ер нь нийт нутаг дэвсгэрийн 56.7% нь ХАА-н газар, 0.6 % нь хот тосгон бусад суурины газар, 0.2% нь зам шугам сүлжээний газар, 39.1% нь ойн сангийн газар, 0.45% нь усан сан бүхий газар байдаг гэж үзвэл нийт нутаг дэвсгэрийнхээ 60-70%-ийг эрчимтэй ашигладаг гэж үзэж болно. Тэгвэл ашиглалтын явцад дараахи өөрчлөлтүүд гарчээ /хүснэгт 49/.

Хүснэгт 49

Ашиглалтын явцад гарсан өөрчлөлтүүд

Д/д	өөрчлөлтийн төрөл	Талбайн хэмжээ,га/хувь	Цаашидын хандлага	Авах арга хэмжээ
1	Нийт талхлагдсан бэлчээр , үүнээс	766439/ 30%	Эрчимтэй нэмэгдэх	
	Их талхлагдсан	439471/ 53.3%		2-3 жил өнжөөх
	Бага талхлагдсан	326968/ 42.7%		Сэлгэн ашиглах
2	Эвдрэлд орсон тариалан	51581/ 45.5%	Эрчимтэй нэмэгдэх	
	Сул эвдэрсэн	29683		Хөрс хамгаалах
	Дунд эвдэрсэн	15687		Хөрс хамгаалах
	Хүчтэй эвдэрсэн	6211		Нөхөн сэргээх
3	Хотжилтийн улмаас эвдэрч зулгарсан	923	Нэмэгдэх	Ногоон байгууламж бий болгох
4	Хотжилтийн улмаас бохирдсон	25.7	Нэмэгдэх	Цэвэрлэх, засч янзлах
5	Бэлчээрийн газарт бохирдсон	134	Нэмэгдэх	Цэвэрлэх, засч янзлах
6	Уурхайн үйл ажиллагаанаас ухагдсан	3500	Эрчимтэй нэмэгдэх	Нөхөн сэргээлт хийх
7	Элсний нүүлтэнд өртсөн	25346	Нэмэгдэх	Ойн зурвас байгуулах
8	Зам харгуй гарсан	64259	Нэмэгдэх	Олон салаа замыг багасгах
9	Усны эвдрэлд орсон	399	Нэмэгдэх	Усны замыг хаах, хүчийг сарниулах
10	Хортон шавьжинд идэгдсэн, үүнээс	6640	Эрчимтэй нэмэгдэх	
	Тариалан	3090		Хор гербицид хэрэглэх
	Ой	3550		Хор цацах,
11	Түймэрт шатсан ой	10808	Нэмэгдэх	Түймрээс урьдчилан сэргийлэх
	Бүгд	983215.7		

Бэлчээрийн газар. Булган аймгийн нийт бэлчээрийн 30% нь ямар нэг хэмжээгээр талхлагдсан бөгөөд үүний 53.3%-ийг их талхлагдсан бэлчээр эзлэж

байна. Бэлчээр талхлагдаж байгаагийн нэг гол шалтгаан бол бэлчээрийг сэлгээгүй жил дараалан төв суурин газар ойр, урсгал ус бүхий гэх мэт шалтгаанаар давтан ашиглах, мөн малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулахгүй хэмжээнээс хэтэрсэн мал агуулж байгаа нь дээрх байдалд хүргэж байна. Иймд бэлчээрийг хуваарьт эдлэн эзэмшилд шилжүүлэх, малын тоо толгойг даацад тохируулах, ашиглалт багатай алс холын бэлчээрийн ашиглалтыг сайжруулах, бэлчээрийг хаших, тордон сайжруулах, усжуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй 2-3, 4-5 жилийн сэлгээг мөрдөх, хадлан тэжээл бэлдэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн түүнчлэн бэлчээрийн ашиглалтыг доройтуулж байгаа олон салаа зам гаргах, уурхайн зориулалтаар ухаж төнхөх, усны эвдрэлд орох, элсний нүүлтэнд өртөх зэрэг сөрөг үзүүлэлтүүдийн хэмжээг аль болох сааруулах хэрэгтэй. Ер нь Булган аймаг газар тариалангийн төв бүс нутаг учир малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах, илүү тооны мал агуулахгүй байх өндөр ашиг шимт цөөн тооны эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх нь чухал.

Газар тариалан. Уг салбарын хувьд Булган нутгийн хөрсөн бүрхэвч, түүний агро шинж чанар харьцангуй сайн, агроүйлдвэрлэлийн өндөр зэрэглэлтэй боловч ашиглалтын явцад нийт талбайн 45.5% ямар нэг байдлаар элэгдэж эвдэрсэн байх юм. Одоогийн байдлаар эвдрэлийн зэрэглэлд сул эвдэрсэн талбай ихэнхи хувийг эзлэж байгаа боловч эвдрэлийн байдлыг ажихад маш эрчимтэй явагдаж байна. Иймд одоогийн мөрдөж байгаа агротехникийн бодлогодоо өөрчлөлт хийж эхний ээлжинд хөрс хамгаалах болон агротехникийн арга хэмжээг иж бүрэн цогц байдлаар бүрэн дүүрэн явуулах, газар тариалангийн арвин туршлагатай тариаланчдад газрыг эзэмшүүлэх, талбайг хэт олноор жижиглэн хувиарлахгүй байх, техникийн парк шинэчлэлт хийх, үрийг шинэчлэх, усалгаатай тариалан эрхлэх гэх мэт олон арга хэмжээг дурьдаж болно. Одоо газар тариалангийн үйлдвэрлэлийг явуулж байгаа ихэнхи аж ахуйн нэгж, иргэд зөвхөн үр булах замаар газарт ямар ч хөрөнгө оруулалт хийхгүйгээр тариалан эрхэлж байгаа нь хөрсний ядуурал, элэгдэл эвдрэлийн процессийг улам түргэсгэж байгааг дурьдах хэрэгтэй.

Хот суурингийн газар. Улс орон, нийгэм эдийн засаг жил ирэх тутам өсөн хөгжиж байгаа нь улс орны хөгжлийг харуулж байгаа сайхан хэрэг боловч нөгөөтэйгүүр түүнийг даган үүсэх сөрөг үр дагаврыг сайтар тооцоолж хор уршигийг бууруулах явдал хөгжилийг түргэтгэхээс эрхэм зорилго болж байгааг өнөөгийн бидний амьдрал харуулж байна. Судалгаанаас үзэхэд хот суурингийн суурьшилийн бүсийн нийт талбай нэлэнхүйдээ 100% ямар нэг байдлаар хөрс ургамлан бүрхэвч нь зулгарсан байх юм. Үүнд ургамлан бүрхэвч ихэнхи газарт байхгүй болж зөвхөн барилга байгууламж, гудам хашааны ёроолоор лууль шарилж, агь, халгай, цахилдаг мэтийн ганц нэг ургамлаар төсөөлөгдөнө. Тэрч байтугай хөрсний өнгөн үе давхарга 1-3 см-ээр нимгэрч бүтэц алдагдан элс, хайрга шорооны холимог болсон байна. Ийм дүр зураг нийт төв сууринд түгээмэл ажиглагдана. Хот суурингийн багахан хувийг /дөнгөж 2%/ ногоон байгуулаж эзэлнэ. Энд анхаарал татсан хамгийн хүнд асуудал бол гэр хорооллын утаа, агаарын бохирдол байдаг. Иймд одоогийн хэрэглэж буй энгийн галлагааны зуухыг бүрэн шаталттай зуухаар солих, утаагүй түлшийг ихээр үйлдвэрлэх, байгаль орчинд хоргүй техник технологи нэвтрүүлж буй аж ахуйн нэгж ард иргэдийг дэмжих, урамшуулах, сөрөг үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд хариуцлага тооцох гэх мэт наад захын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн гэр хорооллын бохир муу ус жорлонгийн асуудлыг ч сайжруулах шаардлагатай байна. Булган аймагт нийт 2568.6 га гэр хорооллын газар байдгаас 1 айл /хашаа/ дундажаар 4,5м² газрыг дээрх зориулалтаар бохирдуулдаг гэж үзвэл нийт 9982 хашаанд 44918

м² газар бохирдсон тооцоо гарч байна. Уг бохирдлыг багасгахын тулд жорлон муу усны нүхийг стандартын дагуу хийх, цооногуудыг хатуу доторлогоотой болгож бохирыг зөөврийн аргаар хотын нэгдсэн цэвэрлэх байгууламжинд нийлүүлэх, хатуу хог хаягдлыг төвлөрсөн цэгт хүргэх, малтай иргэдийн бүс нутгийг нарийн зааглан тогтоох, зам харгуй, гудам хоорондын зайг хэм хэмжээний дагуу гаргах, ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Гэр хороолол нь манай өсөн нэмэгдэж буй хэрэгцээг даган өөрийн хөгжилийн зүй тогтлоороо бие даан бусадаас хамааралгүй хөгжиж байгаа өнөөгийн нөхцөлд түүнийг эрэмбэ дараатай үе шаттайгаар хотын нэг салшгүй хэсэг болгон хөгжүүлэх явдал чухал байна.

Уурхайн газар. Булган аймагт уурхайн газар онцгой байр суурийг эзлэн хөгжихгүй боловч багахан газар нь нэлээдгүй хохирол учруулсан гэж үзэж болно. Үүний тод жишээ бол Бүрэгхангай Заамар сумын нутгийг дамжин байрласан хуулиар болон хууль бусаар алт олборлогчид юм. Сүүлийн 5 жилд алт олборлох явдал эрчимтэй газар авч энд нийт 9646 га талбайг хамарч байгаагаас 3500 га талбай их бага ямар нэг хэмжээгээр ухаж төнхөгдсөн байна. Хамгийн аюултай нь энд нөхөн сэргээлтийн ажил бараг хийгдээгүй гэж хэлж болох бөгөөд алт олборлогч ганц нэг аж ахуйн нэгжүүд бага зэрэг техникийн нөхөн сэргээлтийг ор нэрийн төдий хийсэн ба биологийн нөхөн сэргээлтийн талаар санахын ч хэрэггүй. Газрын хэвлийг ухан төнхсөнөөс гадна тэнд хууль бусаар алт олборлож байгаа олон зуун хүмүүсийн амьдрах орчин болсон тэр газар ямар хэмжээний бохирдол, талхлагдал, зам харгуй гарсныг дурьдахгүй өнгөрч болохгүй. Энэ байдлыг сум орон нутаг, төр засаг нэн даруй таслан зогсооно гэдэгт найдаж байна.

Ойн сангийн газар. нь тус аймгийн газар нутгийн багагүй хувийг /39.1%/ эзлэн оршдог. Ойн сангийн газар гарч байгаа хохирлуудын нэг нь ойн түймэр, хортон шавьжийн асуудал юм. Судалгаанаас үзэхэд аймгийн хэмжээнд нийт 10 808 га талбай ойн түймэрт өртсөн бөгөөд үүний 58 969 га талбайд эхний ээлжинд ойжуулалтын ажлыг яаралтай хийх хэрэгтэй байна. Учир нь ойгүй болсон газар хээрших процесс эрчимтэй явагдаж мод ургах экологийн нөхцөл алддаг учир аль болох хурдан хугацаанд нөхөн сэргээх ажлыг хийх хэрэгтэй. Мөн сибирийн хүр хорхой, өрөөсгөл хүр, бийрэн сүүлт тархсан Хишиг-Өндөр сумын 500 га, Хутаг-Өндөр сумын 500 га, Сайхан сумын 350 га, Сэлэнгэ сумын 1000 га, Тэшиг сумын 1200 га талбайд зохих байгууллагаас тэмцлийн ажлыг даруй хийх хэрэгтэй байна.

Дээрх газруудыг хэрхэн нөхөн сэргээх, хадгалан хамгаалах талаар тухайн тухайн газрын ангилалын бүлэгт тодорхой бичсэн болно.

4.1.3. Газрын хадгалалт, хамгаалалт. Байгалийн унаган төрх байдал, өвөрмөц тогтоц, үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалт газар, ховор ховордсон ургамал, ан амьтны төрөл зүйлийг хадгалан үлдээх, цаашид болзошгүй хүний сөрөг нөлөөллөөс хамгаалахын тулд уг газруудыг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтанд авч байна. Тус аймгийн хувьд нийт га талбай улсын тусгай хамгаалалтанд байдаг. Уг газарт аливаа аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглох бөгөөд зөвхөн амралт аялал жуулчлалын чиглэлээр заасан хэм хэмжээнд хязгаарлалттай ашиглахыг зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл аливаа байгаль орчинд сөрөг нөлөө бүхий үйл ажиллагааг хатуу хориглох бөгөөд зөвхөн тордон сайжруулах, нөхөн сэргээх үйл ажиллагааг дэмждэг. Цаашид Бүрэнгийн нуруу 22 933 га, Зэд Бүтээлийн нуруунд 45 7164 га талбайг тус тус Улсын тусгай хамгаалатанд авах шаардлагатай байна. Мөн түүнчлэн сум орон нутаг улсын тусгай хамгаалалтаас гадна байгалийн үзэсгэлэнт болон

түүх соёлын дурсгалт газар, ховор ан амьтан, ургамал бүхий газруудаа орон нутгийн тусгай хамгаалалтанд авч хайрлан хамгаалах хэрэгтэй.

4.2. Газрын эдийн засгийн үр ашиг, удирдлага, зохион байгуулалт.

4.2.1. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт.

Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилааг төлөвлөлтийн өмнөх болон дараахи үетэй харьцуулахад дараахи дүр зураг харагдаж байна /хүснэгт 50/.

Хүснэгт 50

Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт, га.

Д/д	Газрын зоиулалт	Төлөвлөлтийн өмнө	Төлөвлөлтөөр	өөрчлөлт
1	Нийтийн зориулалттай бэлчээр	2521198	2 310163	
2	Өрхийн аж ахуйн	-	32773	
3	Эрчимжсэн аж ахуйн	-	21671	
4	Хосолмол аж ахуйн	-	91677	
	Нийт бэлчээр	2 521 198	2 456 284	-64914
5	Тариалан	65960	94 907	+28 947/16755/
	Атаршуулах талбай	47182	34 990	-12 192
	Хадлан	112020	118 457	+6437
	Гэр хороолол	1768	2263	+495
	Барилгажсан хэсэг	2779	3002	+223
	Уурхайн газар	2144	9646	+7559
	Хүн амын социал нөхөн сэргэлтийн бүс	303	415	+112
	Ойн сангийн газар	1 905 198	1 868 179	-38053
	Усан сангийн газар	22 232	50 714	+28 482
	Авто зам	2960	4000	+1040
	Төмөр зам	-	3170.4	+3170.4
	Шугам сүлжээ	4656	7595	+2939
	Тусгай хамгаалалттай газар	52790	532887	+480097

Бэлчээрийн газар нь төлөвлөлтийн өмнө зөвхөн нийтээр ашиглах гэсэн статустай байсан бол төлөвлөлтийн дараа өрхийн аж ахуйн, эрчимжсэн аж ахуйн, эрчимжсэн болон нийтээр ашиглах газартай хосолмол гэж хуваагдсан учир нийтээр эзэмших талбайн хэмжээ төлөвлөлтийн өмнөх үеэс багассан дүн гарсан. Дээр нь бусад ангиллын газрыг нэмэгдүүлж төлөвлөсөн учир уг газрыг нийтээр эзэмших бэлчээрийн газраас хасаж төлөвлөсөн учир уг талбай нэлээд буурсан дүнтэй гарлаа. Үүнд бэлчээрээс тариаланд 16 755га, хадланд 4857га, уул уурхайд 7 559га, амралт рашаан сувиллын газарт 112, усан цахилгаан станц барихад 28 482га, авто зам тавихад 1 040га, төмөр зам тавихад 3 170 га, цахилгаан шугам сүлжээг өргөтгөхөд 2 939га талбайг тус тус бэлчээрээс авснаар нийт 64 914 га талбай хасагдаж байгаа бөгөөд түүн дээр нэмээд өрхийн болон фермер хосолмол аж ахуйнуудад 14 621 га бэлчээр ашиглуулна гэж үзвэл нийтээр ашиглах чөлөөт бэлчээрийн талбай **211 035 га талбайгаар хорогдож 2 310 163га болтлоо буурч** байна. Ер нь тус аймгийн хувьд нийтээр эзэмших уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн эзлэх хувийг багасгах эрчимжсэн,

төрөлжсөн цөөн тооны өндөр үр ашигт мал аж ахуйг хөгжүүлэх хэтийн төлөвийг барьсан болно.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн хувьд 65960 га талбай одоо эргэлтэнд байгаа бөгөөд үүн дээр бэлчээрийн газраас 16755 га талбайг шинээр хагалах буюу хуучин тариаланд ашиглаж байгаад атаршуулж бэлчээрт шилжүүлсэн талбайнуудаас авах, хоёрдугаарт одоогийн байгаа атаршсан 47384 га талбайнаас эргүүлэн ашиглах боломжтой 5667га мөн усалгаатай ашиглах боломжтой 6 525га талбайг нэмж ашиглаж болох бөгөөд ингэснээр тариалангийн эргэлтийн талбайн хэмжээг нийт 94 907га талбайд хүргэх боломжтой. Үүний үр дүнд атаршсан талбайн хэмжээ 12 192 га талбайгаар багасах юм. 2015 он гэхэд манай улс нийт гурилынхаа 75%-ийг дотоодоос хангадаг болохын тулд 500 мян, га талбайгаас доошгүй талбайд тариалалт хийх шаардлагатай гэж заажээ. Тэгвэл Булган аймаг 65-75 мянган га талбайд тариалалт хийх үүрэг хүлээх бөгөөд үүнийг бид дээрх замаар шийдвэрлэж болно гэж үзлээ. Мөн төмс, хүнсний ногооны талбайг 629.1 га-д хүргэхээр төлөвлөсөн нь аймгийн дотоодын хэрэгцээгээ хангах бүрэн боломжтой.

Хадлангийн газрын хэмжээ 2006 оны газрын тоо бүртгэлийн материалд 112 020 га талбай эзлэж байгаа бөгөөд үүнийг бэлчээрийн газраас хадах боломжтой газруудыг хадах замаар 4 857 га, ойн сангийн газраас ойн цоорхой болон ойн зах бэл хэсгээс хадах замаар 1 578.2 га талбайг хадаж болох бөгөөд ингэснээр нийт 6437 га талбайгаар хадлангийн нэмэгдэж 118457га болтлоо өсөх боломжтой. Одоогийн байгаа хадлангийн талбайнаас жилдээ дундажаар 65-70 мян. тонн хадлан авдаг бөгөөд эдгээр талбайг сайжруулснаар энэ хэмжээг 15-20 мян. тонноор нэмэгдүүлэн 90.4 мян.тоннд хүргэх боломж бий. Дээр нь ой, бэлчээрийн газраас хадаж болох төлөвлөсөн хадлангийн талбайгаас 4.7 мян, тн хадлан авах боломжтой /хүснэгт 2/ гэж үзвэл хадлангийн арвин их нөөц байна.

Хот суурингийн газар түүний дотор гэр хорооллын газрыг 495 га талбайгаар, барилга байгууламжийн доорх газрыг 223 га талбайгаар нэмэгдүүлэхээр төлөвлөлөө. Статистик мэдээнээс үзэхэд Булган аймгийн хүн ам жилд 1 % хүрэхгүй хувиар өсөж байгаа бөгөөд 2020 он гэхэд 16.5% -иар өсөх тооцоо бий. Тэгвэл энэ өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахын тулд гэр хорооллын газрыг наад зах нь 495 га талбайгаар, барилга байгууламжийн доорх газрыг 223 га талбайгаар тус тус нэмэгдүүлэх шаардлага гарч байна. Гэвч эхний ээлжинд одоогийн байгаа газрын нягтралыг нэмэгдүүлэх замаар цаашилбал шинээр газар нутгийг тэлэх замаар уг асуудлыг шийднэ.

Хүн амын социал нөхөн сэргэлтийн бүсэд шинээр байгуулагдах амралт сувилал, аялал жуулчлалын баазуудыг бараг бүх сумдад төлөвлөж нийт 112 га талбайг бэлчээрийн газраас авлаа. Энд байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газрууд, нутгийн халуун хүйтэн рашаан усыг бараадуулан дээрх газруудыг төлөвлөсөн болно. Дэлгэрэнгүй мэдээллийг тухайн бүлгээс уншина уу.

Уурхайн газарт одоогийн байдлаар Заамарын алтны бүлэг орд, Тавтын алтны орд, Сайхан-Овооны нүүрсний уурхай, Эрээний нүүрсний уурхай, Баяндуурхын нүүрсний уурхай зэрэг уурхайнууд нь нийт 2144 га талбайд яг олборлолт хийж байгаа бөгөөд төлөвлөлтийн хугацаанд энэ хэмжээ зөвшөөрөгдсөн лицензийн талбайн хэмжээнд 7559 га талбайгаар нэмэгдэж 9646 га болтлоо өсөх магадлалтай.

*Ойн сангийн газар. нь 2005 оны газрын тоо бүртгэлийн материалд 1 905 198 га талбай эзлэж байгаа бөгөөд бидний судалгаагаар **1 867 145 га талбайг эзлэж байгаа нь даруй 38053 га талбайгаар дутаж** байна. Энэ нь сүүлийн жилүүдэд ой хээрийн түймэрт өртөх, хортон шавьжинд идэгдэх, түлш болон ахуйн*

хэрэгцээнд түлээ мод огтолж байгаатай холбогдуулан багассан гэж үзэх үндэслэлтэй. Ер нь ойн талбай жилээс жилд багасаж байгаа өнөө үед ойжуулалтын ажлыг эрчимтэй хийх, одоогийн байгаа мод үржүүлгийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, ойд хохирол учруулж байгаа аж ахуйн нэгж иргэдэд ноогдуулах нөхөн төлбөрын хэмжээг эрс нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мод үржүүлгийн талбайг Дашинчилэн, Хялганат, Хангал, Сэлэнгэ, Орхон, Хутаг-Өндөр, Бугат сумын нутагт одоо байгаа талбайн хэмжээг өргөтгөх замаар 20 га талбайгаар нэмэгдүүлбэл зохино.

Тусгай хамгаалалттай газар нутаг. Жил ирэх тутам нийгэм эдийн засгийн хөгжилийг дагаад газар нутгийн онгон дагшин, ховор нандин дахин давтагдашгүй байдал алдагдаж ямар нэг байдлаар доройтох явдал газар авсаар байна. Иймд байгалийн үзэсгэлэнт газруудыг улсын болоод орон нутгийн тусгай хамгаалалтанд авах нэгэнт авсан газрыг зохих ёсоор хадгалан хамгаалах явдал зүй ёсоор шаардагдаж байна. Иймд цаашид Бүрэнгийн нуруу 22933га, Зэд Бүтээлийн нуруунд 457164га талбайг тус тус Улсын тусгай хамгаалатанд авах шаардлагатай байна.

4.2.2. Газрын эдийн засгийн үнэлгээ.

Газар зохион байгуулалтын ажлаар газрын нэгдмэл сангийн ангилаанд өөрчлөлт орж байгаатай уялдуулан газар ашигласны төлбөр хэрхэн өөрчлөгдөж буйг дараахи хүснэгтээр харуулав хүснэгт 51/. Газарт ноогдуулах төлбөрийн дээд болон доод хэмжээг ЗГ-ын 1997оны 152-р тогтоолын 2,3-р хаврсралтанд заасан хэмжээгээр авсан болно. Булган аймаг нь уг тогтоолоор Хангай Хэнтийн уулархаг тойрогт багтаж буй учир уг тойргийн үнэлгээг мөрдлөг болгов.

Хүснэгт 51

Газрын төлбөрийн өөрчлөлт

Д/д	Газрын менежментийн бүсүүд	Төлөвлөлтийн өмнө		Төлөвлөлтөөр		Төлбөрийн өөрчлөлт, мян,төг
		Талбай, га	Төлбөр, мян,төг	Талбай, га	Төлбөр, Мян,төг	
1	Өрхийн аж ахуйн	-	-	32773	25136.9	+25136.9
2	Эрчимжсэн аж ахуйн	-	-	21671	16621.6	+16621.6
3	Хосолмол аж ахуйн	-	-	91677	70316.3	+70316.3
4	Тариалан	65960	61672.6	94907	88738.0	+27065.4
5	Хадлан	112020	-	118457	29377.3	+29377.3
6	Гэр хороолол	1768	130655.2	2263	167235.7	+36580.5
7	Барилгажсан хэсэг	2779	205368.1	3002	221847.8	+16479.7
8	Уурхайн газар	2144	1259600	9646	5667025	+4407425
9	Хүн амын социал нөхөн сэргэлтийн бүс	303	33.3	415	45.6	+12.3
10	Ойн сангийн газар	1 905 198	19051.9	1 868 179	18681.8	-370.2
11	Усан сангийн газар	22 232	8892.8	50714	20285.6	+11392.8
12	Авто зам	2960	-	4000	-	
	Төмөр зам	-	-	3170.4	-	
	Шугам сүлжээ	4656	-	7595	-	

13	Тусгай хамгаалалттай газар	52790	-	532887	-	
	Дүн		1685273.9		6325311.6	4640037.7

Хүснэгтээс үзэхэд үйлдвэр уурхайн газраас олох орлого 2020 гэхэд ч давамгайлсан хэвээр байх болно. Түүний дараа хот суурин газрын төлбөр орох бөгөөд гэр хорооллын газар 495га, барилга байгууламжийн доорхи газрын хэмжээг 223 га талбайгаар нэмэгдүүлснээр газрын төлбөрийн хэмжээг 53060.2 мян, төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой. Тариалангийн газрын хэмжээг одоогийн байгаагаас 28 947га нэмэгдүүлснээр газрын төлбөр 27065.4мян, төгрөгөөр нэмэгдэх бөгөөд нийт талбайн 629.1га талбайг төмс хүнсний ногоо тариалахаар төлөвлөсөн нь төлбөрийг дээрх хэмжээнээс нэмэгдүүлээд зогсохгүй аймгийн дотоодын хэрэгцээгээ хангах бүрэн боломжтой.

Хадлангийн талбайг иргэдэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлснээр 1 га хадлангийн талбайн төлбөрийг 250 төгрөгөөр тооцвол жилдээ нийт 29377.3 мян. төг орон нутгийн төсөвт орох боломжтой. Бэлчээрийн газрыг өрхийн болон фермерийн аж ахуй мөн түүнчлэн хосолмол аж ахуй зэрэг тодорхой хуваарьт эдлэн эзэмшилтэй аж ахуйн нэгжид төлбөртэй эзэмшүүлснээр жилдээ 112074.8 мян. төгрөгийн орлого орох боломж байна, ер нь дээрх маягаар иргэд аж ахуйн нэгжид тодорхой газрыг зориулалтын дагуу олгосноос нийтдээ 4 640 037.7 мян. төгрөгийн орлогыг газар ашигласны төлбөрөөс олж болох бөгөөд тухайн хөрөнгийн 15%-иас багагүй хувийг тухайн газар нутгийг хадгалан хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулдаг хэв жишигийг тогтоох шаадлагатай байна.

Ерөнхий дүгнэлт

1. Булган аймаг нь байгаль экологи, нутаг дэвсгэрийн хувьд ХАА-н үйлдвэрлэл тэр дундаа газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэн дэмжиж хөгжүүлэх чиг бодлогыг энэхүү баримт бичигтээ мөрдлөг болгон ажиллав. Үүний тулд нийгэм эдийн засгийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгуурлан хэтийн төлвийг 2005 - 2010, 2010 - 2015, 2015 - 2020 он хүртэл 5 жилийн хугацаатайгаар 3 үе шатаар төлөвлөв. Энэ хугацаанд тариалангийн нийт газрыг 28 947 га газраар нэмэгдүүлж одоогийн байгаа хэмжээг 94907 га талбайд хүргэв. Үүний 25 389 га талбайг усалгаатай ашиглах боломжтой.
2. Нэгэнт газар тариалангийн төв бүс нутаг учир өндөр үр ашиг бүхий цөөн тооны эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар уламжлалт чөлөөт газар ашиглалттай бэлчээрийн мал аж ахуйн эзлэх хувийг багасгах хэтийн чигийг баримтлав. Ингэснээр өрхийн аж ахуйн бүсэд 32 773га, эрчимжсэн аж ахуйн бүсэд 21 671, хосолмол аж ахуйн бүсэд 91 677га уламжлалт бэлчээрийн аж ахуйд 2310163 га талбайг тус тус хамруулав
3. Хадлангийн талбайг хойшид иргэд, аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэн түүний экологийн төлөв байдалд тавих хяналтыг сайжруулан ургацын хэмжээг нэмэгдүүлэн хувиарт эдлэн эзэмшилтэй эрчимсэн мал аж ахуйн хэрэгцээг хангах чигийг баримтлав. Төлөвлөлтийн хугацаанд хадлангийн талбайг бэлчээрийн болон ойн сангийн газраас хадах замаар 6 437га талбайгаар нэмэгдүүлэв.
4. Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээнд зориулан гэр хорооллын газар 495 га, барилга байгууламжийн доорхи газрын хэмжээг 223 га, хот тэлэх бүсийг 599 га талбайгаар тус тус нэмэгдүүлэхээр төлөвлөв. Үүнд шинээр Тэшиг сумын дэргэд Тавтын уурхайн тосгон /2000 хүн амтай/, Сэлэнгэ

- суманд Эгийн голын цахилгаан станцын дэргэд 200 хүн амтай суурин хөгжүүлэхээр төлөвлөв.
5. Уурхайн газарт одоогийн ажиллаж байгаа уурхайнууд лицензийн талбайгаа 100% бүрэн дүүрэн ашиглахад олборлолтын талбайн хэмжээ 7559 га талбайгаар нэмэгдэж нийт 9646 га болохоор төлөвлөв.
 6. Усан сангийн газрыг төлөвлөхдөө Хутаг-Өндөр сумын нутагт барих Эгийн голын, Орхон суманд баригдах Орхон голын, Бугат сумын нутагт Сэлэнгэ мөрөн дээр баригдах Арцатын усан цахилгаан станцуудын усан санд бэлчээрийн газраас 28 482 га талбай шаардагдах бөгөөд үүнийг усан сангийн газарт оруулж тооцов.
 7. Ойн сангийн газар нь ой хээрийн түймэрт өртөх, хортон шавьжинд идэгдэх, түлш болон ахуйн хэрэгцээнд түлээ мод огтолж байгаатай холбогдуулан 38 053 га талбайгаар хорогдсон учир ойжуулалтын ажлыг 79 226 га талбайд, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг 89 613 га талбайд, нийт 168 839 га талбайд нөхөн сэргээх ажлыг хийхийн дээр одоогийн байгаа мод үржүүлгийн талбайг өргөтгөх замаар 20 га талбайг нэмэхээр төлөвлөв.
 8. Дашинчилэнгээс Өгийн доод гүүр хүртэл 106 км, Булган – Уньт - Мөрөнгийн чиглэлд 174 км хэсэгчилсэн хайрган хучилттай замууд хатуу хучилттай болж байгаа бөгөөд энэхүү хучилтын зөрүү нь 1040 га болж байна.
 9. Дээр заагдсан усан цахилгаан станцуудыг төвийн эрчим хүчний системд холбоход шаардагдах цахилгаан шугам сүлжээний газрууд нийлбэр дүнгээрээ 2 939 га газар бэлчээрээс хасагдаж байна.
 10. Шинээр баригдах аялал жуулчлал амралт сувилалын газрууд, хүүхдийн зусланд зориулан 112 га газар бэлчээрээс хасагдаж байна.
 11. Нийт 460 мянган га бүхий 2 хэсэг газрыг улсын тусгай хамгаалалтанд авч байгаа бөгөөд энэ хэмжээгээр ойн сангийн газраас хасагдах болно
 12. Уг ажлын нэг онцлог тал бол тухайн нутаг орны нийгэм эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвийг газрын нөөц, нөхцөлийн судалгаан дээр тулгуурлан газрын ангилал тус бүрээр хийсэнд оршино. Энэхүү бичиг баримтаар нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөв тодорхойлогдоод зогсохгүй газрын нөөцийг эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай ашиглах, түүнийг унаган төрх байдлаар нь хадгалах, хамгаалах зэрэг байгаль орчны цогц асуудлуудыг хөндөж өгснөөрөө чухал ач холбогдолтой. Мөн түүнчлэн газрын харилцаа, газар эзэмших ашиглах эрх зүйн орчин боловсронгуй болох, газар ашигласны төлбөр түрээсийн орлого нэмэгдэх, ингэснээр түүнийг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгийн эх үүсвэр бүрдэх боломж тодорхой хэмжээгээр бүрдэнэ.

Ашигласан хэвлэлийн жагсаалт

1. Аймгийн ГЗБЕТөлөвлөгөө болосруулах арга зүйн заавар. 2006.
2. Булган аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр
3. Булган аймгийн хөгжлийн үндсэн чиглэл
4. Булган хотын ерөнхий төлөвлөгөө
5. Булган аймгийн Газрын нэгдмэл сангийн ангилалын зураг тооллогын материал
6. Бэлчээр, хадлан тариалангийн болон суурьшилийн бүсэд хийсэн газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажлууд
7. Булган аймагт нийгэм эдийн засгийн болон байгаль экологийн талаар хэрэгжиж байгаа төслүүдийн судалгааны тайлангууд
8. Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал (1996 он)
9. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (1994 он)
10. Монгол улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр (1998 он)
11. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2001 он)
12. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (1998 он)
13. Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (1997 он)
14. Төрөөс хөдөөгийн хөгжлийн талаар баримтлах бодлогын чиглэл (1996 он)
15. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2000 он)
16. Монгол улсын Засгийн газрын “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”-ийн бодлогын баримт бичиг
17. Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал (1995 он)
18. Монгол улсын эдийн засаг, нийгмийн 2002 оны хөгжлийн үндсэн чиглэл, 2003-2005 оны хөгжлийн хандлага (2001 он)
19. Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр (1996 он)
20. Төрөөс ХАА, Хүнсний үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого /2002 он/
21. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр /2000 он/
22. Монгол улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр /2002 он/
23. Булган аймгийн газрын нэгдмэл сангийн ангиллын тайлан, 2005
24. Булган аймгийн статистикийн мэдээ, 2005.
25. Ш. Цэгмид “Монгол орны физик газар зүй” 1969.
26. Ш.Баясгалан Д.Даваадорж . Монгол орны ХАА-н уур амьсгалын лавлах. 1996
27. Булган аймгийн цаг уурын станцын мэдээ, 2005
28. Булган аймгийн хөрсний тайлбар бичиг, зураг.1983
29. А.А.Юнатов БНМАУ-н ургамлан нөмрөгийн үндсэн шинжүүд. 1976.
30. Булган аймгийн бэлчээрийн ТБЧУХБ. Глобус ХХК. 2000.
31. Булган аймгийн тариалангийн талбайн хэмжилт бүртгэлийн материал, УГЗБХЗТИнститут, 1985.
32. Булган аймгийн тариалангийн талбайн хөрсний элэгдэл эвдрэлийн тайлбар бичиг, ГБХүрээлэн, 1991.
33. Булган аймгийн тариалангийн талбайн хянан баталгааны материал. ХАУТЛ. 1999, Глобус ХХК. 2005.
34. Д. Доржготов “ Монгол орны хөрс, 2003.
35. Булган аймгийн газар ашиглалтын зураг 1:50 000
36. “Ойн судалгаа, ой зохион байгуулалтын ажил” Ой хайгуул төслийн төв, 1998

37.Булган аймагт усалгаатай ашиглаж болох талбайн судалгаа” УХТЭШХ,
1982.

ё	Нуруудын нэр	Өндөр м	Талбай га	Урт км	Өргөн км	Дундаж гүн м	Усны эзэлхүүн км ³	Эргийн шугам км	Хөгжлийн коэффициент
1	2	3	4	5	6	7	8	9	10
3-130	Загийн шал нуур	1032	33.1	21	1.5	1	0.003	49.4	2.42
3-131	Бөөнцагаан нуур	1312	252	24	11	16	2.385	81	1.44
3-132	Орог нуур	1217	140	31.8	2	6.3	0.42	75	1.79
3-133	Борвойн нуур	1755	0.5	1.2	0.4	0.8	0.0001	3	1.2
3-134	Хэрсэнгийн цагаан нуур	1287	1.2	2.2	0.5	1.6	0.0004	6.2	1.6
3-135	Дунд цагаан нуур	1290	1.3	2	0.6	0.6	0.0002	5.2	1.29
3-136	Хажуу цагаан нуур	1283	1.3	2.1	0.6	0.9	0.0003	6.4	1.58
3-137	Баян бүрд нуур	1264	0.6	2.5	0.2	1.3	0.0002	5.2	1.89
3-138	Зээрийн ус нуур	1299	1.2	2.2	0.5			5.8	1.49
3-139	Бухтын ширээ нуур	990	1.8	2.5	0.7	2	0.0016	7.2	1.52
3-140	Хөөвөр нуур	697	2	2.7	0.1	1.6	0.0014	11.8	2.35
3-141	Онгон улааны нуур	729	3.1	3.2	0.9	2	0.0031	9	1.44
3-142	Бага цагааны нуур	1283	0.5	1.3	0.3	1	0.0002	3	1.2
3-143	Цагаан нуур	1270	0.5	1.1	0.4	1	0.0002	3	1.2
3-144	Жинст тойром	2077	0.5	1.6	0.3			3.4	1.36
3-145	Хоолойны шар тойром	1310	0.5	1.4	0.3	0.7	0.0001	3.2	1.28
3-146	Загийн цагаан нуур	1070	0.5	1.7	0.2	1.32	0.0003	3.2	1.43
3-147	Бухтын шал тойром	981	0.6	1.4	0.4	0.8	0.0005	3.4	1.24
3-148	Их ширээ худгийн тойром	1060	0.5	1.2	0.4	0.9	0.0002	2.8	1.12
3-149	Өмнө тойром	800	0.6	1.6	0.3	1.1	0.0008	3.8	1.38
3-150	Туулайт тойром	762	1.1	1.7	0.6			4.8	1.29